

**АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ГЭМТ ХЭРГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

**60 Шаталсан алхамт гарын авлага**

**Роналд В.Кларке ба Жонн Э.Экк.**



**ASU School of Criminology  
and Criminal Justice**  
Arizona State University



**Center for  
Problem-Oriented Policing**





АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ГЭМТ ХЭРГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ  
**60 ШАТАЛСАН АЛХАМТ ГАРЫН АВЛАГА**



Роналд В. Кларке ба Жон Э.Экк

### **Гарын авлагын товч тайлбар:**

Энэ төслийг АНУ-ын Хууль зүйн яамны Олон нийтэд чиглэсэн цагдаагийн албаны #2003-CKWX-048 тоот хамтын ажиллагааны гэрээний хүрээнд боловсруулав. Энэхүү төсөлд дурдагдсан аливаа санал, дүгнэлт нь зөвхөн зохиогчийн байр суурийг илэрхийлэх бөгөөд АНУ-ын Хууль зүйн яамны байр суурийг илэрхийлэхгүй юм. Тодорхой нэг газар/хэлтэс, компани, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар энэ баримт бичигт иш татсан нь зохиогч эсвэл АНУ-ын Хууль зүйн яамны зүгээс тэдгээрт аливаа баталгаа буюу дэмжлэг гаргасан явдал биш бөгөөд зөвхөн энэ сэдэвтэй холбоотой хэлэлцүүлгийг баяжуулах зорилготойгоор оруулсан болно.

Энэхүү материалд дурдсан интернэтийн эшлэл материалууд нь уг материалыг хэвлэх үеийн байдлаар хүчинтэй. Өгөгдсөн URLs хаяг, веб сайтуудад өөрчлөлт орж болно. Иймд зохиогч болон COPS-ийн алба нь эдгээр мэдээллийн хучин төгөлдөр эсэхийг хариуцахгүй болно.

### **Санамж:**

Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS) -ийн Монгол дахь Төлөөлөгчийн газраас уг бүтээлийг зохиогчдын зөвшөөрөлтэйгөөр АНУ-ын Төрийн Департаментын Олон улсын Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, хууль сахиулах товчоо (INL)-ны дэмжлэгтэйгээр орчуулан хэвлэв. Энэхүү баримт бичгийн анхны хувилбар болох англи хэлнээс монгол хэл рүү хөрвүүлэхэд гарсан алдаа, дутагдлыг зохиогчид болон Аризона мужийн их сургуулийн Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны төвөөс хариуцлага хүлээхгүй болно. Хэрэв уг бүтээлд орчуулгын алдаа гарсан тохиолдолд анхны хувилбарыг үзнэ үү.

Анхны хэвлэлийн нэр:

Кларк, Роналд В ба Жонн Э.Экк. 2016. Асуудал шийдвэрлэгчдэд зориулсан гэмт хэргийн дүн шинжилгээ 60 шаталсан алхам. Вашингтон Д.С, Олон нийтэд чиглэсэн цагдаагийн алба ISBN: 1-932582-52-5

Эхний хэвлэл 2009, Шинэчлэгдсэн хувилбар 2016.

**Зохиогчид****Өмнөх үг****Талархал****Эхлэн унших хэсэг****Өөрийгөө бэлтгэх хэсэг**

1. Өөрийн ажил мэргэжлээ эргэцүүлэн бодох нь
2. Бус нутгийнхаа гэмт хэргийн "мэргэжилтэн" нь болох нь
3. Цагдаагийн үйл ажиллагааны хамгийн үр дүнтэй (үр дүнгүй) арга барилын тухай мэддэг байх

**Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаанд суралцах**

4. Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаагаар мэргэших нь
5. Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааг туштай хэрэгжүүлэх нь
6. Тухайн гэмт хэрэгт тохирсон арга хэмжээ авч ажиллах нь
7. "SARA" аргачлалыг баримтлах

**Орчны гэмт хэрэг зүйг судлах нь**

8. Асуудалд дүн шинжилгээ хийх гурвалжныг ашиглах
9. Хулгайн хэрэг гарах нөхцөл, шалтгаан бүрдсэн үед хулгайч бий болдог
10. Гэмт хэрэгтний өнцгөөс бодож үзэх
11. Гэмт хэрэгтний хариу үйлдлийг урьдчилан таамаглах
12. Шилжилт хөдөлгөөний онолыг үндэслэсэн эсэргүүцлийг эс харгалзах нь
13. Аливаа арга хэмжээнээс үүдэх эерэг үр дүн тархах эсэхийг үнэлэх

**Гэмт хэргийн асуудал, нөхцөлийг судлах нь**

14. Асуудлыг тодорхойлохдоо "CHEERS" сорилыг хэрэглэх нь
15. Танд ямар төрлийн асуудал тулгарсан болохыг тодорхойлох
16. Гэмт хэрэг үйлдэх зорилгоор туулах замыг судлах нь
17. Гэмт хэргийн өндөр төвлөрөл бүхий газар, байршил хэрхэн үүсдэгийг олж мэдэх
18. 80-20 дүрэмд хамаарах эсэхийг судлах

**Дүн шинжилгээ хийх нь**

19. Тулгарсан асуудлыг судлах
20. Таамаглал дэвшигүүлэх
21. Мэдээллээ өөрөө цуглуулах
22. Мэдээллийн тархалтыг шалгах
23. Хэргийн төвлөрөл өндөр бүхий газар, байршилыг оношлох
24. Өндөр нарийвчлалтай газрын зургийг хэзээ хэрэглэхийг мэддэг байх
25. Өдөр, долоо хоног тутмын амьдралын хэмнэлд анхаарлаа хандуулах
26. Урт хугацааны өөрчлөлтийг харгалзан үзэх
27. Хувь хэмжээ, харьцаа болон хуваагчийг хэрхэн хэрэглэх тухай суралцах
28. Эрсдэлтэй обьектыг тодорхойлох
29. Давтан хохирогч бий болох тохиолдолд бэлэн байх
30. Давтан гэмт хэргийг харгалзан үзэх



31. Гэмт хэрэгтнүүдийн хүсэж байгаа зүйлсийг тодорхойлох (CRAVED аргачлал)
32. Кейс, хяналтын кейс бүхий судалгаа хийх
33. Хамаарлыг хэмжих
34. Гэмт хэрэг үйлдэхийг хялбаршуулагч хүчин зүйлийг судлах
35. Гэмт хэргийг эхнээс нь эцэс хүртэл нь ойлгох
36. Таван "W" (нэг "H" асуулт) асуултад хариулах
37. Алдаа гаргадагтүй хүн байхгүй гэдгийг ойлгох

#### **Хэрэгжихүйц хариу арга хэмжээг олох нь**

38. Хариу арга хэмжээнд гүйцэтгэх өөрийн үүргийг хүлээн зөвшөөрөх
39. Гэмт хэрэг үйлдэхэд шаардлагатай хүчин чармайлт, хичээл зүтгэлийг нэмэгдүүлэх
40. Гэмт хэрэг үйлдэхэд хүлээх эрсдэлийг нэмэгдүүлэх
41. Гэмт хэрэг үйлдсэнээр хүртэх өгөөжийг бууруулах
42. Гэмт хэрэг өдөөгч хүчин зүйлсийг бууруулах
43. Гэмт хэрэг үйлдэх шалтгийг бууруулах
44. Асуудал, зөрчлийн гол эзэн холбогдогчийг олох
45. Хэрэгжүүлэх хариу арга хэмжээг сонгох

#### **Нөлөөллийг үнэлэх**

46. Үйл явцын үнэлгээ хийх
47. Хяналтыг хэрхэн хэрэгжүүлэхийг судлах
48. Газар зүйн болон цаг хугацааны шилжилт хөдөлгөөнийг тооцоолох
49. Өөр бай, арга зам, гэмт хэргийн төрөлд шилжилт хөдөлгөөнийг шалган тодорхойлох
50. Шинэ, өөр гэмт хэрэгтэн гарч ирж байгаа эсэхэд хяналт тавих
51. Санамсаргүй, гэнэтийн эерэг нөлөөлөлд сэрэмжтэй хандах
52. Гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө цуцлагдсан, орхигдсон эсэхийг төсөөлөх
53. Ач холбогдлыг шалгах сорил

#### **Үр дүнг танилцуулах**

54. Тодорхой түүхийг өгүүлэх
55. Зураглалыг тодорхой гаргах
56. Энгийн бөгөөд ойлгомжтой хүснэгт ашиглах
57. Энгийн бөгөөд ойлгомжтой дүрслэл ашиглах
58. Агууламж сайтай, сайн танилцуулга хийх
59. Үр чадвартай илтгэгч болох
60. Мэдлэг, мэдээлэл хадгалах, хуримтлуулахад хувь нэмрээ оруулах

#### **Нэр томъёо**

**X**язгаарлагдмал төсөв, санхүүжилттэй холбоотой асуудал өнөөдрийн байдлаар тулгараад буй гол бэрхшээлүүдийн нэг болоод байгаа бөгөөд цаашид ч энэ нөхцөл байдал үргэлжлэхээр байна. Цагдаагийн албаны төсвийн гол хувийг хүний нөөцийн зардалд хуваарилан зарцуулдаг. Улмаар цагдаагийн газар, нэгжүүд боломжит хүчин чадлаасаа доогуур түвшинд үйл ажиллагаагаа явуулж байна. Өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагаар шинэ боловсон хүчин ажилд томилж, ажиллуулах санхүүжилт, төсвийг батлуулахад хүндрэлтэй байдаг. Үүнтэй холбоотойгоор их хэмжээний хүн цаг зарцуулдаг цагдаагийн уламжлалт үйл ажиллагааны хэрэглээг багасгаж өхлээд байна. Иргэний аливаа дуудлагыг өмнөхийн адил түргэн шуурхайгаар шийдвэрлэх боломж буурсан бөгөөд мөрдөн шалгах, нэгжлэг хийх, тусгай ажиллагаа явуулах зэргээр гэмт хэрэгтэй тулж ажиллахад шаардлагатай хүн хүчиний нөөц дутмаг болоод байна.

Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан одоогийн цагдаагийн үйл ажиллагааны арга барил, аргачлалыг шинэчлэх хэрэгцээ, шаардлага нэмэгдээд байгаа юм. Энэ нь цагдаагийн үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх талаар өмнө тодорхойлсон зорилттой нийтэйгээс гадна удаан хугацааны турш хөндөгдөөгүй зарим асуудлууд (ажлын үр дагаврыг хянах цагдаагийн институцийн чадавхыг нэмэгдүүлэх; цагдаагийн албаны үндсэн зорилго, түүнийг хэрхэн илүү үр дүнтэйгээр биелүүлэх боломжтой талаар эргэцүүлэн бодох)-ыг шийдэх нөхцөл, боломжийг бүрдүүлээд байна.

Цагдаагийн үйл ажиллагааны одоогийн арга барил, аргачлалыг өөрчлөхөд цагдаагийн албаны үүрэг, хариуцлагын талаарх алба хаагчдын болон олон нийтийн ойлголтыг шинэчлэх шаардлагатай. Цагдаагийн үйл ажиллагаа нь нарийн төвөгтэй бөгөөд зөвхөн хариу үйлдэл үзүүлэхэд тулгуурласан бус, харин олон талт, зан байдлын шинж чанартай

асуудлыг (behavioral problems) шийдвэрлэхийг шаарддаг ажилюм. Түүнчлэн, цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарчмаар ажиллах шаардлагатай гэсэн хүлээлт олон нийт дунд дэлгэрээд байна.

Цагдаагийн үйл ажиллагааны талаар баримтлах зарчим, байр суурийг шинэчлэн тодорхойлоход цагдаагийн алба нь аливаа гэмт хэрэг үүсэх сэдэл, санааг төрүүлж, өдөөдөг зан байдлын шинж чанартай асуудлын (хүчин зүйлс) талаар сайтар судалж ойлгосон байх; гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн давтамжийг бууруулах, шуурхай шийдвэрлэхтэй холбоотой төлөвлөгөө, стратегийг боловсруулсан байх; шинээр авч хэрэгжүүлж буй асуудалд чиглэсэн арга хэмжээний үр дүнтэй байдалд нарийвчилсан дүгнэлт хийдэг байх шаардлагатай. Эдгээр нь асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны нэн чухал хэсэг юм.

Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааг анх 1979 онд нэвтрүүлснээс хойш олон ахиц дэвшил гарсан хэдий ч цагдаагийн үйл ажиллагаанд түгээмэл хэрэглэгдэггүй хэвээр байна. Өөрөөр хэлбэл ихээхэн хүн хүч зарцуулдаг, эргүүлийн явцад баривчилгаа хийх арга барилд суурилсан уламжлалт цагдаагийн үйл ажиллагааны хэрэглээ нийтлэг хэвээр байна.

Зан байдлын шинж чанартай асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх нь чухал бөгөөд үүнд зориулан нэмэлт судалгаа хийж, шинээр төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй. Учир нь цагдаагийн үйл ажиллагаанд тулгардаг ихэнх зан байдлын шинж чанартай асуудлууд, мөн тэдгээрээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар бид хангалттай хэмжээний ойлголттой болсон. Гэмт хэрэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэр дундаа гэмт хэрэг гарах нөхцөл, шалтгааныг арилгах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний

талаарх судалгааны ажлаас энэ талаар олж үзэх боломжтой. Цагдаагийн алба болон алба хаагчдын туршлага, дадлагаас мөн үнэ цэнтэй мэдлэг мэдээлэл олж авах боломжтой. Энэ шугамаар олж авсан мэдээллийг харин сайтар судалж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр нэвтрүүлж хэрэглэх нь зүйтэй болов уу.

Асуудалд суурилсан цагдаагийн үйл ажиллагааны төв (POP Center) ([www.pop-center.org](http://www.pop-center.org)) нь цагдаагийн байгууллагуудад тулгардаг нийтлэг асуудлуудын талаарх мэдээллийн төвлөрсөн сан болоод байна. Төв нь энэ сан дахь мэдээллийг зөвлөмж бүхий хэвлэмэл бүтээгдэхүүн болон бусад арга хэлбэрээр бусдад түгээж, тархаадаг бөгөөд судалгаа, үнэлэлт, дүгнэлт зэргийг нэгтгэсэн уг зөвлөмжүүд нь аливаа асуудлыг шийдвэрлэх арга барилыг тухайн бүс нутгийн онцлог шинж чанарт нийцүүлэн өөрчлөх, үр дүнтэй байдлыг нь сайжруулах хүсэл, сонирхлыг нэмэгдүүлж, хамгийн оновчтой хувилбарыг алба хаагчаар боловсруулах зорилттой билээ.

Хэдий "POP Center" нь асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны арга барилын амжилтын талаар баримтжуулсан олон жишигтэй боловч энэ арга барилыг дэлгэрүүлэх, түгээх явц цагдаагийн байгууллагуудын дүн шинжилгээ хийх дутмаг хүчин чадал, чадварын улмаас удаан байна. Цагдаагийн байгууллагуудад нэг ба түүнээс дээш тооны гэмт хэрэг шинжээчийг ажиллуулах тохиолдол хэдий байдаг ч томоохон хэлтсүүдэд энэ чиглэлээр мэргэшсэн ажилтан байдаггүй, байсан ч тухайн ажилтны үүрэг даалгавар гэмт хэргийн нөхцөл байдлын талаарх хүснэгт боловсруулахаас хэтэрдэггүй. Цөөн тохиолдолд уг ажилтны чиг үүрэгт гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй этгээдийг тогтоож, саатуулах зорилгоор тухайн гэмт хэргийн хэв маягийг (crime pattern) ялан тодорхойлох, бүүр цөөн буюу илүү дэвшилтэй хэрэглээнд гэмт хэргийн хэв маягт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох ажил багтдаг. Гэхдээ эдгээрт хэрхэн хариу арга хэмжээ авч ажиллах чиг үүрэг нь илүү уламжлалт арга барил хэрэглэх хандлагатай үйл ажиллагаа хариуцсан нэгжид хуваарилагдах нь олонтоо.

Харин гэмт хэрэг шинжлэхүйн ухаан улам хөгжин дэвшиж, боловсронгуй болоод байна. Түүний чадамж, чадавхын талаар судалгааны ажлууд хийгдэж, олон нийт эдгээртэй танилцах боломжтой болсон. Цагдаагийн алба хаагчдын өдөр тутамдаа цуглуулдаг их хэмжээний өгөгдөл мэдээллийг цахимаар нэгтгэж, хэрэглэх боломж бололцоо арван жилийн өмнөхтэй харьцуулахад ихээр нэмэгдсэн. Гэмт хэргийг газар зүйн хувьд зураглах чадвар нь гэмт хэргийн дүн шинжилгээнд маш чухал үүрэг гүйцэтгэдэг болжээ. Мөн бус дамнан мэдээлэл цуглуулах, тэдгээрт дүн шинжилгээ хийх, тэдгээрийг тархааж түгээх стандарт аргачлалыг боловсруулаад байна.

Энэ зааварт Роналд Кларк ба Жонн Экк нар шинжээчийн ажлын арга барилын илүү дэвшилтэй бөгөөд үр дүнтэй хувилбарын талаар танилцуулсан. Гэмт хэргийн шинжээч нь аливаа асуудалд үзүүлэх хариу арга хэмжээг боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд гар бие оролцож ажиллах нь зүйтэй. Шинжээч цагдаагийн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор шинэ, илүү бүтээмжтэй, үр дүнтэй арга замуудыг эрж хайхад хувь нэмрээ оруулах шаардлагатай. Энэхүү гарын авлагын тусламжтайгаар Кларк болон Экк нар зохих сургалтад хамрагдсан гэмт хэргийн шинжээч цагдаагийн олон зуун албан хаагчдын ажлын бүтээмж, үр дүнтэй байдлыг хэд дахин нэмэгдүүлэх боломжтойг харуулсан билээ. Иймд олон нийтээс цагдаагийн албандаа хийж буй хөрөнгө оруулалтыг шинжээч хэлсөх, сургахад хуваарилах нь илүү үр ашигтай байх болов уу.

Судлаач болохын хувьд болон цагдаагийн үйл ажиллагааны мэдлэгийнхээ хүрээнд Кларк, Экк нар холбогдох бүх мэдлэг мэдээлэл, аргачлалыг нэгтгэж, 60 шатлалд буулган эмхэтгэв. Энэ заавар нь их хэмжээний чухал бөгөөд боловсронгуй мэдээлэл агуулснаараа цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд сүүлийн хэдэн арван жил хийгдээгүй томоохон судалгааны ажлуудын нэг болоод буй.

Энэхүү гарын авлагын хамгийн ойрын зорилго гэмт хэргийн шинжээчээр ажиллаж байгаа цөөн тооны алба хаагчдын чиг үүргийг

өргөжүүлэх замаар тухайн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад оршино. Үүний дараагаар гэмт хэргийн шинэ шинжээчийн буюу асуудал шийдвэрлэгчийн сургалтад хувь нэмрээ оруулах, шинжээчдийн тоог нэмэгдүүлэх, тэдний ажил мэргэжлийг тусгайлан хөгжүүлэх зорилготой. Гэхдээ асуудал шинжлэхүйн ухаан нь зөвхөн техникч буюу арга зүйчид хамаарах ажил биш билээ. Бид цагдаагийн

байгууллагын алба хаагч, мэргэжилтэн болон удирдлага бүр, цаашлаад олон нийтийн болон хувийн салбарт ажиллаж байгаа хүн бүр энэ гарын авлагад дурдсан санал зөвлөмжийг өөрсдийн ажилдаа хэрэгжүүлнэ гэдэгт найдаж байна.

### **Херман Голдштейн**

Висконсин –Мадисон Их Сургуулийн  
Хуулийн тэнхимиийн профессор

**Э**нэхүү бүтээл нь Их Британи улсын Дотоод хэргийн яам (Home Office)-ны санхүүгийн дэмжлэгтэйгээр Лондон Их Сургуулийн дэргэдэх Гэмт Хэргийн Шинжлэх Ухааны Жилл Дандо Институтэд Асуудал Шийдвэрлэх Гэмт Хэргийн Дүн Шинжээч Болох нь гарын авлагыг сайжруулан, шинэчилсэн хувилбар болно. АНУ-д зориулж тус гарын авлагын энэхүү хувилбарыг боловсруулах, бүтээх боломжийг олгосон Их Британи улсын Дотоод хэргийн яам болон тус институтэд гүн талархал илэрхийлье. Мөн энэ ажлыг хийх хүсэлтийг гаргасан АНУ-ын Олон нийтэд чиглэсэн цагдаагийн албанц гүн талархал илэрхийлье. Өмнөх хувилбарын талархлын хуудсанд бидний ажилд туслалцаа үзүүлсэн хамт олон, найз нөхөд, мэргэжил нэгт хүмүүстээ талархсан сэтгэгдлээ илэрхийлсэн. Баримт мэдээллийн үндсэн дээр энэхүү хувилбарыг бүтээхэд гүн туслалцаа үзүүлсэн дараах хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлж байна. Үүнд:

Stacy Belledin, Rachel Boba, Barbie Brookover, Christopher Bruce, Andy Brumwell, Karen Bullock, Graham Farrell, Rob Guerette, Samantha Gwinn, Shane Johnson, Johannes Knutsson, Gloria Laycock, Nancy Leach, Deborah Loewen, Tamara Madensen, Mangai Natarajan, Cynthia Pappas, Ken Pease, Nanci Plouffe, Barry Poyner, Jerry Ratcliffe, George Rengert, Nick Ross, Kim Rossmo, Rana Sampson, Matthew Scheider, Karin Schmerler, Michael Scott, Nick Tilley, Susan Wernicke, Matt White, Deborah Lamm Weisel нар юм. Та бүгдэд дахин талархал илэрхийлье.

# Эхлэн унших хэсэг

**Э**нэхүү 60 шатлал бүхий зааврыг цагдаагийн үйл ажиллагааг дэмжихэд хэрэгтэй мэдээ мэдээллийг бэлтгэдэг, туршлагатай шинжээч хэрэглэнэ гэх төсөөлөлд үндэслэн боловсруулсан болно. Өөрөөр хэлбэл таныг доорх чадваруудыг эзэмшсэн гэж төсөөлсөн болно. Үүнд:

- Та орчин үеийн компьютер тооцооллыг ашигладаг, дэлгэрэнгүй мэдээллийн сан хөтлөх, түүнд хэрхэн нэвтэрч хэрэглэх талаар мэддэг.
- Гэмт хэргийн өндөр төвлөрөл бүхий цэг, байршил, хэргийн газрыг тодорхойлохын тулд гэмт хэргийн зураглал, газрын зургийн программыг ашиглаж чаддаг, эдгээрийг хүн ам зүй болон бусад холбогдох хүчин зүйлстэй холбон дүгнэлт гаргаж чаддаг.
- Компстат-хэв маягийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн тулд хэлтэс, тасгийн түвшинд долоо хоног, сарын гэмт хэргийн нөхцөл байдлын өөрчлөлт, хөдөлгөөнийг харуулсан график зохиож чаддаг.
- Гэмт хэрэгтний хаяг, машины хулгай, орон байрны хулгайн хоорондоо уялдаа холбоо зэрэг сэдвээр дүн шинжилгээ хийдэг.
- Төвлөрсөн цагдаагийн үйл ажиллагааны (crackdown) өмнөх болон дараах нөхцөл байдлын харьцуулсан дүн шинжилгээг хийдэг (хулгайн хэрэгт үзүүлсэн нөлөөллийн хувьд гэх мэт).
- Статистик, судалгааны арга зүйн суурь мэдлэгтэй буюу энэ чиглэлээр бакалаврын зэрэгт суралцаж байсан.

Энэхүү гарын авлага нь дээрх туршлагад тулгуурлан таныг асуудал шийдвэрлэх багийн түлхүүрийн хувьд янз бүрийн дүн шинжилгээний ажилд бэлтгэх зорилготой. Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны сүүлийн үеийн судалгаанаас үзэхэд гэмт хэргийн шинжээч нь нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах цагдаагийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэхээр байна. Эдгээр судалгааны зохиогчид цагдаагийн үйл ажиллагааны одоогийн арга барилын сул тал, дутагдал нь асуудал шийдвэрлэх бүх үе шатад гэмт хэргийн шинжээчийн оролцоо бага

байгаатай холбоотой гэж дүгнэсэн байдаг.

Энэхүү гарын авлага нь танд асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааб болон үүнтэй холбогдох орчны гэмт криминологи, гэмт хэрэг гарах нөхцөл, шалтгааныг арилгах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга барилын талаарх суурь мэдлэгийг олгож, гэмт хэрэг шинжээчийн шинэ чиг үүрэгт таныг бэлтгэх болно. Та эдгээрийн талаар суралцахгүй, эсвэл өөрийн ажлын үүргийнхээ талаар эргэцүүлэн бодохгүй байх тохиолдолд асуудал шийдвэрлэх гэмт хэргийн шинжээчээр ажиллаж чадахгүй билээ. Иймд энэ гарын авлагын эхний хэдэн булэгт уг чиглэлээр хэрхэн илүү идэвхтэй арга хэмжээ авах талаар тайлбарласан болно. Мэдээлэл авах хүсэлтийн дагуу тантай хамтран ажиллах мэргэжил нэгт алба хаагчийг хүлээн суухын оронд та асуудал шийдвэрлэх үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлоход аливаа төслийн бүх үе шатанд зохих санал, санаачилгыг гаргаж, асуудлын шалтгааныг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, идэвхтэй хариу арга хэмжээг олоход туслах, төлөвлөгөөнд үнэлгээ хийх, алба хаагчид үр дүнгээс нь суралцах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл асуудал шийдвэрлэх багийн салшгүй нэг гишүүн байж, өгөгдөл, мэдлэг, мэдээллийн эх үүсвэрийг шинжлэх буюу өдөр тутмын ажилд хэрэглэдгээс гадна мэдээллийн бусад эх сурвалж хайж олох, ашиглах, аливаа нэг төсөлд илүү хүчин чармайлт гаргах, ажлын сөрөг болон ээрэг үр дүнд багийн бусад гишүүдтэй хамтран хариуцлага хүлээдэг байх хэрэгтэй.

Энд дурдсан гэмт хэргийн шинжээчийн үүргийг гүйцэтгэх алба хаагч нь уг мэргэжлийн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулах нийтлэг зорилттой гэж энэ зааварт төсөөлсөн болно. Сайжруулсан мэдээллийн сан, сайн хүчин чадалтай компьютер, түүний программ хангамжийн тусламжтайгаар гэмт хэргийн шинжээчийн мэргэшил цаашид хөгжин дэвших төлөвтэй байна. 21 дүгээр зууны цагдаагийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд амин чухал үүрэгтэй өндөр үр чадвартай мэргэжилтнүүд тус салбарт нэгдэж эхлээд байна. Та үүнд мэргэжлийн хурал, зөвлөгөөн,

сонин, сэтгүүлд өөрийн ажил мэргэжлийн онцлог, үр дүнг танилцуулах замаар хувь нэмрээ оруулах боломжтой. Ингэснээр та цагдаагийн үйл ажиллагаа болон гэмт хэрэг шинжээчийн мэргэшлийн хөгжилд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ байгууллагадаа илүү мэдээлэлтэй, үнэ цэнтэй ажилтан болж чадна.

Энэхүү зааврыг амралтын өдрүүдэд уншиж дуусгах боломжтой. Хэдий тийм ч зааврыг тогтмол хэрэглэж, шаардлагатай үед лавлах болгон ашиглах нь зүйтэй болов уу. Иймдээ ч аль нэг шатлалыг нээлттэй орхиход таны гар дор буюу компьютер дээр ажиллах үед хаагдахгүйгээр хялбар ашиглагдах боломжтой байдлаар энэ зааврыг боловсруулж загварлав.

"SARA" загварын дагуу эдгээр алхмуудыг логикийн хувьд ойлгомжтой дарааллаар боловсруулсан хэдий ч алхам тус бүр нь бие даасан сэдэв юм. Иймд аль нэг сэдвээр ажиллаж байх үед зааврын бусад хэсгийг унших шаардлагагүй билээ. Зааврыг бүрэн эзэмшихийн тулд та сэдвийн агуулга, гарчгийг сайтар судалж, бүлгүүдтэй их бага хэмжээгээр танилцсан байх нь зүйтэй. Гэхдээ тухайлсан нэг асуудлаар мэдээлэл, зөвлөмж хэрэгтэй бол зөвхөн тухайн холбогдох алхмыг судлахад хангалттай. Ямар ч тохиолдолд шаардлага үүссэн тохиолдолд мэдээлэл цуглувуж, хэрэглэх нь суралцах хамгийн оновчтой арга юм.

Зарим тохиолдолд нэг сэдэв зааврын хэд хэдэн хэсэгт дурдагдсан болно. Жишээлбэл, 12 дугаар алхамд шилжилт хөдөлгөөний

талаар ерөнхий тайлбар оруулсан бол 48 ба 49 дүгээр алхамд үнэлгээ, дүгнэлт хийх үед шилжилт хөдөлгөөний тусгай хэлбэрүүдийг авч үзсэн. Зааврын төгсгөлд байх нэр томьёоны хэсгээс тодорхой нэг сэдвийг аль хэсэгт дурдсан болохыг харах боломжтой.

Бид АНУ-аас гадна өөр бусад улс орны жишээг ашигласан болно. Бид тухайн сэдэвт хамгийн сайн тохирох жишээг оруулахыг хичээлээ. Тухайн жишээг гадаад улс орны туршлагаас татаж хэрэглэсэн байсан ч тэдгээр нь нийтлэг зарчимтай байх тул бүх нөхцөлд хэрэглэх боломжтой. Олон талт эдгээр жишээ нь алба хаагчдын бүтээлч сэтгэхүйг дэмжиж, "Энэ аргачлалыг энэ асуудалд хэрэглэх боломжтой эсэх? Хэрхэн хэрэглэх вэ?" зэрэг асуултууд тавигдана гэж бид үзэж байна.

Энэ зааврыг хэд хэдэн шалтгааны улмаас эрдэм шинжилгээний ажил хэлбэрээр бичээгүй болно. Шатлал бүрт холбогдох баримт судалгааны хамгийн гол чухал зүйлсийг танилцуулахыг зорьсон. Мөн гэмт хэргийн шинжээчдэд энэ зааврыг бүрдүүлж буй эрдэм шинжилгээний ажлуудыг судлах боломж цаг хугацаа болон олдцын хувьд хязгаарлагдмал байх болов уу. Хэдий тийм ч аливаа сэдвийн талаар нэмж судлах шаардлага үүсэж болзошгүй гэдгийг харгалzan цахим хайлтаар болон бусад арга хэлбэрээр олоход хялбар гэж үзсэн зарим ажлуудыг тухай бүр тоочиж ишиллээ. Танд нэмж лавлагаа авах шаардлагатай бол бидэнтэй цахим шуудангаар холбоо барина уу. Бид гарын авлагыг сайжруулахад зориулагдсан санал, зөвлөмж, сэтгэгдэл, тайлбарыг хүлээн авахад баяртай байх болно.

### Дотоод хэргийн яам ба Их Британийн цагдаагийн байгууллага

Талархал хэсэгт тайлбарласны дагуу Лондоны их сургуулийн гэмт хэрэг шинжлэхүйн ухааны Жилл Дандо институттэд зориулан бэлтгэсэн өмнөх хувилбаруудын үндсэн дээр энэхүү зааврыг боловсруулав. Уг бүтээлд Англи нэр томьёо, бичиглэлээс зайлсхийж, АНУ-д хэрэглэгдэх нэр томьёог хэрэглэсэн. Гэхдээ Их Британи улстай холбоотой хэд хэдэн эшлэл, лавлах материалын тусгайлыг авч үлдсэн. Тухайлбал та АНУ-ын Хууль зүйн яамтай ижил үйл ажиллагаа явуулдаг Их Британи улсын Дотоод хэргийн яам нь Англи, Вэйлс дэх цагдаа, гэмт хэрэг, хууль зүйн холбогдолтой асуудлуудыг хариуцдаг. Англи ба Вэйлст ердөө 43 цагдаагийн байгууллага (50 орчим сая хүн амтай улсад) ажилладаг бөгөөд эдгээр байгууллагууд АНУ-ын цагдаагийн хэлтсүүдээс харьцангуй том, өргөн хүрээтэй. Түүнчлэн Их Британи улсын цагдаагийн албаны цагдаа, цол зэрэг, багаж төхөөрөмж, дайчилгаа зэрэг зүйлс илүү жигд байдаг. Энэ нь Дотоод хэргийн яам (тус яам нь цагдаагийн албуудын төсвийн 51 хувийг санхүүжүүлдэг) болон Хатан хааны хяналтын албанаас тавьдаг хяналттай холбоотой. Дотоод хэргийн яам нь гэмт хэрэг, гэмт хэргийн эрх зүйн судалгаанд зориулан их хэмжээний хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд цагдаагийн үйл ажиллагаанд хамааралтай судалгаа хийж, нийтлэлдэг тусгайлсан судалгааны газар нэгжтэй билээ. Уул газар, нэгж нь энэ зааврын эх хувь зэрэг асуудалд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагаатай холбоотой ажлуудад ихээхэн дэмжлэг туслалцаа үзүүлж байгаа болно.

# Өөрийгөө бэлтгэх хэсэг

## 1. Ажил үүргийнхээ талаар эргэцүүлэн бодох нь

**И**хэнх гэмт хэргийн шинжээчдийн адил та өөрийн ажлын үүргээ дутуу үнэлдэг байж болзошгүй. Тухайлбал та аливаа гэмт хэргийг дан ганцаараа мөрдөн шалгаж, хэрэгтнийг илрүүлдэггүй, эсвэл харьяалагдах нэгжийнхээ үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэггүй, харин гэмт хэрэгтнийг баривчилдаг алба хаагчдад зориулан өгөгдөл, мэдээлэл боловсруулж, дүн шинжилгээ хийдэг, бусад албан хаагчдын хүсэлтийн дагуу тоон мэдээлэл бэлтгэж боловсруулдаг, долоо хоног тутмын шуурхай хурлын тайланг бэлтгэдэг байж болно. Өөрөөр хэлбэл та цагдаагийн үйл ажиллагаанд туслах үүрэгтэйгээр оролцдог байж болно.

Энэ заавар нь таныг ажлын үүргийнхээ талаар эргэцүүлэн бодоход дэмжлэг үзүүлэх болно. Туслах үүрэгтэй оролцож буй алба хаагч нь цагдаагийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж, бусдыг чиглүүлж өгдөг. Аливаа өгөгдөл, мэдээллийг үнэлж, дүгнэлт гаргах чадвар аль ч багийн үйл ажиллагаанд онц шаардлагатай тул та багийн нэн чухал гишүүн юм. Энэ нь тухайн ажилтны нэр хүнд, эрх мэдэл гэхээс илүүтэй цагдаагийн үйл ажиллагаанд тулгараад буй нийтлэг бэрхшээл болох тогтмол бөгөөд өндөр давтамжтайгаар гардаг гэмт хэргийн төрлийг нэг мөсөн таслан зогсоох арга замыг тодорхойлохтой холбоотой юм. Та энэ зааврыг ашигласнаар үүнийг хэрхэн гүйцэтгэх, мөн өөрийн чиг үүргийн ач холбогдлын талаар илүү сайн ойлголттой болно.

Дээрх үүргийг биелүүлэхэд та илүү мэдлэг, мэдээлэлтэй байх шаардлагатай. Компьютерын ахисан шатны мэдлэг, газрын зураг дээр ажиллах чадвар хэдий чухал ч та гэмт хэрэг болон түүний шинж чанарын талаар суралцах нь зүйтэй. Хэрвээ хулгайн хэргийн давтамж нэмэгдэж байгаа бол энэ талаар та хамгийн эхэнд мэдэж, бусдад танилцуулахаас эхэнлэ. Та статистик өгөгдөл,

тоон мэдээ бүрдүүлж, дүгнэлт гаргаж бусад албан хаагчдад тухайн үеийн нөхцөл байдлын талаар түргэн шуурхай мэдээлж байх шаардлагатай. Ингэхгүй байх тохиолдолд та туслах үүрэгтэй хэвээр байх болно. Иймд та хамгийн үр дүнтэй бөгөөд хурдан аргуудыг ашиглан нөхцөл байдлыг шуурхай тодорхойлох ёстай. Үүнд хохирогч, гэмт хэрэгтэн, аж ахуйн нэгжийн дотоод бүртгэл зэрэг цагдаагийн мэдээллийн сангаас бусад эх сурвалж ашиглан цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийх шаардлага тулгарч болзошгүй. Иймд энэ зааварт мэдээллийн бүхий л эх үүсвэрийг ашиглаж суралцах талаар тайлбарласан болно. Та бусад алба хаагчдын мэдээллийн эх үүсвэр байж, зөвлөгөө өгдөг мэргэжилтэн байх нь чухал. Энэ нь хэдий удирдлагын үзэмж, арга барилаас шалтгаалах ч та бусад албан хаагчдад дэмжлэг үзүүлж шаардлагатай мэдлэг, мэдээллээр хангадаг байх нь зүйтэй.

Та цагдаагийн үйл ажиллагаанд ямар арга барил үр дүнтэй байдгийг мэддэг байх шаардлагатай. Санамсаргүй эргүүл хэр үр дүнтэй вэ? Эргүүлийн цагдаа нар гэмт хэрэг үйлдэгдэж байх үед гэмт хэргийг илрүүлж чаддаг уу? Мөрдөн шалгах замаар хэрэгтнийг илрүүлж, амжилттайгаар баривчлах магадлал хэд вэ? Тандан ажиллагааны үр дүнд баривчлах үндэслэл бүрддэг эсэх? Баривчлах хувь/харьцаа гэмт хэрэг тус бүрээр хэд вэ? Цагдаагийн байгууллагад хэдэн төрлийн хэдэн гэмт хэрэг бүртгэгдсэн байгаа вэ? Эдгээрт хариулснаар та асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны хэрэглээ сүүлийн хугацаанд ихээр нэмэгдэх болсон шалтгааны талаар олж мэдэх болно.

Энэ зааварт асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны талаар болон түүнийг хэрэгжүүлэхэд таны гүйцэтгэх үүрэг, мөн нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн цагдаагийн бусад үйл ажиллагаанаас хэрхэн ялгарч буй талаар

танилцуулна. Мөн орчны криминологи, гэмт хэрэг гарах нөхцөл, шалтгаан болон өдөөгч хүчин зүйлсийг арилгах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга барилыг асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаатай хослуулан хэрэглэснээр уул арга барилын үр дүнг нэмэгдүүлэх боломжтой гэдгийг харуулна. Энэ заавар асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны дөрвөн үе шат болох (i) гэмт хэргийн нөхцөл байдлыг судлах, бүртгэх, тандах (scanning); (ii) нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх (analyzing), (iii) аливаа асуудалд хариу арга хэмжээ авах (responding), (iv) ажлын үр дүнг үнэлэх (assessing) талаар, мөн үе шат тус бүрт харгалзах мэдээ, мэдээллийн талаар жишээ авч танилцуулна. Энэхүү гарын авлагад эдгээр үе шат бүрд тохиорх мэдээлэл, жишээг оруулна. Эцэст нь асуудлыг шийдвэрлэх багийн гишүүний хувьд үр дүнтэй ажиллахын тулд дээрх дөрвөн үе шатанд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, дүн шинжилгээг танилцуулах юм.

Асуудалд чиглэсэн арга барил, холбогдох үе шатын хүрээнд та аливаа нэг ажилд илүү их цаг хугацаа зарцуулах шаардлагатай болно. Уламжлалт гэмт хэргийн шинжээч нь орон байрны хулгайн хэргийн өндөр төвлөрөл бүхий цэг, байршлыг тодорхойлж зураглах, эвсэл сарын тайлан бэлтгэхэд хэдхэн цаг зарцуулдаг бол асуудалд чиглэсэн төсөлд хэдэн долоо хоног, сарын хугацаа шаардагдана. Үр дүнгийн дэлгэрэнгүй үнэлгээ хийж, тайлан бэлдэх тохиолдолд таны оролцоо нэг жилээс дээш хугацаагаар ч үргэлжилж болно. Танд туслалцаа үзүүлдэг алба хаагчдад та үүнийг тайлбарлах шаардлага тулгарч болно. Нэг төсөлд ийм урт хугацаа зарцуулж байгааг сонсоод тэд эхэндээ гайхаж магадгүй юм. Гэвч удалгүй тэд таны ажил, хичээл зүтгэлийг тань ойлгож эхэлнэ.

Хэрвээ өөрийн ажлын үр дүнг бусдад илтгэж танилцуулж чадахгүй бол таны зарцуулсан цаг хугацаа дэмий зүйл болж хувирна. Зааврын дараагийн хэсгүүдэд энэ үр чадварын талаар буюу энгийн зураг, хүснэгт ашиглан түүх өгүүлж, ажлын үр дүнгээ бусдад илүү үр дүнтэй танилцуулах тухай оруулсан. Таны танилцуулга цагдаагийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох зорилготой байх нь зохимжтой. Хэдий тийм ч танилцуулгадаа

дүн шинжилгээнд ашигласан өгөгдөл болон түүний хязгаарлалт, хэрэв зөвлөмжийн үндэслэл нь баримтаас илүүтэй таамаглалд суурилсан бол энэ талаар мөн тусгасан байх шаардлагатай.

Энэхүү заавар нь асуудалд чиглэсэн гэмт хэргийн шинжээч болоход шаардлагатай мэдлэг, хийвэл зохих зүйлсийн талаар бүрэн тайлбарлаж чадахгүй. Та мэргэжлийн болон бусад арга зүйн чадвараа байнга сайжруулж холбогдох чиглэлээр гарсан сүүлийн үеийн ололт амжилтыг судалж санаачилгатай байх хэрэгтэй. Бусад мэдээллийн эх үүсвэрүүдийг судлах, өргөн хүрээтэй судалгаа явуулах, уншихыг зөвлөж байна. Үүний тулд бусад тасаг, хэлтсийн шинжээчтэй хамтарч ажиллах, мэдээлэл солилцох, мэргэжлийн хурал, зөвлөгөөнд оролцох, эзэмшсэн мэдлэг, туршлагаа бусадтай хуваалцах хэрэгтэй.

Товчхон хэлэхэд таны ажил туслах, туслалцаа үзүүлэх чиг үүргээр хязгаарлагдахгүй бөгөөд өөрийн үүргээ илүү өргөн хүрээнд авч үзэж, цагдаагийн үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгох чиглэлээр шинжээчээс гадна судлаач мэт ажиллах, энэхүү шинээр бий болж байгаа мэргэжлийн нэг хэсэг гэдгээ мөн хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

#### **Өөрийн ажил мэргэжлээ эргэцүүлээрэй:**

- Гэмт хэрэг зүйгээр мэргэших
- Үр дүнтэй арга барилыг тодорхойлох, олж мэдэх
- Асуудал шийдвэрлэх арга барилыг түгээх, дэмжих
- Төслийн багт оролцож ажиллах
- Орчны криминологийн талаар суралцах
- Судалгааны чадвараа хөгжүүлэх
- Бусадтай үр дүнтэй харилцах
- Мэргэжлийн чадвараа сайжруулах, дээшлүүлэх

#### **Нэмэлт материал:**

Braga, Anthony. 2002. *Problem-Oriented Policing and Crime Prevention*. Monsey (New York): Criminal Justice Press.

## 2. Бүс нутгийнхаа гэмт хэргийн “мэргэжилтэн” байх нь

**A**жил гүйцэтгэх явцдаа доорх асуултуудтай хэр их тулгардаг вэ? Үүнд:

- Одоогийн байдлаар автомашины хулгайн гэмт хэргийн өндөр төвлөрөл бүхий цэг, байршууд албай вэ?
- Аль дэлгүүр дээрэм тонуулд их өртөж байна бэ? Яагаад өртөж байна вэ?
- Дэлгүүрээс юу хулгайлж байна вэ? Тэд хулгайн бараа бүтээгдэхүүнийг хэрхэн худалдаалж байна вэ?
- Гэрэлтүүлэг сайтай гудамжинд гэмт хэргийн гаралт харьцангуй бага байдаг уу?
- Аль орон сууцны хотхонд хууль бус мансууруулах бодисын худалдаа хийгддэг вэ?

Эдгээрийн заримд нь та хариулж огт чадаагүй, эвсэл зөвхөн судалсны дараа хариулт өгөх боломжтой байсан байх. Гэхдээ танд хариултууд нь бэлэн байсан гэж төсөөльье. Та бүс нутгийнхаа гэмт хэргийн нөхцөл байдлын талаар хамгийн их мэдээлэлтэй нь буюу “мэргэжилтэн” нь гэж төсөөльье. Үнэндээ энэ үүргийг гүйцэтгэх боломжтой өөр алба хаагч байхгүй юм. Учир нь:

- Цагдаагийн алба хаагчид иргэдээс өгсөн дуудлагуудыг шийдвэрлэж байгаа тул боломжгүй.
- Мөрдөн байцаагчид гэмт хэрэг шийдвэрлэж байгаа тул боломжгүй.
- Ахлагч нар алба хаагчдад хяналт тавьж байгаа тул боломжгүй.
- Дэслэгч нар газар зүйн том бүс нутаг дахь эргүүлийн үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа тул боломжгүй.
- Дарга болон даргын туслах, ахмад нар захиргааны ажлын улмаас боломжгүй.

Товчоор хэлбэл гэмт хэргийн нөхцөл байдлыг бүрэн гүйцэд ойлгох боломжтой алба хаагч байхгүй. Харин та бүс нутгийнхаа гэмт хэргийн “мэргэжилтэн” болсноор хэлтэс, тасгийнхаа мэдээллийн хангамжийг сайжруулах, үйл ажиллагааны үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, нөөц боломжкоо

илүү үр өгөөжтэйгөөр ашиглах нөхцөлийг бүрдүүлж өгөх юм. Тухайлбал иргэдэд анхааруулга хүргүүлэх, гэмт хэрэгтнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Товчоор хэлэхэд та зохих мэдээллийг цуглуулснаар олон хүмүүст тусалж чадна.

Бүс нутгийнхаа гэмт хэргийн нөхцөл байдлын талаар хамгийн их мэдээлэлтэй буюу мэргэжилтэн нь болохын тулд та диспетчер болон бусад алба хаагчтай тогтмол харилцаатай байж, мэдээлэл солилцох хэрэгтэй. Оройн ээлжийнхэн өглөөний ээлжийн алба хаагч нартай тааралдахгүй байх, хотын нэг дүүрэг хариуцсан алба хаагч өөр дүүрэг хариуцсан алба хаагчтай мөн тааралдахгүй байх магадлал өндөр гэдгийг санаарай. Тэд дурэм, журам, гэмт хэргийн хэв маягийн талаар бус онцгой содон зүйлсийн талаар хоорондоо ярилцах нь олонтоо. Гэвч гэмт хэргийн хэв маяг нь гэмт хэрэг шинжлэхүйн ухаанд нэн чухал билээ.

Боломжтой тохиолдолд алба хаагч нартай хамт эргүүлд гарах нь зүйтэй. Ингэснээр хэлтсийн албан хаагчидтайгаа танилцахаас гадна тэдний ажил, үүрэг, тулгардаг асуудал, бэрхшээлийн талаар ойлголттой болох юм. Жаксонвилл хотын Цагдаагийн газрын (Флорида) гэмт хэргийн шинжээч Матт Вайт газар зүйн мэдээллийн систем (GIS) суулгасан зөөврийн компьютерыг биедээ авч явахыг зөвлөдөг. Ингэснээр та тухайн бүс нутгийн мэдээллийг алба хаагчийн төсөөлөлтэй харьцуулж үзэх боломжтой байна.

Онц ноцтой гэмт хэргээс ялгаатайгаар ердийн, байнга гардаг гэмт хэрэгт төдийлөн анхаарал тавьж, хүчин чармайлт гаргадаггүй. Иймд хэргийн газартай биечлэн танилцсанаар тухайн хэргийн тайландаа тусгагдаагүй байж болзошгүй баримт, мэдээллийн талаар олж мэдэх боломжтой байдаг. Хэрэв тайлангийн загвар тусгагдаагүй боловч чухал баримт, мэдээлэл орхигдсон бол тайлангийн загварыг өөрчилж, ийм төрлийн мэдээлэл оруулдаг болох нь зүйтэй. Ингэснээр тус шинэ

баримт, мэдээлэлд үндэслэн хэрэгтнийг илрүүлэх, цаашид тухайн төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар судлах боломжтой болно.

Гэмт хэргийн сүүлийн үеийн нөхцөл байдал, шинээр үүсэж буй чиг хандлагыг тогтмол судалж байх нь зүйтэй. Та долоо хоног тутам гэмт хэргийн тайлан мэдээтэй танилцаж, аливаа өөрчлөлт гарсан эсэхийг үнэлж, дүгнэлт гаргадаг байх хэрэгтэй. Зарим тохиолдолд гэмт хэрэг үйлдэхээр завдаж буй этгээд шинэ арга барил ашиглахдаа туршилт хийж үздэг тул гэмт хэргийн амжилтгүй оролдлого, завдсан үйлдлүүдэд мөн анхаарал хандуулаарай. Жишээлбэл, бэлэн мөнгөний ATM болон билетийн машиныг зүй бусаар ашиглах шинэ арга зам олоход хэцүү ч олох тохиолдолд энэ тухай мэдээлэл хурдан тархдаг. Иймд хэрвээ та аливаа шинэ арга барилын талаар мэдэж авсан бол бусад албан хаагч нарт мэдээлж байх нь зүйтэй.

Нэг бүс нутаг, дүүрэгт гарсан гэмт хэрэг өөр бүс нутаг, дүүрэгт гарах нь олонтоо. Өмнө илэрдэггүй байсан гэмт хэргийн төрөл танай хэлтсийн хариуцах бүс нутагт их хэмжээгээр, эсвэл өндөр давтамжтайгаар гарч эхэлж болзошгүй. Гэхдээ тус гэмт хэрэг нь өөр бусад хэлтсийн хариуцдаг бүс нутаг, дүүрэгт гарч байсан нь дамжиггүй. Иймээс та гэмт хэргийн бай, гэмт хэрэг үйлдэх арга барилд (*modus operandi*) орсон өөрчлөлт бүрийг анзаарч байх нь чухал юм. Та цахим орчноос гэмт хэргийн нөхцөл байдлын талаар их хэмжээний мэдээлэл авах боломжтой. Түүнчлэн тантай ижил төрлийн гэмт хэргийн асуудал шийдвэрлэхээр, эсвэл нэг ижил хэрэгтнийг илрүүлэхээр ажиллаж байж болзошгүй тул бусад цагдаагийн хэлтсүүдийн шинжээчидтэй мөн холбоотой ажиллаж байх нь чухал.

Гэмт хэргийн талаар мэдэж байж болзошгүй цагдаагийн алба хаагч бүс этгээдтэй харилцаа тогтоож ажиллах нь мөн өгөөжтэй:

- Хяналтын байцаагч нар сүүлийн бусдаас түрүүлж гэмт хэргийн талаар мэдээлэл авсан байдаг.
- Баарны өзэд насанд хүрээгүй иргэдийн архидан согтуурал, үйлчилгээний стандарттай холбоотой зөрчил зэргийн талаар мэдээлэлтэй байдаг.

- Сургуулийн захирлууд сургуулийн орчинд үйлдэгдсэн дээрэм, эд хөрөнгөд халдсан, сүйтгэх зөрчлийн талаар мэддэг.
- Жижиг аж ахуйн нэгжийн эзэд өөрийн байгууллагын ойр орчинд гарсан аливаа хэргийн талаар мэдээлэлтэй байдаг. Тухайлбал эмийн санч ойр орчныхоо хулгайн хэрэг, мөн мансууруулах болон согтуурооулах үйлчилгээтэй бүтээгдэхүүний зүй зохисгүй хэрэглээ зэргийн талаар мэддэг.
- Яаралтай тусlamжийн төвийн эмч, сувилагч нар гэмт хэргийн хохирогч, гэмтэж бэртсэн хүмүүсийн талаар бүртгэж авдаг боловч цагдаагийн албанд мэдэгдэггүй байж болзошгүй.
- Эмэгтэйчүүдийн түр хоноглох газар, хүчирхийллийн төвүүд гэр бүлийн хүчирхийллийн талаар цагдаагийн албаас илүү мэдээлэлтэй байдаг.
- Тодорхой зарим нэг хэргийн талаар хувийн хамгаалалтын байгууллагууд хамгийн түрүүнд олж мэдсэн байдаг. Иймд тус байгууллагууд аливаа бүс нутагт гарч буй гэмт хэргийн хэв маягийн талаар танд ойлголт өгч чадах юм.

Гэмт хэрэгтнүүд өөрсдөө мэдээллийн гайхалтай эх үүсвэр байж чаддаг. Тэд хэдий гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрөхгүй ч тухайн гэмт хэргийг үйлдэх арга зүйн талаар буюу байгаа хэрхэн сонгодог, хулгайлсан эд зүйлсээ хэрхэн худалддаг, гэмт хэрэгт өртөх өндөр магадлалтай эд хөрөнгийн талаар ярих их сонирхолтой байдаг. Иймд гэмт хэрэгтнээс энэ тухай лавлаж асуухыг цагдаагийн алба хаагчдаас хүсэх нь зүйтэй.

Хохирогчид мөн адил танд багагүй мэдээлэл өгч чадна. Орон байрны хулгайн хэргийн хохирогчид хэрэгтэн тухайн орон байранд хэрхэн нэвтэрч юу хулгайлсан, аль өрөө, давхар эзгүй байсан талаар мэдээлэл өгөх боломжтой.

### **Хэрхэн бүс нутгийнхаа гэмт хэргийн мэргэжилтэн нь болох вэ?**

- Компьютероос холдох
- Цагдаагийн алба хаагчтай нөхцөл байдлын талаар ярилцах

- Цагдаагийн алба хаагчтай хамт эргүүлд гарах, диспетчертэй хамтарч ажиллах
- Хэргийн газарт очих, хэргийн тайлантай танилцах
- Аливаа асуудлын талаар нарийн судлахын тулд гэмт хэргийн амжилтгүй оролдлогуудын талаар судлах
- Тодорхой нэг гэмт хэргийн асуудлаар хотын захиргааны ажилтантай ярилцах
- Хувийн хэвшлийнхэнтэй мэдээлэл солилцох
- Гэмт хэргийн хохирогч, бай, арга хэрэгслийн өөрчлөлтийн талаар бусад хэлтсийн шинжээчидтэй санал солилцох
- Гэмт хэрэгтнээс хэргийн арга зүйн талаар нь асуухыг алба хаагчдаас хүсэх
- Хэрэг хэзээ, хаана, хэрхэн үйлдэгдсэн талаар хохирогчдоос мэдээлэл авах
- Гэмт хэргийн тайлангийн загвар болон тоон өгөгдөл цуглуулах арга замыг сайжруулах чиглэлээр ажиллах

### Гэмт хэргийн амжилтгүй оролдлогоос суралцах нь

Хотын барилга, байгууламжийн хурдацтай хөгжил нь орон байрны хулгайн нөхцөл байдлыг дордуулах аюултай гэдгийг Чула Вистагийн (Калифорни) Цагдаагийн Хэлтэс таамаглаж байжээ. Ихэнх тохиолдолд орон байрны хулгайд өдрийн цагаар баян чинээлэг өрхийн шинэ орон сууцууд өртдөг байж. Иймээс баригдаж буй болон шинээр баригдсан байр, орон сууцад хамгийн үр дүнтэй хамгаалалтын систем суулгах зорилгоор шаардлагатай дун шинжилгээг хийхээр шийдэв. Тус хэлтсийн гэмт хэргийн шинжээч Кати Бурциага нь тухайн хотын 569 байранд гарсан

орон байрны амжилттай болон амжилтгүй хулгайн хэргийн 18 сар бүхий тоон мэдээлэлд харьцуулсан судалгаа хийв. Тус судалгаанаас үзэхэд аливаа орон байрны хажуугийн болон урд хаалганд нэмэлт цоож, түгжээ суулгах нь зүйтэй гэж дүгнэжээ. Түүнчлэн орон байрны хулгайн 250 хохирогч, 50 гэмт хэрэгтэнтэй хийсэн яриллагаас харахад хулгайчид давхар бүрхүүлтэй цонхийг хагалж, нэвтрэхийг завддаггүй аж. Үүний дагуу шинэ орон байрны бүх цонхийг давхар бүрхүүлтэй байлгах, хүчээр нэвтрэхээс хамгаалах стандартыг хангасан байхыг зөвлөсөн байна.

	Орон байрны хулгайн хэрэг - амжилттай тохиолдол	Орон байрны хулгайн хэрэг - амжилтгүй тохиолдол буюу оролдлого	Үр дүнтэй эсэх?
Өглөөнөөс орой хүртэл гэрэлтэй байх	28%	29%	Үгүй
Дотор гэрэлтүүлэгтэй байх	26%	29%	Үгүй
Хуваарьт дотор гэрэлтэй байх	9%	11%	Үгүй
Урд хаалганд нэмэлт цоож, түгжээ суурилуулах	28%	25%	Үгүй
Урд болон хажуугийн хаалганд нэмэлт цоож, түгжээ суурилуулах	15%	29%	Тийм
Гадна талд хөдөлгөөн мэдрэгч суурилуулах	23%	36%	Тийм
Радио/телевиз асаалттай байх	9%	18%	Тийм
Дохиоллын компанийн тэмдэг, сануулга байрлуулах	19%	36%	Тийм

\*Тухайн хамгаалалтын систем нь хулгайн амжилттай тохиолдлуудаас илүүтэй амжилтгүй оролдлоготой илүү холбоотой байвал "Тийм" гэж тэмдэглэв

### 3. Цагдаагийн үйл ажиллагааны хамгийн үр дүнтэй (үр дүнгүй) арга барилын тухай мэддэг байх

**Ц**агдаагийн үйл ажиллагааны арга барилын хүрээнд хийсэн судалгааны цагдаагийн үйл ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэхэд гэмт хэргийн шинжээчийн үүрэг маш чухал байна. Энэ судалгааны талаар ойлголттой болох нь цагдаагийн алба хаагчдын сүүлийн гучин жилийн хугацаанд сурсан сургамжийг өөрийн ажилдаа хэрэгжүүлэхэд туслах болно.

Гэмт хэргийн давтамж, гаралтыг бууруулах зорилгын хүрээнд цагдаагийн байгууллагууд аль үйл ажиллагаа нь үр дүнтэй, мөн аль нь үр дүнгүй тогтоох чиглэлээр багагүй судалгаа хийжээ. Үндэсний шинжлэх ухааны академиас Цагдаагийн үйл ажиллагаа, тэр дундаа түүний үр дүнтэй байдлаар судалгаа гаргах зорилгоор нийгмийн шинжлэх ухааны мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулсан билээ. Энэ ажлын хэсгээс гаргасан тайланг үндэслэн дараагийн хуудас дахь схемийг боловсруулав. Гэмт хэргийн гаралтыг бууруулахад хамгийн бага үр дүнтэй аргуудыг схемийн зүүн доод хэсэгт, харин хамгийн үр дүнтэйг баруун дээд хэсэгт оруулав.

Зургийн зүүн доод буюу үр дүн бага хэсэгт цагдаагийн үйл ажиллагааны "стандарт загвар" орсон байна. Энэ нь Хойд Америкийн цагдаагийн үйл ажиллагаанд өргөн хэрэглэгддэг арга барил билээ. "Стандарт загвар" нь хууль сахиулах үйл ажиллагаанд суурилсан бөгөөд тодорхой зорилгогүй байдаг. Сэжигтнийг saatuuлах зорилгоор эргүүл хийх, дуудлагад түргэн шуурхай хариу өгч шийдвэрлэх, гэмт хэрэг мөрдөн шалгах зэрэг ажиллагааг энэ загварын дагуу хэрэгжүүлэхэд хүн, газар байршил, цаг хугацаа, тухайн нөхцөл байдлын онцлог шинж чанарыг төдийлөн харгалзаж үздэггүй. Олон нийтээс гэмт хэргийг бууруулах шаардлага тавихад хариуд нь, энэ загварт итгэдэг төрийн алба хаагчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд цагдаагийн алба хаагчдын тоог нэмэх, дуудлагад хариу өгөх хугацааг

бууруулах, ил тод байдал, мөрдөн байцаалтын үр дүн, баривчилгааг нэмэгдүүлэхийг хүсдэг. Харин хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн алба хаагч нарын төдийлөн асуугаад байдаггүй хэн, юу, хэзээ, хаана, яагаад, яаж, хэрхэн, мөн гэмт хэргийн төрөл хоорондын ялгаа, гэмт хэрэгтэй тэмцэхэд бусад төрийн ба хувийн байгууллагуудын оролцоо, цагдаагийн үйл ажиллагааг хууль сахиулахаас бусад арга замаар хийх боломжийн талаарх асуултууд мөн эн тэнцүү ач холбогдолтой юм.

Цагдаагийн үйл ажиллагааны үр дүнтэй байдалтай холбоотой хамгийн эхэн үеийн судалгааны ажлууд "стандарт загвар"-ын талаар судалсан байдаг. Тус судалгаануудад стандарт загварын дагуу хэрэгжих цагдаагийн үйл ажиллагаа нь гэмт хэрэг, эмх замбараагүй байдал, гэмт хэргийн айдсыг бууруулахад нөлөө үзүүлдэг гэдгийг баталж чадаагүй. Сананаандгүй эргүүл, шуурхай хариу арга хэмжээ, мөрдөн шалгах, saatuuлах ажиллагаа нь бусад зорилгоор үр дүнтэй байж болох ч гэмт хэргийг бууруулахад үр дүнгүй юм. Түүнчлэн эдгээр ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор цагдаагийн алба хаагчдын тоог нэмэгдүүлснээр гэмт хэрэг буурна гэснийг нотлох баримт байхгүй билээ.

Судалгаанаас үзэхэд гэмт хэрэгт аливаа байдлаар нөлөөлөхийн тулд цагдаагийн үйл ажиллагаанд хоёр элемент агуулагдаж байх шаардлагатай байна. Эдгээрийг схемийн тэнхлэгээр илэрхийлэв. Нэгдүгээрт стратеги нь гэмт хэрэг, зөрчлийг шийдэх аргачлалаа төрөлжүүлэх юм. Өөрөөр хэлбэл цагдаагийн үйл ажиллагаанд хууль сахиулахаас гадна олон төрлийн хэрэгсэл ашиглавал зүйтэй. Үүнийг босоо тэнхлэгт буулгав. Олон нийт, иргэдтэй тулж буюу хамтран ажиллах нь гэмт хэрэг, эмх замбараагүй байдлыг бууруулахад бага хэмжээгээр нөлөөлдөг бөгөөд тус хамаарал нь цагдаа-иргэн хоорондын хувийн харилцаа нэмэгдэх хэрээр ихэсдэг аж.

Цагдаагийн үйл ажиллагааны үр дүнтэй байдалд нөлөөлдөг хоёр дахь элемент

нь тодорхой зорилго, чиглэл (focus) юм. Энэ элементийг схемийн хэвтээ тэнхлэгт буулгав. Цагдаагийн үйл ажиллагааг гэмт хэргийн өндөр төвлөрөл бүхий цэг, байршилд төвлөрүүлэн хэрэгжүүлэх нь үр дүнтэй байдаг (богино хугацаандаа). Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн төвлөрөл буюу тохиолдол өндөр (булан тойруу гэх мэт) цэгт төвлөрсөн эргүүл хийх нь гэмт хэрэгт дунд хэмжээгээр, эмх замbaraагүй байдалд их хэмжээгээр нөлөөлдөг. Үүнийг эрчимжүүлсэн баривчлах ажиллагааны туслалцаатайгаар эсвэл туслалцаагүйгээр хэрэгжүүлэх боломжтой. Компстат болон 1990-2000 онд гарсан бусад инноваци нь эдгээр дүгнэлтийг ашиглан хэрэглэхэд чиглэсэн байдаг. Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны албаас үр дүнтэй болон үр дүнгүй стратеги, тактикийг ялган танилцуулсан "асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны зөвлөмж"-ийг хэвлэн гаргасан ("Нэмэлт материал" хэсгээс үзнэ үү).

Хэрвээ цөөн тооны, тодорхой хэсэг бүлэг хүмүүс олон тооны гэмт хэрэг, эмх замbaraагүй байдал бий болох шалтгаан нь бол тэдгээрийг saatuulsnaар гэмт хэргийн гаралт буурах учиртай. Хэдийгээр энэхүү үзэл санаа нь зарчмын хувьд зөв ч энэ чиглэлээр судалгааны ажил хязгаарлагдмал тул үр нөлөөтэй эсэхэд нь үнэлгээ, дүгнэлт өгөх боломжгүй юм.

Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа нь дээрх хоёр элементийн шинж чанарыг хослуулсан буюу олон төрлийн аргачлалыг тодорхой зорилго, чиглэлтэйгээр хэрэглэхийг зорьсон арга барил юм. Энэ нь хэр үр дүнтэй бэ? Судалгааны олон төрлийн аргачлал ашигласан нотлох баримт бичгүүдээс үзэхэд уг хослол бүхий арга барил нь гэмт хэрэг, эмх замbaraагүй байдлыг бууруулахад нөлөө үзүүлж чаддаг. Эхлээд, төвлөрсөн хууль сахиулах арга хэмжээ хэрэгжүүлснээр гэмт хэргийн нөхцөл байдалд урт хугацааны өөрчлөлт гараагүй тул асуудал шийдвэрлэхэд чиглэсэн аргачлалуудыг хэрэглээнд оруулсан билээ. Виржиниагийн Ньюпорт Ньюсийн Цагдаагийн байгууллага Нью Бриарфилд хотод тухайн үед өндөр давтамжтайгаар гарч байсан орон байрны хулгайн асуудлыг шийдвэрлэж чадалгүй арван жилийг өнгөрөөгөөд байсан нэг

жишээг татья. Тэд явган эргүүл, түр хэлтэс зэрэг янз бурийн арга хэмжээ авч ажиллан тодорхой үр дунд хүрдэг байсан боловч шилжүүлэг хийгдэх даруйд орон байрны хулгайн тоо хэмжээ эргээд өсдөг асуудалтай тулгараад байжээ. Энэ асуудлыг иргэд, нийтийн орон сууцын газар, онцгой байдлын газар, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, АНУ-ын Барилга, хот байгуулалтын яам зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, асуудалд чиглэсэн аргачлал ашигласны үр дунд шийдвэрлэж байсан. Түүнчлэн, Нью Жэrsi мужийн Жэrsi хотод мансууруулах үйлчилгээтэй бүтээгдэхүүний улмаас үсээд байсан гэмт хэргийн өндөр төвлөрөл бүхий цэгт Давид Висбард болон Лоррэйн Грийн нарын хийсэн асуудалд чиглэсэн болон уламжлалт цагдаагийн үйл ажиллагааг харьцуулсан санамсаргүй туршилтын (randomized experiment) үр дүнгээс үзэхэд асуудалд чиглэсэн арга барил нь илүү үр дүнтэй болохыг тогтоосон байдаг. Иймд тодорхой зорилго, чиглэлтэй цагдаагийн үйл ажиллагаа нь тодорхой зорилгогүй үйл ажиллагаанаас илүү үр дүнтэй байдаг хэдий ч тодорхой зорилготой бөгөөд асуудалд чиглэсэн үйл ажиллагаа хамгийн үр дүнтэй нь юм.


Өнгөрсөн гучин жилийн хугацаанд хийгдсэн судалгааны сургамж одоо тодорхой болоод байна. Үр дүнтэй цагдаагийн үйл ажиллагаа нь олон төрлийн буюу олон талт аргачлал ашиглахын зэрэгцээ төвлөрсөн (тодорхой) зорилготой байх шаардлагатай. Хамгийн муу үр дүнтэй цагдаагийн үйл ажиллагаа аль ч элементийг агуулаагүй байдаг. Үүний учир шалтгаан ч мөн тодорхой байна. Хэрвээ ямар нэгэн зорилгогүйгээр олон төрлийн буюу олон талт аргачлалыг авч хэрэгжүүлбэл зорилтолт газар, хүмүүст үр дүн нь хүрэхгүй. Хэрвээ цагдаагийн үйл ажиллагааг гэмт хэргийн өндөр төвлөрөл бүхий цэг, байршилд төвлөрүүлэхдээ зөвхөн хууль сахиулах арга хэмжээ авбал гарах үр дүнг бууруулж, хязгаарлах болно. Үр дүнтэй ажилладаг цагдаагийн алба нь аливаа гэмт хэргийн талаарх мэдээллийг бүрэн ашиглаж, гэмт хэрэгүйлдэх нөхцөл, шалтгааныг, улмаар гэмт хэргийг бууруулах чадвартай байдаг. Гэмт хэргийн шинжээч нь дээрх хоёр элементийг хэрэглээнд оруулах чухал үүрэг буюу дүн шинжилгээний аргуудыг ашиглан зорилго,

чиглэлийг тодорхойлж, тухайн асуудалд тохирсон цагдаагийн үйл ажиллагааны стратеги, тактикийг боловсруулах үүрэгтэй билээ. Иймээс 21 дүгээр зууны цагдаагийн үйл ажиллагаанд гэмт хэргийг шинжлэх, дүн шинжилгээ хийх ажиллагаа маш чухал юм.

#### Нэмэлт материал:

Scott, Michael S. 2003. *The Benefits and Consequences of Police Crackdowns*. Problem-Oriented Policing Guides: Response Guides Series No. 1. Washington, DC: Office of Community Oriented Policing Services. <http://ric-zai-inc.com/ric.php?Page=detail&id=COPS-P049>.

Weisburd, David, and John Eck. 2004. "What Can Police Do to Reduce Crime, Disorder and Fear?" *Annals of the American Academy of Political and Social Science* 593 (May): 42–65.



# Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаанд суралцах

## 4. Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааар мэргэших нь

**Н**оцтой гэмт хэрэг гарах үед цагдаагийн албанаас авах хариу арга хэмжээ шуурхай, хурдан байх хэрэгтэй. Тэд хохирогчид тусалж, хохирогчийг тайвшурулахын зэрэгцээ хэрэгтнийг баривчлахын тулд түргэн шуурхай арга хэмжээ авах шаардлагатай байдаг. Гэвч хэрэгтнийг баривчилж саатуулж чадахгүй байх, баривчилж саатуулсан ч хянан шийдвэрлэх явцад гэм бурууг нь тогтоолгож чадахгүй байх тохиолдол олонтоо. Түүнчлэн санамсаргүй эргүүл хийхийг хэдий олон нийтээс хүсдэг ч тус арга зам нь хэрэгтнийг барихад үр дүнтэй байж чаддаггүй. Өөрөөр хэлбэл олон нийтийн санал гомдлын дагуу авч хэрэгжүүлдэг цагдаагийн ихэнх үйл ажиллагаа нь гэмт хэрэг хянахад үр нөлөө багатай байдаг байна.

Иргэд дээрх бодит байдлын талаар олж мэдсэн ч цагдаагийн байгууллагаас ноцтой гэмт хэрэгт авах хариу арга хэмжээгээ сулруулах, эргүүл хийхээ болихыг хүсэхгүй, харин уламжлалт цагдаагийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ гэмт хэрэг хянах шинэ, үр дүнтэй арга зам боловсруулахыг шаардах болов уу. Иймдээ ч цагдаагийн албаны удирдлагууд Компстат (CompStat), үл тэвчих бодлого (zero tolerance), олон нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хамгаалах цагдаагийн үйл ажиллагаа, асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа зэрэг бодлогуудыг шинээр боловсруулж, туршиж, хэрэгжүүлсээр ирсэн. Гэмт хэрэг шинжээчид уг шинэ бодлогуудыг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэгдээс гадна асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд цагдаагийн албаны тулхүүр ажилтан болохоор байгаа тул та энэ талаар суралцах нь зүйтэй.

Херман Голдстэйн 1979 онд хэвлүүлсэн нэгэн бүтээлдээ асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны зарчим, үзэл баримтлалыг анх томьёолсон бөгөөд түүний гол санаа нь цагдаагийн үйл ажиллагаа гэж гэмт хэрэг гарах үед хариу арга хэмжээ авах, эсвэл эргүүл хийж гэмт хэргийг хойшлуулах биш, харин байнга гардаг гэмт хэргүүдийг өдөөж буй нөхцөл, шалтгаанд анхааран тэдгээрийг өөрчлөх явдал юм гэжээ. Цагдаагийн алба хаагчид байнга гарч байдаг гэмт хэрэг, үйлдэгддэг газар, тэдгээрийг үйлддэг хэсэг бүлэг хүмүүстэй байнга харьцахаас цааргалдаг. Цагдаагийн байгууллагад орж ирдэг их хэмжээний дуудлагуудыг шийдэхийн тулд цагдаагийн алба хаагчид ачаалал ихтэй ажилладаг бөгөөд үүний улмаас тэдгээрийн үр бүтээлтэй байдал ихээр буурдаг. Үүнээс зайлсхийхийн тулд Голдштейн аливаа гэмт хэрэгт асуудалд чиглэсэн байдлаар хандаж, шийдвэрлэх буюу асуудалд тулгуурласан арга барил хэрэглэх нь зүйтэй гэжээ. Энэхүү арга нь дөрвөн үе шаттай. Үүнд:

1. Өдөр тутамдаа шийддэг хэрэг, зөрчлийн хэв маягийг тодорхойлох зорилгоор өгөгдлийг ТАНДАХ (Scan)
2. Дээр тодорхойлсон хэв маяг (буюу асуудал)-ийн учир шалтгааныг тодорхойлох зорилгоор ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ (Analyze)
3. Аливаа гэмт хэрэг үүсэхэд нөлөөлж буй учир шалтгааны хэлхээний (causal chain) эхэнд үед интервенц хийх буюу арга хэмжээ авч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх (Response). Шинээр хийгдэх эдгээр хариу арга хэмжээ нь хэрэгтнийг тодорхойлох, саатуулах, гэм бурууг нь тогтоох буюу яллах ажиллагаагаар хязгаарлагдахгүй. Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа нь

урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй хариу арга хэмжээ авахыг эрмэлзэх бөгөөд үүнд хууль сахиулах ажиллагаа мөн багтана.

4. Хариу арга хэмжээний үр дүнтэй байдлыг үнэлж (Assess), үр дүнгүй байх тохиолдолд энэ үе шатуудыг дахин хийх.

"SARA" гэдэг нь дээрх дөрвөн үе шатыг илэрхийлсэн үгийн товчлол юм - Тандалт хийх (Scanning), дүн шинжилгээ хийх (Analysis), хариу арга хэмжээ авах (Response), үнэлэх (Assessment). Энэ зааврын дараагийн хэсэгт эдгээрийн талаар дэлгэрэнгүй авч үзэх боловч гэмт хэргийн шинжээч та ягаад асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаанд түлхүүр үүрэг гүйцэтгэж байгаа нь илэрхий байна. Учир нь та цагдаагийн үйл ажиллагааны явцад цугларсан тоон мэдээлэлтэй танилцсан бөгөөд тэдгээрт дүн шинжилгээ хийх, тэдгээрийг зураглах, хэв маягийг нь тодорхойлох хамгийн оновчтой арга замын талаар мэддэг алба хаагч юм. Шинэ арга барил, бодлогод дүгнэлт хийх зорилгоор цагдаагийн албад буй тоон мэдээллийг хамгийн оночтой ашиглаж чадах нь та ч байж болох юм. Хэрвээ та өөрийн хариуцсан бус нутгийнхаа "гэмт хэргийн мэргэжилтэн" (энэ зааврын Хоёрдугаар шат) нь болж чадвал шаардлагатай мэдээллийг хаанаас, хэрхэн олж авахыг та хамгийн сайн мэдэх болно; үр дүнтэй хариу арга хэмжээний талаарх судалгааны ажлыг хаанаас олж авахыг мэдэх болно; орчны криминологийн (environmental criminology) ойлголтод үндэслэн асуудалд дүн шинжилгээ хийх чадвартай болно; шилжилт хөдөлгөөн (displacement)-ийг урьдчилан таамаглаж, хэмжих чадвартай болно. Та дээрх дөрвөн үе шатанд өдөр бүр оролцож, хувь нэмрээ оруулахгүй байх тохиолдолд асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа бүхий төсөл нь гэмт хэрэг гаралтыг бууруулах зорилгодоо хүрч чадахгүй байх эрсдэлтэй.

Асуудлыг шийдвэрлэх ажиллагаа, ялангуяа дүн шинжилгээ хийх болон үнэлэх үе шатууд нь хүндрэл ихтэй тул үүнд таны хувь нэмэр чухал юм. Голдштейн асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа нь цагдаагийн байгууллагын дүн шинжилгээ хийх чадвараас ихээхэн хамаарлтай гэж дүгнэжээ, энэ талаар сүүлийн судалгаандаа ч мөн дурдсан

юм. Тэрбээр асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаан дахь гэмт хэрэг шинжээчийн үүргийн талаар өгүүлж буй энэ зааврыг боловсруулахыг ихээхэн дэмжсэн билээ.

Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны үзэл баримтлал болон энэ хүрээнд таны гүйцэтгэх үүрэг өндөр ач холбогдолтой гэдэгтэй та санал нийлж болох ч тус үүргийг амжилттай биелүүлж чадах эсэх талаар эргэлзэж байж болзошгүй. Тухайлбал, дүн шинжилгээ хийх ажлыг ажлын хуваарьтаа хэрхэн оруулж, үүнд зориулж цаг зав гаргах вэ? Статистик тайлан, мэдээ, зураглал зэргийг яаралтай боловсруулах шаардлага тогтмол гардаг ажилтайгаа зэрэгцүүлэн урт хугацаа шаардагдах төсөлд та ямар хэмжээнд оролцох нь зүйтэй вэ? Жирийн иргэн таныг багийн жинхэнэ гишүүн гэж хүлээн зөвшөөрөх үү? Танай удирдлага таны танилцуулсан дүн шинжилгээ, санал бүрийг хянаж батлахыг шаарддаг бол та хэрхэн багийн жинхэнэ гишүүн мэт ажиллах вэ? Дүн шинжилгээ дуусахаас өмнө шийдвэр гаргахгүй байхыг цагдаагийн алба хаагчдаас хэрхэн хүсэх вэ? Хэрэгтнийг тодорхойлж баривчлахаас өөр арга зам авч үздэг байх зуршлыг алба хаагчдад хэрхэн хэвшигүүлэх вэ? Таныг практикаас илүүтэй судалгаанд анхаарал хандуулдаг гэсэн шүүмжлэлд та хэрхэн хандах вэ? Товчондоо та бэрхшээл, хүндрэлтэй гагцхүү тулгарах болно.

Эдгээрт хариулж гаргалаа олоход хэцүү билээ. Гэхдээ цагдаагийн үйл ажиллагааны үзэл баримтлал өөрчлөгдж байгаа бөгөөд энэ өөрчлөлтийг та хурдасгахад хувь нэмрээ оруулах боломжтой. Цагдаагийн үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх шаардлага өдөр ирэх бүр нэмэгдэж байгаа энэ үед хязгаарлагдмал нөөц, төсвийн улмаас гэмт хэрэгт хяналт тавьж чадахгүй байна гэж хэлтсийн дарга нар шалтаглах нь хангалтгүй болоод байна. Өнөө үед цагдаагийн хэлтсүүд, ялангуяа томоохон хэлтэс, тасгуудын хувьд эдгээр нөөц, төсвийн зарцуулалт, хэрэглээ зэргээр баримттай суурилсан дэлгэрэнгүй үндэслэл гаргах шаардлагатай. Өдөр ирэх бүр цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны үр дүн, төлөвлөгөөний биелэлтэд тавигдах хяналт ихэссээр байна.

Товчхондоо, цагдаагийн байгууллагуудад нөөц, төсвөө батлуулж, оновчтой зарцуулахад тоон мэдээлэл чухал болох нь гарцаагүй. Иймд та багаа тоон мэдээллээр ханган ажиллаж, ажлын үр дүнгээ нэмэгдүүлэх боломжтой хэдий ч холбогдох мэдээллийг зохих хэлбэрийн дагуу түргэн шуурхай боловсруулж чаддаг болох хүртэл цаг хугацаа, тэсвэр тэвчээр хэрэгтэй. Хэрэв та энэ чиглэлээр, мөн гэмт хэрэг гаралтыг бууруулахад төвлөрөн ажиллавал цагдаагийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг болох бөгөөд асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны арга барил нь үүнд шаардлагатай хэрэгсэл мөн юм. Цагдаагийн үйл ажиллагаа ерөнхийдөө тухайн үеийн онцлог сэдэв буюу "моод"-нд өртөмтгийг гэдгийг бид бүхэн мэднэ. Туршлагатай цагдаагийн алба хаагчид аливаа "моод"-нд удирдлагаас хандуулж буй сонирхол буурахыг хүлээж, буурсны

дараагаар цагдаагийн ажлаа хийж эхэлдэг. Гэхдээ асуудалд тулгуурласан цагдаагийн дээрх үйл ажиллагаа нь түр зуурын "моод" биш гэдгийг анхаарах хэрэгтэй.

#### **Нэмэлт материал:**

Goldstein, Herman. 1979. "Improving Policing: A Problem-Oriented Approach." *Crime & Delinquency* 25(2): 234–58.

Goldstein, Herman. 1990. *Problem-Oriented Policing*. New York: mcgraw-Hill.

Goldstein, Herman. 2003. "On Further Developing Problem-Oriented Policing: The Most Critical Need, The Major Impediments, and a Proposal." In *Problem-Oriented Policing: From Innovation to Mainstream*, edited by Johannes Knutsson. Vol. 15 of *Crime Prevention Studies*. Monsey (New York): Criminal Justice Press.

## 5. Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааг тууштай хэрэгжүүлэх нь

**А**суудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааг "Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа" (Community policing), "Хагархай цонхны онол" (Broken windows policing), "Мэдээлэлд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа" (Intelligence-led), Компстат зэрэг бусад арга барилтай хослуулан хэрэглэх тохиолдлууд байдаг. Ийнхүү хослуулан хэрэглэх нь асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаатай нийтэй, эсвэл нийцгүй байж болох ч ижил зүйл биш юм. Иймд асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа бусад арга барилаас хэрхэн ялгарч байгааг ойлгох нь чухал юм.

Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа нь гэмт хэрэгт дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх аргачлал юм. Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа нь харин цагдаагийн албаны зохион байгуулалтын зарчимтай холбоотой ойлголт билээ. Тус арга барилд асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаан дахь асуудал шийдвэрлэх аргачлалаас гадна хөндлөнгийн буюу олон нийтийн тусlamж, оролцоонд түшиглэсэн аргачлалуудыг хэрэглэдэг. Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд цагдаагийн албаны зохион байгуулалтыг асуудлыг хамтын ажиллагаагаар шийдэх, олон нийттэй түншлэлийн харилцаанд орох, гэмт хэргийн болон нийгмийн асуудалд идэвх санаачилгатай хандах боломж бүхий бүтцээр өөрчлөн байгуулах талаар дурддаг (төвлөрсөн буй шийдвэр гаргалт, хүний нөөц чадавхжуулах сургалт гэх мэт). Өөрөөр хэлбэл олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа нь асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны шинж чанарыг агуулсан, цагдаагийн алба, олон нийт хоорондын харилцаанд түшиглэсэн, цагдаагийн албаны зохион байгуулалттай илүү холбоотой арга барил юм. Энэ арга барилыг амжилттайгаар хэрэгжүүлж чадсан тохиолдолд асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааг нэвтрүүлэх (зарчмын) үндэслэл, нэхцэл бүрддэг. Харин асуудалд тулгуурласан цагдаагийн үйл

ажиллагааны шинж чанарыг агуулаагүй олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа нь гэмт хэрэг гаралтыг төдийлөн бууруулж чадахгүй болов уу.

Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаанд аливаа асуудлыг шийдвэрлэхийн тулд оролцуулбал зохих бусад этгээдийг тодорхойлох хэрэгтэй. Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаанд мөн адил оролцуулах шаардлагатай бусад этгээдийг тодорхойлох нь зүйтэй. Жишээлбэл, автобусны зогсоолын орчинд гардаг халдлага, дайралтын хэрэгт хяналт тавих бол эрх бүхий нийтийн тээврийн газартай, дэлгүүрийн хулгайн хэрэгт хяналт тавих бол тухайн бус нутгийн бизнес эрхлэгчидтэй тус тус хамтран ажиллах шаардлагатай. Аливаа асуудлыг тодорхойлох, түүний шийдлийг хэрэгжүүлэхэд олон нийт, иргэд хамтарч ажиллах, туслалцаа, дэмжлэг үзүүлэх нь элбэг (хаалганд цоож суулгах, орон гэргүй хүнд мөнгөн тусламж үзүүлэхгүй байх зэрэг) бөгөөд мөн шийдэл боловсруулахад хэрэгтэй мэдээ мэдээллийг олон нийт, иргэдээс олж авах боломжтой. Түүнчлэн асуудал шийдвэрлэсэн байдлыг олон нийтийн үзэмж, хариу үйлдэлд үндэслэн дүгнэж болно. Харин асуудалд дүн шинжилгээ хийх, шийдэл боловсруулах, үнэлгээ хийхэд шаардагдах мэргэжлийн ажлуудад тусламж үзүүлэх боломж хязгаарлагдмал болов уу. Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа нь тодорхой асуудлын хүрээнд болон хамтын ажиллагааг сайжруулах, итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор олон нийт, төрийн байгууллагуудтай түншлэлийн харилцаанд орохыг эрмэлздэг. Иймд олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны дагуу олон нийттэй тогтоох түншлэл нь илүү өргөн цар хүрээтэй байна. Энэ арга барилыг үйл ажиллагаандаа баримтлах цагдаагийн алба нь ерөнхий зорилгоор байгуулсан түншлэлийн улмаас илүү төвлөрсөн, асуудал шийдвэрлэхэд чиглэсэн түншлэлийг орхигдуулахгүй байхад анхаарал тавих хэрэгтэй.

Хомсдол ихтэй дүүрэгт хэрэгжүүлж буй асуудалд чиглэсэн төслийн хувьд түншлэл хоорондын дээрх ялгааг хольж төөрөгүүлэхэд хялбар байдаг. Энэ тохиолдолд төсөл нь юуны түрүүнд аливаа том асуудлыг бүрдүүлж байгаа жижиг асуудлуудыг тодорхойлох нь зүйтэй (14 дүгээр алхмыг харна уу). Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа нь олон нийттэй түншлэл байгуулахаас илүүтэй тодорхой нэг асуудлыг (жишээлбэл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын үйлдвэрлэл, дэлгүүрийн хулгай, нийтийн үйлчилгээний газар танхайрах) шийдэхийг зорьдог. Энэ хүрээнд олон нийттэй түншлэлийн харилцаанд орохдоо асуудал тус бүрээр өөр өөр нэг эсвэл бүлэг этгээдүүдтэй хамтран ажиллах боломжтой. Иймд энэ ажиллагааг хялбаршуулах зорилгоор цагдаагийн албанолон нийтийн харилцааг ерөнхийд нь бэхжүүлж, итгэлцлийг нэмэгдүүлэх чиглэлээр илүү түншлэл байгуулж болно. Хэдий тийм ч дээрх асуудлуудыг тодорхой системтэйгээр буюу тодорхой зорилтыг үндэслэн боловсруулсан төлөвлөгөөний дагуу шийдэх нь зүйтэй.

Цагдаагийн алба хаагч нь асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа болон "Хагархай цонхны онол" (Broken windows policing) хоорондын ялгааг мэдэж байх хэрэгтэй. Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны дагуу гэмт хэрэг үүсэх нөхцөл, шалтгаан, өдөөгч зэрэгт дун шинжилгээ хийсний үндсэн дээр цагдаагийн албад тулгарч буй асуудал тус бүрт өвөрмөц шийдэл боловсруулна. Нэгөөтээгүүр "Хагархай цонхны онол" нь аливаа гэмт хэрэгт хяналт тавихад бэрхшээлтэй болохоос сэргийлсэн, нэг ижил шийдэл буюу олон нийтийн хэв журамд хяналт тавьж, дэг журмыг сахиулахад суурилсан. Энэхүү онол нь хоёр шалтгаанаас улбаатай. Нэгдүгээрт, жижиг гэмт хэрэг нь олон нийтийн амьдрал ахуйд бага хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэг ч даамжрах аюултай. Жишээ нь ганц нэг хүн гудамж талбайд хог хаях нь олон нийтэд ноцтой аюул учруулахгүй. Гэхдээ олон хүн хог хаяд эхэлбэл гудамж талбай хогийн цэг болж хувирна. Хоёрдугаарт жижиг гэмт хэрэг, зөрчил нь бусад том хэрэг үүсэхэд нөлөөлж, өдөөдөг. Жишээ нь эзэнгүй, хаалга үүдийг нь битүүлж хадсан байшин нь хууль

бус хар тамхины наймаа гарах, хүн амины хэрэг, хүчирхийлэл үйлдэх зэрэг илүү ноцтой гэмт хэрэг гарах нөхцөл болдог. Үүнтэй холбоотойгоор зарим хотуудад цагдаа нар жижиг хэрэг, зөрчлүүдэд илүү анхаарал хандуулж эхэлсэн.

Цагдаагийн бүхий л үйл ажиллагаанд цагдаагийн алба хаагчийн үзэмж, гаргах шийдвэр чухал байдаг. (Иймээс "Хагархай цонхны онол"-ыг "Үл тэвчих бодлого"-той хольж болохгүй. "Үл тэвчих бодлого" нь улс төрийн уриа лоозон бөгөөд хэрэгжүүлэх боломжгүй юм). Цагдаагийн алба нь ямар жижиг гэмт хэрэг, зөрчлүүд бусад хэргүүдийг өдөөдөг болохыг тодорхойлох хэрэгтэй. Жишээлбэл, Нью-Йорк хотын метроны зохицуулагчийн олж мэдсэнээр үнэгүй зорчихын тулд эргэдэг хаалга дээгүүр үсэрч байгаа этгээд хулгай, дээрэм хийж болзошгүй байдаг байна. Иймд энэ төрлийн жижиг хэрэгт хяналт тавьснаар илүү хүнд хэрэг үүсэхээс урьдчилан сэргийлж чадсан байна. Гэхдээ ханан дээр граффити зурдаг этгээдүүд илүү хүнд төрлийн гэмт хэрэг үйлддэггүй байна. Иймд цагдаагийн алба граффити зурах хэрэгт хяналт тавьж чадсан ч (41 дүгээр алхмыг үзнэ үү) хулгайн хэргийг төдийлөн бууруулж чадаагүй байна.

Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны дагуу хэдий илүү хүнд хэрэг гарахад нөлөөлөхгүй гэж дүгнэгдсэн ч жижиг хэрэг, зөрчлийг шийдвэрлэхийг эрмэлздэг. Цэцэрлэгт хүрээлэн дэх нийтийн өмч хөрөнгийг эвдлэн сүйтгэх буюу вандализм нь хулгайн хэрэгт нөлөөлөхгүй ч шийдвэрлэх шаардлагатай асуудалмөн. Хэдийөөр төрлийн хэрэг өдөөхгүй ч иргэд хурд хэтрүүлэх, замын түгжрэл үүсгэх, дуу чимээ гаргах зэргийг шийдвэрлүүлэх хүсэлтэй байдаг. Иймд 14 дүгээр алхамд тусгасан асуудлын тодорхойлолтод нийцэж байгаа асуудлыг бусад гэмт хэрэг өдөөх магадлалтай эсэхээс нь үл хамааран асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаагаар шийдвэрлэх боломжтой.

Цагдаагийн үйл ажиллагааг чиглүүлэхэд чухал мэдээлэлд өндөр ач холбогдол өгдөг "Мэдээлэлд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа"-нд гэмт хэргийн шинжээч түлхүүр үүрэг гүйцэтгэдэг. Гэвч энэ

арга барил нь зөвхөн мэдээ мэдээлэл боловсруулах аргачлал юм. "SARA" загварын адил гэмт хэрэг гаралтыг бууруулах арга зам, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх талаар дурдаггүйгээс гадна энэ арга барилын хүрээнд гэмт хэрэг шинжээчид тухайн арга зам, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэггүй. Иймд асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа нь шинжээчдэд илүү үр өгөөжтэй бөгөөд энэ хэрээр илүү үүрэг даалгавар оногдуулдаг юм.

Эцэст нь Компстат, асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа нь хоорондоо төстэй боловч ижил биш юм. Компстат гэмт хэргийн өндөр төвлөрөл бүхий газар зүйн байршилаар хязгаарлагддаг бол асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа нь гэмт хэргийн бусад төрлийн төвлөрийг авч

үздэг. Хэдий тус хоёр арга барил нь мэдээлэлд тулгуурладаг ч мэдээллийн төрөл, хэмжээ зэрэг нь илүү өргөн хүрээтэй байдгаараа асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа онцлог. Түүнчлэн Компстат дан хууль сахиулах арга, тактикт суурисан бөгөөд энэ арга барилын дагуу боловсруулж, хэрэгжүүлэх шийдлийн гэмт хэрэг гаралтад үзүүлэх нөлөө түр зуурынх бол асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааных урт хугацааных байдаг. Иймд Компстат арга барилыг анхны тусламж, асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааг илүү урт хугацааны шийдэл гэж авч үзвэл тус хоёр арга барилыг хослуулан хэрэгжүүлэх нь зүйтэй.

#### Нэмэлт материал:

Kelling, George L., and James Q. Wilson. 1982. "Broken Windows." *The Atlantic* (March): 29–38.

Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа ба бусад арга барилын хоорондох ялгаа					
	Анхаарах асуудал	Зорилт	Үндэслэл	Аргачлал	Эхний үе шатууд
<b>POP арга</b>	Тухайлсан, тогтмол гардаг гэмт хэрэг, зөрчил	Эдгээр хэрэг, зөрчлийн нөхцөл, шалтгааныг арилгах	Үрьдчилан сэргийлэх нь хууль сахиулахаас илүү үр дүнтэй арга болно.	Тодорхой зорилго, чиглэл бүхий арга хэмжээ авч хэрэгжүүлэх (SARA)	Анхаарах шаардлагатай асуудлуудыг тодорхойлох
<b>Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа</b>	Олон нийт-цагдаагийн харилцаа, зохион байгуулалтын өөрчлөлт, асуудал шийдвэрлэлт	Гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс сэргийлэх, олон нийтийг итгэлцлийг нэмэгдүүлэх, цагдаагийн үйл ажиллагааг дэмжих	Дэмжлэг туслалцаа чухал үүрэгтэй. Зохион байгуулалтын өөрчлөлт нь өөрчлөлтийг хадгалахад чухал үүрэгтэй. Асуудал шийдвэрлэх аргачлал гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлийг шийдвэрлэх гол аргачлал юм.	Оршин сууچидтай хамтран ажиллах, олон нийттэй уулзалт хийх замаар олон нийтийн итгэлцлийг сайжруулах, нөлөөллийг дэмжих зорилгоор зохион байгуулалтын өөрчлөлтийг хэрэгжүүлэх, асуудал шийдвэрлэхэд оролцох,	Гудамж талбайд ажиллах олон нийтийн ажилтныг томилох, анхаарал хандуулах шаардлагатай асуудлыг тодорхойлох, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх шаардлагатай зохион байгуулалтын өөрчлөлтийг тодорхойлох.
<b>Хагарсан цонхны онол</b>	Дордож буй нөхцөл байдал	Гэмт хэрэг хүндэрхээс сэргийлэх	Хэрэг зөрчлийг яаралтай таслан зогсоох	Нийтийн хэв журрам, дэг журмыг сахиулах	Дордож байгаа нөхцөл байдлыг тодорхойлох
<b>Мэдээлэлд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа</b>	Мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа	Хууль сахиулах стратеги, тактик, арга хэмжээг мэдээлэлд үндэслэх	Мэдээлэлд суурилсан байх тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байна.	Мэдээллийг цуглуулах, үнэлэн дүгнэх, дүн шинжилгээ хийх, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг дэмжих,	Мэдээлэл цуглуулах, боловсруулах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хөгжүүлэх
<b>Компстат</b>	Хурц, богино хугацаатай гэмт хэргийн газар зүйн хэв маяг (crime patterns)	Гэмт хэргийн өндөр төвлөрөл бүхий байршилын тоог бууруулах.	Гэмт хэргийн өндөр төвлөрөл бүхий байршуудыг бууруулнаар гэмт хэргийн гаралт буурна.	Компьютероор хэргийн өндөр төвлөрөл бүхий байршиг тодорхойлж, эргүүл хийх, хууль сахиулах.	Гэмт хэргийн зураглал, зураг гаргах, газар зүйн байдлаар хяналт тавих.

Энэхүү баримт бичгийг хөрвүүлэх явцад гарсан зөрүүтэй ойлголтод зохиогчид хариуцлага хулээхгүй болно.

## 6. Тухайн гэмт хэрэгт тохирсон арга хэмжээ авч ажиллах нь

**T**анай хэлтсээс тээврийн хэрэгслийн, орон байрны хulgай зэрэг тухайлсан гэмт хэргийн ангилал, төрөлд эрчимжүүлсэн арга хэмжээ авахад (crack-down) уул хэргүүдийг зураглаж газрын зурагт буулгах, эсвэл өөр тоон мэдээлэл бэлтгэх замаар та дэмжлэг үзүүлдэг байж болно. Гэвч асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаанд ашиглахад дээрх нийтлэг хэрэглэгддэг гэмт хэргийн ангилал, төрөл (энд Эрүүгийн хуульд заасан хүнд болон хөнгөхөн гэмт хэргийн ангилал бус харин тухайн гэмт хэргийн шинж чанартай холбоотой ангиллын буюу төрлийн талаар дурдсан болно) нь хэт өргөн хүрээтэй, ерөнхий буюу олон тооны хэргүүдийг багцлан нэг ангилал, төрөлд хамруулсан байдаг. Жишээлбэл тээврийн хэрэгслийн гэмт хэрэгт дараах багтдаг.

Үүнд:

- Цуглуулах, зарж ашиг олох зорилгоор автомашины дугуйны тагийг хulgайлах
- Машин доторх эд зүйлсийг хulgайлах зорилгоор автомашиинд хүчээр нэвтрэх
- Радио зэрэг тоноглол хulgайлах зорилгоор автомашиинд хүчээр нэвтрэх
- Арван зургаан насанд хүрээгүй хүн тухайн автомашиныг ашиглах зорилгоор хulgailсан
- Түр хугацаанд бусдын автомашиныг зөвшөөрөлгүйгээр ашиглах
- Өөр гэмт хэрэгт ашиглах зорилгоор автомашин хulgayлах
- Автомашин хulgayлж, хадгалах
- Автомашины сэлбэгийг худалдах зорилгоор хulgayлах
- Худалдах зорилгоор автомашин хulgayлах
- Экспортлох зорилгоор автомашин хulgayлах
- Автомашин дээрэмдэх.

Дээр дурдсанаар автомашины гэмт хэргийг зохион байгуулалт, туршлага, ур чадварын хувьд харилцан адилгүй этгээдүүд өөр өөр сэдэл, зорилгоор үйлддэг. Автомашины дугуйн тагийг хulgayлахад хялбар тул энэ гэмт хэргийг бага насын хүүхдүүд үйлдэх нь олонтоо. Автомашиныг унаж ашиглахад дугуйн таг хulgayлахаас их хэмжээний

ур чадвар, эр зориг шаардагдана. Харин экспортлох зорилгоор автомашин хulgayлах нь олон үе шаттай, олон хүн оролцдог, нарийн зохион байгуулалт шаарддаг, үйлдэхэд төвөгтэй хэрэг юм. Гэм буруутай этгээд нь ёс зүйгүй, аж ахуй эрхлэгч эсвэл мэргэжлийн гэмт хэрэгтэн байж болно. Харин харгис хэрцгий, туршлагатай гэмт хэрэгтнүүд машин дээрэмдэх хэргийг үйлддэг.

Гэмт хэргийн хоорондох ялгаатай байдлаас шалтгаалаад авах хариу арга хэмжээ, шийдэл нь харилцан адилгүй. Иммобилизатор (энэ нь автомашины хөдөлгүүрийг түлхүүр эсвэл өөр тусгай хэрэгсэлгүйгээр асаахаас сэргийлдэг төхөөрөмж) суулгаснаар автомашины хulgayн хэрэг буурсан боловч автомашины дээрэмд өөрчлөлт гараагүй. Учир нь автомашины өмчлөгчөөс түлхүүрийг хүчээр булаан авч, дээрэмдэхээс иммобилизатор сэргийлж чадахгүй. Эсрэгээрээ зарим судлаачид иммобилизатор суулгасан автомашиныг хulgayлахад хэцүү учраас автомашин дээрэмдэх тохиолдол нэмэгдсэн байж болзошгүй гэж үзсэн. Түүнчлэн иммобилизатор нь энэ чиглэлээр мэргэшсэн этгээд, эсвэл экспортлох зорилгоор хulgay хийж буй этгээдийг хulgay хийхээс төдийлөн сэргийлж чадахгүй. Энэ тохиолдолд хил, гаалийн хяналтыг сайжруулах, хуулбарлах хэцүү бичиг баримт шаардах нь илүү үр дүнтэй болов уу.

Том, цогц гэмт хэргийг жижиг хэсгүүдэд хувааж, задлах нь асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эхний алхам юм. Жишээ нь Хойд Каролинагийн Шарлотт хотын төв хэсгийн автомашины хulgay асуудалд төвлөрч байсан цагдаагийн үйл ажиллагаа нь уул хэрэгт хийсэн дүн шинжилгээний үр дүнд илүү тодорхой зорилго, чиглэлтэй болж эхэлсэн. Автомашины хulgay ихэнхдээ автомашины гадуур зогсоолд гардаг нь эхлээд илрэв. Хulgayлагдсан автомашинуудын 17 хувь гудамж, талбай, орон сууцны хороололд зогссон автомашинууд байв. Нийт автомашины зогсоолыг тоолсны дараа гадуур зогсоосон автомашин хulgayд өртөх эрсдэл дотуур

зогсоосон автомашинтай харьцуулахад зургаа дахин өндөр гэдэг нь илэрсэн (27 дугаар алхмыг үзнэ үү). Иймд асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд гудамж талбайн гэрэлтүүлгийн сайжруулах, хашаа, хашлага татах, харуул хамгаалалтын ажилтан ажиллуулах зэргээр автомашины гадуур зогсоолын аюулгүй байдлыг сайжруулах боломжтой. Энэ арга хэмжээ нь дотуур зогсоолд гардаг цөөн тооны хулгайн хэргийг бууруулахаас хялбар юм. Ийм байдлаар асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны зорилгыг төвлөрүүлэх нь үр дүн, нөөц зарцуулалтын хувьд оновчтой юм.

Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны зорилгыг хэр хэмжээнд төвлөрүүлбэл зохицтой талаар хэд хэдэн дүрэм байдаг. Зорилгыг хэт төвлөрүүлбэл цөөн тооны хэргийг өндөр зардалтайгаар шийдэх шаардлага үүсэх бөгөөд ингэх зохицтой эсэх нь тухайн хэргийн шинж чанар, ангиллаас хамаарна. Хэрвээ автомашины дугуйн тагийг цөөн тоогоор хулгайлсан бол үүнийг бүрэн хэмжээний асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаагаар шийдэх шаардлагагүй. Нөгөөтээгүүр дэлгүүрийн дээрмийн хэрэг жилд цөөн удаа гардаг байсан ч хүн амины хэрэг болж хүндрэх, улмаар олон нийтийг айдаст автуулж болзошгүй тулэдгээрийг бууруулах зорилгоор асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй.

"Орон байрны хулгай, дээрэм, автомашины хулгай зэрэг гэмт хэргүүдийг хэт ерөнхий байдлаар багцлан ангилдгийн улмаас эдгээр хэргүүдийг өдөөгч нөхцөл, шалтгааны талаарх мэдээллийг олж, тодорхойлоход хүндрэлтэй байдаг. Иймд бид гэмт хэргийг шийдвэрлэхийн тулд тэвчээртэй байж, шат дараатай алхмууд авах шаардлагатай гэсэн үг юм."

Эх сурвалж: Pyoner, Barry. 1986. "A Model for Action." *Situational Crime Prevention*, edited by Gloria Laycock and Kevin Heal. London: Her Majesty's Stationery Office.

### Орон байрны хулгайн гэмт хэрэгт тохирсон арга хэмжээ авч ажиллах нь

Цахилгаан бараа хулгайлах зорилготой орон байрны хулгайн хэргээс сэргийлэх, үнэт эдлэл, бэлэн мөнгө хулгайлах зорилготой орон байрны хулгайн хэргээс сэргийлэхэд тус тус шаардлагатай арга хэмжээ нь хоорондоо ялгаатай байх нь зүйтэй гэж судлаач Барри Пойнер, Барри Вэбб нар үздэг. Учир нь тэдний хийсэн судалгааны үр дүнд энэ хоёр төрлийн хэрэг нь хоорондоо багагүй ялгаатай байдгийг олж илрүүлжээ. Гэмт хэрэг үйлдэгчийн бай үнэт эдлэл, бэлэн мөнгө байх тохиолдолд хэрэгтнүүд ихэвчлэн хотын төвийн ойр орчин дахь хуучин байшингуудыг онилж, хулгайг аливаа тээврийн хэрэгслийн тусlamжгүйгээр хийдэг байв. Харин зурагт, кассет тоглуулагч зэрэг цахилгаан хэрэгслийн хулгайн тохиолдлууд ихэвчлэн хотын захаар шинэвтэр байр, сууцанд үйлдэгддэг, гэмт хэрэг үйлдэгч нь автомашин ашигласан байдаг байв. Гэмт хэрэг үйлдэхээр завдаж буй этгээд хулгайлсан эд зүйлсээ тээвэрлэхэд ашиглах автомашинаа онилж байгаа байр, сууцны ойролцоо боловч сэжиг төрүүлэхүйц биш зай бүхий зогсоолд байршуулдаг аж. Хотын захад байрлах орон сууцууд нь ийнхүү хэрэг үйлдэхэд боломж бүхий зохион байгуулалттай байсан бөгөөд судлаач Пойнер ба Вэбб нарын зөвлөмж үндсэндээ гадуур зогсоолын хяналтыг сайжруулах замаар уул хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой. Харин хот доторх хулгайн хэргээс урьдчилан сэргийлэхэд сууцад нэвтрэх цэгийн хяналт, хамгаалалтыг бэхжүүлэх нь зүйтэй гэж зөвлөсөн байдаг.

Эх сурвалж: Pyoner, Barry and Barry Webb. 1991. *Crime Free Housing*. Oxford: Butterworth-Architecture

Сургуулийн буудлага зэрэг ховор боловч онц ноцтой гэмт хэргүүдийг тухайн бүс нутгийн түвшинд асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд шийдвэрлэх боломжгүй. Учир нь энэ арга барилын дагуу аливаа гэмт хэргийн нөхцөл, шалтгааныг судлан тодорхойлоход тухайн хэрэг тодорхой давтамжтайгаар гардаг байх шаардлагатай. Энэ төрлийн гэмт хэргийн хувьд цагдаагийн

байгууллагаас харуул хамгаалалтын арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх, аливаа нөхцөл байдалд тохирсон хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй байх нь зүйтэй билээ.

Хэдийгээр аливаа асуудалд тохирсон шийдлийг судалгаа, дүн шинжилгээний үр дүнд тодорхойлох нь зүйтэй ч зарим тохиолдолд үр дүнтэй байдал нь нотлогдсон бэлэн шийдэл ашиглаж, тус шийдэлд үндэслэн асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа бүхий төслийг боловсруулах нь оновчтой байдаг. Дэлгүүрийн дээрмийн хэргийн жишээг ашиглая. Дэлгүүрт хоёр ба түүнээс дээш ажилтан хамт ажиллах нь шөнийн цагаар үйлдэгдэг дээрмийн хэргийг бууруулдаг тухай судалгаанууд байдаг. Иймд таны хариуцаж буй бус нутагт шөнийн цагаар гардаг дэлгүүрийн дээрмийн хэргийн

давтамжийг олж мэдэж, их байх тохиолдолд үүнд төвлөрсөн асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа бүхий төсөл боловсруулж дээрх шийдлийг хэрэгжүүлэх талаар удирдлагадаа хүсэлт гаргах нь зүйтэй.

Эцэст нь та дүн шинжилгээний шатанд аливаа асуудлын талаар судлах үедээ тухайн асуудалтай ижил төстэй гэмт хэргийг хамтад нь нэг дор шийдвэрлэх боломжтой гэж үзэж магадгүй. Тухайлбал та таксины жолоочийн бие махбодод халдах гэмт хэрэг дээрмийн хэрэгтэй өндөр хамаарлтай тул асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа бүхий төслийн хүрээнд уул хоёр хэргийг нэг дор шийдвэрлэх боломжтой бөгөөд энэ нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй гэдгийг илрүүлж болно. Ийм байдлаар та хоёр хэргийг хамтад нь шийдвэрлэх багц арга хэмжээг тодорхойлж болно.

### Тусдаа хэрэг зөрчлүүдийг нэг шийдлээр шийдвэрлэх

Хуучин байр, ойр орчин, орон сууцны цогцолборт гарсан тодорхой нэг хэрэг зөрчлүүдэд тусгайлан дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Гэхдээ өртөг зардлыг хэмнэх зорилгоор арга зам, шийдлийг нэгтгэн үзэж болно. Доор дурдсан жишээнд хамгийн доор эрэмбэлэгдсэн харуул хамгаалалтын ажилтан, хяналтын камерын систем (CCTV) бүхий шийдэл нь тоочсон шийдлүүдээс хамгийн өндөр өртөгтэй нь юм. Гэхдээ тус шийдэл нь бусад хэрэг, зөрлийг шийдэхэд хамгийн үр дүнтэй хувилбар юм. Иймээс доорх асуудлуудыг тус бүрээр нь авч үзвэл өндөр өртөг, зардлынх нь улмаас энэ хувилбарыг сонгохооргүй, харин нэг дор авч үзвэл хамгийн оновчтой хувилбар нь байна.

Тодорхойлогдсон шийдэл, арга замууд (зардал багатайгаас зардал ихтэй рүү дараалуулан харуулав)	Цахилгаан шат руу орох үед эвдэх, сүйтгэх	Машинаас эд зүйл хулгайлах	Орон байрны хулгай
Харагдах байдлыг сайжруулах зорилгоор мод, бутыг тайрах (\$)		**	**
Харуул хамгаалалтын ажилтан гаргах (\$)	***	*	*
Цахилгаан шатны дохиолол (\$\$)	****		
Зогсоолын талбай руу цахимаар, цахим үнэмлэхээр нэвтрэх (\$\$)		****	****
Нэвтрэх, орох хэсэгт дотуур утас суурилуулах (\$\$\$)	**		
Харуул хамгаалалтын ажилтан эргүүл хийх (\$\$\$\$)	*	**	**
Орон байрны цонхыг цоожлох, хаалгыг бэхжүүлэх (\$\$\$\$\$)	****	****	****

§ өртөг, зардал; \*үр дүнтэй байдал.

## 7. "SARA" аргачлалыг баримтлах

**A**суудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд цагдаа нар (1) тухайлсан асуудлыг тодорхойлох ("асуудал"-ын тодорхойлолтыг 14 дүгээр алхмаас үзнэ үү), (2) тэдгээрийн нөхцөл, шалтгааныг ойлгохын тулд дүн шинжилгээ хийх, (3) эдгээрийг бүр мөсөн арилгах арга хэмжээ, шийдлийг боловсруулахын тулд судалгаа хийх, (4) тус арга хэмжээ, шийдлийн үр дүнтэй байдлыг үнэлэн дүгнэдэг билээ. Энэ нь нийгмийн ухаанд нийтлэг ашиглагддаг "үйл ажиллагааны судалгаа" (action research)-ны нэг хэлбэр юм. Тодруулбал уул аргачлалын дагуу судлаачид газар дээр ажилладаг мэргэжилтнүүдтэй хамтран аливаа асуудалд шийдэл боловсруулж, тухайн төслийн зорилгыг биелүүлэх хүrtэл тус шийдлийг боловсронгуй болгоход тусалцаа, дэмжлэг үзүүлэн ажилладаг. Судлаачид ерөнхийдөө мэдээлэл цуглуулах, судалгаа хийх, дүгнэлт гаргах зэрэг ажлуудыг бие даан хийдэг. Харин "үйл ажиллагааны судалгаа"-ны хүрээнд судлаач газар дээрх мэргэжилтнүүдтэй хамтарч ажилладаг бөгөөд аливаа асуудлыг шийдвэрлэх багийн салшгүй гишүүн байдаг. Энэ бол гэмт хэрэг шинжээчийн үүрэг юм. Таны дүн шинжилгээ аливаа үйл ажиллагааны үе шат бүрийг удирдан чиглүүлж байх ёстой.

"SARA" танд болон танай багийн үйл ажиллагааг чиглүүлж өгөхөд туслалцаа үзүүлэх болно. "SARA" нь Жон Экк, Билл Спелман нарын томъёолсон "Задлах", "Дүн шинжилгээ хийх", "Хариу арга хэмжээ авах", "Үнэлэх" гэсэн дөрвөн үе шаттай асуудал шийдвэрлэх аргачлал юм. Энэ аргачлал нь цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, түгээх, үнэлэх бүхий гэмт хэргийн стандарт шинжилгээний үйл явц болон бусад анализик үйл явцтай төстэй. "SARA" аливаа төслийг шатлан хуваах замаар шаардлагатай алхмуудыг зөв дарааллаар хийх журмыг тодорхойлж өгдөг юм (тухайлбал, асуудлын шийдлийг дүн шинжилгээ хийхээс өмнө гаргахгүй байх). Энэ нь асуудлын тодорхойлолт, дүн шинжилгээг ёс төдий хийх, асуудалд бодитой нөлөөлөх эсэхийг үнэлэхгүй байхаас сэргийлэх зэргээр дүн шинжилгээ хийхээс өмнө шийдлийг тодорхойлох хүний төрөлхийн хандлагад хяналт тавьж буй явдал юм.

Асуудлыг шийдвэрлэх төслүүд нь нарийн төвөгтэй байж болно. Үйл ажиллагааны судалгааны хүрээнд баг өмнөх туршлагаас сурсан зүйлдээ үндэслэн хариу арга хэмжээг зорилгодоо хүрэх хүртэл боловсронгуй болгож, сайжруулахыг шаарддаг. Үнэлгээ дууссанаар энэ үйл явц заавал дуусах албагүй. Хэрэв асуудал шийдэгдэхгүй байх, эсвэл хэлбэр нь өөрчлөгдсөн бол баг энэ үйл явцыг дахин шинээр өхлүүлэх шаардлагатай тулгарч магадгүй. Үүнийг доорх зурагт "Үнэлэх"-ээс "Задлах" үет шат руу шилжих сумаар харуулав.

Хэдий тийм ч уул дөрвөн үе шатуудыг дээр тодорхойлсон дарааллын дагуу хийж гүйцэтгэх шаардлагагүй. Ихэнх төслүүд задлах, дүн шинжилгээ хийх, үүний дараагаар хариу арга хэмжээ авах, хариу арга хэмжээг үнэлэх гэсэн дарааллаар дагуу хэрэгждэггүй, харин нэг шатаас өмнөх шат руу буцах байдлаар үргэлжлэх боломжтой. Тухайлбал дүн шинжилгээний үр дүнд зорилгоо дахин тодорхойлох шаардлага үүсэн буцаад нэгдүгээр шат буюу задлах шат руу шилжих, эсвэл хариу арга хэмжээтэй холбоотой үүссэн асуудлуудыг тодруулах зорилгоор дүн шинжилгээний шатыг дахин хийх нөхцөл үүсэх боломжтой. Ийнхүү өмнөх шат руу буцах шилжилт хөдөлгөөн нь тухайн төслийн нарийн төвөгтэй байдал, түүнд шаарддагдах хугацаа зэргээс хамаарна. Үүнийг доор дурсэлсэн зургийн доторх сумуудаар харуулав. Жишээлбэл, дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ аливаа асуудлыг тогтвортжуулах үүднээс задлах шатнаас хариу арга хэмжээ хүртэл шат алхсан шилжих боломжтой. Тус арга хэмжээ нь түр зуурын байж болох бөгөөд мөн үүнтэй холбоотой гарсан үр дагаврыг дүн шинжилгээнд ашиглах нь зүйтэй. Тус асуудлын мөн чанар өөрчлөгдх, эсвэл шинэ асуудал олж илрүүлэх тохиолдолд тухайн шинэ мэдээлэлд үндэслэн задлах шатыг дахин хийх шаардлага үүсэж болзошгүй. Дүн шинжилгээ, үнэлгээ хийх шатуудыг гүйцэтгэх нь чухал бөгөөд задлахаас хариу арга хэмжээ авах шат рүү шууд шилжиж, уг хоёр шатыг алгасан шийдэл хэрэгжүүлснийг зорилгоо биелүүлсэн гэж үзэхгүй.

## Асуудал шийдвэрлэх үйл ажиллагааны SARA үе шатууд



Энэ зааврыг боловсруулсан судлаачдын нэг (Кларк) Хойд Каролинагийн Шарлотт хотод баригдаж буй орон сууцны цахилгаан хэрэгслийн хулгайн хэргийг бууруулах зорилго бүхий төсөлд Херман Голдштейнтэй хамтран ажиллаж байсан. Эдгээр орон сууцууд нь ихэвчлэн тусгаарлагдмал, хөдөө орон нутагт байхаас гадна барилгын компани, захиалагч нь худалдан авагчдад баригдаж буй сууцуудыг орой болон амралтын дөрүүдээр танилцуулдаг байсан тул эргүүл хийх, хамгаалалтад авахад бэрхшээлтэй байв. Түүнчлэн цөөн тооны гэмт хэрэгтнийг саатуулж, баривчилж байсан учраас хэрэгтнүүдийн талаар, цахилгаан хэрэгслүүдийг хэрхэн хулгайлж, худалдсан талаар буюу хэргийг хэрхэн, хэн үйлдсэн талаар мэдээлэлгүй байв. Цахилгаан хэрэгслийг орон байранд найдвартай сав, шүүгээнд хадгалах, зөөврийн дохиолол, хяналтын камер ашиглах зэрэг олон боломжит шийдлүүдийг авч үзсэнээс бид жижиг барилгын компаниудын хэрэглэдэг сууц худалдагдах хүртэл хугацаанд цахилгаан хэрэгслүүдийг суурилуулахгүй байх шийдлийг сонгосон юм.

Барилгын компаниуд энэ санааг эхэндээ эсэргүүцэж байсан. Борлуулалтын ажилтнууд гэр ахуйн цахилгаан хэрэгслийг суурилуулсанар байшинг илүү хурдан худалдах боломжтой байдаг, хулгайн хэргээс шалтгаалан тухайн байранд цахилгаан хэрэгсэл суурилуулаагүй нь эрэлт бууруулах эрсдэлтэй гэж үзэж байв. Худалдан авагчид сууцандaa нүүж орж байх үед цахилгаан

хэрэгслийг суурилуулах нь нэгдсэн журмаар суурилуулахаас илүү төвөгтэй гэж барилга хяналтын ажилтнууд үзэж байв. Цахилгаан хэрэгсэл суурилуулаагүй улмаас сууцыг ашиглалтад оруулахыг эрх бүхий этгээд зөвшөөрөхгүй байх эрсдэлтэй, эсвэл энэ нь ипотекийн зээлийн шаардлага гэж зарим хүмүүс буруугаар боддог. Эцэст нь, сууц бүрийн цахилгаан хэрэгслийг тус тусад нь суурилуулсанар эрх бүхий этгээдээс сууц ашиглалтад оруулах зөвшөөрлийг нэг дор авах боломжгүй болгож байв.

Гэвч дээрх шийдэл нь олон давуу талтай байсан тул барилгын компанийн эсэргүүцэлд хариу олохын тулд дун шинжилгээ хийх шат руу буцаж, үр дүнд нь барилгын компаниуд тус шийдлийг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн бөгөөд цахилгаан хэрэгслийн хулгайн хэргийн тоог бууруулж чадсан.

### SARA ба таван "I" гэж юу вэ?

Их Британийн Дотоод хэргийн яамны ажилтан Пол Экблом 5 бүрэлдэхүүн бүхий "SARA" загварыг боловсронгуй болгох саналыг дэвшүүлсэн. Үүнд мэдээлэл (Intelligence), хариу арга хэмжээ (Intervention), хэрэгжүүлэлт (Implementation), оролцоо (Involvement), нөлөөллийн ба үйл явцын үнэлгээнээс (Impact and process evaluation) багтана. "5 I's" нь маш олон практик ойлголт, арга хэрэгслээр батлагдсан.

Хураангуйг [www.crimereduction.gov.uk](http://www.crimereduction.gov.uk) болон [www.jdi.ucl.ac.uk](http://www.jdi.ucl.ac.uk) сайтаас олж авах боломжтой.

Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа бүхий төсөл хэрхэн хэрэгждэг, энэ явцад өгөгдөл, мэдээлэл цуглуулж, улмаар илүү их асуулт, бэрхшээлтэй тулгардаг, бэрхшээлтэй тулгараах тухай бүр авах хариу арга хэмжээг боловсронгуй болгох, асуудлыг дахин тодорхойлох, эсвэл зорилгоо өөрчлөх нөхцөл байдал үүсдэг гэдгийг дээрх жишээ харуулж байна. Боломжит хариу арга хэмжээг тодорхойлсон даруйд зардал, Үр ашгийн шинжилгээ хийх нь зүйтэй. Бусад бүх боломжит хариу арга хэмжээг бүрэн судлах нь төслийн явцыг удаашруулах, холбогдох талуудын дэмжлэгийг алдах зэрэг эрсдэлийг бий болгодог.

#### **Нэмэлт материал:**

Clarke, Ronald, and Herman Goldstein. 2002. "Reducing Theft at Construction Sites: Lessons from a Problem-Oriented Project." In *Analysis for Crime Prevention*, edited by Nick Tilley. Vol. 13 of *Crime Prevention Studies*. Monsey (New York): Criminal Justice Press. [http://www.popcenter.org/library/crimeprevention/volume\\_13/06-Clarke.pdf](http://www.popcenter.org/library/crimeprevention/volume_13/06-Clarke.pdf).

Eck, John. 2003. "Why Don't Problems Get Solved?" In *Community Policing: Can It Work?*, edited by Wesley Skogan. Belmont, CA: Wadsworth.

# Орчны гэмт хэрэг зүйг судлах нь

## 8. Асуудалд дүн шинжилгээ хийх гурвалжныг ашиглах

**И**хэнх криминологийн онолууд гэмт хэрэгтэн үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйлд төвлөрч, энэ талаар судалдаг. Тухайлбал хүүхэд өсгөн хүмүүжүүлэх арга барил, удамшил, сэтгэлзүйн болон нийгмийн үйл явц зэрэг хүчин зүйлс үүнд хэрхэн нөлөөлдөг эсэхийг үнэлдэг. Эдгээр онолуудын дүгнэлтийг туршихад амаргүй; олон талт, янз бүрийн шинжлэх ухааны үндэслэлтэй; цагдаагийн үйл ажиллагаанд ашиглах боломж хязгаарлагдмал байдаг. Гэхдээ орчны криминологийн онол, үзэл баримтлал (гэмт хэргийн шинжлэх ухааны шинэ ойлголт) нь цагдаагийн өдөр тутмын ажилд тустай байж чаддаг. Учир нь энэ онол гэмт хэргийн нөхцөл, шалтгаан буюу өдөөг хүчин зүйлс, байг хамгаалсан байдал зэрэгт төвлөрч, шийдэл боловсруулахыг эрмэлздэг. Та энэ онолтой судалж танилцсанаар асуудалд тулгуурласан багийн түлхүүр гишүүн болж чадах юм.

Асуудалд дүн шинжилгээ хийх гурвалжин (өөрөөр гэмт хэргийн гурвалжин гэгддэг) нь орчны криминологийн үндсэн онолуудын нэг болох "ердийн үйл ажиллагааны онол" (routine activity theory)-оос гаралтай. Лоуренс Коэн, Маркус Фэлсон нарын анх боловсруулсан ердийн үйл ажиллагааны онол нь хэрэг үйлдэж болзошгүй этгээд болон гэмт хэрэгт өртөхүйц этгээд/бай хоёр аливаа хамгаалалтын системгүй газар таарах үед гэмт хэрэг гардаг гэж тайлбарладаг. Гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээд гэж аливаа хүнийг хэлнэ. Учир нь шунал, хувия хичээсэн байдал зэрэг хүний төрөлх зан араншин нь гэмт хэрэг үйлдэх сэдэл болдог гэж үздэг. Гэмт хэрэгт өртөхүйц этгээд/бай нь гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийн зорилгоос хамаарах бөгөөд хүн байх шаардлагагүй билээ. Хамгаалалтын систем гэж аливаа зүйлийг хамгаалах зорилго бүхий хүн эсвэл төхөөрөмж байж болно. Энэхүү томьёолол

нь гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээд, гэмт хэрэгт өртөхүйц этгээд/бай, газар/байршил гэх гурван зүйл нь анхны дүн шинжилгээ хийх гурвалжныг бүрдүүлж буй талууд буюу элементүүд юм (зургийн дотоод гурвалжныг харна уу).

Энэ асуудалд дүн шинжилгээ хийх гурвалжныг ашигласнаар та дүн шинжилгээнээсээ дээрх гурван тал/элементийг орхигдуулахгүй байж чадах юм. Цагдаагийн алба хаагч нар аливаа асуудлыг зөвхөн гэмт хэрэгтнийг судалж, дүн шинжилгээ хийх зуршилд дассан байдаг – тухайн хэрэгтнийг илрүүлж, saatuuulaahad илүү анхаардаг гэсэн үг юм. Гэвч асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд аливаа асуудлыг үүнээс илүү хүрээнд авч үзэж, бусад тал/элементийг тодорхойлох шаардлагатай байдаг бөгөөд үүнд хохирогч/бай болон газрын/байршилын талаарх мэдээлэл шаардлагатай.

Асуудалд дүн шинжилгээ хийх гурвалжны хамгийн суулийн хувилбар нь дээрх гурвалжны гурван тал/элемент тус бүрийн нь "хянагч" хүчин зүйлийг илэрхийлэх элементийг нэмж, түүний гадуур шинэ гурвалжин нэмсэн хэлбэртэй байдаг (зургийг харна уу):

- Гэмт хэрэгт өртөхүйц этгээд/байн хувьд: "ердийн үйл ажиллагааны онол"-ын анхны томьёололд тусгагдсан хамгаалалтын систем (guardian)-д өөрийгөө эсвэл өөрийн, гэр бүлийн гишүүд, найз нөхөд, хамтран ажиллагсдынхаа эд зүйлсийг гэмт хэргээс хамгаалж буй хүн, эсвэл цагдаагийн алба хаагч, хувийн хамгаалалтын байгууллагын ажилтан багтана.
- Гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийн хувьд: зохицуулагч (handler) гэж гэмт хэрэгтэнд нөлөөлөхүйц, түүний үйлдэлд

тодорхой хяналт тавихуйц, түүнийг сайн мэддэг хүнийг хэлнэ. Үүнд эцэг эх, ах эгч, багш, найз нөхөд, эхнэр/нөхөр зэрэг багтана. Тэнсэн суллагсдад хяналт тавих эрх бүхий этгээд зохицуулагчийн үүргийг орлон гүйцэтгэх, эсвэл зохицуулагчид туслалцаа үзүүлэх байдлаар оролцож болно.

- Газар/байршлын хувьд: менежер (manager) гэж аливаа газар, байршилд өрнөж буй үйл явдалд хяналт тавих, чиглүүлэн удирдах үүрэг бүхий хүнийг хэлнэ. Үүнд дэлгүүрийн эзэн, автобусны жолооч, сургуулийн багш, баарны эзэн, түрээсийн байрны эзэн, онгоцны үйлчлэгч зэрэг багтана.



Асуудалд дүн шинжилгээ хийх гурвалжин нь цагдаагийн алба хаагч нарт тулгардаг түгээмэл асуудлуудыг гурван ангилалд ангилах аргачлал, тус асуудлууд ямар учир шалтгааны улмаас үүсдэг талаарх өөр нэг онол, дүн шинжилгээний хэрэгслийн суурь болж өгдөг. Жон Экк, Уильям Спелман эдгээрийг "чоно", "нугас", "ичээ" хэмээн ангилахыг санал болгосон байдаг. Үүнд:

- Гэмт хэрэг давтан үйлдэхдээ ижил газар эсвэл бай сонгодоггүй этгээдтэй холбоотой асуудлыг "чоно" гэж нэрлэнэ. Нэгээс дээш тооны банканд галт зэвсэгт дээрэм хийх гэмт хэрэгтэн нь "чоно" гэсэн асуудалд хамаарах юм. Аливаа хэрэгтэн бай, газар байршлын харуул хамгаалалт түр зуур супарч, гэмт хэрэгт өртөмтгий болсон нь ил байх эсвэл энэ талаар

олж мэдсэн тохиолдолд чонын асуудал үүсэх нөхцөл бүрддэг. Энэ тохиолдолд эдгээр газар, байршлын хянач этгээд ирээдүйд дахин хэрэг үүсэхээс сэргийлэх арга хэмжээ авах бөгөөд үүний хариуд хэрэгтэн дараагийн бай, газар/байршил руу шилжинэ. Хяначийн дутуу хяналтын улмаас чонын асуудал үүсэх нөхцөл бүрддэг.

- Аливаа этгээд хоорондоо холбоогүй гэмт хэрэг, халдлагад дахин дахин өртөх асуудлыг "нугас" гэсэн асуудал хамаарна. Хоорондоо холбоогүй, хамааралгүй газар, байршилд халдлага, дээрэмд өртдөг таксины жолооч нь "нугас"-ны асуудал юм. Нугасны асуудал хэмээн ангилалд багтах асуудал нь гэмт хэрэгт өртөж болзошгүй этгээд/бай гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдтэй өөрийгөө хамгаалах арга хэмжээ авахгүйгээр, эсвэл хамгаалагчгүйгээр хэд хэдэн удаа харилцаанд орох тохиолдолд үүсдэг.
- Гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээд, гэмт хэрэгт өртөж болзошгүй этгээд хэн байхаас үл хамааран гэмт хэрэг өндөр давтамжтайгаар гардаг газар/байршлыг "ичээ"-ний асуудал хэмээн нэрлэнэ. Жишээлбэл, баар, цэнгээний газарт аливаа этгээд хооронд үүсэх маргалдааны тоо, давтамж их байх тохиолдолд үүнийг ичээний асуудал гэж ойлгоно. Ичээ ангиллын гэмт хэргүүд нь менежерийн хяналт тавих чадвараас хамаарна.

Чоно, нугас, ичээний асуудлыг тодорхойлоход бэрхшээлтэй. Ихэнх гэмт хэргүүд энэ гурван ангиллын холимог байдаг тул аль ангилал давамгайлж буйг тодорхойлох нь зүйтэй: чоно, нугас эсвэл ичээ аль нь болох зэрэг юм.

Гэмт хэрэг үүсэхэд дотор гурвалжны бүх талууд/элементүүд бүрдсэн байх шаардлагатай бөгөөд гадуур гурвалжны талууд/элементүүд бүрдсэн байх шаардлагагүй. Жишээлбэл, гэмт хэрэг хамгаалагч тал/элемент байхгүй үед гардаг бол хамгаалагч тал/элементийн хуваарийг өөрчлөх нь зүйтэй. "Гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө, үйлдэх явцад болон дараа нь асуудалд дүн шинжилгээ хийх гурвалжин ямархуу

байдалтай харагддаг вэ?" гэж өөрөөсөө асуугаарай.

Боломж нөхцөлөөс шалтгаалж гэмт хэрэг хэрхэн үүсдэгийг ойлгох нь зохицуулагч тал/элементийн тусламжтайгаар гэмт хэрэг гэмт хэрэг давтан үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх; гэмт хэрэгт өртөж болзошгүй этгээд/байг гэмт хэрэгт давтан

өртөх эрсдэлийг бууруулах; гэмт хэрэг их гардаг газар/байршлыг (сургууль, зогсоол, баар гэх мэт) өөрчлөхөд хэрэгтэй билээ. Товчхондоо, энэ ойлголт нь практик шийдэл боловсруулахад хэрэгтэй эдгээр зургаан тал/элементэд төвлөрч, шаардлагатай мэдээллийг цуглуулахад танд дэмжлэг үзүүлнэ.

### Гэмт хэрэг шинжлэх ухаан гэж юу вэ?

Гэмт хэргийн шинжлэх ухааны хүрээнд нийгэм дэх гэмт хэргийн асуудалд хандах хандлага, авах арга хэмжээ нь ердийн арга барилаас эрс ялгаатай билээ. Энэхүү ойлголтын шинж чанар нэршилд нь агуулагдаж буй.

Нэгдүгээрт, гэмт хэргийн шинжлэх ухаан **ГЭМТ ХЭРГИЙН** талаар судалдаг. Уламжлалт криминологийн аргачлал нь ядуурал, нийгмийн тэгш бус байдал, эцэг эх ба сургуулиас авах хүмүүжил зэрэг шууд бус, холын шалтгаанд төвлөрч, голчлон гэмт хэрэг зүйд анхаардаг. Харин гэмт хэргийн шинжлэх ухаан гэмт хэргийн шууд шалтгаан буюу яагаад, хаана, хэзээ, хэн, хэрхэнгэх асуултад хариулахыг эрмэлздэг. Уг шинжлэх ухаан нь тодорхой хэв маяг бүхий гэмт хэрэг гаралт, тархалтыг өдөөн хатгадаг, бий болоход нөлөөлдөг хүчин зүйл, нөхцөл байдал, шалтгааныг судалдаг.

Хоёрдугаарт, гэмт хэргийн шинжлэх ухаан нь **шинжлэх ухааны** арга барилд тулгуурласан билээ. Гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийг хянах зорилгоор авч хэрэгжүүлдэг ихэнх уламжлалт хариу арга хэмжээ нь аливаа системд тулгуурлаагүй, үр дүнг нь баталгаажуулаагүй таамаглалаас хамааралтай байдаг.

Нэгөөтээгүүр, гэмт хэргийн шинжлэх ухаан нь баримтад тулгуурласан, асуудалд чиглэсэн, эмпирик судалгаанд үндэслэсэн арга барил юм. Шинжлэх ухааны аргыг хэрэглэдэг гэмт хэрэг судлаачид / эрдэмтэд/ гэмт хэргийн талаар өгөгдэл мэдээлэл цуглуулж, гэмт хэргийн хэв маяг, чиг хандлагын талаар таамаглал дэвшүүлж, турших боломж бүхий загварт тулгуурлан аливаа ажиглалтад тайлбар боловсруулж ажилладаг.

Гэмт хэргийн шинжлэх ухаан нь практикт чиглэсэн бөгөөд олон төрлийн ойлголт, арга зүйд тулгуурласан арга барил билээ. Гэмт хэрэг судлаачид /эрдэмтэд/ гэмт хэрэг үйлдэхэд хүндрэлтэй болгох, гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд баривчлагдах магадлалыг нэмэгдүүлэх замаар гэмт хэрэг гаралтыг бууруулахын тулд эрүүгийн эрх зүйн тогтолцооны мэргэжилтнүүдтэй (цагдаагийн алба хаагч, хууль, шүүгч гэх мэт) идэвхтэй хамтран ажилладаг. Гэмт хэргийн шинжлэх ухаанд криминологи, нийгэм зүй, сэтгэл зүй, газар зүй, архитектур, үйлдвэрлэлийн дизайн, тархвар судал, компьютерын шинжлэх ухаан, математик, инженерчлэл, биологи гэх мэт олон төрлийн ойлголт, арга зүй ашиглагддаг.

Эх сурвалж: Jill Dando Institute for Crime Science. Accessed May 22, 2015. <http://www.jdi.ucl.ac.uk>.

## 9. Хулгайн хэрэг гарах нөхцөл, шалтгаан бүрдсэн үед хулгайч бий болдог

**О**рчны криминологичдын хувьд "нөхцөл, шалтгаан хулгайчийг бий болгодог" гэдэг нь арга барилын тулгын чулуу юм. Гэмт хэрэг үйлдэх нөхцөл, шалтгаан нэмэгдэх хэрээр гэмт хэрэг нэмэгдэнэ гэж тэд үздэг. Жилл Дандрогийн Гэмт хэргийн шинжлэх ухааны хүрээлэнгийн Глория Лайкок, Ник Тилли нарын санал болгосон доорх жишээтэй танилцаж, үүнтэй санал нийлж байгаа эсэхээ харна уу:

Хяналтыг бүх тогтолцоог хэрэгжүүлэхээ больё гэж төсөөльье: хаалга цоожгүй, хил гаалийн хяналт байхгүй, бэлэн мөнгийг ил орхисон, нисэх онгоцны буудал дээр ачаа тээш шалгахгүй, галт тэрэгний буудалд тасалбар шалгахгүй, зам зохицуулах гэрлэн дохио байхгүй байх тохиолдолд гэмт хэргийн давтамжид өөрчлөлт гарах уу?

Хэрэв гэмт хэрэг, зөрчил нэмэгдэнэ гэж үзэж байвал та ч бас нөхцөл, шалтгааны улмаас гэмт хэрэг үүсдэгтэй санал нийлж байгаа хэрэг. Гайхалтай нь ихэнх криминологичид үүнтэй санал нийлэхгүй. Учир нь тэд нөхцөл, шалтгаан гэмт хэрэг тохиолдох эсэхийг бус харин гэмт хэрэг хэзээ, хаана гарахыг тодорхойлдог гэж үздэг. Тэд гэмт хэрэг үйлдэх эсэх нь гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийн хандлагаас хамаардаг бөгөөд тус хандлага нь нийгэмд гарч буй гэмт хэргийн давтамжийг тодорхойлдог гэж үздэг.

Үнэн хэрэгтээ гэмт хэрэг нь тухайн нийгмийн зохион байгуулалт буюу нөхцөл, шалтгаан болон хүн амын хандлагаас хамаарна. Үүнийг батлахад туршилт хийх шаардлагатай боловч хулгай, дээрэм гарах нөхцөл, шалтгааныг бүрдүүлж өгөх нь ёс зүйгүй хэрэг юм. Хэдий тийм ч хөнгөхөн зөрчилтэй холбоотой туршилтуудыг өмнө хийж байсан. 1920-иод онд судлаачид шалгалтын явцад хууран мэхлэх, үүнийг нуун дарагдуулах, тааварт тоглоомоос зоос хулгайлалт нөхцөл, шалтгааны зохиомлоопр бүрдүүлж, бага насны хүүхдүүдэд туршилт хийж байсан туршлага бий. Өөр нэг хэсэг эрдэмтэд гудамжинд тамга, хаягтай дугтуй тарааж, заримд нь мөнгө хийж эдгээрийг

зохих хаягт илгээх эсэхийг туршиж байсан. Мөн, лабораторийн туршилтын нөхцөлд зарим аппаратын туслалцаатайгаар хүчтэй цахилгаанаар цочроо замаар туршилтын зааврыг дагаагүй хүмүүсийг шийтгэх нөхцөлийг бүрдүүлж байсан (цахилгаанаар жинхэнээсээ цохиогүй).

Эдгээр туршилтуудын үр дүн нөхцөл, шалтгаан нь учир шалтгаан мөн гэдгийг батлан харуулсан. Ихэнх оролцогчид өдөөгч хүчин зүйлсийг эсэргүүцсэн боловч шударга биш, түрэмгий зан гаргах боломжийг ашигласан. Гэвч хөнгөхөн хэрэг, зөрчлийн хүрээнд гарсан энэхүү дүгнэлтийг үндэслэн машины хулгай зэрэг илүү хүнд төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаар дүгнэлт хийх нь зохимжгүй юм. Иймд гэмт хэрэг үйлдэхэд нөхцөл, шалтгаан нөлөөлдөг эсэхийг нотлох бусад эх сурвалж ашиглах шаардлагатай.

### **Амиа хорлолт ба нөхцөл, шалтгаан.**

Амиа хорлох нь гэмт хэрэг биш боловч бусад гэмт хэргийн адил тодорхой санаа, сэдлийн үндсэн дээр үйлдэгддэг. Хэдий тийм ч амиа хорлоход боломж нөхцөл чухал үүрэг гүйцэтгэдэг тухай Их Британид хийгдсэн судалгааны нотолгоонууд бий. 1950-иад оны үед Их Британид амиа хорлосон хүмүүсийн тал орчим хувь нь үхлийнаюлтай нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) агуулсан ахуйн хэрэглээний хийг ашигласан байдаг. Үүнийг "хийн зуух руу толгойго шургуулах" гэж нэрлэдэг байж. 1960-аад оноос хийг нүүрсний оронд газрын тоскоор үйлдвэрлэж эхэлсэн. Шинэ хий нь CO-ийн ялгарал багатай байсан учраас хийгээр амиа хорлогчдын тоо буурч эхэлсэн. 1968 он гэхэд нийт амиа хорлолтын 20 орчим хувийг хийтэй холбож болохоор байв. Энэ үед хоёр дахь өөрчлөлт эхэлсэн: үйлдвэрлэсэн хийг Хойд тэнгисийн (North Sea) байгалийн хийгээр орлов. Байгалийн хий нь CO ялгаруулдаггүй бөгөөд амиа хорлоход ашиглах бараг боломжгүй юм. 1970-аад оны дунд үеэр Их Британид амиа хорлогчдын 1 хүрэхгүй хувь хийгээр амиа хорлох аргыг хэрэглэж байжээ.

Гол нь амиа хорлогчид амиа хорлох өөр арга зам ашиглаж эхлээгүй нь хачирхалтай байв.

Хүснэгтээс үзэхэд 1958-1976 оны хооронд амия хорлолт 5298-aac 3816 болж, 30 орчим хувиар буурчээ (эдийн засгийн хүнд хэцүү үед Европын бусад орнуудын адил амия хорлолт өсөөгүй гэсэн үг). Хүмүүс амия хорлолтын өөр арга зам ашигладаггүй байсан учир нь бусад арга зам ямарваа нэг байдлаар оновчтой биш байсантай холбоотой. Эмийн бодис хэтрүүлэн хэрэглэх СО-тай харьцуулахад үхэлд хүргэх магадлал багатай. Өөрийгөө дүүжлэхэд илүү их мэдлэг болон эр зориг шаарддаг. Хүн бүр буу авах боломжгүй бөгөөд буу хэрэглэх нь үхэлд хүргэхээс илүүтэй тахир дутуу болгох эрсдэлтэй. Ахуйн хий харин бараг айл бүрт байдаг бөгөөд үхэлд аливаа хүндрэл, өвчингүйгээр хүргэдэг. Эдгээр шалтгаануудын улмаас СО хий нь удаан хугацааны туршид амия хорлох оновчтой арга замд тооцогдож байсан бөгөөд ашиглах нөхцөл, шалтгааныг бууруулснаар амия хорлолт буурсан нь гайхах зүйл биш юм.

#### 1958-1977 оны хооронд Англи ба Вэйлст үйлдэгдсэн амия хорлолтууд

Он	Нийт амия хорлолт	Ахуйн хийгээр амия хорлох	Эзлэх хувь
1958	5,298	2,637	49.8
1960	5,112	2,499	48.9
1962	5,588	2,469	44.2
1964	5,566	2,088	37.5
1966	4,994	1,593	31.9
1968	4,584	998	21.6
1970	3,940	511	13.0
1972	3,770	197	5.2
1974	3,899	50	1.3
1976	3,816	14	0.4

Эх сурвалж: *Mortality Statistics, England and Wales: Causes*. London: Her Majesty's Stationery Office, Annual.

#### Хүн амины хэрэг ба боломж нөхцөл.

АНУ болон Их Британи улсын хүн амины хэргийн түвшнийг харьцуулсан хэдэн жилийн өмнөх судалгаа хүн амины хэрэгт нөхцөл, шаардлага чухал нөлөө үзүүлдэг болохыг харуулсан. 1980-84 онд АНУ-д хүн амины хэргийн нийт хэмжээ Англи, Уэльсийнхээс 8.5

дахин их байжээ. Хүний амийг буугаар буудах замаар хороосон хэрэг 63 дахин, гар буугаар хороосон хэрэг 75 дахин их байжээ. Англи, Уэльст (50 сая орчим хүн амтай) гар буугаар буудах замаар хүний амийг хороосон хэрэг нийт 57 байсан бол энэ төрлийн хэрэг 230 сая хүн амтай (даруй 5 дахин их) АНУ-д нийт 46,553 гарчээ.

Тухайн үед АНУ-н гэмт хэргийн түвшин ерөнхийдөө Англи, Уэльсийнхээс өндөр байсан учраас дээрх дүгнэлтэд төдийлөн ач холбогдол өгдөггүй байсан. Гэвч сүүлийн 15 жилийн хугацаанд хоёр улсын гэмт хэргийн нийт түвшин ойртон хэдий ч хүн амины хэргийн тоо ялгаатай буюу АНУ-д харьцангуй өндөр хэвээр байгаа бөгөөд энэ нь буу, гар буу эзэмшдэг хүний тоотой холбоотой юм. Их Британийн цагдаагийн алба хаагчид хүртэл биедээ буу байнга авч явдаггүй! АНУ-д аливаа маргаан гарах үед нэгнийгээ буудах магадлал Их Британиас хамаагүй өндөр. Үүнтэй ижил дүгнэлтийг АНУ болон Канад дахь хүн амины хэргийн түвшнийг харьцуулсан судалгаанаас мөн гарсан байдаг (дөрвөлжинг харна уу). Өөрөөр хэлбэл, буу эзэмшихийг хязгаарлахгүй байх нь (нөхцөл, шалтгааны хувьсагч) хүн амины хэргийг нэмэгдүүлэх нөлөөтэй байдаг байна.

Энэ хэсэгт дурдсан нөхцөл, шалтгааны талаар ойлголттой болж, эдгээр нь гэмт хэргэг гарахад нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрөх нь бусад хамаарал бүхий хүчин зүйлсийн (хувь хүний хандлага гэх мэт) ач холбогдлыг үүгүйсгэ гэсэн үг биш юм. Гэвч та хүний зан чанар ба хандлага, гэр бүл цуцлалтын түвшин, зүй зохисгүй хүмүүжилд нөлөөлж чадахгүй билээ. Харин та нөхцөл, шалтгааныг өөрчлөх замаар аливаа хүний гэмт хэргэг үйлдэх магадлалд (криминоген) нөлөөлж чадна. Та нөхцөл, шалтгаан хулгайчийг бий болгодог гэдгийг ойлгосноор гэмт хэргээс урьдчилан сэргийлэхдээ илүү практик хандлагатай болж, практикт суурилсан арга зам ашиглаж эхлэх бөгөөд эдгээр арга замыг шүүмжлэлээс хамгаалах боломжтой болно.

## Галт зэвсэг ба хүн амины хэрэг АНУ Канадад

Нэгэн сонгодог судалгаанд 1980-1986 оны хооронд АНУ-ын Сиатл хот, Канад Улсын Ванкувер хотод гарсан хүн амины хэрэг, халдлагын түвшнийг гар буунд тавих хяналтаас хамааруулж, харьцуулсан судалгаа хийсэн байдаг. Хэдий тус хотууд хоорондоо төстэй ч Ванкуверт гар буу эзэмшихэд илүү хатуу хяналт тавьдаг. Тус судалгаа гар буунд тавих хяналт, хүн амины гэмт хэрэг хоорондоо харилцан хамааралтай гэж дүгнэсэн. Гол ололтууд:

1. Халдлагын хэргийн давтамжийн хувьд тус хотууд ижил байв.
2. Сиатл хотод гэмт хэрэгт амия алдах эрсдэл Ванкувер хотынхос хамаагүй өндөр байсан нь гар буугаар буудуулж амия алдах эрсдэл тав дахин их байсантай холбоотой.
3. Галт зэвсгийн бус арга замаар хүнийг алах гэмт хэргийн хувьд тус хоёр хотууд ижил байв.

Эх сурвалж: Sloan, John, et al. 1988. "Handgun Regulations, Crime, Assaults, and Homicide." *The New England Journal of Medicine* 319: 1256–1262.

### Нэмэлт материал:

Felson, Marcus, and Ronald Clarke. 1998. Opportunity Makes the Thief: Practical Theory for Crime Prevention. No. 98 in Police Research Series. London: Home Office. <http://www.popcenter.org/library/reading/pdfs/thief.pdf>

# 10. ГЭМТ ХЭРЭГТНИЙ ӨНЦГӨӨС БОДОЖ ҮЗЭХ

ГЭМТ хэргийн асуудалд дүн шинжилгээ хийх, асуудлыг шийдвэрлэх арга замыг боловсруулахдаа гэмт хэрэгтний өнцгөөс харахыг эрмэлзэхийг зөвлөж байна. Тэдний гэмт хэрэг үйлдэх болсон сэдэл, шалтгааны талаар буюу нийгэм, сэтгэл зүйн байдал гэхээс илүүтэй ашиг, сонирхлыг нь ойлгохыг хичээ. Банк дээрэмдэж буй этгээдийн удамшил, ген банк дээрэмдэхэд нөлөөлдөггүй, харин тухайн этгээдийн баян болох хүсэл банк дээрэмдэхэд хүргэдэг гэж 30 жилийн өмнөх криминолигийн салбарт уг шүүмж байсан.

Ихэнх хулгай, дээрмийг үйлдэх болсон сэдэл, шалтгаан тодорхой байдаг боловч графити, нийтийн өмчийг эвдлэн сүйтгэх, бүлэглэлийн хүчирхийлэл үйлдэх зэрэг хэргийнх нь тодорхой бус байх нь олонтоо. Графити нь гэмт бүлэглэлийн нутаг дэвсгэрийг, мансууруулах бодис түгээх газрыг тэмдэглэх, эсвэл зүгээр бусад онгирох зорилготой байж болно. Эдгээр сэдэл, шалтгааны аль нь давамгайлж гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн болохыг тогтоох нь асуудал шийдвэрлэх үйл ажиллагааны чиглэл, зорилгыг тодорхойлох, нөлөөлж буй хүчин зүйлсийг задлан үзэх, мөн асуудалд тохирсон шийдлүүдийг боловсруулахад хэрэгтэй. Иймд, Нью-Йорк хотын метро тээврийн алба графити зурах үйлдлийн сэдэл метрогоор зорчиж буй хүмүүст урлагийн бүтээлээ танилцуулах зорилготой байсныг олж мэдсэний үр дүнд тус асуудлыг шийдвэрлэж чадсан билээ (41 дүгээр алхмыг үзнэ үү).

Гэмт хэрэгтэн аливаа хэргийг хэрхэн үйлдэж байгааг ойлгохоос гадна яагаад үйлдэж буйг ойлгох нь чухал юм. Эдгээр асуултуудын талаар бodoход "оновчтой сонголтын онол" (rational choice theory) танд хэрэг болно. Уг онол нь гэмт хэрэгтэн гэмт хэргээ сайтар төлөвлөдөг эсэх, зорилгоо биелүүлдэг эсэх талаар ямарваа нэг төсөөлөл, таамаглал дэвшүүлдэггүй, харин өөрт ашиг, өгөөж хүртээх боломж бүхий гэмт хэрэг үйлдэхийг

сонгодог гэж төсөөлдөг. Учир нь гэмт хэрэг үйлдэх этгээдэд оновчтой сонголт хийхэд нь шаардлагатай мэдээлэл байдаггүй, эсвэл тус этгээд гэмт хэрэг төлөвлөхөд хангалттай цаг зарцуулдаггүй тул хэрэг үйлдэх эрсдэлийг хүлээж, алдаа гаргадаг байна. Бид нар ч мөн адил өдөр тутамдаа ийм байдлаар шийдвэр гаргадаг. Судлаачид үүнийг "хязгаарлагдмал оновчтой байдал" (limited or bounded rationality) гэж нэрлэдэг.

Гэмт хэрэг үйлдэх гэж буй этгээд зорилгоо баригдахгүйгээр биелүүлэх талаар шийдвэрээ хурдан гаргах хэрэгтэй байдаг. Гэмт хэрэгтэнтэй ярилцлага хийж энэ шийдвэрийг хэрхэн гаргадаг талаар ойлголттой болж болно. (Гэмт хэрэг үйлдсэн хүмүүстэй ярилцлага хийх тухай "Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн алба" (COPS)-ны гаргасан гарын авлагад эдгээр ярилцлагыг хийхэд тулгардаг хууль зүйн болон техникийн хүндрэлийг шийдвэрлэхэд дурдсан байдаг. Энэ талаар "Нэмэлт материал"-с үзнэ үү.) Гэмт хэрэгтэнтэй хийх эдгээр ярилцлагаар тухайлсан гэмт хэргийн талаар бус, харин аливаа нэг төрлийн гэмт хэргийн ерөнхий шинж чанарын хүрээнд асуултаяа тавих нь зүйтэй бөгөөд хэрэгтнүүд энэ талаар ярихаас цааргалдаггүй. Бид өөрсдийнхөө тухай болон хийж буй ажлынхаа талаар ярих дуртай байдгийн адил гэмт хэрэгтнүүд ажлынхаа талаар ярилцах дуртай байдаг. Хэдий тийм ч хууль, дүрэм зөрчих зуршилтай аливаа этгээд хэтрүүлэн эсвэл худлаа ярих хандлагатай байдгийг анхаарах хэрэгтэй.

Английн Лестерийн их сургуулийн Мартин Гилл широнд туршлагатай гэмт хэрэгтэнтэй ярилцлага хийсэн тухай нэгэн түүхийг өгүүлдэг. Түүнийг баривчлахад хүргэсэн гэмт хэргийн талаар ярихдаа "Чи баригдана гэж бодсон уу?" гэж Жилл асуусан аж. Үүнд хоригдол сандал дээрээ налан түүн рүү удаан харснаа "Их сургуулийн хэн нэгнээс ийм тэнэг асуулт асууна гэж бодож байсангүй. Хэрэв баригдана гэж бодсон бол хийх байсан гэж бодож байна уу?" гэж хариулжээ.

Хэрэв та гэмт хэрэгтэнтэй ярилцлага хийх боломжгүй бол гэмт хэргийн явцыг төсөөлөхийг хичээгээрэй (35 дугаар алхмыг үзнэ үү). Гэмт хэргийн үе шат бүрт юу хийх ёстой вэ? Хохирогч, байг хэрхэн сонгох вэ? Хохирогч, байг хэрхэн дийлж, хууран мэхлэх вэ? Цагдаа нараас хэрхэн зугтах вэ? Хулгайлсан эд зүйлсээ яаж худалдах вэ? Та хэрэг үйлдэх явцын тухай уг асуултад хариулж чадахгүй байсан ч гэмт хэрэгтний өнцгөөс бодож эхлэх нь хариу арга хэмжээ боловсруулахад тань тусална. Энэ нь психоанализ буюу сэтгэл судлалын онолд суурилсан дүн шинжилгээ хийгээд үз гэсэн үг биш юм. Гэмт этгээдийн ухамсыг судлахын оронд гэмт хэрэгтэн ямар зорилготой болохыг, мөн аливаа гэмт хэрэгт хэт их хүчин чармайлт гаргахгүйгээр эсвэл эрсдэл хулээхгүйгээр тухайн хэргийг үйлдэх боломжтой талаар бодолцож үзээрэй. Английн Дотоод хэргийн яамны Судалгааны хэлтсийн Пол Экблом "хулгайч шиг бод" гэж хэлэхдээ энэ утга санааг илэрхийлсэн байдаг.

Пол Экблом Лондоны метроны хулгайч нартай ярилцлага хийх үед тус хэрэгтнүүд түүнд хулгайчаас болгоомжил гэсэн тэмдгийг харсан зорчигчид түрийвчтэй халаасаа тэмтэрдэг тул үүнийг анзаарч эд зүйлс нь хаана буйг олж мэдэх зорилгоор тэмдгийн дэргэд зогсдог гэж хэлсэн байдаг.

Гэмт хэрэгтэнтэй ярилцлага хийх боломжгүй тохиолдолд ижил төстэй гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдтэй хийсэн ярилцлагын түүх, тайланг мөн судалж болох юм. Орчны криминологичид автомашины хулгайч, дэлгүүрийн хулгайч, орон байрны хулгайч нартай ярилцлага хийж, гэмт хэрэгтнүүдийн түгээмэл ашигладаг арга хэрэгслийн талаарх бидний ойлголтод ихээхэн хувь нэмэр оруулсан. Хэдий уншиж, судалж буй гэмт хэрэгтнүүд таны харьцаж байгаа гэмт хэрэгтэнтэй ижил биш ч эдгээр ярилцлагын судалгааны үр дүнтэй сайтар танилцсанаар өөрт тулгарч буй асуудлын талаар тодорхой ойлголттой болж чадах юм.

## Зэвсэгт дээрэмчний өгүүлэлж

### Хэргийн сэдэл:

Хэрэгтний өгүүлэлжээс: "Та тэнд ганцаараа сууж байна, таны түрүүвч хөнгөрснийг мэдэрч байна. Түрээсийн төлбөр чинь дөхөж байна, цахилгааны болон ахуйн хийн төлбөрийн талаар бодно, Та төлбөр хураагч нараас байнга төлбөрийн нэхэмжлэл хулээн авдаг, "Надад мөнгө байдаг ч болоосой гэж та бодно. Надад мөнгө хэрэгтэй байна." гэж та элдвийг бодно. Чамд мөнгө байхгүй, асуудал бэрхшээл үүдэнд тулж ирээд байгаа тул таны сэтгэл зүйд шаналгаатай байдал үүснэ. .... Би түрээсний төлбөрт бага зэрэг мөнгө зарцуулсан, цахилгааны компанид бага зэрэг төлбөр хийсэн, ахуйн хийн компанид бас бага зэрэг мөнгө төлсэн. Миний халаасанд хорь, гучин доллар л байсан. Би шар айраг, тамхи авч, нунтаг кокаин худалдаж авсан, би хэсэг хугацаанд ч гэсэн өөрийгөө тайвшруулж, таашаалыг мэдэрсэн" (х. 43–44)

### Дээрэм хийх давуу тал:

Хэрэгтний өгүүлэлжээс: "Дээрэм, хулгай бол мөнгө олох хамгийн хурдан арга. Дээрэм, хулгай бол богино хугацаанд их мөнгө олох хялбар арга. .... Орон байрны хулгайн хувьд та хулгайлсан бараагаа худалдах шаардлагатай. Мансууруулах бодисын хүрээнд та хэт их олон хүнтэй харьцана. Үүнд нэлээд хугацаа орно" (х. 51–52).

### Хохирогчийг сонгох нь:

Хэрэгтний өгүүлэлжээс: "Хаана очиж дээрэм хийхээ би сайн мэднэ [дээрэм хийхэд тохирсон байг олохыг тулд]. Ер нь би хар тамхи худалддаг хүмүүсийн очдог газар очдог... ATM-с гарч буй хүмүүсийг мөн дээрэмдэж байсан (х. 78) "Миний дээрмийн бай бол хар тамхины наймаачид юм... Тэд цагдаа дууддаггүй. Цагдаа дуудлаа гэхэд тэд юу хэлэх бэ дээ? Тэр намайг хар тамхины төлөө дээрэмдсэн гэж үү? Тэд бол миний хувьд хамгийн хялбархан өгөөш юм. Би ямар ч гэм зэмгүй хүмүүст хор хөнөөл

учруулахыг хүсэхгүй байна, би зүгээр л хар тамхины наймаачидтай харьцдаг" (х. 64).

### Хүчирхийлэл

Хэрэгтний өгүүлэмжээс: "За, [хохирогч] эргэлзээд байвал жоохон түрэмгий зан гаргаад, түлхэнэ. . . . Гар буугаа аваад, толгойг нь хага цохиж магадгүй. "Яг одоо мөнгөө өгөхгүй бол алчихна шүү" гэж сүрдүүлэхэд ихэнх тохиолдолд мөнгөө гаргаж өгдөг л юм" (х. 109).

Эх сурвалж: Wright, Richard, and Scott Decker. 1997. *Armed Robbers in Action: Stickups and Street Culture*. Boston: Northeastern University Press.

### Нэмэлт материал:

Decker, Scott. 2004. Using Offender Interviews to Inform Police Problem-Solving. No. 3 of Problem-Oriented Guides for Police: Problem Solving Tool Series. Washington, DC: Office of Community Oriented Policing Services. [Http://ric-zai-inc.com/ric.php?Page=detail&id=COPS-P074](http://ric-zai-inc.com/ric.php?Page=detail&id=COPS-P074).

# 11. Гэмт хэрэгтний хариу үйлдлийг урьдчилан таамаглах

Гэмт хэрэгтэн гэмт хэрэг үйлдэх боломжийн талаарх ёөрсдийн ойлголтдоо тулгуурлан тухай хэргийг үйлдэх эсэх шийдвэрээ гаргадаг. Гэмт хэрэгтэн аливаа зүйлийг хэрхэн харж байгааг ойлгох нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Учир нь ихэнх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэмт хэрэгтний хэрэг үйлдэх боломжийн талаарх ойлголтод нөлөөлж, өөрчлөх зарчимд сууринсан байдаг. Зарим урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэмт хэрэгтний ойлголтод шууд нөлөөлөх зарчимтай байдаг (тухайлбал ажиглалтад байгаа гэдгийг тухайн этгээдэд шууд мэдэгдэх). Гэхдээ ихэнх урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь нэг ба хэд хэдэн завсрын үе шатаар замаар хэрэгждэг (жишээлбэл, оршин суугчид цонхон дээрээ хөрөнгийн тэмдэглэгээ наах замаар хөрөнгө тэмдэглэлийн хотолборт (property marking scheme) оролцож буйгаа мэдэгдэх). Орчны өөрчлөлт нь хэрэгтний ойлголтод мөн нөлөөлдөг. Уг ойлголт нь хэрэгтний зан төлөвт нөлөөлж, улмаар хэргийн хэв маягийг өөрчилдөг.

Ихэнх тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь тухайн хэрэгтнийг давтан хэрэг үйлдэхээс сэргийлэх нөлөөтэй байдаг бөгөөд зорилго, чиглэл тусгагдаагүй буюу төлөвлөгөөт бус эерэг үр дагаврууд ч мөн гардаг: (1) Тухайн арга хэмжээний зорилго, чиглэлийн хүрээнээс гадуурх гэмт хэрэгт нөлөөлж, бууруулах явдал юм. Үүнийг “эерэг нөлөөллийн тархалт” (diffusion of benefits) гэж нэрлэдэг (13 ба 47 дугаар алхмуудыг үзнэ үү); (2) Арга хэмжээг хэрэгжүүлж өхлэхээс өмнө гэмт хэрэг гаралтыг буруулах явдал юм. Үүнийг “урьдчилан таамаглагдсанаар үссэн эерэг нөлөө” (anticipatory benefits) гэж нэрлэнэ. Гэвч зарим тохиолдолд гэмт хэрэгтнүүд урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд авч хэрэгжүүлж буй интервенцийн талаар мэдээгүй байх магадлалтай тул урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь үргэлж хүссэн үр дүндээ хүрч чаддаггүй. Жишээлбэл, гэмт хэрэгтэн далд буюу нууцаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний улмаас баривчлагдах эрсдэл нь нэмэгдсэн гэдгийг мэдэлгүйгээр

гэмт хэрэг үйлдэх боломжтой. Учир нь тэд баригдах эрсдэл нэмэгдэж байгаагаа мэддэггүй. Эсвэл гэмт хэрэгтнүүд урьдчилан сэргийлэх арга хэмжээнд сөрөг хариу үйлдэл үзүүлж болно. Үүнд шилжилт хөдөлгөөн хийх, урт хугацаанд даасан зохицох зэрэг багтана.

- Гэмт хэрэгтэн урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс зайлсхийх, уг арга хэмжээнд өртөхгүй байхын тулд зан байдал, үйлдлээ өөрчлөх тохиолдолд “шилжилт хөдөлгөөн” (displacement) тохиолдоно. Шилжилт хөдөлгөөн нь үүсэж болзошгүй нөхцөл байдал мөн боловч түүнээс зайлсхийж болно. Үнэлгээний үр дүнгээс үзэхэд нөхцөл, шалтгаанд тулгуурласан урьдчилан сэргийлэх арга хэмжээний улмаас шилжилт хөдөлгөөн үүссэн тохиолдол байхгүй, үүссэн ч урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс үүдэх ээрэг нөлөөллийг давамгайлдаггүй байна (12 дугаар алхам).
- Дасан зохицох гэдэг нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсний дараагаар гэмт хэрэгтэн тус арга хэмжээг тойрч, шинэ арга замаар гэмт хэрэг үйлдэх явдал юм. Пол Экблом, Кэнн Пийс болон бусад судлаачид үүнийг урьдчилан сэргийлэгч болон гэмт хэрэгтний хоорондох “зэвсгийн уралдаан”-тай зүйрлэдэг. Иймээс бид урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд буурсан гэмт хэрэг өөр хэлбэр, арга замаар дахин үйлдэгдэж болзошгүй гэх хүлээлттэй байх нь зүйтэй. Гэмт хэрэгтэн үйлдсэн этгээд шинэ арга зам хайж олох, эсвэл өөр этгээд урьдчилан сэргийлэх арга хэмжээний улмаас өөрчлөгджэх буй нөхцөл байдлыг ашиглан гэмт хэрэг үйлдэх замаар дасан зохицож болно.

Дасан зохицох процессын нэг тод жишээ бол зээлийн картын залилан (доорх жишээг үзнэ үү), мөн дугуйн түгжээтэй холбоотойгоор саяхнаас үүссэн хэргүүд юм. Дугуйн хулгайчид жирийн үзгэн бал ашиглан дугуйн

түгжээг хялбархан онгойлгох боломжтой гэдгийг олж мэдсэн. Гэхдээ бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэмт хэргийн заль мэхнүүдэд ялагдаад байдаггүй. Жишээлбэл, сейфийг хүчээр онгойлгох (safecracking) хэрэг технологи хөгжих хэрээр буурсан нь байнгын үр дагавар гэж Нийл Шовер дүгнэсэн.

Зарим тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь "эсэргүүцэл" бүхий хариу үйлдлийг өдөөдөг. Гэмт хэрэгтнүүд урьдчилан сэргийлэх арга хэмжээг эсэргүүцэн сорьж, хэрэг үйлдэхээ бууруулахаас илүүтэй нэмэгдүүлж болзошгүй. Жишээлбэл, цагдаагийн алба хаагч нар тохиромжгүй цагт хүч хэрэглэх нь үймээн самуун дэгдээх эрсдэлтэй байдгийг харгалзан зөвхөн зайлшгүй шаардлагатай нөхцөлд л үймээн самууны эсрэг хэрэгсэл, өмсгөл ашигладаг (riot gear). Цагдаагийн алба хаагчид иргэдтэй шударга бус, хатуу

чанга ханддаг гэсэн ойлголт дэлгэрэх үед эсэргүүцэл нэмэгддэг, харин шударгаар хандах үед иргэд үр дүнг нь эсэргүүцэн ч хууль сахидаг гэсэн дүгнэлт бүхий судалгаа байдаг. Ерөнхийдөө эсэргүүцэл бүхий хариу үйлдлийн судалгаа цөөн байдаг хэдий ч гарч болзошгүй үр дагавар мөн гэдгийг үгүйсгэж болохгүй юм. Ялангуяа урьдчилан сэргийлэх арга хэмжээг голчлон хууль сахиулах, албадлагын арга хэмжээ авах зэргээр хэрэгжүүлдэг тохиолдолд цагдаагийн алба эсэргүүцэлтэй тулгарах эрсдэлтэй.

### Нэмэлт материал:

Ekblom, Paul. 1997. "Gearing up Against Crime: a Dynamic Framework to Help Designers Keep up with the Adaptive Criminal in a Changing World." International Journal of Risk, Security and Crime Prevention 2(4): 249–265. [Https://www.ncjrs.gov/App/publications/abstract.aspx?ID=178131](https://www.ncjrs.gov/App/publications/abstract.aspx?ID=178131).

### Гэмт хэрэгтний дасан зохицох үйлдэл ба зээлийн картын залилан

Майкл Леви болон түүний хамтрагч нар Английн Дотоод хэргийн яам (АНУ-ын Хууль зүйн яамтай төстэй чиг үүрэгтэй) болон зээлийн карт гаргагчдын хоорондын хамтын ажиллагааны үр дүнд 1990-ээд оны дундуур зээлийн картын луйврыг амжилттайгаар бууруулж чадсан тухай тайлбарлав. Тэд дэлгүүрт зөвшөөрөл шаардахгүйгээр гүйлгээ хийх дээд хязгаарыг бууруулах, шуудангаар зээлийн карт илгээх үйл ажиллагааны аюулгүй байдлыг сайжруулах зэрэг арга хэмжээ авсан байдаг. Доорх зургаас харахад кредит картын залилантай холбоотой хохирлын хэмжээ (нийт, алдагдсан ба хулгайлагдсан, шуудангаар хүлээн аваагүй) мэдэгдэхүйц буурсан байна. Гэвч сүүлийн уг хохирлын хэмжээ буцаж нэмэгдсэн. Энэ нь бусдын картын мэдээллийг ашиглан онлайн худалдан авалт хийх, кредит карт хуурамчаар үйлдэх (Зүүн Азийн зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагаатай холбоотой гэгддэг) гэмт хэрэг нэмэгдсэнтэй холбоотой.

### Зээлийн картын залилан, Их Британид



## 12. Шилжилт хөдөлгөөний онолыг үндэслэсэн эсэргүүцлийг эс харгалзах нь

**A**суудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа нь ихэвчлэн гэмт хэрэг гарах нөхцөл, шалтгааныг бууруулахыг зорьдог. Тухайлбал, орон сууцны хороололд хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд цонхны түгжээ суурилуулах эсвэл зогсоол дээр хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналтын камер суурилуулж болно. Гэмт хэрэг гарах нөхцөл, шалтгааныг бууруулах эдгээр арга зам нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бус харин гэмт хэргийг өөр газар луу шилжүүлэх үр дагавартай байдаг гэх эсэргүүцэлтэй тулгардаг. Энэхүү шилжилт хөдөлгөөний тухай онол гэмт хэргийг үндсэн таван арга замаар шилждэг гэж үздэг. Үүнд:

- Гэмт хэрэг нэг цэгээс нөгөө рүү шилжих (газар зүйн шилжилт хөдөлгөөн)
- Гэмт хэрэг нэг цаг үеэс өөр цаг үе рүү шилжих (цаг хугацааны шилжилт хөдөлгөөн)
- Гэмт хэрэг нэг байнаас өөр байруушилжих (хэргийн байн шилжилт хөдөлгөөн)
- Гэмт хэрэг үйлдэх арга өөрчлөгдөх (арга, тактикийн шилжилт хөдөлгөөн)
- Гэмт хэргийн төрөл өөрчлөгдөх (гэмт хэргийн төрлийн шилжилт хөдөлгөөн)

Дээр дурдсан таван тохиолдол тус бүрт гэмт хэрэгтэн ямар ч саад бэрхшээл тулгарсан гэмт хэрэг үйлдэхийг зайлшгүй хүсдэг гэж шилжилт хөдөлгөөний онол үздэг. Уул дүгнэлт нь "мэргэжлийн" гэмт хэрэгтэн эсвэл хар тамхинд донтсон хүмүүс амьдралын хэв маягаа хадгалахын тулд, эсвэл бэлгийн харьцаанд орох хүслийн адил гэмт хэрэг хийх хүсэл өсөн нэмэгдэж, уг хэрэгцээг хангахын тулд гэмт хэрэг үйлддэг гэх төсөөлөл, таамаглалыг үндэслэдэг. Гэмт хэрэг үйлдэгчид гэмт хэрэг үйлдэх сэтгэл зүйн хүсэл, сонирхлыг хангах ёстой гэснийг батлах нотолгоо байдаггүй, харин гэмт хэрэгтэн ямар байдлаар, хэрхэн, яаж, хаана, хэзээ гэмт хэрэг үйлдэх талаар сонголт хийдгийг нотлох олон баримт бий. Ямар ч үндэслэлтэй байсан шилжилт хөдөлгөөний онол гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлдөг сэдэл бүхий хүчин зүйл,

нөхцөл, шалтгааны ач холбогдол үгүйсгэдэг билээ (9 дүгээр алхам).

Түүнчлэн, шилжилт хөдөлгөөний онол нь давтан гэмт хэрэгтний гэмт хэрэг үйлдэх боломжид ач холбогдол өгдөггүй. Жишээлбэл, судалгаанаас үзэхэд мансуурах донтой хүмүүс мансууруулах бодисын нийлүүлэлтийн тасалдал, өөрчлөлтөд дасан зохицох чадвартай байдаг бөгөөд хэрэглээгээ нэмэгдүүлдэггүй байна. Мансууруулах бодис, хар тамхины нийлүүлэлт зогссон үед харин мансуурах донтой хүн хэрэглээгээ багасгах, эсвэл өөр орлуулах бодис хэрэглэж эхэлдэг.

Банкны дээрэмчин гэх мэт мэргэжлийн гэмт хэрэгтнүүд гэмт хэргээс тодорхой, тогтсон орлого олохыг зорьдог гэж үзэх үндэслэл байхгүй. Дээрмийн гэмт хэрэг үйлдэхэд хэцүү, эрсдэлтэй бол давтамж нь буурна, хэрэг үйлдэхэд амар хялбар бол эсрэгээрээ хэргийн гаралт нэмэгдэнэ. Банкны дээрэмчин бусад хэрэгтнүүдийн адил нөхцөл байдалдаа дасан зохицож, орлого нь гагцүү буурна гэдгийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай болно.

Хэдий тийм ч бид гэмт хэргийн шилжилт хөдөлгөөнийг үгүйсгэж болохгүй. Оновчтой сонголтын онолын дагуу шилжилт хөдөлгөөн хийх нь ашигтай байх тохиолдолд гэмт хэрэгтнүүд шилжиж хөдөлнө. Жишээлбэл, 1990-ээд оны эхээр Нью-Йорк хотын цагдаагийн газар хар тамхины гэмт хэрэг их гардаг хэд хэдэн дүүргүүдэд хар тамхитай тэмцэх ажлын хэсгийг томилсон. Энэ үед хар тамхины наймаачид хар тамхины наймаахийх байрлалаа өөрчилж, замын хажууд зогсдог байснаа орон сууцны үүдний танхим руу шилжсэн. Гэвч бусад судалгаанууд шилжилт хөдөлгөөн хийгдээгүй эсвэл хязгаарлагдмал хүрээнд хийгдсэн гэж дүгнэсэн байdag. Жишээлбэл:

- Миссуригийн Канзас хотод бууны эргүүлийг тогтмол хийснээр галт зэвсэгтэй холбоотой гэмт хэргийн тоог бууруулсан бөгөөд үүний улмаас газарзүйн аливаа шилжилт хөдөлгөөн хийгдээгүй.

- Швед улсад нэвтрүүлсэн шинэ таньж мэдэх аргачлал мөнгөний чекийн залиланг бууруулсан бөгөөд үүнтэй холбоотойгоор бусад төрлийн гэмт хэрэг нэмэгдсэн баталгаа, нотолгоо олдоогүй.
- Австралийн банкуудын аюулгүй байдал, хамгаалалтыг сайжруулах зорилтот арга хэмжээний үр дүнд банкны дээрмийн хэргийн тоог бууруулсан бөгөөд үүнтэй холбоотойгоор хүнсний дэлгүүр, шатахуун түгээх станц, бооцоот дэлгүүр, зочид будал, гудамжны дээрмийн хэрэг ихэссэн шинж тэмдэг ажиглагдаагүй.
- Виржиниа мужийн Ньюпорт Ньюс хотод орон байрны хулгай, дээрэм ихтэй хотхонуудад асуудалд тулгуурласан арга хэмжээ авч хэрэгжүүлж, орон байрны хулгай, дээрмийг бууруулж чадсан бөгөөд ойр орчмын сууцуудад хулгай, дээрмийн шинж чанартай гэмт хэрэг нэмэгдээгүй.
- Лондоны Финсбэри парк орчмын замыг хааж, эрчимжүүлсэн эргүүл хийдэг болсноор биеэ үнэлэгчид ойролцоо байрлалууд руу шилжсэн гэх баталгаа нотолгоо олдоогүй. Ийнхүү биеэ үнэлж байсан эмэгтэйчүүдэд биеэ үнэлэх зайлшгүй шаардлага байгаагүй, харин мөнгө олох харьцангуй хялбар арга байсан учир уул хэргийг үйлдэг байсан байж болзошгүй гэж судлаачид дүгнэсэн байдаг. Иймд нэхцэл байдал өөрчлөгдхөд тус эмэгтэйчүүд биеэ үнэлэхээ больсон гэж дүгнэж болохоор байна (50 дугаар алхам).
- Калифорниа мужийн Сан Диего хотод хулгай, халдлагыг таслан зогоох зорилгоор троллейбусны буудлуудыг дахин төлөвлөж, энэ төрлийг гэмт хэргийг бууруулж чадсан бөгөөд үүнтэй холбоотойгоор бусад буудлууд руу шилжилт хөдөлгөөн хийгдээгүй.

Эдгээр болон бусад олон тооны жишээнүүдэд гэмт хэрэгтэнд шилжилт хөдөлгөөн хийх нь ашиггүй байсан байж болзошгүй бөгөөд дээрх жишээнүүд шилжилт хөдөлгөөн түгээмэл тохиолддог гэх нийтлэг үзэл бодлыг үгүйсгэж байна. Энэ бол Англи, Канад, АНУ, Нидерландад хийсэн шилжилт хөдөлгөөний талаарх дөрвөн өөр судалгааны ажлын нэгдсэн дүгнэлт юм. Хамгийн сүүлд гарсан Нийдерладын судалгаанаас үзэхэд шилжилт хөдөлгөөний талаар дэлхийн дахинд

хийгдсэн 55 судалгааны 22-т нь шилжилт хөдөлгөөн хийгдсэн эсэхийг нотлох баримт олдоогүй буюу хийгдээгүй гэж үзсэн. Үлдсэн 33 судалгаанд шилжилтийн талаар нотлох баримт олдсон боловч зөвхөн зарим хэргүүд шилжиж хөдөлсөн байна. Шилжиж хөдөлсөн гэмт хэргийн тоо урьдчилан сэргийлэгдсэн гэмт хэргээс цөн байжээ. Мөн шилжилт хөдөлгөөний улмаас гэмт хэрэг нэмэгдсэн тохиолдолд илрээгүй байна.

Шилжилт хөдөлгөөн хязгаарлагдмал байдгийн учир гэмт хэрэгтнүүд бүгд хурдан дасан зохицож чаддаггүйд оршино. Гэмт хэрэгтнүүд хийхэд харьцангуй хялбар гэдгийг нь харгалzan газар, цаг хугацаа, бай, арга зам, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд тохиолдохоос сэргийлж буй гэмт хэргийн төрлөөр шилжиж хөдлөх магадлал өндөр болов уу. Иймд шилжилт хөдөлгөөнийг хийхэд хяр хялбар гэдэгт тулгуурлан гэмт хэрэгтний хийж болзошгүй шилжилт хөдөлгөөнийг таамаглах боломжтой тул үүнийг урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй. Хэрвээ эдгээрийг төлөвлөгөөнд тусгах боломжгүй бол боломжит шилжилт хөдөлгөөнийг илрүүлэхийн тулд зохих хяналтыг тавих хэрэгтэй.

Нэгтгэн дүгнэхэд шилжилт хөдөлгөөний эрсдэлд үргэлж байх ч үүнээс сэргийлэх боломжтой. Шилжилт хөдөлгөөн үүссэн ч тухайн хэрэг бүрэн шилжихгүй бөгөөд гэмт хэрэг үйлдэх нэхцэлийг бууруулж урьдчилан сэргийлэх нь гэмт хэргийг баагайх хэмжээгээр бууруулдаг билээ.

#### **Нэмэлт материал:**

Hesseling, Rene. 1994. "Displacement: A Review of the Empirical Literature." In vol. 3 of Crime Prevention Studies, edited by Ronald V. Clarke. Monsey (New York): Criminal Justice Press. [Http://www.popcenter.org/library/crimeprevention/volume\\_03/07\\_hesseling.pdf](http://www.popcenter.org/library/crimeprevention/volume_03/07_hesseling.pdf).

## Шилжилт хөдөлгөөн үүссэн гэх маргааныг хянаж үзэхэд үндэслэлгүй байх нь олонтоо

1980-аадоны дундуур судлаач Жон Экк Ньюпорт Ньюс (Виржиниагийн) –ийн цагдаагийн хэлтсийн хүрээнд хэргийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой маргааныг ажиглажээ. Гудамжны марихуанагийн зах руу чиглэсэн арга хэмжээний үр дүнд тухайн орчны хар тамхи худалдаалдаг газрууд хаагдсан бөгөөд зарим цагдаагийн албаныхны дүгнэснээр тус гэмт хэрэгтнүүд үйл ажиллагаагаа зогсоосон гэхээс илүүтэй ойролцоо, зэргэлдээх байршуулуд руу шилжиж хөдөлсөн аж. Гэхдээ бусад цагдаагийн алба хаагчид доорх чухал нөхцөл байдлыг илрүүлжээ. Үүнд:

- Ойролцоо захын худалдаачид марихуана биш героин зарж байсан.
- Героини захаас марихуанагийн худалдаачид олдоогүй.
- Героиний зах нь харьцангуй жижиг юм байна.
- Героиний зах марихуанагийн зах нээгдэхээс өмнө оршин тогтнож байжээ.

Гэмт хэргийн шилжилтийн талаарх дээрх маргаан нь сонгомол ойлголттой холбоотой байж болзошгүй. Марихуаны худалдаанаас өмнө бусад хар тамхины захууд олон нийтийн анхаарлыг төдийлөн татдаггүй байсан. Иймээс хар тамхины худалдаа нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд чухал байр суурь эзэлдэггүй байсан боловч олон нийтээс марихуанагийн эдгээр захуудын талаар гардасны үр дүнд цагдаагийн алба хар тамхины бусад захуудад анхаарал хандуулдаг болсон.

# 13. Аливаа арга хэмжээнээс үүдэх эерэг үр дүн тархах эсэхийг үнэлэх

ГЭМТ ХЭРГИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ СУДАЛСАН СУДЛААЧИД ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ЭСРЭГ ҮР ДАГАВАР ҮҮСДЭГ ГЭДГИЙГ ОЛЖ ИЛРҮҮЛЖ БАЙСАН. АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДАГАВАРТ ГЭМТ ХЭРЭГ ӨӨР ГАЗАР, ЦАГ ХУГАЦАА РУУ ШИЛЖИХ ХӨДӨЛСӨН ГЭХЭЭС ИЛҮҮТЭЙ БУСАД ТӨРЛИЙН БУЮУ ТУХАЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОРИЛТ, ЧИГЛЭЛЭЭС ГАДУУРХ ГЭМТ ХЭРЭГ БУУРСАН ГЭЖ ДҮГНЭЖЭЭ. ХЭДИЙ СҮҮЛИЙН ҮЕИЙН ОЛОЛТ, ДҮГНЭЛТ Ч ЭНЭ ТАЛААР ОЛОН ЖИШЭЭ ДУРДАЖ БОЛНО.

Үүнд:

- Висконсины Их Сургуулийн номын санд номыг цахим шошготой болгосноор номын хулгай багассан. Ийм шошгогүй видео кассет болон бусад материалыг хулгайллах гэмт хэрэг мөн буурчээ.
- Нью-Жерсигийн хямдралтай цахилгаан барааны дэлгүүрийн агуулахад тооллого хийж эхэлснээр ажилчид хулгай хийх нь буурснаас гадна тооллогод хамрагдаагүй барааны хулгай мөн буурсан.
- Ложак тээврийн хэрэгслийн хяналтын системийг зургаан том хотод нэвтрүүлснээр хулгайн хэрэг зөвхөн төхөөрөмжийг суулгасан автомашины хувьд төдийгүй хотын бүх автомашины хулгай буурчээ.
- Темпл Их Сургуулийн Саймон Хаким болон түүний хамт олон Филадельфийн ойролцоо чинээлэг оршин суугчдын сууцад хулгайн дохиолол суурилуулсан нь хулгайн гэмт хэргийн гаралтыг тухайн дүүргийн хэмжээнд бууруулсан гэдгийг харуулсан.
- Шотландын томоохон Стратклид хотын зарим уулзвар улаан гэрлийн камер суурилуулснаар зөвхөн эдгээр байршилд төдийгүй ойр орчмын гэрлэн дохионуудад гарах зөрчил буурсан (жижигхэн хотын оршин суугчид аль уулзварт камер суурилуулсныг олж мэдэх боломжтой тул энэ өөрчлөлт удаан хугацаанд үргэлжлэхгүй болов уу).
- Их Британийн Кирхолт дахь нийтийн орон сууцны хороололд удаа дараа

хулгайд өртөж байсан байшингуудад нэмэлт хамгаалалт суурьшуулснаар зөвхөн тус байшингууд төдийгүй бусад байшингуудын хулгайн хэрэг буурсан.

Эдгээр нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд бий болж буй эерэг үр дүнгийн тархалтын жишээ юм. Гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээд урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжиж эхэлсэн гэдгийг мэддэг боловч түүний хамрах хүрээний талаар сайн мэддэггүй. Тэд урьдчилан сэргийлэх арга хэмжээг газар байршил, цаг хугацаа, бай зэргийн хувьд өргөн хүрээ хамарсан тул гэмт хэрэг үйлдэхэд шаардагдах хүчин чармайлт, эрсдэл нэмэгдсэн гэж үздэг аж (бодит нөхцөл байдалд хамрах хүрээ нь хязгаарлагдмал байж болно). Өөрөөр хэлбэл аливаа арга хэмжээнээс үүдэлтэй эерэг нөлөөллийн тархалт гэмт хэргийн шилжилт хөдөлгөөнтэй ижил хэлбэр, замаар дамждаг байна (доорх хүснэгтийг үзнэ үү).

Эерэг нөлөөллийн тархалт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга барилын ач холбогдлыг нэмэгдүүлдэг боловч уг нөлөөг хэрхэн санаатайгаар сайжруулах талаар бид сайн мэдэхгүй. Нэлэөллийг нэмэгдүүлэх нэг боломж олон нийтэд сурталчлах явдал байж болно. Хэдхэн автобусанд суулгасан хяналтын камерын бичлэгийг олон нийтэд сурталчилснаар үр дагавар нь Английн хойд хэсгийн нийт 80 автобусанд нөлөөлж тархсан байдаг. Сурагчдын автобусанд үйлдэсэн зүй бус үйлдэл, хэрэг зөрчил, эвдлэн сүйтгэх үйлдлийг камерт бичиж, тус автобусыг сургуулиудаар аялуулж бичлэгийг бусад сурагчдад харуулсан бөгөөд уул бичлэгийг үндэслэн хийсэн баривчилгааг мэдээллийн хэрэгслээр олон нийтэд өргөнөөр танилцуулсан.

**Орон сууцны хулгайн гэмт хэргийн шилжилт хөдөлгөөн болон эерэг нөлөөллийн тархалт**

<b>Төрөл, хэлбэр</b>	<b>Тодорхойлолт</b>	<b>Шилжилт хөдөлгөөн</b>	<b>Үр дүнгийн тархалт</b>
Газар зүйн	Газар зүйн өөрчлөлт	Өөр барилга руу шилжих	Зорилтот болон эргэн тойрны орон байрны хулгайн хэргийг бууруулах
Цаг хугацааны	Цаг хугацааны өөрчлөлт	Өдөр биш шөнө үйлдэх	Өдөр ба шөнийн цагт орон байрны хулгайг бууруулах
Бай	Бай өөрчлөгдөх	Нийтийн орон сууцнаас хувийн орон сууц руу шилжих	Нийтийн болон хувийн орон байрны хулгайн хэргийг бууруулах
Арга замын	Арга зам өөрчлөгдөх	Цоожгүй байшингаас цоожтой байшин руу шилжих	Цоожтой болон цоожгүй байруудын халдлагыг бууруулах
Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн төрөл өөрчлөгдөх	Орон байрны хулгайгаас ердийн хулгай руу шилжих	Орон байрны хулгай ба бусад төрлийн хулгай буурах

Гэмт хэргийг үйлдэхэд хүлээх эрсдэл, шаардагдах хүчин чармайлт гэмт хэрэгтний бодсон хэмжээнд нэмэгдээгүй гэдгийг олж мэдсэн тохиолдолд эерэг нөлөөллийн тархалт хумигдаж болзошгүй. Судалгаанаас үзэхэд Их Британид согтуурлын түвшин хэмжигчийг хэрэглэх эхэн үед баривчлагдах эрсдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор согтуугаар автомашин жолоодох тохиолдол төлөвлөж байснаас их хэмжээгээр буурчээ. Гэвч жолооч нар автомашиныг зогсоох эрсдэл багасаагүй гэдгийг мэдсэн даруйд согтуугаар автомашин жолоодох явдал буцаад нэмэгдэж эхэлсэн байна. Өөрөөр хэлбэл урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд баривчлагдах эрсдэл, эсвэл гэмт хэрэгүйлдэхэд шаардагдах хүчин чармайлт хэдий хэмжээнд нэмэгдсэн талаар гэмт хэрэгтнүүдэд мэдэгдүүлэхгүйн тулд цагдаагийн алба шинэ арга зам тогтмол боловсруулах шаардлага үүсэж болзошгүй.

Практикийн хувьд, эерэг нөлөөллийн тархалт нь гэмт хэргийн шилжилт хөдөлгөөнд тулгуурлан урьдчилан сэргийлэх арга


хэмжээг нэвтрүүлэхийг эсэргүүцэх тохиолдолд хэрэглэх үндэслэл юм. Та ийм нөхцөл байдалтай олон удаа тулгарах болно. Түүнчлэн арга хэмжээг үнэлэхдээ эерэг нөлөөллийн тархалтыг тооцоололдоо тусгах нь чухал юм. Үүнийг хийх арга замуудыг 51 дүгээр алхамд ойрын болон холын гэсэн хоёр хяналтын бүс ашиглан тайлбарласан. Эс бөгөөс гэмт хэрэг ерөнхийдөө буурсан гэх үндэслэлээр хүмүүс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг үгүйсгэж болзошгүй билээ.

**Нэмэлт материал:**

Clarke, Ronald V., and David Weisburd. 1994. "Diffusion of Crime Control Benefits: Observations on the Reverse of Displacement." In vol. 2 of Crime Prevention Studies, edited by Ronald V. Clarke. Monsey (New York): Criminal Justice Press. [Http://www.popcenter.org/library/crime-prevention/volume\\_02/08clarke.pdf](http://www.popcenter.org/library/crime-prevention/volume_02/08clarke.pdf).

## Их сургуулийн автомашины зогсоол дахь хяналтын камер болов эерэг нөлөөллийн тархалт

Англи улсын Суррэй их сургуульд харуул хамгаалалтын газрын шинэ дарга их сургуулийн автомашины зогсоолд гараад байсан хулгайн хэргийг бууруулахын тулд видео хяналтын систем нэвтрүүлэхээр шийдэж, зогсоолын багана дээр хяналтын камер суурилуулжээ. Зурагт үзүүлснээр 1-р зогсоолын харагдах байдалд барилга байшин хаалт болсон учраас бүх дөрвөн зогсоолыг камерт тусгаж, адилхан хянах боломжгүй байлаа.



Иймд хэрэв камер нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөтэй бол түүний тусгалд буй зогсоолд нөлөөлөх байсан болов уу. Түүнчлэн уул камерын улмаас тусгалд ороогүй зогсоол руу гэмт хэрэг шилжин хөдөлж болзошгүй гэж таамаглаж болох байсан. Гэвч хяналтын камер суурилуулсны дараах жилд зогсоолын талбайд өмч хөрөнгийг эвдэн сүйтгэх, хулгайн гэмт хэрэг 50 хувиар буюу 138-аас 65 болж буурсан билээ. Бусад гурван зогсоолын адилаар камерын тусгалд ороогүй 1 дүгээр зогсоолын талбайн гэмт хэргийн гаралт мөн буурсан. Видео хяналтын энэхүү эерэг нөлөөллийн тархалт нь гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүд их сургуулийн зогсоолын талбайд камерын систем нэвтрүүлсэн гэдгийг мэдсэн ч түүний тусгалын талаар мэдэхгүй байсантай холбоотой байж болзошгүй. Их сургуулийн зогсоол руу очиж, эрсдэл хүлээж, хүчин чармайлт гарган хэрэг үйлдэх нь хэт зардалтай гэж хэрэгтнүүд үзсэн байж болзошгүй юм.

Эх сурвалж: Poyner, Barry. 1997. "Situational Prevention in Two Parking Facilities." In *Situational Crime Prevention: Successful Case Studies*, 2nd edition, edited by Ronald V. Clarke. Guilderland (New York): Harrow and Heston.

# ГЭМТ ХЭРГИЙН АСУУДАЛ, НӨХЦӨЛИЙГ СУДЛАХ НЬ

## 14. Асуудлыг тодорхойлохдоо “CHEERS” сорилыг хэрэглэх нь

**A**суудал гэж нийгэмд давтан гардаг хоорондоо харилцан хамаарал бүхий бөгөөд олон нийтээс цагдаагийн байгууллагыг шийдвэрлэхийг шаарддаг хоруу нөлөөтэй үйл явдал, тохиолдлыг хэлнэ. Энэ тодорхойлолт асуудлын зургаан элементийг агуулсан болно:

- олон нийт буюу хүмүүс (community)
- аюул хөнөөл, хоруу нөлөө (harm)
- шаардлага, хүлээлт (expectation)
- үйл явдал (event)
- давтагдах шинж чанар (recurrence)
- ижил төстэй байдал (similarity) буюу англиар “CHEERS” гэж товчилно.

### 1. Олон нийт буюу хүмүүс (community):

Олон нийтийн зарим бүлгүүд (бүгд байх шаардлагагүй) хоруу нөлөөтэй тохиолдолтой тулгарч байх ёстой. Олон нийт гэдэгт хувь хүн, бизнес эрхлэгчид, төрийн байгууллагууд болон бусад бүлгүүд багтана.

### 2. Гэмт хэрэг, аюул хөнөөл (harm):

Хүн, хуулийн этгээд асуудлын улмаас хохирох буюу асуудлын хоруу нөлөөнд өртөх ёстой. Хоруу нөлөө гэдэгт өмч хөрөнгийн гэмтэл, бие махбодын гэмтэл, амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохирох, эсвэл цагдаагийн үйл ажиллагаанд садаа учруулах (жишээлбэл хуурамч дуудлагууд гэх мэт) зэрэг багтана. Хууль бус байх нь гэмт хэрэг, асуудал бэрхшээлийг тодорхойлох шинж чанар биш бөгөөд хуультай нийтэй хэдий ч зарим асуудлыг цагдаагийн үйл ажиллагаагаар шийдвэрлэх шаардлагатай байж болно. Тухайлбал, хууль, журмын дагуу явуулж буй үйл ажиллагааны дуу чимээний улмаас тухайн бус нутгийн оршин суугчид гомдол мэдүүлэх нь элбэг тохиолдоно. Зарим асуудлыг хууль бус хэмээн мэдүүлдэг боловч үнэндээ хуультай нийтэй байх боломжтой бөгөөд хэрэв тухайн мэдүүлэг “CHEERS” сорилыг

хангаж байвал түүнийг асуудал гэж үзнэ.

### 3. Шаардлага, хүлээлт (expectation)

Нийгмийн зарим булэг цагдаагийн байгууллагыг тухайн асуудлыг шийдвэрлэхийг шаардах ёстой (тэдний тоо их биш байх албагүй). Олон нийтээс ийм шаардлага тавьж байгаа гэж үндэслэлгүйгээр таамаглах нь буруу бөгөөд уул үндэслэл нь иргэдийн дуудлага, олон нийтийн уулзалт, хэвлэлийн мэдээ болон бусад арга хэрэгслээс илт байх ёстой. Энэхүү элементийн хүрээнд цагдаагийн алба нь асуудал, түүний учир шалтгаан, шийдлийг олон нийтийн тодорхойлсноор хүлээн зөвшөөрөх шаардлагагүй. Олон нийт асуудлын учир шалтгаан, онцлогийг буруугаар тодорхойлсон байж болзошгүй бөгөөд эдгээрийг тодорхойлох нь шинжээчийн үүрэг юм.

### 4. Үйл явдал (events)

Та асуудлыг үүсгэж, бурдүүлж буй үйл явдлын төрөл, хэлбэрийг тайлбарлах чадвартай байх нь зүйтэй. Асуудал нь салангид үйл явдлаас бүрдэх бөгөөд үүнд орон гэрт хууль бусаар нэвтрэн орох, нэг хүн нөгөө хүнээ нудрах, цохих, чанга дуу чимээ гаргах, бэлгийн харилцаанд орох зорилгоор мөнгө солилцох зэрэг багтана. Ихэнх үйл явдал богино хугацаанд өрнөдөг ч луйвар зэрэг хэрэгт урт хугацаа шаардлагатай байж болно.

### 5. Давтагдах шинж чанар (recurrence)

Эдгээр үйл явдлууд нь олон дахин давтагдана. Давтагдах шинж чанар нь хурц эсвэл архаг асуудлын шинж тэмдэг юм. Хурц асуудал гэнэт илэрдэг - тухайлбал автомашинтай холбоотой хэрэг цөөн тоогоор гардаг байсан дүүрэгт гэнэт нэмэгдэж хурцдах тохиолдол үүнд хамаарна. Ямарваа хариу арга хэмжээ авахгүй байх тохиолдолд зарим хурц асуудал өөрөө замхран арилдаг бол бусад нь хүндэрч,

архаг асуудал болж хувирдаг. Энэ шалтгааны улмаас хурц асуудал хүндрэх эрсдэлтэй эсэхийг үнэлэх шаардлагатай. Архаг асуудал нь удаан хугацааны туршид үргэлжилдэг. Жишээлбэл, олон жилийн турш нэг гудамж дагаж үргэлжилдэг биеэ үнэлэх хэрэг гэх мэт. Архаг асуудал өөрөө шийдэгдэггүй тул хариу арга хэмжээ авах шаардлагатай.

## 6. Ижил төстэй байдал (similarity)

Олон дахин давтагдах үйл явдлууд нь нэгэн ижил хүн үйлддэг, ижил төрлийн хохирогчтой, ижил байрлал, нөхцөлд гардаг, ижил зэвсэг хэрэглэдэг, эсвэл өөр нэг ба түүнээс дээш нийтлэг шинж чанартай байх шаардлагатай. Нийтлэг шинж чанаргүй бол асуудал биш, харин хоорондоо харилцан хамааралгүй үйл явдлууд төдий юм. Гэмт Хэргийн Нэгдсэн Тайланд ашигладаг гэмт хэргийн ангиллуудыг үүнд хэрэглэх нь зохимжгүй. Жишээлбэл, машины хулгай гэдэгт машины сэлбэгийг худалдаж ашиг олох, автомашиныг унах, экспортлох зорилгоор автомашин хулгайлах, өөр хэрэгт ашиглахаар автомашин хулгайлах зэрэг хэргүүд багтдаг. Иймд машины хулгайн хэргүүд нь ганц асуудал биш буюу хэд хэдэн асуудал байж болно. Үүнийг тодорхойлоход нэмэлт мэдээлэл шаардлагатай бөгөөд асуудлыг тухайн хэргийн хэв маягаас хамааруулан тодорхойлох нь зүйтэй - тухайлбал, нэг ижил зорилгоор аль нэг дүүрэгт микро автобус хулгайлж буй нь нэг асуудал юм.

Аливаа нэг мэдээлэл, өгөгдлөөс шалтгаалан үйл явдал хор хөнөөлтэй эсэхийг тогтоох боломжтой байдаг тул асуудлыг нарийн нягталж үзэх шаардлагатай (6 ба 15 дугаар алхмуудыг үзнэ үү). "CHEERS" нь тандах (scanning) үе шатанд дараах зургаан асуултанд хариулахыг зөвлөдөг. Үүнд:

1. Асуудалд хэн өртөж байна вэ?
2. Асуудлын үүсгэж буй хоруу нөлөө юу вэ?
3. Цагдаагийн албанаас юу шаардаж байна вэ?
4. Ямар төрлийн үйл явдал асуудлыг бүрдүүлж байна вэ?
5. Эдгээр үйл явдлуудын давтамж юу вэ?
6. Үйл явдлууд нь хоорондоо төстэй юу, нийтлэг шинж чанарууд нь юу вэ?

Цагдаагийн албад мэдүүлсэн мэдүүлэг бүр асуудал биш байж болох бөгөөд асуудал мөн эсэхийг тодорхойлоход танд "CHEERS" сорил тусална. Асуудал гэх ойлголтыг бид өдөр тутамдаа ашигладаг утгаар бус, харин асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаанд ашиглагддаг утгаар хэрэглэж байгаа тул асуудал гэж тодорхойлогдоогүй байсан ч цагдаагийн алба хаагчийн оролцоо шаардлагатай зүйлс байж болно. Үүнд:

- **Бие даасан, ганц үйл явдал:** Хариу арга хэмжээ авсан эсэхээс үл хамааран өөр ижил төстэй үйл явдал тохиолдох магадлал бага бол хэчнээн ноцтой байсан ч бие даасан, ганц үйл явдлыг мөрдөн байцаалтын ажиллагаа эсвэл цагдаагийн бусад үйл ажиллагаагаар шийдэж болох ч асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд шийдвэрлэх боломжгүй. Учир нь ийм төрлийн үйл явдалд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь ач холбогдолгүй юм.
- **Бус нутаг:** Хотын төв, орон сууцны хороолол гэх мэт жижиг газруудыг асуудал гэж үзэх нь түгээмэл ч ихэнх тохиолдолд биш байдаг. Эсрэгээрээ эдгээр газруудад хэд хэдэн асуудалтай байдаг бөгөөд эдгээр нь хоорондоо харилцан хамааралтай байж болно. Хэдий тийм ч бүхэл бүтэн нэг бус нутгийг нэг асуудал гэж үзэх нь түүнийг шийдвэрлэх үлажиллагааны нарийн төвөгтэй байдал, хүндрэл, шийдвэрлэхэд шаардагдах хүчин чармайлтыг нэмэгдүүлэхээс гадна ийнхүү тодорхойлсон асуудалд үр дүнтэй шийдэл олох боломжийг бууруулдаг. Үүний оронд та тус бус нутагт үүсэж буй асуудлуудыг тодорхойлж, тус тусад нь шийдвэрлэх хэрэгтэй. Хэрэв асуудлууд хоорондоо харилцан хамааралтай бол (жишээлбэл, гудамжны зохион байгуулалтын улмаас хэд хэдэн асуудал үүсэхэд нөлөөлдөг) тус хамаарлыг үүсгэж буй холбоосыг шийдвэрлэх нь зүйтэй. Асуудлууд нь орон зайн хувьд ойролцоо байгаа учраас хоорондоо харилцан хамааралтай гэж дүгнэж болохгүй. Зарим тохиолдолд салангид асуудлуудыг нэг шийдлийн хүрээнд шийдвэрлэж болно. (6 дугаар алхмыг үзнэ үү).

- **Төлөв байдал (status condition):** Хичээл тасалж буй сурагч, уйдсан өсвөр насын хүүхэд, орон гэргүй эсвэл ажилгүй хүн, гэм буруутай нь тогтоогдсон хэрэгтнийг хичээлээ тасалсан, хийх зүйлгүй, ажилгүй, гэм буруутай гэж тогтоогдсон зэрэг төлвөөс нь хамаарч асуудал гэж үзэх нь буруу юм. Олон нийтийн зүгээс цагдаагийн албыг тэдгээрт чиглэсэн арга хэмжээ авахыг шаарддаг боловч хор хөнөөл, үйл явдал гэсэн элементүүдийг агуулаагүй тул тэдгээр нь асуудал биш юм.

Уг этгээдүүд хэргийн бай, хэрэг үйлдэгч зэрэг хэлбэрээр асуудалд тодорхой нэг үүрэг гүйцэтгэх боломжтой ч тэд өөрсдөө асуудал биш билээ. Аливаа зүйлийг тэдгээрийн төлөв байдлаас нь хамааруулан асуудал гэж тодорхойлох явдал нь асуудалд дутуу, дулимаг хандаж байгаагийн илрэл юм. Төлөв байдлын нь илүү томоохон асуудлыг бүрэлдэхүүн хэсэг байж болно.

Аливаа асуудлыг тодорхойлохдоо CHEERS сорилыг хэрэглэхийг буюу дээр дурдсан зургаан элементийг агуулж байгаа эсэхийг шалгахыг зөвлөе. Хэрвээ зургаан элементийг агуулаагүй бол асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд шийдвэрлэх нь тохиромжгүй болов уу.

# 15. Танд ямар төрлийн асуудал тулгарсан болохыг тодорхойлох

**Ц**агдаагийн алба хаагч нар "CHEERS" сорилыг (14 дүгээр алхам) хангасан олон тооны асуудал дээр ажилладаг учраас бид эдгээрийг ангилах аргачлалыг боловсрууллаа. Ангиллын энэхүү аргачлал нь танд асуудлыг тодорхойлох, төстэй боловч өөр асуудлуудыг хооронд нь ялгахад тус болно. Түүнчлэн өмнө шийдвэрлэгдэж байсан ижил төстэй асуудлыг танд тулгарсан асуудалтай харьцуулах боломжийг бүрдүүлж, хянан шалгах хүрээ, чиглэлийг тодорхойлоход тань тус болно. Жишээлбэл, нийтлэг тулгардаг асуудлуудыг шийдвэрлэхтэй холбоотой зөвлөмжүүдийг Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны алба, А тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны төвийн цахим хуудаснаас унших (19 дүгээр алхам) боломжтой. Мөрдөн шалгаж буй асуудлынхаа төрлийг тодорхойлох нь өөрт хэрэгтэй удирдамж, зөвлөмжийг олоход тань мөн тусална (эдгээр удирдамж, зөвлөмж нь танд тулгарсан асуудалтай шууд холбоотой биш байсан ч). Ангиллын аргачлал нь хоёр шалгуурт сууринласан билээ: асуудал үүсэж байгаа орчин болон оролцогчдын зан төлөв (энэхүү ангиллын аргачлал нь 8 дугаар алхамд дурдсан чоно, нугас, ичээ гэсэн ангиллаас ялгаатай. Чоно, нугас, ичээ ангилал нь олон дахин давтагдаг гэмт хэргүүдийг ангилах аргачлал юм).

**Хэргийн орчин:** Орчин нь хэргийн боломжит бай, мөн оролцогч нар ямар үйлдэл хийх боломжтой болох, тухайн байршлыг хэн удирдахыг зохицуулдаг. Орчныг тодорхойлох нь асуудал үүссэн болон үүсээгүй орчинг харьцуулах боломжийг бүрдүүлдэг. Орчин нь асуудал шийдвэрлэхэд чухал үүрэгтэй байж болох эзэмшигчтэй байдаг (44 дүгээр алхмыг үзнэ үү). Цагдаагийн үйл ажиллагааны хамгийн түгээмэл асуудал 11 төрлийн орчинд хамаарч болно. Үүнд:

- Орон сууц.** Хүмүүс амьдардаг газрууд. Байшин, орон сууц, зочид буудлын өрөөнүүд гэх мэт. Хэдийгээр ихэнх нь суурин газарт байдаг ч цөөхөн хэсэг нь чөлөөт цагаа өнгөрөөх машин, вагончик гэх мэт хөдөлгөөнт объектууд байна.

- Амралт зугаалгын орчин.** Хүмүүс чөлөөт цагийг зугаатай өнгөрүүлэх зорилгоор очдог газрууд. Баар, шөнийн цэнгээний газар, ресторан, кино театр, тоглоомын талбай, далаан эрэг, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт.
- Оффисууд.** Албан байгууллагын оффисыг хэлнэ. Төрийн болон бизнесийн байгууллагууд ихэвчлэн энэ төрөлд багтана. Эдгээр байршилд нэвтрэх эрх ихэвчлэн хязгаарлагдмал байдаг.
- Жижиглэн худалдаа эрхлэгчид, дэлгүүрүүд.** Үйлчлүүлэгчдийн ирж мөнгөн гүйлгээ хийдэг газрууд. Үүний жишээ бол дэлгүүр, банк юм.
- Аж үйлдвэрийн газрууд.** Бараа бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх газрууд. Бэлэн мөнгөний гүйлгээ нь эдгээр орчинд тийм ч гол байр суурийг эзлэхгүй бөгөөд олон нийтийн хөдөлгөөн багатай. Үйлдвэрүүд, агуулахууд, савлагаа ангилах байгууламжууд нь гэх мэт.
- Хөдөө аж ахуй.** Газар тариалан эрхлэх газар, тариан талбай, мал аж ахуйн фермууд гэх мэт.
- Боловсрол.** Сурах эсвэл суралцах газар. Өдөр өнжүүлэх газар, асрамжийн газар, сургууль, коллеж, их дээд сургууль, номын сан, мөргөлийн газар гэх мэт.
- Хүмүүст чиглэсэн үйлчилгээний газар.** Ямар нэгэн асуудал, хүндрэл тулгарсан үед хүмүүсийн очдог газар. Жишээ нь шүүх, шорон, хорих анги, цагдаагийн газар, эмнэлэг, хар тамхины эмчилгээний төв гэх мэт.
- Нийтийн замууд.** Бусад бүх орчныг холбосон замууд. Зам, хурдны зам, явган хүний зам, дугуйн зам, авто зам, зогсоол зэрэг гэх мэт.
- Тээвэр.** Хүмүүсийг тээвэрлэх газрууд. Үүнд автобус, автобусны буудал ба метро,

онгоц ба нисэх онгоцны буудал, галт тэргэн дотор эсвэл галт тэрэгний буудал, гарал болон усан онгоцны зогсоол, далайн хөлөг онгоц дотор, хөлөг онгоцны зогсоол орно.

11. **Нээлттэй/завсрын бүс.** Тогтсон зориулалтгүй газар. Эдгээр цэцэрлэгт хүрээлэнгүүдээс ялгаатай нь амралт зугаалгын зориулалтаар зориулагдаагүй боловч хүмүүс үүнийг ашиглах боломжтой. Завсрын бүсэд орхигдсон үл хөдлөх хөрөнгө, барилгын талбай зэрэг багтана.

**Зан төлөв:** зан төлөв бол асуудлыг ангилах хоёр дахь шалгуур юм. Зан төлөвийг тодорхойлох нь аюул хөнөөл, сэдэл, санаа зорилго, гэмт хэрэгтэн-бай хоорондын харилцаа зэргийг дэлгэрүүлэн тодорхойлоход тусална. Зан төлөвийн зургаан үндсэн төрөл байна. Үүнд:

- Түрэмгийлж гэмт хэрэг үйлдсэн.** Гэмт хэрэгтэн нь хохирогчоос илт ялгаатай, хохирогч нь гэмт хэрэгтний үйлдлийг эсэргүүцдэг. Ихэнх гэмт хэргүүд энэ ангилалд багтдаг. Тухайлбал дээрэм, хүүхдийн хүчирхийлэл, дээрэм, дээрэлхэх, хулгай гэх мэт.
- Харилцан зөвшлилжэж гэмт хэрэг үйлдсэн.** Оролцогч талууд санаатайгаар, сайн дураараа харилцаанд ордог. Энд ямар нэг байдаар гүйлгээ хийгддэг. Тухайлбал хар тамхины худалдаа, биеэ үнэлэлт, хулгайн эд зүйлс худалдаалах гэх мэт. Гэхдээ биеэ үнэлэгчид рүү халдах нь түрэмгийллийн ангилалд багтахыг анхаарна уу.
- Зөрчилдөөний төрлийн гэмт хэрэг.** Харилцан адил эрхтэй, өмнө харилцаанд орж байсан этгээдүүд хооронд үүссэн зөрчил. Насанд хүрэгчдийн дунд үүсэх гэр бүлийн хүчирхийллийн зарим хэлбэр энэ төрөлд багтдаг ч хүүхэд, өндөр настнуудын эсрэг хүчирхийлэл үйлдэх нь түрэмгийлэх төрөлд багтана.
- Соёлгүй байдал.** Гэмт этгээдүүдийг хохирогчдоос ялгах боломжтой бөгөөд тухайн этгээдийн үйлдсэн хэрэг олон үүнд хөнгөн хохирол учруулдаг. Чанга дуу

чимээ шуугиан үүсгэх зэрэг замаар олон нийтийнамартайванбайдлыг алдагдуулах боловч эд хөрөнгө, бие махбодод ноцтой хохирол, гэмтэл учруулахааргүй төрлийн асуудал энэ ангилалд багтана (дуу чимээ ихтэй үдэшлэг гэх мэт). Энэ ангилалд вандализм буюу нийтийн, хувийн өмч, хөрөнгийг эвдэж гэмтээх хэрэг багтаж эсэх нь тухайн хэргээс хамаарах бөгөөд вандализмыг зарим хэрэг түрэмгийллийн шинж чанартай байх боломжтой. Соёлгүй байдал бүхий зарим хэргүүд үйлдэгдсэн орчноосоо үл хамааран төвөгтэй, хүндрэлтэй байж болно.

- Хайхрамжгүй, санаатай бус байдлаар өөрт болон бусдад хохирол учруулах.** Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон хохирогч нь нэгэн ижил хүн байх, эсвэл гэмт хэрэгтэн хохирогчийг хохирох зорилгогүйгээр үйлдсэн хэрэг багтана. Амиа хорлох оролдлого, мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэх, тээврийн хэрэгсэлд осолдох зэрэг нь жишээ юм.
- Цагдааг зүй бусаар ашиглах.** Цагдаагийн албад үндэслэлгүй шаардлага тавих хэргүүд үүнд багтана. Худал мэдүүлэг өгөх, өөрсдөө шийдвэрлэж болох асуудлын талаар удаа дараа дуудлага хийх нь үүний жишээ юм. Энэ төрөл нь зан төлөвийн шинж чанартай холбоотой эцсийн төрөл юм. Үүнд бусад төрлийн тодорхойлолтод багтаагүй хэргүүд багтаж бөгөөд уул төрөлд багтсан хэргүүдээс үүдэх хохирол нь дан цагдаагийн нөөц, хүчиний зарцуулалт юм.

Доорх хүснэгтэд ангилал хийх хүснэгтийг харуулав. Аливаа асуудлыг тус хүснэгтийн харгалзах багана, мөрийн огтоллцох нүдэнд оруулж ангилна. Жишээлбэл, 2001 оны Тиллий шагналын (Tilley Award) эзэн пабуудын эргэн тойронд гарсан архи, дарсны шилтэй холбоотой гэмтлийн буюу зөрчилдөөн-амралт зугаалга бүхий асуудлыг (A) судалсан. Сан-Диегогийн цагдаагийн алба хаагчид хүнсний дэлгүүрт гэмт хэргийн бүлэглэлийн заналхийлэлд өртсөн гэх хуурамч дуудлага бүхий асуудлыг (B) шийдвэрлэсэн. Энэ нь Техас мужийн Плано хотын насанд хүрээгүй хүүхдүүдэд архи худалддаг дэлгүүр бүхий 2003 оны Голдштейн шагналын дэд байрт

шалгарсан асуудлаас (C) ялгаатай билээ. 2002 оны Голдштейн шагналын эзэн нь цагаач фермерүүдийн авто тээврийн осолтой холбоотой хайхрамжгүй байдлаас шалтгаалсан хохирол-нийтийн зам ангилал бүхий асуудлыг (D) авч үзсэн. 1999 оны Голдштейн шагналын эзэн нь хог хаягдал, орон гэргүй хүмүүсийн буюу олон нийтийн зам/соёлгүй байдал бүхий асуудлыг авч үзсэн (E). Хар тамхины наймаа (F) болон хар тамхины наймаачдын хоорондох маргаанаас үүдэлтэй дээрэм/өшөө авалтын хэргүүдийн (G) хоорондох ялгааг авч үзье. Эдгээр нь хоорондоо давхцаж байгаа боловч өөр асуудлууд юм.

Хэдийгээр ихэнх асуудлууд нэг нүдэнд багтдаг ч заримдаа асуудал зан төлөвийн эсвэл орчны хэд хэдэн ангиллын тодорхойлолтод таарч болно. Жишээлбэл Стафффордшайр (Английн)-ийн Цагдаагийн албандаа тулгарсан асуудлыг авч үзье. Энэ нь барилгын ажлын замын дагуух орхигдсон барилгуудыг жагсагчид эзэлснээр үүссэн асуудал юм. Орчны хувьд нээлттэй, завсрын бус ангилалд багтаж буй. Зан төлөвийн хувьд соёлгүй үйлдэл, мөн барилгуудыг эзлэх үйлдэл, арга замаас шалтгаалан хайхрамжгүй байдлаар өөрт болон бусдад хохирол учруулах ангилалд (хүснэгтэд Н-ээр тэмдэглэсэн) буюу зан

төлөвийн хоёр ангилалд багтаад буй. Ийм байдлаар асуудлыг хэд хэдэн ангилалд оруулж болох ч оновчгүй байдал үүсгэх эрсдэлтэй.

Асуудлыг ийнхүү ангилснаар цагдаагийн байгууллагууд ижил орчин, зан төлөв бүхий асуудлуудыг шийдвэрлэхээр зорьж буй асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааг хооронд нь харьцуулж үзэх боломжтой. Эдгээр асуудлууд нийтлэг шийдэл, эсхүл бэрхшээлтэй юу? Энэ төрлийн асуудалд хамаарах дүн шинжилгээ, хариу арга хэмжээ нь бусад асуудлаас юугаараа ялгаатай вэ? Ийм төрлийн асуултуудад хариулах нь асуудал шийдвэрлэх болон асуудалшийдвэрлэхсургалтуудыг сайжруулж, янз бүрийн ангилал, төрлийн асуудлуудад ямар шийдэл тохиромжтой талаарх бидний ойлголтыг сайжруулахад хэрэгтэй юм.

#### Нэмэлт материал:

Eck, John, and Ronald V. Clarke. 2003. "Classifying Common Police Problems: A Routine Activity Approach." In *Theory for Practice in Situational Crime Prevention*, edited by Martha Smith and Derek Cornish. Vol. 16 of *Crime Prevention Studies*. Monsey (New York): Criminal Justice Press. [Http://www.popcenter.org/library/crimeprevention/volume\\_16/](http://www.popcenter.org/library/crimeprevention/volume_16/).

Цагдаагийн албандаа түгээмэл тулгардаг асуудлыг ангилах хүснэгт					
Орчин	Зан төлөв				
	Түрэмгийнээл	Харилцан зөвшлилжэж үйлсэн	Зөрчилдөөн	Соёлгүй байдал	Хайхрамжгүй байдлаар өөрт болон бусдад хохирол учруулах
Орон сууцны бус					
Амралт чөлөөт цагийн бус			A		
Оффис					
Жижиглэн худалдаа		C			B
Аж үйлдвэрийн					
Хөдөө аж ахуйн					
Боловсролын					
Хүнд чиглэсэн үйлчилгээ					
Олон нийтийн замын	G	F		E	E
Тээврийн					
Нээлттэй/шилжилтийн бус			H	H	

# 16. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХ ЗОРИЛГООР ТУУЛАХ ЗАМЫГ СУДЛАХ НЬ

**А**суудалд дүн шинжилгээ хийх гурвалжин (алхам 8) нь гэмт хэргийн үндсэн гурван элементийг тодорхойлсон хэдий ч гэмт хэрэгтэн байг хэрхэн сонгодог болохыг тайлбарладаггүй. Маркус Фэлсоны үзэж байгаагаар тэд үүнийг гурван үндсэн замаар хийдэг.

1. Хохирогчийн хувийн мэдээллээр (танай хөршийн хүүхдийн хэлснээр танай гэр хээээ эзгүй байдгийг мэдэж болно)
2. Ажлаар дамжуулан (холбооны инженерээр ажилладаг хулгайч таныг ирэх долоо хоногт аялна гэдгийг сонссон байж болзошгүй)
3. Давхардсан "амьдралын орон зайд"-аар дамжуулан.

"Амьдралын орон зайд"-н ойлголт нь Канадын орчны криминологич Пэт, Пол Брантингхэм нарын (зураг харна уу) боловсруулсан гэмт хэргийн хэв маягийн онолд гол байр суурийг эзэлдэг. Тэд гэмт хэрэгтнүүд өдөр тутмын амьдралынхаа явцад дараагийн байгаа хэрхэн сонгодгийг дээрх ойлголтыг ашиглан тайлбарладаг. Гурвалжныг ашиглан судлаачид гэрээсээ ажил руугаа, ажлаасаа амралт зугаалга руу шилжих гэмт хэрэгтнүүдийг авч үздэг. Гэмт хэрэгтэн нь энэ гурван байршилийн эргэн тойрон, тэдгээрийг холбох зам дагуу (түүнийг таних газраас бусад) гэмт хэрэг үйлдэх боломжийг эрэлхийлдэг байна. Гэмт хэрэгтнүүд мэдэх орчноосоо бага зэрэг хазайх боломжтой ч төдийлөн холддоггүй. Учир нь гэмт хэргийг өөр газар, байршилаас илүүтэй байнга зорчдог газар, замын дагуу үйлдэх нь хялбар байдагт оршино.

Судлаачид мөн "зааг, хязгаар" гэсэн нэр томьёог хэрэглэдэг. Энэ нь хүмүүсийн амьдардаг, ажилладаг газар, зочилдог дэлгүүр, амралт чөлөөт цагаа өнгөрөөдөг газрын зааг, хязгаарыг илэрхийлж буй юм. Тус зааг, хязгаарт бие бие таньдаггүй хүмүүс цуглардаг учраас арьс өнгөөр ялгavarлан гадуурхах, дээрэмдэх, дэлгүүрээс хулгай хийх зэрэг гэмт хэрэг гарах магадлал өндөр байдаг. Судлаачдын хийсэн анхны

судалгаагаар Флоридагийн Таллахасси хотод орон сууцны хулгайн гэмт хэрэг баян чинээлэг дүүрэг ядуу дүүрэгтэй хиллэдэг газар буюу зааг, хязгаарт их тохиолдох хандлагатай байдгийг тогтоожээ. Тэдний тайлбарласнаар чинээлэг дүүрэг нь ядуу дүүргийн хулгайч нарын сонирхлыг татахуйц байсан ч тус дүүргийг сайн мэдэхгүй, тэнд амьдардаггүй гэдэг нь мэдэгдэх эрсдэлтэй байсан учраас хулгайч нар зааг, хязгаарыг давж хулгай хийдэггүй байжээ. Түүнчлэн гэмт хэрэгтнүүд баян чинээлэг дүүргийн зааг, хязгаарыг давж хулгай хийвэл хулгайлсан эд зүйлсээ илүү хол зайд тээвэрлэх шаардлага үүсэж, улмаар баригдах эрсдэл нэмэгдэх нь нөлөөлсөн байж болзошгүй.

Хүмүүсийн өдөр тутмын амьдралынхаа явцад зорчдог зам, амьдардаг газар, байршил нь хохирогч болох эрсдэл, мөн гэмт хэргийн хэв маягийг тайлбарладаг. Ийм учраас Брантингемс болон бусад гэмт хэргийн хэв маягийн судлаачид гэмт хэргийн газарзүйн тархалт, амьдралын өдөр тутмын хэмнэлд анхаарлаа хандуулдаг байна. Жишээлбэл, эдгээр судлаачид гэмт хэргийн зураглалыг өдөр, долоо хоногийн өөр өөр цагуудад гаргаж, тодорхой төрлийн гэмт хэргийг зорчигчдын урсгал, сургуулийн цаг, дэлгүүрийн ажлын хуваарь эсвэл хүмүүсийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой бусад хуваарьтай давхцуулж, харьцуулдаг байна. Халаасны, дэлгүүрийн хулгайчид хүн ихтэй газар хайдаг бол бусад гэмт хэрэгтнүүд хүнгүй орчин эрэлхийлнэ. Тухайлбал ажлын цаг эхэлж, хүмүүс ажил руугаа зорчих үед орон байрны хулгайч нар эсрэгээрээ орон сууцны бүсүүд рүү аялна. Орой, амралтын өдрийдээр ажилчид гэр лүүгээ буцахад хулгайчид ажлын газрууд шилжинэ.

Гэмт хэргийн байршил ихэвчлэн тухайн гэмт хэрэгтний гэрээс нэг, хоёр милийн зайд оршдог гэдгийг олон судалгаа харуулж байна. Жишээлбэл, Их Британийн хамгийн том цагдаагийн хэлтэс нэг Вест Мидлендсийн гэмт хэргийн шинжээч Энди Брумвелл хоёр жилийг хамарсан 258,074 гэмт хэрэг дүн шинжилгээ хийж, дараах дүгнэлтийг гаргажээ. Үүнд:

- Судалгаанд хамрагдсан гэмт хэргийн тал орчим хувь нь тухайн этгээдийн гэрээс нэг миль хүрэхгүй зйтай байжээ (АНУ-ын хувьд хүн амын нягтрал бага, тээврийн хэрэгслийн хүртээмж их зэргээс шалтгаалан энэ зай илүү хол байж болзошгүй)
- Гэмт хэргээсээ хамааран туулсан зайд нь харилцан адилгүй байв. Жишээлбэл, дэлгүүрийн хулгайчид бусад төрлийн гэмт хэрэг үйлдэгчдээс илүү хол явах хандлагатай байдаг.
- Эмэгтэйчүүд эрчүүдээс илүү хол аялдаг байсан ба энэ нь олон дэлгүүрээс хулгай хийсэнтэй холбоотой байж болзошгүй.
- Гэмт хэрэг үйлдэгчдийн гэмт хэрэг үйлдэх зорилгоор туулсан зам харилцан адилгүй байв. Зарим нь амьдарч буй орчиндоо гэмт хэрэг үйлддэг, бусад нь (ялангуяа хам хэрэгтэнтэй байх тохиолдолд) илүү хол замыг туулдаг.
- Бага насны хүүхдүүд гэмт хэрэг үйлдэхдээ гэрийнхээ орчинд, харин хориод насны гэмт хэрэгтнүүд хамгийн хол зайд туулж гэмт хэрэг үйлддэг байв.

Канзас мужийн Оверланд Парк хотын гэмт хэргийн шинжлэх Сюзан Вернике 2000 онд Калифорния муж улсын Сан Диего хотод болсон Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн гэмт хэргийн газрын зургийн үндэсний бага хуралд 18 насанд хүрээгүй хүүхдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулав. Тэрээр Оверланд Паркд баривчлагдсан 11 настай хүүхдүүд гэрээсээ дунджаар 1.5 милийн зайд гэмт хэрэг үйлддэг болохыг харуулсан. Нас ахих тусам энэ зайд аажмаар нэмэгдэж, 17 нас хүрэхэд 2.7 миль болжээ. Тэрээр энэ өсөлтийг автомашины хүртээмж нэмэгдсэнтэй холбон тайлбарлав.

### Гэмт хэрэг үйлдэх зам болон өөрийгөө хязгаарласан байдлын үзүүлэлт

Энди Брумвелл аливаа бүс нутгийн гэмт хэргийн хэдэн хувийг тухайн бүс нутагт амьдарч буй этгээд үйлдсэн нийгхаруулдаг "өөрийгөө хязгаарласан байдлын үзүүлэлт"-ийг боловсруулсан байдаг. 100 гэсэн утга нь аливаа бүс нутгийн бүх гэмт хэргийг тухайн бүс нутагт амьдардаг гэмт хэрэгтнүүд үйлдсэн болохыг илэрхийлэх бол 0 гэсэн утга нь тухайн бүс нутгийн бүх гэмт хэргийг өөр бүс нутагт амьдардаг гэмт хэрэгтэн үйлдсэн болохыг илэрхийлнэ. Аливаа асуудалд дүн шинжилгээ хийхдээ энэ үзүүлэлтийг тооцоолох хэрэгтэй бөгөөд түрэмгийллийн шинж чанартай хэргийг тухайн бүс нутгийн гэмт хэрэгтэн эсвэл өөр бүс нутгийн гэмт хэрэгтэн үйлдсэн эсэхээс хамааран урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах нь зүйтэй. Жишээлбэл, аливаа хорооллын замыг хаах нь гэмт хэрэгтнүүдийн олонх нь тус хороолол руу автомашинаар нэвтэрдэг бол илүү үр дүнтэй байна.

Та өөрийн харьяаллын нутаг дэвсгэрт гарч байгаа гэмт хэргийг ойлгохын тулд гэмт хэргийн хэв маягийн онолын зарчмыг ашиглах боломжтой. Та хэргийн газар байршил, замнал, зааг хязгаарыг илрүүлж олох замаар гэмт хэрэгтэн, гэмт хэргийн хэв маягийг холбохыг хичээх хэрэгтэй. Та дүн шинжилгээгээ гэмт хэрэгтэн гэмт хэргийг хэрхэн хайж олдог болон санамсаргүйгээр олох хоёрын хоорондох ялгааг тогтоохоос эхэлж болно. Та гэмт хэрэгтнүүд хаана байдаггүй бөгөөд байдаг, гэмт хэрэг төвлөрөл өндөр бүхий газар, байршлын хаана цуглардаг болон түүний учир шалтгааныг судлах нь зүйтэй (17 дугаар алхам). Бүс нутгийн гэмт хэргийн хэв маяг нь түүх өгүүлдэг гэдгийг та олж мэдэх болно. Орон нутгийн гэмт хэргийн байдлыг судалснаар гэмт хэрэг их гардаг дүүргүүдэд гэмт хэрэг огт гардаггүй хэсэг, гудамж байдаг, мөн эсрэгээрээ бусад газар, гудамжинд нь гэмт хэрэг хамгийн их тохиолддог гэдгийг олж мэдэх болно. Тухайн газрын оршин сууучид аль гудамжинд гэмт хэрэг их гардаг, аль хэсэгт гэмт хэрэг бага гардгийг сайн мэддэг. Оршин сууучид

гудамжны нэг тал нь нөгөөгөөсөө илүү их гэмт хэрэг гардаг гэдгийг мэддэг тул хаагуур зорчихоо мэддэг. Хэрэв оршин суугчид мэдэж байгаа бол та яагаад олж мэдэж болохгүй гэж? Гэмт хэргийн хэв маягийн онол нь үүнд туслах бөгөөд задлах үе шатанд асуудлыг тодорхойлох, дун шинжилгээний үе шатанд учир шалтгааныг ойлгоход хэрэгтэй.


Felson, Marcus. 2002. *Crime and Everyday Life*. Thousand Oaks (California): Sage.

Wiles, Paul, and Andrew Costello. 2000. *The Road to Nowhere: The Evidence for Travelling Criminals*. Home Office Research Study no. 207. London: Home Office. [Http://www.popcenter.org/tools/offender\\_interviews/pdfs/wilescostello.pdf](http://www.popcenter.org/tools/offender_interviews/pdfs/wilescostello.pdf).

### Нэмэлт материал

Brantingham, Patricia, and Paul Brantingham. 1993. "Environment, Routine, and Situation: Toward a Pattern Theory of Crime." In *Routine Activity and Rational Choice*, edited by Ronald V. Clarke and Marcus Felson. Vol. 5 of *Advances in Criminological Theory*. New Brunswick (New Jersey): Transaction.

#### Брантингамын боловсруулсан гэмт хэргийн дүр зургийн онол



Брантингхэмийн онолыг илэрхийлэхийн тулд Ким Россмо энэхүү диаграммыг бэлтгэсэн. Энэ нь гэмт хэрэгтний үйл ажиллагааны (амьдралын) орон зайд (оршин суух, ажил, амралт, тэдгээрийн хоорондох аяллын маршрут), гэмт хэрэгтэн ихэвчлэн гэмт хэрэг үйлдэггүй тухайн этгээдийн гэртэй ойр орчны бус (буфер бус), таван бай (жишээлбэл, зогсоол) зэргийг харуулдаг. Гэмт этгээдийн үйл ажиллагааны (амьдралын) орон зайд байтай огтлолцсон тохиолдолд гэмт хэрэг түлхүү гардаг. Энэ жишээнд гэмт хэрэг үйлдэгчийн ажлын байрны эргэн тойронд ямар ч гэмт хэрэг гарахгүй гэдгийг анхаарна уу, учир нь тэнд тохиромжтой байх байхгүй. Мөн гэмт хэрэг гардаггүй хоёр газар байгаа нь гэмт хэрэгтэн тус газар, байршлын талаар мэддэггүйтэй холбоотой.

Эх сурвалж: Rossmo, Kim. 2000. *Geographic Profiling*. Boca Raton (Florida): CRC Press.

# 17. ГЭМТ ХЭРГИЙН ӨНДӨР ТӨВЛӨРӨЛ БҮХИЙ ГАЗАР, БАЙРШИЛ ХЭРХЭН ҮҮСДЭГИЙГ ОЛЖ МЭДЭХ

Шинжээчид ихэвчлэн гэмт хэргийн төвлөрөл өндөр бүхий газар, байршлыг зөвхөн газарзүйн тусламжтайгаар судалж үздэг. Энэ нь зөв эхлэлийн цэг байж болох ч ийм төрлийн газар, байршлыг багасгах эсвэл арилгахад тухайн газар яагаад гэмт хэргийн өндөр төвлөрөлтэй болохыг ойлгож, илүү гүнзгий судлах хэрэгтэй. Бид ийм газар, байршлыг үүсгэдэг үйл явцын талаарх ойлголтыг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж, танилцууллаа. Дараа нь 23, 55 дугаар алхмуудад бид зураглалын программ хангамжид найдахгүйгээр гэмт хэргийн төвлөрөл өндөр бүхий газар, байршлыг хэрхэн шинжилж, зураглахыг судлах болно. Өмнөх алхмуудад бидний харсанчлан жижиг газар буюу газрууд нь олон асуудлыг ойлгож, үр дүнтэй хариу арга хэмжээ авахад чухал үүрэгтэй. Тиймээс бид энэ алхамд ийм газар, байршилд анхаарлаа хандуулна. Дараа дараагийн алхмуудад бид гэмт хэргийн төвлөрөл өндөр бүхий газар, байршил болох гудамж, бус нутгийг судлахын тулд энэ ойлголтоо ашиглах болно.

Гурван төрлийн ийм газар, байршил байдаг бөгөөд тус бүр өөрийн гэсэн шалтгааны механизмтай байдаг:

**1. Гэмт хэрэг үүсгэгч** (crime generator place) нь гэмт хэргийн сэдэлтэй холбоогүй шалтгаанаар олон тооны хүмүүсийг өөртөө татдаг газар юм. Гэмт хэрэгтэнд олон боломж нөхцөлийг олгож, цаг хугацаа болон орон зайны хувьд бай, гэмт хэрэгтнүүдийг давхцуулах нь гэмт хэрэг, зөрчлийг өдөөдөг. Гэмт хэрэг үүсгэгч газруудад худалдааны төв, тээврийн газрууд, баяр наадам, спортын арга хэмжээ багтана. Гэмт хэрэг үүсгэгч газарт олон тооны хэрэг гардаг нь голчлон тухайн газарт олон тооны бай цуглардагтай холбоотой билээ.

**2. Гэмт хэрэгт татагч** (crime attractor place) нь гэмт хэрэгтнүүдийн сайн мэддэг гэмт хэргийн олон боломж бүхий газар юм. Гэмт хэргийн сэдэл бүхий хүмүүс ийм газарт татагддаг. Богино хугацаанд гэмт хэрэг үйлдэгчид тухайн бус нутгаас биш гаднаас ирж болох боловч урт хугацаандаа тус гэмт хэрэгтнүүд өдгээр бус рүү шилжин суурьшдаг.

Биеэ үнэлэлт, хар тамхины наймаа явагддаг газруудыг жишээ болгон дурдаж болно. Зарим зугаа цэнгэлийн газрууд үүнд багтана. Ийм газруудыг зөвхөн тухайн бус нутгийнхан л мэддэг байж болох ч тэдгээр газруудын нэр хүнд өсөхийн хэрээр гэмт хэрэг үйлдэгсийн тоо нэмэгдэж, улмаар гэмт хэрэг, эмх замбараагүй байдлын тоо нэмэгдсээр байна.

**3. Гэмт хэрэг үйлдэх боломж олгох нөхцөл** (crime enabler) нь зан төлөвийн зохицуулалт багатай газар тохиолддог: нийтийн хэв маягийг сахиулах хууль, журам байхгүй эсвэл хэрэгжүүлдэггүй газрууд юм. Авто зогсоолын харуул хамгаалалтыг сулруулах нь авто зогсоолын дундуур сэлгүүцэх боломжийг нэмэгдүүлж, улмаар машины хулгайг нэмэгдүүлэхэд хүргэдэг. Энэ бол байрлалын менежментийн огцом өөрчлөлтийн жишээ юм. Заримдаа байрлалын менежмент нь цаг хугацааны явцад өөрчлөгджэй, хэрэг зөрчлийн тоог аажмаар нэмэгдүүлэхэд хүргэдэг. Зохицуулагч, хамгаалагчийн систем суларч эхлэхэд гэмт хэрэг үйлдэх боломж нэмэгдэнэ. Жишээ нь эцэг, эх тоглоомын талбайд хүүхэдтэйгээ хамт байх үед хүүхдээ харж хамгаалахын (хамгаалагч) зэрэгцээ хүүхдээ буруу үйлдэл хийхээс сэргийлдэг (зохицуулагч). Хэрвээ эцэг эх хүүхдээ хүмүүжүүлэх арга барил өөрчлөгджэй, хараа хяналтаа бууруулах тохиолдолд хүүхдүүд гэмт хэрэгт өртөх, гэмт хэрэгтэн болох магадлал нэмэгддэг.

Патрисия, Пол Брантингхэм нар зарим газар гэмт хэргийн хувьд саармаг буюу гэмт хэрэгтэн, бай татдаггүй, хяналт сайтай байж болно гэж үздэг. Эдгээр газар, байрлал нь харьцангуй бага гэмт хэрэг гарах, гэмт хэрэг нь тодорхой хэв маяггүй байх хандлагатай. Энэ шалтгааны улмаас гэмт хэргийн хувьд саармаг газар, байрлал нь цагдаагийн анхаарлыг бага татдаг. Хэдийгээр ийм саармаг газруудад гэмт хэргийн дүн шинжилгээ хийх шаардлага бага ч бусад газар, байрлалуудтай харьцуулах боломжийг бүрдүүлдэг учраас харьцуулалтын чухал ач холбогдолтой. Гэмт хэргийн хувьд саармаг газар, байрлалыг гэмт хэрэг их гардаг

газруудтай харьцуулснаар гэмт хэргийн үүсгэгч газар орон, гэмт хэргийг татагч газар орон, гэмт хэрэг үйлдэх боломж олгодог нөхцөл зэрэг газруудад хүндрэл бэрхшээл үүсгэдэг ялгааг олж, тодорхойлоход хэрэгтэй. Ийм зорилгоор нөхцөл байдлын хяналтын судалгааг хийх нь зүйтэй. (32 дугаар алхам).

Нэгтгэн дүгнэвэл гэмт хэрэг, хэрэг зөрчлийн өндөр төвлөрөл бүхий газар, байршил нь ерөнхийдөө өртөгч, байн тоо хэмжээ нэмэгдсэн, гэмт хэрэгтнүүдийн ашиглах боломж, нөхцөл нэмэгдсэн, эсвэл тухайн газар, байрлалд авч хэрэгжүүлэх хяналт, хараа хяналтын түвшин багассанаас болж үүсдэг. Ихэвчлэн энэ гурван шалтгаан бүгд тодорхой үүрэг гүйцэтгэдэг. Жишээ нь шинэ зам бий болсонтой холбоотойгоор дэлгүүрээр худалдан авагчдын тоо нэмэгдэж болно. Улмаар үүнийг дагаж гэмт хэрэгтнүүд хулгай хийх шинэ боломжийг ашигласнаар хулгайн тохиолдол нэмэгдэхэд хүргэдэг. Тухайн газарт тодорхой нэггэмт хэрэг үйлдэгдсэнээр бусад гэмт хэрэгтнүүдийг шинээр татаж болно. Гэмт хэрэг нэмэгдсэнээр дэлгүүрээр худалдан авагчдын тоог бууруулахад хүргэж болно. Гэвч энэ нь өөр нэг нөлөө үзүүлнэ. Энэ нь бизнесийн нөөц багасах үед газар, байрлалын менежментийг бууруулж болно. Иймээс гэмт хэргийн өдөөгч газар нь гэмт хэргийн татагч газар, байрлал болж хувирах, улмаар гэмт хэргийн боломж нөхцөлийг бүрдүүлэгч болж хувирна.

Бид тодорхой нэг газар, байрлалд эдгээр механизмуудын аль нь үйлчилж байгаа эсэхийг оношлохын тулд гэмт хэргийн тоо, баримтыг харьцуулах хэрэгтэй. Боломжит гэмт хэргийн бай, өртөгчийн тоогоор гэмт хэргийг хувааж харьцааг тооцож болно (27 дугаар алхам). Үүнийг ихэвчлэн 100 бай, өртөгч тутам дахь гэмт хэргийн тоогоор илэрхийлнэ. Иймээс жишээ нь нэг машины зогсоолын талбайд нэг жилд 15 удаа машины хулгайн гэмт хэрэг гардаг, тухайн зогсоол нийт 150 машины багтаамжтай бөгөөд байнга дүүрэн байдаг бол машины хулгайн зөрчлийн харьцаа 15/150 буюу 0.1 байна. Энэ нь нэг жилд зогсоол тутамд 10 зөрчил гардаг гэсэн үг юм. Хэрвээ зогсоол нь бүрэн хүчин чадлаараа ажилладаг тохиолдолд энэхүү дүн шинжилгээ ач холбогдолтой болохыг анхаарна уу. Хэрвээ ихэнх өдрийдэд 50 машин байрладаг бол хэргийн харьцаа тоо гурав

дахин нэмэгдэнэ (нэг жилд машин тутамд 15/5=3 эсвэл 30 зөрчил гардаг гэсэн үг).

1-р зурагт тоо, хэмжээ эсвэл харьцаа ашиглаж байгаа эсэхээс хамаарч хэргийн төвлөрөл өндөр бүхий газар, байршлын ач холбогдлын эрэмбэ үүсэж буй ялгааг харууллаа. А байрлал нь тоо, хэмжээгээрээ хамгийн өндөр төвлөрөлтэй боловч хэргийн харьцаагаараа хоёрт эрэмбэлэгдэнэ. С байрлалын хувьд тоо хэмжээнээс хувь хэмжээ рүү шилжүүлэн үзэхэд гуравдугаар байрлалаас нэгдүгээр байрлал руу шилжинэ.

Халуун цэгийн механизм тоо болон хувь хэмжээний хослолыг хэрхэн бүрдүүлж байгааг харцаа. Гэмт хэргийн үүсгэгч газар (crime generator place)-т олон гэмт хэрэг гардаг хэдий ч боломжит байн тоо өндөр тул хэргийн харьцааны хувьд доогур эрэмбэлэгдэнэ (1 дүгээр хүснэгтийн А байрлал, цэг). Гэмт хэргийн татагч газарт (crime attractor place) мөн олон гэмт хэрэг гардаг бөгөөд эдгээр газруудад харьцаангуй цөөн боломжит бай байдаг учраас гэмт хэргийн харьцаа өндөр (В байрлал, цэг) байна. Гэмт хэргийн боломж нөхцөлийг бүрдүүлэгч (crime enabler) цэгүүдэд хяналт сүл байдаг тул хүмүүс тус газарт цуглараад байдаггүй. Гэхдээ тус газарт цугларсан цөөн тооны боломжит бай нь өндөр хүлээдэг. Иймээс цөөн гэмт хэрэг гардаг боловч гэмт хэргийн харьцаа өндөр газар, байршлыг гэмт хэргийн нөхцөл боломжийг бүрдүүлэгч (crime enabler) гэж үзэх боломжтой (С цэг). Эцэст нь гэмт хэргийн хувьд саармаг байрлалуудад гэмт хэргийн тоо хэмжээ, хэргийн харьцаа бага байна (D цэг). 2 дугаар хүснэгтэд энэхүү харилцааг харуулав.

Тоо болон хэргийн харьцааны утга нь чухал биш боловч харьцуулалт хийхэд чухал үүрэгтэй. Мөн олон механизмууд үйлчилж байж болно. Хяналт бага байдал (боломж олгогч, enablers) гэмт хэрэгтнүүдийг ихээр татаж болно. Гэсэн хэдий ч ийм харьцуулалт нь цаашдын хяналт шалгалтын талаар таамаглал дэвшүүлж, хэрэгжүүлэхэд хэрэгтэй үзүүлэлт болдог (20 дугаар алхам). Энэхүү дүн шинжилгээ нь үр дүнтэй байж болох хариу арга хэмжээнүүдийн төрлийг тодорхойлоход тусална. Үүнийг 3 дугаар хүснэгтэд харуулав.

### Нэмэлт материал:

Brantingham, Patricia, and Paul Brantingham. 1995. "Criminality of Place: Crime Generators and Crime Attractors." European Journal on Criminal Policy and Research 3(3):1–26.

Хүснэгт 1. Тоо ба хэргийн харьцаа				
Цэг, газар, байрлал	Гэмт хэрэг	Бай	Хувь хэмжээ	100 бай тутамд
A	148	1,795	,082	8
B	341	898	,350	35
C	117	243	,481	48
D	28	638	0,44	4

Хүснэгт 2. Хэргийн өндөр төвлөрөл бүхий газрын механизмыг оношлон тогтоох нь:		
	Тоо хэмжээ	Хувь хэмжээ
Гэмт хэргийн үүсгэгч байрлал	Өндөр	Бага
Гэмт хэрэгт татах байрлал	Өндөр	Өндөр
Гэмт хэргийн нөхцөл бүрдүүлэгч	Бага	Өндөр
Гэмт хэргийн саармаг цаг	Бага	Бага

Хүснэгт 3. Өндөр төвлөрөл бүхий хэргийн газрын нөхцөл байдал хүндрэх үед авах арга хэмжээ			
Газар, байршлын төрөл	Учир шалтгаан	Хариу ага хэмжээний төрөл	Хариулах асуултууд
Гэмт хэргийг үүсгэгч байрлал	Хамгаалалтгүй олон бай цуугларах	Хамгаалалтыг нэмэгдүүлэх хэрэгтэй.	Ямар нөхцөлд бай өртөмтгий boldog вэ? Өртөмтгий байдал хэрхэн өөрчлөгдөх боломжтой бэ?
Гэмт хэрэгт татагч байрлал	Гэмт хэрэгтнийг татах	Гэмт хэрэгтнүүд цуугларах нөхцөлийг арилгах	Гэмт хэрэгтнийг юу татдаг бэ? Үүнийг хэрхэн өөрчлөх бэ?
Гэмт хэргийн нөхцөл бүрдүүлэгч	Хараа хяналт сулрах	Хамгаалалт, зохицуулалт, менежментийн системийг сэргээх	Хэн хяналт тавих бэ? Хяналтыг хэрэгжүүлэхийн тулд тэдгээрийг хэрхэн дэмжих бэ?

# 18. 80-20 дүрэмд хамаарах эсэхийг судлах

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал зарчим бол гэмт хэрэг нь тодорхой хүн, газар, эд зүйл дээр төвлөрдөг явдал юм. Иймд гэмт хэргийн гаралт ихтэй цэг, байрлалд цагдаагийн хүч, нөөцийг төвлөрүүлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр өгөөжийг сайжруулна. Энэхүү төвлөрөл нь зарим нэр томъёоны хэрэглээг нэмэгдүүлж байна. Үүнд:

- Давтан гэмт хэрэгтэн:** Вольфгангийн алдартай Филадельфиийн бүлэгт судалгаанд хамрагдсан нийт гэмт хэрэгтнүүдийн 5 орчим хувь нь гэмт хэргийн 50 гаруй хувийг үйлдсэн.
- Давтан хохирогчид:** Британийн Гэмт хэргийн судалгаанаас үзэхэд давтан хохирогчид (нийт хохирогчдын дөнгөж 4 гаруй хувь нь) судалгаанд бүртгэгдсэн гэмт хэргийн 40 хувьд өртөж байсан (29 дүгээр алхмыг үзнэ үү).
- Хэргийн өндөр төвлөрөл бүхий газар, байршил:** энэхүү ойлголтыг алдаршуулсан судалгаанд Лоурэнс Шерман болон түүний хамтран судлаачид Минneapolis дахь хаяг, байршуудын 6 хувь нь нийт цагдаагийн дуудлагын 60 орчим хувийг эзэлж байгааг тогтоосон.
- Өртөмтгийй байнууд:** Хурдны замын хулгайн гэмт хэргийн мэдээллийн хүрээлэнгээс гаргасан жилийн тайлан мэдээллээс үзэхэд зарим загварын автомашины хулгайн хэрэг бусад машинтай харьцуулахад 30 дахин их байдаг (31 дүгээр алхмыг үзнэ үү).
- Эрсдэлтэй байгууллагууд.** Массачусетс мужийн Данверс хотод 78 дэлгүүрийн гурав нь (5 хувь) цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хулгайн гэмт хэргийн 55 хувийг эзэлж байж (28 дугаар алхмыг үзнэ үү).

Төвлөрлийн энэхүү зарчим нь гэмт хэрэг, зөрчилд өвөрмөц бус бөгөөд бусад салбарт үүсдэг түгээмэл үзэгдэл юм. Үүнийг зүйрлэвэл Дэлхийн гадаргуугийн багахан хувьд ихэнх амьтад амьдардаг. Дэлхий дээр маш олон удаагийн газар хөдлөлтүүд явагддаг боловч цөөн хэд нь маш их гэмтэл, хохирол учруулдаг. Дэлхийн хүн амын маш очижүүхэн хувь нь ихэнх баялгийг эзэмшиж

байдаг. Цагдаагийн албан хаагчдын маш бага хувь нь ихэнх баривчилгааг гүйцэтгэдэг.

Энэ үзэгдлийг 80-20-ийн дүрэм гэж нэрлэдэг бөгөөд аливаа үйлдэгчийн 20 хувь нь нийт үр дүнгийн 80 хувийг үүсгэсэн байдаг. Бодит байдалд яаг 80, 20-ийн харьцаатай байдаггүй ч энэ дүрэм үйлчилдэг нь үнэн билээ. Хүснэгтэд энэ дүрмийн тоон үзүүлэлтийг харуулав. Энэхүү хүснэгтэд Флоридагийн Жаксонвиллэд судлаач Стаси Бэллэдин 55 барилгын компанийн хүрээнд хийсэн барилгын талбайн хулгай, орон байрны хулгайн талаар хийсэн дүн шинжилгээг харуулсан. Барилгачдын 11 нь (ойролцоогоор 20 хувь нь) 2004 оны 1 дүгээр сараас 9 дүгээр сарын барилгын талбайд гарсан хулгай, дээрмийн гэмт хэргийн 85 хувийг Жексонвиллийн Шерифийн хэлтэст мэдэгджээ.

Тиймээс аливаа асуудлыг судлах, тодорхойлоходоо 80-20 дүрэм үйлчилж байгаа эсэхийгүргэлжасууж, тодруулж байх хэрэгтэй. Энгийн зургаан үе шаттай аргачлалаар үүнд хэрхэн хариулахыг харууллаа.

- Хүмүүс, газар, бүтээгдэхүүнийг тэдгээрт харгалзах үр дүнгийн тооны хамт жагсаах
- Үр дүнгийн хувьд ихээс бага руу эрэмбэлнэ.
- Хүн, газар, бүтээгдэхүүн тус бүртэй холбоотой үр дүнгийн нийт үр дүнд эзлэх хувь хэмжээг тооцоолно. Хүснэгтэд хулгай, дээрмийн гэмт хэрэг 386 байна. Эдгээр хэрэг зөрчлийн 60 (15.5 хувь) нь Барилгачин 1-н эзэмшлийн барилгын талбайд гарсан байна.
- Хамгийн их оролцоотой хүн, газар, бүтээгдэхүүнээс (эсвэл энэ жишээнд байшин барилгачид) эхлэн үр дүнгийн хувь хэмжээг нэмж хуримтлуулна.
- Хүмүүс, газар эсвэл бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмж хуримтлуулна (бидний жишээн дээр 5-р баганад байгаа байшин барилгачдын хуримтлуулан тооцсон хувь хэмжээ).
- Хүмүүс, газар эсвэл бүтээгдэхүүний нийт хувийг (5-р багана) үр дүнгийн нийт хувьтай (4-р багана) харьцуулна. Энэ

нь асуудалд хамгийн их өртдөг, үр дүн гаргадаг хүмүүс эсвэл газрууд асуудалд хэр их нөлөөлж байгааг харуулна.

Ийм төрлийн тооцоолол нь тандах үе шатанд урьдчилан сэргийлэх ажлыг удирдан чиглүүлэхэд маш их тус болно. Жэксонвиллийн жишээнд зөвхөн таван барилгачин хэргийн 50 гаруй хувьд өртсөн байна. Онолын хувьд нийт 55-д бус, харин эдгээр таван барилгачинд урьдчилан сэргийлэх арга хэмжээ төвлөрүүлэх нь хотын барилгын талбайн хулгай, дээрмийн асуудлыг бууруулахад илүү ач холбогдолтой, үр дүнтэй стратеги байж болох юм.

Дүн шинжилгээний шатанд, ийм хүснэгтүүд нь жагсаалтын дээд ба доод хэсэгт байгаа хүмүүс, газар эсвэл бүтээгдэхүүний хооронд чухал ялгаа байгаа эсэхийг тодорхойлоход тусалдаг. Бидний жишээн дээр судлаач Стейси Белледин нь тухайн компанийн барьсан барилга, байшингийн тоо нь хулгай, дээрмийн гэмт хэргийн тоотой нэлээд нарийн хамааралтай болохыг олж мэдсэн боловч эрсдэлийнх нь ялгааг тайлбарлаагүй байна. Эдгээр ялгааг үүсэхэд нөлөөлж буй бусад чухал хүчин зүйлсэд барилгачдын ажилладаг орчин, нөхцөл, цагдаагийн албаны мэдүүлэг авах болон аюулгүй байдлын журам зэрэг багтаж болно.

Флоридагийн Жаксонвиллэд 2004 оны 1-ээс 9-р сар хүртэлх хугацаанд гарсан барилгын талбайд хулгай болон орон байранд нэвтрэх хэргүүд, 55 барилгачин				
Багана 1	Багана 2	Багана 3	Багана 4	Багана 5
Барилгачин	Хэрэг	Нийт хэрэгт эзэлж буй хувь	Хэргийн хуримтлуулсан хувь	Барилгачдын хуримтлуулсан хувь
#1	60	15.5	15.5	1.8
#2	39	10.1	25.6	3.6
#3	38	9.8	35.5	5.5
#4	34	8.8	44.3	7.3
#5	34	8.8	53.1	9.1
#6	31	8.0	61.1	10.9
#7	29	7.5	68.7	12.7
#8	26	6.7	75.4	14.5
#9	19	4.9	80.3	16.4
#10	11	2.8	83.2	18.2
#11	8	2.1	85.2	20.0
#12	7	1.8	87.0	21.8
#13	7	1.8	88.9	23.6
#14	6	1.6	90.4	25.5
#15	5	1.3	91.7	27.3
#16	12	3.1	94.8	32.7
3 барилгачин, 4 хэрэг				
#17	9	2.3	97.2	38.2
3 барилгачин, 4 хэрэг				
#18	2	0.5	97.7	40.0
3 барилгачин, 4 хэрэг				
#19	9	2.3	100	56.4
3 барилгачин, 4 хэрэг				
#20	0	0	100	100
3 барилгачин, 4 хэрэг				
<b>55 барилгачин</b>	<b>386</b>	<b>100*</b>	<b>100*</b>	<b>100*</b>

\*Багцаалах, тоймлохын тулд тоонуудыг 100% хүртэл нэмсэн.

# Дүн шинжилгээ хийх нь

## 19. Тулгарсан асуудлыг судлах

Бусад цагдаагийн газруудад танд тулгарсантай ижил асуудал тулгарсан байж болно, эсвэл судлаачид таны асуудалтай төстэй асуудлыг судалсан байж болно. Иймд асуудлаа хэрхэн шийдвэрлэсэн, ямар хариу арга хэмжээ үр дүнтэй байсан, ямар нь үр дүнтэй байсан тухай бусдын туршлагыг судалснаар та цагаа хэмнэх боломжтой. Бусдын туршлагыг судалснаар өөрт тулгарсан асуудлыг ойлгоход тань туслах болно (20 дугаар алхам).

Та [www.cops.usdoj.gov](http://www.cops.usdoj.gov) and [www.popcenter.org](http://www.popcenter.org) хаягаас Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны зөвлөмжөөс эхлээрэй. Зөвлөмж тус бүр тодорхой нэг асуудлаарх судалгааг товчлон эмхэтгэж, түүнд авах хариу арга хэмжээг хэлэлцсэн (энэхүү зөвлөмжийн цахим хувилбарт хэвлэмэл хувилбарт багтаагүй зарим мэдээллийг оруулсан). Зөвлөмжүүд шинээр гарч байгаа хэдий ч таны тулгарсан асуудлаар байхгүй бол холбогдох бусад зөвлөмжийг үзээрэй. Жишээ нь нийтийн байранд хар тамхи худалдаалах асуудлын талаар зөвлөмж байхгүй ч "хувийн эзэмшлийн хотхонд хар тамхи худалдаалах", мөн "хар тамхины зах" зэрэг асуудлаар зөвлөмж байгаа тул өдгөөрийг судалж үзнэ үү.

### Ашиг тустай веб сайтууд:

Судалгаагаа өргөтгөхийн тулд доор жагсаасан веб сайтуудаар ороод үзээрэй. Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааг Австрали, Их Британи улсуудын туршлага манай улстай төстэй (АНУ) учраас эдгээр улсын жишээ баримтуудыг орхилгүй сайн судлах хэрэгтэй. Сан Фрациско хотын гэмт хэргийн асуудал Тэннэссии, Лиузана зэрэг жижиг хотоос илүүтэй Австралийн Сидней хотын нөхцөл байдалтай төстэй болов уу.

- **Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны төв:** ([www.popcenter.org](http://www.popcenter.org)) Цахим хуудас нь асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны зөвлөмжөөс гадна Голдштейн, Тиллигийн шагнал гардуулах ёслолд танилцуулсан, олон жилийн турш судлагдсан асуудалд чиглэсэн төслүүдийн олон зуун тайланг агуулдаг. Эдгээрийг цахим хуудасны хайлтын системээс сэдэвт хайлт хийж олж уншиж, татаж авах боломжтой.
- **"NCJRS" Хураангуй мэдээллийн сан:** ([abstractsdb.ncjrs.gov](http://abstractsdb.ncjrs.gov)) Энэхүү асар том мэдээллийн сангийн жижиг хэсэг цагдаагийн үйл ажиллагаатай шууд холбоотой байж болох ч танд хэрэгтэй материалыг агуулж магадгүй. Тус сан дахь товчлол нь нийтлэл эсвэл тайлангийн бүрэн эхтэй холбогдсон байдаг тул та өөрт шаардлагатай материалыг татаж авах боломжтой. Бусад тохиолдолд та хуулбарыг нь авах хүсэлт гаргаж болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй, ашиглахад хялбар бөгөөд материалыг хүлээн авахад хоёроос гурван долоо хоногоос илүү хугацаа шаардагдахгүй.
- **Дотоод хэргийн яам, Англи улс:** ([www.homeoffice.gov.uk](http://www.homeoffice.gov.uk)) АНУ-ын Хууль зүйн яамтай төстэй Англи улсын Дотоод хэргийн яам нь цагдаагийн үйл ажиллагаатай холбоотой олон судалгаа хийсэн, санхүүжүүлсэн байдаг. Веб хуудасны үндсэн цэсээс хайлт хийж, хураангуйг олох боломжтой бөгөөд хураангуй эхийг сонгож бүрэн эхтэй танилцах боломжтой.
- **Гэмт хэргийг бууруулах веб сайт, Дотоод хэргийн яам:** ([www.crimereduction.gov.uk](http://www.crimereduction.gov.uk)) Энэ нь дээрэм, орон байрны хулгай, гэр бүлийн

хүчирхийлэл, гудамжинд үйлдэгддэг гэмт хэрэг, коллежийн оюутнууд хохирогч болох хэрэг зэрэг олон гэмт хэрэгтэй тэмцэхэд практик зөвлөмж бүхий "багаж хэрэгсэл" болон "мини сайтууд"-тай.

- Австралийн Криминологийн хүрээлэн:** ([www.aic.govt.au](http://www.aic.govt.au)) Нээлтийн хуудаснаас хайлтаа эхлээрэй. Хайлтын үр дүнд хэргийн товч тайлбарууд гарч ирнэ. Та гарчиг дээр дарж дэлгэрэнгүй тайлбарыг авах боломжтой. Олон баримт бичгийг бүрэн текстээр татаж авах боломжтой.

#### Бусад чухал ач холбогдолтой эх сурвалжууд:

- Google:** Хэрэв цахим сайтуудад ач холбогдолтой мэдээлэл бага бол шаардлагатай мэдээллийг Google-ээс хайж үзээрэй. Google нь интернэт дэх хамгийн шилдэг хайлтын хэрэгсэл гэж тооцогддог. Хайлтын утга оруулахын тулд хэдэн тайлбар үг бичээд, холбогдох цахим хуудаснуудын жагсаалтыг хайх товчийг дарна уу. Хайлтын үр дүнг сайтын холбоосны тоогоор тооцсон ач холбогдлын дарааллаар жагсаадаг. Хайлтаа нарийсгахын тулд та хайлтын үгэнд үг, холбоо үг нэмэх хэрэгтэй. Ингэснээр таны шинэ хайлт нь таны анхны хэт өргөн асуулгад илэрсэн үр дүнгээс илүү нарийвчилсан утгатай, цөөн хуудаснуудыг харуулах болно.
- Цагдаагийн бусад хэлтэс:** Хэрэв та бусад цагдаагийн хэлтсүүд танайхтай ижил асуудлыг шийдсэн бол тэдэнтэй холбогдож мэдээлэл авах боломжтой. Төсөлд анх оролцсон гэмт хэргийн шинжээчид эсвэл алба хаагчидтай ярилцахыг хичээ. Тайлан мэдээлэл байхгүй бол аман байдлаар илэрхийлсэн мэдээлэлд хэт их найдвар тавьж болохгүй, учир нь хүний ой санамжид итгэхэд бэрх билээ.
- Боловсролын байгууллагууд:** Их сургуулийн эрүүгийн гэмт хэргийн тэнхимийн багш нараа хэрэгцээтэй зөвлөмж авч болно. Хэн нэгэнтэй холбоо барихын өмнө их дээд сургуулийн цахим сайтуудаас сургуулийн тэнхимүүдийн талаар мэдээлэл авах нь зүйтэй.

Хэдийгээр зарим их дээд сургуулиуд төр засгийн байгууллагад үйлчилгээ үзүүлэх нь чиг үүрэг нь мөн гэж үздэг боловч нэг цагаас дээш хугацааны мэдээлэл, зөвлөгөө зэрэгт багш нар төлбөр авахыг хүсэж магадгүй.

#### Эрдмийн бүтээл, нийтлэлүүдтэй танилцах

Ихэнх эрдэм шинжилгээний өгүүллүүд нь товч хураангуйгаар эхэлдэг. Хэрэв энэ нь танд сонирхолтой байвал хураангуй, хэлэлцүүлэг, дүгнэлтийг нь уншаарай. Хэрэв эдгээрт танд хэрэгтэй мэдээлэл байгаа бол нийтлэлийн эхэнд байгаа тоймыг унших нь зүйтэй. Та ихэвчлэн өгөгдөл, дүн шинжилгээ, үр дүнтэй холбоотой хэсгүүдийг алгасаж болно. Хэдийгээр нийтлэл нь танд шууд хамааралгүй байсан ч лавлагаанд жагсаасан жагсаалтаас хэрэгтэй материалыг олж болно.

- Дотоод мэргэжилтнүүд:** Хэрэв хайлтын явцад зарим мэргэжилтнүүдийг удаа дараа ишилсэн бол тэр хүнээс зөвлөгөө авахын тулд цахим шуудангаар холбогдож болно. Тухайн мэргэжилтэн хурдан хариулахуйц тодорхой мэдээллийн талаар асуу. Мэдээлэл авахдаа уншсан зүйлсээ жагсааж бичээрэй, ингэснээр ямар нэг чухал зүйлийг орхигдуулсан эсэхэд мэргэжилтэн хариу өгөх болно.
- Номын сангаас мэдээлэл авах:** Ихэнх томоохон нийтийн номын сангууд болон коллежийн номын сангууд ном номын сан хооронд солилцоо хийдэг. Иймд танд бусад номын сангаас хэрэгтэй байж болох ном, нийтлэлийг авах боломжийг олгоно. Та номын сангаас өгөх маягтыг бөглөж хоёр долоо хоногийн дотор тухайн номыг авах боломжтой.
- Эрүүгийн шүүхийн хураангуй (CJA):** CJA-д онлайнаар хандах нь зөвхөн эрүүгийн эрх зүйн хөтөлбөртэй коллежид олддог чухал эх сурвалж юм. Та өөрийн цагдаагийн хэлтсийг энэ үйлчилгээнд бүртгүүлэхийг хүсэх хэрэгтэй. Энэ нь тухайн салбарын томоохон сэтгүүл, ном, тайлангуудыг агуулдаг. Энэ нь NCJRS-ээс илүү эрдэм шинжилгээний баримт материалыг хамардаг билээ.

## Мэдээллийн хязгаарлалт

Таны хамгийн сайн мэдээллийн эх сурвалж нь (1) танд тулгарч буй асуудлыг судалсан судлаачдын судалгаа, нийтлэл, (2) мөн асуудалтай тулгарсан цагдаагийн хэлтсээс гаргасан тайлан байна. Гэсэн хэдий ч энэ хоёр эх сурвалж нь өөр өөрийн гэсэн сүл тал, хязгаарлалттай:

- Ихэнх криминологичид гэмт хэргийн тодорхой хэлбэрээс илүүтэй гэмт хэрэг, зөрчлийг ерөнхийд нь сонирхдог. Мөн тэд хараа хяналт, харуул хамгаалалт, зэрэг гэмт хэрэгтэнд шууд нөлөөлөх шалтгаанаас илүүтэй нийгмийн болон гэр бүлийн зэрэг суурь шалтгааныг сонирхдог. Тиймээс танд тулгарч буй асуудлыг хөндсөн эрдэм шинжилгээний ажуулудыг олсон ч тэдний тодорхойлсон шалтгаан нь үр дүнтэй хариу арга хэмжээ авахад төдийлөн тус болж чадахгүй болов уу.
- Таны асуудал маш нийтлэг тохиолддоггүй бол цагдаагийн бусад хэлтсээс хэрэгтэй мэдээ мэдээлэл хайж олно гэж найдаад хэрэггүй. Үнэлгээ бүхий үндэслэлгүй тохиолдолд асуудлыг амжилттайгаар шийдвэрлэсэн гэдэгт хэт их итгээд

хэрэггүй. Голдштейн эсвэл Тиллигийн шагнал авсан төслүүд хүртэл сайн үнэлгээ дүгнэлт хийгээгүй байж болно. Түүнчлэн тодорхой хот эсвэл хороололтой холбоотой төсөл, судалгаа, тайлан зэрэг нь таны нөхцөл байдалд тохиорхгүй, улмаар үр дүнгээ өгөхгүй байж болно. Таны судалж байгаа нөхцөл байдал нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Гэсэн хэдий ч цагдаагийн үйл ажиллагааны өмнөх туршлага нь тухайн асуудалд юу тустай байж болох талаар чухал эх сурвалж байж чаддаг.

Хэрэв хариу арга хэмжээ боловсруулахад тань илүү нарийвчилсан мэдээлэл хэрэгтэй бол (жишээлбэл, камерын хяналт гэх мэт) компьютер, номын сангаас хайлт хийн хэрэгтэй мэдээлэл, баримтуудыг олж, бусдын туршлагаас суралцах боломжтой.

### Нэмэлт материал:

Clarke, Ronald, and Phyllis Schultze. 2004. Researching a Problem. No. 2 of Problem-Oriented Guides for Police: Problem Solving Tool Series. Washington, DC: Office of Community Oriented Policing Services. [Http://ric-zai-inc.com/ric.php?Page=detail&id=COPS-W0744](http://ric-zai-inc.com/ric.php?Page=detail&id=COPS-W0744).

### Хариу арга хэмжээг тодорхойлох нь:

Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны зөвлөмжид танилцуулсан доорх хүснэгтийг боловсруулж, тодорхойлсон хариу арга хэмжээнүүдээ эмхэтгээрэй. Доорх хүснэгтэд хариулт бүр нэг мөр, таван баганатай.

	Хариу арга хэмжээ	Эх үүсвэр	Энэ нь хэрхэн ажилладаг бэ?	.. бол хамгийн сайн ажиллана.	Дүгнэлт
1					
2					

## 20. Таамаглал дэвшүүлэх

**Б**ид ямар нэгэн шинэ, эргэлзээтэй зүйлтэй тулгарах бүртээ дутмаг мэдээлэлд үндэслэн гэмт хэргийн хэв маяг, түүний учир шалтгааны талаар таамаглал дэвшүүлдэг. Туршлага ба онол нь таамаглал дэвшүүлэх тулгуур байж чаддаг. Та эхлээд (1) тодорхой таамаглал дэвшүүлэх, (2) таамаглалдаа хэт их найдаж болохгүй (3) таамаглал нь үнэн зөв эсэхийг мэдэхийн тулд мэдээлэл, өгөгдөл үндэслэн дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Шаардлагатай өгөгдлийг шалгасны дараа бүх таамаглал өөрчлөгдхөн эсвэл устгагдах магадлалтай байдаг, учир нь таамаглал дандаа үнэн зөв байдаггүй. Ийм учраас хэд хэдэн хоорондоо зөрчилдөх таамаглал дэвшүүлж, шалгах нь зүйтэй.

Багц таамаглалууд дүн шинжилгээний замын зураглал болдог. Таамаглал нь ямар төрлийн мэдээлэл цуглуулах, энэ өгөгдлийг хэрхэн шинжлэх, шинжилгээний үр дүng хэрхэн тайлбарлах талаар чиг баримжаа болдог. Хэрэв та бааранд архидан согтуурахтай холбоотой хэрэг зөрчлийг шалгаж байгаа бол "ийм төрлийн хэрэг зөрчил их гардаг баарууд хэд байдаг вэ?" гэсэн асуултаас эхэлж болно. 80-20-н дүрэмд (18 дугаар алхам) үндэслэн зарим бааранд зодоон, хэрүүл маргаан их болдог боловч ихэнх бааранд ийм хэрэг зөрчил цөөхөн эсвэл огт гардаггүй гэсэн таамаглалыг дэвшүүлж болно. Дараа нь таархины худалдах зөвшөөрөлтэй газруудыг жагсааж, сүүлийн 12 сарын хугацаанд зөрчил гарсан тухай мэдээллүүдийн тоог тоолох замаар энэ таамаглалыг шалгаж, нотолж болно.

Хэрэв таны таамаглал дэмжигдсэн бол "хэрэг зөрчил цөөн гардаг баарнаас юугаараа ялгаатай вэ?" гэсэн асуултыг тавьж болно. Эрсдэлтэй байгууллагын тухай ойлголт (28 дугаар алхам) нь танд гурван таамаглалыг дэвшүүлэхэд тусалж болно. Энэ гурван таамаглалд:

1. Эрсдэлтэй баарууд илүү олон үйлчлүүлэгчтэй байдаг.
2. Эрсдэлтэй баар нь гэмт хэрэгтэн татах онцлогтой.
3. Эрсдэлтэй бааранд байdag баарны ажилчид нэг бол маргалдаан өдөөдөг,

эсвэл хэрүүл маргаанд хяналт тавьж чаддаггүй.

Та эрсдэл багатай болон эрсдэл өндөртэй баарны үйлчлүүлэгчдийн талаарх мэдээлэл цуглуулах, нэг үйлчлүүлэгчид ногдох хэрэг зөрчлийн тоо, хувь хэмжээнд дүн шинжилгээ хийх, хэрэг зөрчил гардаггүй бааранд байгаа хүмүүсийн нөхцөл байдал, харилцааг ажиглах, ажилтнууд болон үйлчлүүлэгчидтэй ярилцлага хийх замаар эдгээр таамаглалыг шалгаж болно.

Хэрэв таны анхны таамаглалыг тоон мэдээлэл дэмжихгүй, харин баар, цэнгээний газруудаар гарсан хэрэг зөрчлийн тоонд тийм ч их ялгаа байхгүй болохыг мэдсэн бол "Яагаад ийм олон бааранд хэрэг зөрчил гарч байна бэ?" гэсэн асуултыг асууж магадгүй юм. Иймд дахин өөр нэг таамаглал гаргая: Энэ бол ойлголтын асуудал; тус хотод гарч буй баарны хэрэг зөрчлийн тоо бусад ижил төстэй хотынхтой ойролцоо байна гэсэн. таамаглалыг батлахын тулд танд бусад хотын мэдээлэл, өгөгдөл хэрэгтэй.

Шаардлагатай мэдээллийг цуглуулсны дараа ч мөн адил танай хотод гарч буй баарны хэрэг зөрчлийн тоо их байх тохиолдолд та "бааранд ийм их хэрэг зөрчил гаргахад хүргэж буй нийтлэг хүчин зүйл юу вэ?" гэж асууж болно. Архи борлуулах зөвшөөрлийг олгож буй зарчим, баарны зохицуулалтай холбоотой байж болно гэсэн таамаглал дэвшүүлж болох юм. Эсвэл баараар үйлчлүүлдэг хүмүүсийн зан төлөв, онцлог шинж чанартай холбоотой байж болзошгүй. Эдгээрийг нотлоход танд нэмэлт мэдээлэл шаардлагатай билээ.

### Дүн шинжилгээний улмаас гацаанд орох

Тодорхойгүй таамаглал дэвшүүлэх нь хэт их мэдээлэл цуглуулах, хэт их дүн шинжилгээ хийх, ашигтай дүгнэлт гаргаж чадахгүй байх зэрэг нь "шинжилгээний улмаас гацаанд орох"-д хүргэдэг.

Дэвшүүлж буй асуулт, таамаглал нь дүн шинжилгээний зохион байгуулалтад нөлөөлж буйг анзаараарай. Туршилтын үр дүнд - эерэг эсвэл сөрөг - илүү тодорхой асуултуудыг дэвшүүлж буй. Энэ үйл явцын зорилго нь өргөн хүрээтэй асуулт, таамаглалаас эхэлж, таамаглалуудыг баталгаажуулахын хэрээр зарим нь няцаагдаж, зарим таамаглал дэмжигдэж, илүү тодорхой асуулт, таамаглал дэвшүүлж боломжит хариу арга хэмжээ боловсруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Таамаглалаасаа шалтгаалан мэдээ мэдээлэл цуглуулдаг. Жишээлбэл, бааранд гардаг хэрэг зөрчилд дэвшүүлсэн таамаглал тус бүрийг нотлоход тодорхой өгөгдөл шаардлагатай. Зарим тохиолдолд ижил өгөгдлөөр олон таамаглалыг нэгэн зэрэг шалгаж болно (эрсдэлтэй баарны гурван өөр тайлбараас сонголт хийх тохиолдлын адил). Ихэнхдээ хэд хэдэн таамаглалаас сонголт хийхэд янз бүрийн өгөгдөл шаардлагатай байдаг (сүүлийн таамаглалын адил). Таны таамаглал илүү тодорхой байх хэрээр цуглуулах мэдээллийн төрөл, хүрээ мөн нарийн байна. Ийм учраас тодорхой бус боловч танд таалагдаж буй таамаглал дэвшүүлэх эсвэл огт таамаглал дэвшүүлэхгүй байхаас илүүтэй дургүй боловч тодорхой таамаглал дэвшүүлэх нь илүү чухал юм.

Таамаглал нь өгөгдлийн дүн шинжилгээг чиглүүлж өгдөг. Тодорхой таамаглал бүр (зөв байх тохиолдолд) ажиглагдахуйц өгөгдлөөтэй байдаг. Дээрх жишээнд эрсдэлтэй байгууллагын талаарх үзэл баримтлалаас үүдэлтэй таамаглалыг энгийн дүн шинжилгээний аргачлал ашиглан шалгах боломжтой. Хэрэв баар нь гэмт хэрэг үүсгэгч газар бол та халдлага их, үйлчлүүлэгчдийн тоо их, халдлагын харьцаа бага бүхий өгөгдлийг харах болно. (17 дугаар алхмыг үзнэ үү). Хэрэв өгөгдөл нь ийм шинж чанартай биш бол таамаглал буруу байгааг илтгэнэ. Тиймээс ямар нөхцөлд таны таамаглал зөв, ямар нөхцөлд буруу талаар тодорхой ойлголттой байх нь чухал юм (хүснэгтийн гурав дахь баганыг харна уу). Хэрэв ингэж чадахгүй бол таны дэвшүүлсэн таамаг тодорхой бус байна гэсэн үг.

Таамаглал нь шинжилгээний үр дүнг ойлгож, тайлбарлахад тусалдаг. Бааранд гарсан танхаарлын хэргийг судлахад цөөн хэдэн бааранд дийлэнх танхаарлын тохиолдол гарсан бөгөөд өндөр болон бага эрсдэлтэй бааруудыг харьцуулахад эрсдэлтэй баарны хамгаалалтын ажилтнууд танхаарлыг өдөөсөн гэж төсөөлье. Энэ тохиолдолд хөндлөнгөөс оролцох арга зам илт тодорхой байна. Товчхондоо, таамаглал үндэслэлтэй байх тохиолдолд таны дүн шинжилгээнд тодорхой өөрчлөлт орох ёстой. Өөрөөр хэлбэл, таны дэвшүүлсэн таамаглал нотлогдох тохиолдолд таны авах арга хэмжээ нотлогдохгүй байх тохиолдлоос өөр байх ёстой. Хэрэв та таамаглал нотлогдсон эсэхээс үл хамааран ижил шийдвэр гаргах юм бол тухайн таамаглал болон түүний дүгнэлт нь ач холбогдолгүй юм.

Дүгнэж хэлэхэд, таамаглал нь дүн шинжилгээг чиглүүлэхэд чухалачхолбогдолтой. Таамаглал дэвшүүлэхийн тулд та асуулт тавьж, түүнд энгийн болон таамаг бүхий хариултууд боловсруулах хэрэгтэй. Эдгээр хариулт нь таны дэвшүүлэх таамаглал юм. Эдгээр таамаглал нь буруу байж болохуйц зоримог байх хэрэгтэй бөгөөд зөв эсвэл бурууг нь нотлох арга заам байх ёстой. Боломжтой бол өрсөлдөгч таамаглал дэвшүүлэх нь зүйтэй.

Таамаглал дэвшүүлэх нь эсрэг үзэл бодолтой оролцогчдод өөрсдийн үзэл бодлыг тодорхой бөгөөд бодитойгоор шалгах боломжийг олгодог тул багийн ашигтай дасгал юм. Ийм байдлаар үндэслэлгүй таамаглал дэвшүүлсэн оролцогчид асуудлын дүн шинжилгээнд ихээхэн хувь нэмэр оруулдаг. Үүнийг эсрэгээс нь батлах арга гэж нэрлэдэг. Хэрэв таамаглал бүр боломжит шийдэлтэй холбоотой бол эдгээр таамаглалыг нотлох явцад хэрэгжих боломжтой болон үр дүнгүй хариу арга хэмжээг ялган тодорхойлох боломжтой болдог.

Асуулт, таамаглал, түүнийг нотлох		
Асуулт	Таамаглалын жишээ	Таамаглалыг шалгах
Энэ газар яагаад эрсдэлтэй вэ?	Энэ нь олон тооны бай байгаатай холбоотой юм.	Тухайн байршилд байгаа боломжит байг тоолж, гэмт хэргийн харьцааг тооцоолно. Энэ харьцааг ойр орчмын газрынхтай харьцуулаарай. Хэрэв эрсдэлтэй газрын харьцаа илүү өндөр бол таамаглал нотлогдохгүй; Хэрэв тус харьцаа нь ойролцоо эсвэл бага байвал таамаглалыг нотлогдсонд тооцно.
Яагаад эрсдэлтэй газарт автомашины хулгай ойр орчны газруудаас их гардаг вэ?	Бусад байрлал, газрын оршин суугчдаас ялгаатай нь тус хэсгийн оршин суугчид автомашинаа гудамжинд байрлуулдаг.	Эрсдэлтэй газарт гудамжны зогсоолын үнэ бусадтай ижил эсвэл доогуур байвал таамаглалыг үгүйсгэ. Илүү өндөр бол таамаглалыг нотлогдсонд тооцно.
Шинээр баригдаж байгаа барилгуудад зэсэн хоолойн хулгай яагаад гэнэт нэмэгдэв?	Ойр хавьд хоёрдогч түүхий эдийн төв нээгдсэн.	Ийм төв нээгдэхээс өмнө болон нээгдсэний дараа хулгайн хэрэгт өөрчлөлт гарсан эсэхийг шалгаж харьцуулах. Хэрэв хулгайн хэрэг дээрх өөрчлөлтөөс өмнө ба дараа нь ижил түвшинд байсан, эсвэл өөрчлөлт гарахаас өмнө хулгайн гэмт хэргийн хандлага аль хэдийн өсөж байсан бол таамаглал буруу байж болзошгүй. Бусад тохиолдолд таамаглал үндэслэлтэй харагдаж байна.

# 21. Мэдээллээ өөрөө цуглуулах

Та ердийн дүн шинжилгээндээ гэмт хэргийн тайлан болон баривчилгааны тайланг голчлон ашигладаг байх. Гэхдээ асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаанд та илүү өргөнхүрээний өгөгдлийг ашиглах шаардлагатай. Жишээлбэл, хар тамхины худалдаатай холбоотой асуудлын хувьд танд баривчилгааны өгөгдлөөс илүүтэй цагдаагийн дуудлагын мэдээлэл хэрэгтэй. Цагдаагийн тайлангууд нийтийн болон бусдын эд хөрөнгийг эвдлэн сүйтгэх, дэлгүүрийн хулгай зэрэг гэмт хэргийг бүрэн толилуулж чаддаггүй тул хотын захиргааны болон бизнес эрхлэгчдийн цуглуулсан мэдээлэл тухайн хэргийг тодорхойлоход тань илүү хэрэгцээтэй байж болзошгүй. Гэхдээ ихэнх асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд та "газар дээр нь очиж" өөрөө мэдээлэл цуглуулах шаардлагатай. Жишээлбэл, та болон танай төслийн баг тухайн гэмт хэргийн газрын орчны онцлогт системчилсэн ажиглалт хийх, хохирогчдоос судалгаа авах, гэмт хэрэгтэнтэй өөрөө эсвэл цагдаагийн алба хаагчаар дамжуулан ярилцлага хийх шаардлагатай болж болзошгүй. Дараах жишээгээр харуулсны дагуу "SARA"-ийн дөрвөн үе шатны аль нэгт та мэдээллээ өөрөө цуглуулах хэрэгцээ үүсэж болно. Үүнд:

- Роналд Кларк Хойд Каролина мужийн Шарлотт хотын төвийн зогсоолуудад машинтай холбоотой хулгайн гэмт хэрэгт чиглэсэн төсөлд оролцож байжээ. Нурсан барилгуудын суурин дээр байнга шинэ зогсоолууд нээгдэж, хуучин зогсоолын талбай дээр шинэ барилгууд ихээр баригдаж байснаас шалтгаалан тус хотын зогсоолуудын байршлыг харуулсан сүүлийн үеийн газрын зураг байхгүй байсан. Тиймээс уг төсөл дээр ажиллаж байсан цагдаагийн алба хаагчид хотын төвийн бүсийг бүхэлд нь судалж, иж бүрэн тооллого хийх шаардлагатай болсон. Төслийн дараа алба хаагчид зогсоол тутамд ногдох хулгайн эрсдэлийг тооцоолохын тулд зогсоолын багтаамжийг тоолсон. Ингэснээр машины зогсоолуудыг хулгайд өртөх эрсдэлээр нь буурсан эрэмбээр

жагсаах боломжтой болов. Дараа нь зогсоол тус бүрийн эрсдэлийн ялгаатай байдлыг тайлбарлахын тулд алба хаагчид зогсоолуудын аюулгүй байдал, дотор гэрэлтүүлэг, харуул хамгаалалтын эргүүл зэрэг мэдээллийг цуглуулсан билээ.

- Шарлотт хотын барилгын талбайн хулгайн хэрэгт чиглэсэн өөр нэг төсөл дээр ажиллаж байсан цагдаагийн хоёр алба хаагч Дан Куниус, Эрик Рост нар барилгачид тохиролцсоны дагуу урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж байгаа эсэхийг шалгахын тулд төслийн байшин бүрийг тогтмол шалгаж байв. Судалгаа дуусах үед алба хаагчид нийтдээ 8050 удаа шалгалт хийсэн нь нүсэр том мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа байлаа.
- Калифорния мужийн Чула Виста хотын олон нийтийн аюулгүй байдлын шинжээч Карин Шмерлер нь Үндэсний Хууль Сахиулах, Засан Хүмүүжүүлэх Арга Зүйн Төвд хийсэн тайландаа Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны шилдэг төслийг шалгаруулах Голдштейн шагналд нэр дэвшүүлсэн төслүүдийн анхан шатны мэдээлэл цуглуулахтай холбоотой жишээ, баримтыг цуглуулж тусгасан байв. Үүнд:
  - Нью-Йоркийн Буффало хотод биеэ үнэлэгчтэй холбоотой дуудлагыг бууруулах төслийн хүрээнд цагдаа нар 15 биеэ үнэлэгчидтэй, 116 үйлчлүүлэгчидтэй ярилцлага хийж судалгаа авчээ. Цуглуулсан мэдээллийг үйлчлүүлэгчдэд хуулийн дагуу арга хэмжээ авах, биеэ үнэлэгчдийг хар тамхины эсрэг эмчилгээнд хамруулж, шүүхээр шийдвэрлүүлэх чиглэлээр олон нийтийн дэмжлэг туслалцааг авахад ашигласан.
  - Калифорнийн хурдны замын эргүүлийн төслийн хүрээнд хөдөө орон нутгийн замд нас баралтыг 35 хувиар бууруулсан төслийн хүрээнд 30 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 20 миль

замыг автобусаар таван цаг шалгасан. Ажлын хэсгээс гаргасан гол зөвлөмж бол 24 цагийн турш "машины урд гэрлийг асаах" арга хэмжээ байлаа.

- Охайо мужийн Өмнөд Евклид хотын сургуульд хүүхдүүд бие биеэ дээрэлхэх зөрчлийг бууруулах төслийн хүрээнд цагдаа нар сурагчидтай тусгай бүлгийн ярилцлага хийж, хаана, хэзээ өөрийгөө аюулд өртөж болзошгүй гэж боддог талаар сурагчдаас асуужээ. Сурагчид коридорт болон анги солигдох үед дээрэлхэх хэрэг зөрчил гарах өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон бөгөөд цагдаагийнхан сургуулийн зөрчлийн бүртгэлийг судалж энэ хариултыг баталгаажуулжээ. Эдгээр дүгнэлтэд үндэслэн анги солигдох цагийг шат дараатай болгож, багш нар багаар ажиллаж коридорт тавих хяналтыг нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд коридорт хүүхдүүд бие биеэ дээрэлхэх явдал 60 хувиар буурсан байна.

Карин Шмерлер судалгаандаа шаардлага гарсан тухай бүр холбогдох мэдээллийг цуглуулан ажиллах нь мөн тохиromжтой онцолж, байршил болон гэрэлтүүлгийг нь шалгахын тулд байнга гэмт хэрэгт өртөж байдаг ATM-уудыг шалгасан тухай жишээг танилцуулсан. Бусад тохиолдолд, мэдээлэл цуглуулах ажлыг төлөвлөх, гүйцэтгэхэд их сургуулийн тусламж шаардлагатай байдаг.

### Өөрийн мэдээллийг цуглуулахдаа хянуур, болгоомжтой хандаарай.

Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд танаас олон зүйл шаардах боловч таныг хулгай, дээрмийн эрсдэл хүлээ гэсэн үг биш юм.

Хүндрэлтэй байдал, шаардлагатай цаг хугацааны улмаас та мэдээллээ өөрөө цуглуулахаас цааргалж болох ч энэ нь асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаанд заримдаа зайлшгүй шаардлагатайгаас гадна олон зэрэг үр дагавартай:

- Та хэчинээн их өгөгдөлтэй байсан ч газар дээр очсоноор тус асуудлын талаарх ойлголтоо компьютерын ард сууснаас илүү өргөжүүлэх болно.
- Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг төлөвлөх, боловсруулах нь таныг асуудлын мөн чанар, үр дүнтэй хариу арга хэмжээ, хүчин чармайлтаа хэрхэн үнэлэх талаар бодуулах болно.
- Цагдаагийн алба хаагчдыг мэдээлэл цуглуулах ажилд татан оролцуулах (болон үйлажиллагааны зорилтыг боловсруулах) нь асуудалд чиглэсэн хатуу, системтэй аргад сургах чухал боломжийг олгодог.
- Мэдээлэл цуглуулах ажлыг бие даан гүйцэтгэх нь судалгааны ур чадвараа дээшлүүлэх, бүтээлч байх боломжийг танд олгоно.

### Нэмэлт материал:

Schmerler, Karin, and Mary Velasco. 2002. "Primary Data Collection: A Problem-Solving Necessity." In Advanced Crime Mapping Topics. Denver: University of Denver.

## Машины хуурамч дугаарын талаар

Шарлотт-Мекленбургийн (Хойд Каролина) цагдаагийн хэлтэст ажиллаж байсан Мэтт Уайт, Чарльз Дин нар олон гэмт хэрэгтнүүд машиндаа хуурамч марк, дугаар хэрэглэж байгаа гэдэгт итгэлтэй болжээ. Эдгээр хуурамч марк, дугаарууд нь гэмт хэрэгтнүүд татвар төлөхгүй, даатгалд хамрагдаагүйгээр тээврийн хэрэгслийг хэдэн сар, бүр жилээр ашиглах, бусад гэмт хэрэг үйлдэхэд тус болдог байна. Уайт, Дин нар түр зуурын, хуурамч дугаарын системийг шинэчлэхийн тулд оройн цагаар Шарлоттод ижил хэмжээтэй, хөрш зэргэлдээ орших хоёр хороололд албан бус судалгаа хийсэн. Энэ судалгаанд нэг хороололд гэмт хэрэг ихтэй, нөгөө хороололд гэмт хэрэг бага байсан. Гэмт хэрэг ихтэй бүсэд (Газрын зургийн зүүн талд байгаа Белмонт) нь судалгаа явуулахаас өмнөх 12 сарын хугацаанд гэмт хэрэг багатай бүс (Плаза-Мидвуд)-тэй харьцуулахад хүчирхийллийн гэмт хэрэг 6.4 дахин их, 5.6 дахин их олон хүн баривчлагдсан байна. Хүлээлтийн дагуу тэд Бэлмэнтод хуурамч дугаартай 12 машиныг илрүүлсэн (доорх газрын зураг дээр хар өнгөөр тэмдэглэсэн) бол Плаза Мидвүүдэд нэг ч илрээгүй. Түүнчлэн Бэлмонтод машин зам руу машинаа ухраан байрлуулах нь элбэг байсан нь машины дугаарыг эргүүлийн цагдаад харагдуулахгүй байхтай холбоотой ажээ.



Эх сурвалж: White, Matt, and Charles Dean. 2004. "Abuse of Temporary License Tags in North Carolina." In *Understanding and Preventing Car Theft*, edited by Michael Maxfield and Ronald Clarke. Vol. 17 of Crime Prevention Studies. Monsey (New York): Criminal Justice Press.  
[http://www.popcenter.org/library/crimeprevention/volume\\_17/](http://www.popcenter.org/library/crimeprevention/volume_17/).

## 22. Мэдээллийн тархалтыг шалгах

 Гөгдлөө цуглуулсны дараа энэ мэдээлэл нь танд юу өгүүлж байгааг ойлгох хэрэгтэй. Та таксины жолооч нарт халдсан тохиолдлын талаар мэдээлэл цуглуулсан гэж бодъё. Цөөн тооны жолооч нарын дунд халдлага төвлөрч байна уу? Долоо хоногийн зарим өдөр эсвэл өдрийн цагаар халдлага төвлөрч байна уу?

Эдгээр асуултад хариулахын тулд та өгөгдлийн тархалтыг ажиглах хэрэгтэй. Доорх зураг нь Цинциннатигийн 53 хороололд 36 сарын хугацаанд гарсан хүн амины хэргийн тархалтыг харуулж байна. Хэвтээ тэнхлэг нь ойр орчмын газруудад хүн амины хэргийн тоог харуулдаг. Босоо тэнхлэгт эдгээр тоо тус бүр хэдэн хороололд хуваарилагдаж байгааг харуулдаг (үүнээс үзвэл эхний баганад 13 хороололд хүн амины хэрэг 0 байсан). Ихэнх хороололд хүн амины хэрэг цөөхөн байсан ч баруун тийшээ сунасан байдалтай, цөөн хэдэн хороололд хүн амины хэрэг их гарч байв. Ихэнхдээ та хуваарилалтыг нэгтгэн дүгнэх хэрэгтэй. Тархалтын талаар хоёр үндсэн тодорхойлолт байдаг: ердийн буюу дундаж тохиолдол, тохиолдлын өөрчлөлт буюу тархалт зэрэг юм.

**Дундаж тохиолдол.** Дундаж утгыг гурван аргаар тооцоолж болно.

**1. Дундаж утга.** Энэ бол дундаж утгын хамгийн түгээмэл хэмжигдэхүүн юм. Цинциннатигийн хороолол дахь хүн амины хэргийн дундаж тоо нь нэг хороололд 3.7 хүн амины хэрэг үйлдэгдэж байгаа бөгөөд үүнийг тооцоолоходоо 198 хүн амины хэргийг 53 хороололд хувааж тооцсон үр дүн юм.

**2. Голч.** Энэ нь хэрэг зөрчлүүдийг хоёр тэнцүү, бүлэгт хуваадаг хэмжигдэхүүн юм. Цинциннати дүүргийн тал хувьд хоёр ба түүнээс дээш хүн амины хэрэг тохиолдсон, тал хувь нь хоёр ба түүнээс цөөн тохиолдол байдаг.

**3. Хамгийн өндөр давтамжтай дээд утга (mode).** Энэ нь хамгийн олон тохиолдлыг илэрхийлэх утга юм. Энэ жишээнд хамгийн том хороололд хүн амины хэрэг


гараагүй учраас хүн амины хэргийн төрөл 0 байна.

**Хэргийн тархалт.** Тархалтыг хэмжих гурван өрөнхий арга байдаг:

- Цар хүрээ.** Энэ бол тархалтын үндсэн хэмжүүр юм. Энэ бол хамгийн бага болон хамгийн өндөр утгыг илэрхийлдэг. Бидний жишээн дээр энэ нь 0-27 хүн амины хэрэг байна.
- Дотоод квартилийн хүрээ (25-75 дахь хувийн тархалт).** Энэ хэмжүүр нь тохиолдлын дундах 50 хувийн доод ба дээд хязгаарыг тодорхойлдог. Цинциннатигийн жишээн дээр 1-5 хүн амины хэрэг дотоод квартильт багтаж байна. Хорооллуудын тал гаруй хувь нь энэ бүлэгт багтдаг. Нэгдүгээр квартильд буюу хорооллын эхний 25 дахь хувьд хүн амины хэрэг нэг эсвэл огт тохиолдол байхгүй, дөрөвдүгээр квартильд буюу хорооллын сүүлийн 25 дахь хувьд 5 ба түүнээс дээш хүн амины хэрэг үйлдэгдсэн байна. Дотор квартилийн мужийг олохын тулд тохиолдуудыг эрэмбэлж, тэдгээрийг дөрвөн тэнцүү бүлэгт хуваана. Хоёр дунд бүлэг нь дотоод квартилууд (3, 4 дүгээр квартиль) юм. Дотор квартилийн муж нь эдгээр хоёр дунд бүлгийн хамгийн бага ба хамгийн өндөр утгыг илэрхийлнэ.
- Стандарт хазайлт.** Тархалтын энэ хэмжигдэхүүн нь тархалтын дундаж утгаар дундаж зөрүүг илэрхийлдэг. Стандарт хазайлт бага байх тусам дундгийг тойрсон дундаж тархалт бага байна. Томьёо нь нэлээд төвөгтэй боловч excel-ийн хүснэгт эсвэл статистикийн программын тусламжтайгаар үүнийг тооцоолж болно. Тохиолдлын гуравны хоёр нь дундаж утгын хоёр тал дахь нэг стандарт хазайлтад багтдаг. Цинциннатигийн жишээнд стандарт хазайлт нь 5.2 хүн амины хэрэг байна.

## Цинцинатийн хорооллуудад хүн амины хэргийн давтамжийн тархалт

### 0-ээс 27 хүртэлх тоотой хүн амины хэрэг



Ердийн байдал, тархалтын хэмжигдэхүүний аль нь хамгийн тохиромжтой болох нь тухайн өгөгдлийн хоёр шинж чанараас хамаарна. Эхнийх нь тархалтын тэгш хэм юм. Тэгш хэмтэй тархалтын хувьд дундаж утгын нэг тал дахь хэлбэр нь нөгөө талдаа толины тусгал болдог. Энэ тохиолдолд дундаж, голч хоёр тэнцүү байна. Хэрэв хамгийн их тохиолдол бүхий утга нь төвдөө байвал дээд утга нь бусад хоёр дундаж хэмжигдэхүүнтэй ижил байх болно. Гэхдээ дээд утга нь тэнцүү байх албагүй. Тархалтаасаа хамаараад хоёр дээд утгатай байна. Хэрэв тархалт нь бараг тэгш хэмтэй байвал дундаж болон стандарт хазайлт тохиромжтой байж болно.

Хэрэв тархалт тэгш бус бол дундаж ба стандарт хазайлтыг ашиглах хэрэггүй. Голч эсвэл дээд утга, дотоод квартиль эсвэл бүтэн хүрээг ашиглана уу. Асуудлыг шинжлэхэд тэгш бус байдал маш түгээмэл байдаг.

Ердийн байдал батархалтын хэмжигдэхүүнийг сонгоход ашигладаг хоёр дахь шинж чанар бол өгөгдөл зориулан ашигласан оноо, хэмжилтийн нэгж юм. Оноо, хэмжилтийн нэгжийн гурван ерөнхий төрөл байна.

**1. Нэрлэсэн нэгж:** энэ нь ердийн нэгжийг хэрэглэдэг. Хүйс (эрэгтэй=1, эмэгтэй=2) нь нэрлэсэн нэгжээр хэмжигдэнэ, учир нь тоо нь үгийн утгыг илэрхийлнэ. Эрэгтэй=2, эмэгтэй=1 гэж өөрөөр тэмдэглэж болно.

Хэрэв таны мэдээлэлд нэрлэгдсэн утга өгөгдсөн бол дээд утга илүү нийцтэй.

**2. Дэс дарааллын нэгж:** энэ нь тохиолдуудыг эрэмбэлж, хэмжих нэгж. Цинциннатигийн хорооллуудын хамгийн ихээс цөөн тооны хүн амины хэрэг хүртэл эрэмбэлэгдсэн жагсаалт нь дараалсан нэгжийг гаргадаг (нэгдүгээр, хоёр дахь, гурав дахь гэх мэт). Та дараалсан өгөгдлийг нэмэх, хасах, үржүүлэх, хуваах боломжгүй. Та зөвхөн эрэг зөрчил, тохиолдол нь өөр тохиолдолд илүү их, бага эсвэл тэнцүү эрэмбэтэй эсэхийг тодорхойлох боломжтой. Хэрэв өгөгдөл дэс дарааллын нэгж бол дундаж болон стандарт хазайлтыг ашиглах боломжгүй. Голч болон дотоод кварталийг ашиглана.

**3. Харьцааны нэгж:** утга тус бүрийн ялгаа тэнцүү, ач холбогдолтой тэг утгатай байдаг учраас харьцааны нэгжид нэмэх, хасах, үржүүлэх, хуваах үйлдэл хийх боломжтой. Ойролцоо хорооллуудад хүн амины хэргийн тоог харьцааны нэгжээр хэмждэг: хүн амины хэрэг 0 ба 1 байхын хоорондох зөрүү нь хүн амины хэрэг 26 ба 27 байхын хоорондох зөрүү хүн амины хэргийн зөрүүтэй ижил утгатай бөгөөд хүн амины хэрэг 0 байх нь мөн тодорхой утга учрыг илэрхийлнэ. Та энэ төрлийн өгөгдөл дундаж болон стандарт хазайлтыг ашиглаж болно.

**Нэмэлт материал:**

Lane, David M. N.d.. Hyperstat Online Textbook.  
Accessed November 4, 2014. [Http://www.davidmlane.com/hyperstat/index.html](http://www.davidmlane.com/hyperstat/index.html).

Өгөгдлийн төрөл, түүний ашиглалт, сүл талууд			
	Нэрлэсэн нэгж	Дэс дарааллын нэгж	Харьцааны нэгж
Тодорхойлолт	Ангиллыг нэрлэнэ.	Ангиллыг эрэмбэл, нэрлэнэ.	Тоонуудын хооронд тэнцүү интервалтай, тэг нь ач холбогдолтой.
Жишээ	0 = хохирогч байхгүй. 1 = хохирогч Энэ нь доорхын адил хүчинтэй. 0 = хохирогч 1 = хохирогч байхгүй.	0=гэмт хэрэг байхгүй 1=нэг гэмт хэрэг 2=нэгээс олон тооны гэмт хэрэг	Гэмт хэргийн тоо: 0, 1, 2, .... (0=гэмт хэрэг гараагүй)
Баруун талд байгаа нэгжүүд нь зүүн талд байгаа бүх шинж чанаруудыг агуулахын зэрэгцээ өөрийн шинж чанаруутдай (жишээ нь: нэрлэсэн болон дэс тооны өгөгдөл, харьцааны өгөгдлөөр таны хийж болох зүйлс).			
Зөвшөөрөгдөх тооцоо	Ижил ба ижил биш	Илүү их, илүү бага, эсвэл тэнцүү	Нэмэх, хасах, үржүүлэх, хуваах
Зөвшөөрөгдөх дундаж утга	Төрөл	Дундаж утга эсвэл төрөл	Дундаж утга, төрөл
Зөвшөөрөгдөх тархалт	Хамрах хүрээ	Дотоод квартилийн утга ба хамрах хүрээ	Стандарт хазайлт ба бусад хэмжигдэхүүн.
Тайлбар	Ангилал (жишээ нь хүйс) болон групптэй (жишээ нь сүлжээ дэлгүүр мөн эсвэл биш байх) ажиллахад ашиглана.	Натурал эрэмбэ эсвэл ангиллын дараалал байгаа үед (цагдаагийн цол зэргээр) ашиглана. Гэхдээ эрэмбийн зөрүү нь үргэлж ижил биш эсвэл тодорхой бус байдаг.	Хувь хэмжээ, тоо болон бусад олон тооны хэмжүүрийг ашиглах.

## 23. Хэргийн төвлөрөл өндөр бүхий газар, байршлыг оношлох

Гэмт хэргийн зураглал хийхдээ төвлөрөл өндөр бүхий газар, байршлыг хурц болон архаг хэмээн ялгах нь зүйтэй (алхам 17). Хурц төрлийн газар, байршил нь гэмт хэргийн тоонд гарсан хэвийн бус өсөлтийг харуулдаг. Энэ нь өөрийн жамаараа буурч болно, харин архаг төрлийн газар, байршил нь бусад бус нутгуудтай харьцуулахад гэмт хэргийн түвшин байнга өндөр байдаг бөгөөд ямар нэгэн арга хэмжээ авахгүй л бол буурах магадлал бага байдаг. Архаг төрлийн газар, байршлын гурван үндсэн хэлбэр байдаг бөгөөд тус бүр нь тодорхой онол, хариу үйлдэлтэй холбоотой байдаг (төвлөрөл өндөр бүхий газар, байршлыг цаашид "халуун цэг" гэх. Үүнийг англиар Hot Spot гэж нэрлэдэг).

1. **Hot dots: Халуун дэд цэг** нь гэмт хэргийн төвшин өндөртэй байрлал юм. Эдгээр нь барилга байгууламж эсвэл давтан хохирогчдын хаяг дээр төвлөрсөн гэмт хэргийг харуулдаг (28, 29 дүгээр алхмыг үзнэ үү). Олон гэмт хэрэг тохиолддог газруудыг цэгээр дүрсэлсэн.
2. **Hot lines: Халуун шугам** нь гэмт хэрэг төвлөрдөг гудамжны хэсэг юм. Жишээлбэл, тодорхой гудамжны дагуу зогсоосон тээврийн хэрэгсэл эвдэрч гэмтэх тохиолдол их гардаг. Гудамжны хэсэг дагуух олон гэмт хэргийг зураасаар харуулав.
3. **Hot areas: Халуун бус** нь гэмт хэрэг төвлөрдөг хороолол юм. Халуун бус нь янз бүрийн шалтгааны улмаас үүсдэг. Тухайн газар нутгийн онцлог нь гэмт хэрэг үйлдэх шалтгаан болдог. Эсвэл халуун бус нь олон тусдаа, салангид асуудлуудыг агуулж болно. Газрын зураг дээр халуун бусийг сүүдэр, хүрээгээр мөн гэмт хэргийн түвшнийг харуулсан градиентээр харуулсан. Жерри Рэтклиффийн халуун цэгийн хэв шинж (хажуугийн самбарыг харна уу)-ийн нэр томьёо нь халуун цэгийн хоёр үндсэн төрлийг ялгадаг. Үүнд:
  - Үйл явдлын нарийн бүлэглэсэн загвар бүхий халуун цэгүүд
  - Халуун бусэд үйл явдал харьцангуй жигд тархсан халуун цэгүүд.

Дараагийн хуудсан дээрх зурагт халуун цэгийн өдгээр гурван хэлбэрийг дүрсэлсэн байна. Гэмт халдлагууд нь тодорхой хаягуудад явагддаг учраас хүндрэлтэй байрлалуудыг цэгээр харуулсан. Гэсэн хэдий ч тээврийн хэрэгсэлд нэвтрэх гэмт хэрэг нь гудамжны үргэлжилсэн хэсгүүдийн дагуу ихэвчлэн явагддаг тул энэ төвлөрлийг огтлолцсон хоёр шугамаар харуулав. Эцэст нь, хүмүүс оршин суух хорооллын халуун цэгийн тэгшитгэсэн дурс нь бусдын эд зүйлсэд халдах хэргийн эрсдэл нь нэг жижиг бусэд хамгийн их байдаг боловч төвөөс шилжилт хийх үед энэ эрсдэл буурдаг болохыг харуулж байна. Энэ талбайн доторх цэгүүд нь давтан хулгай их тохиолддог газрыг дүрсэлдэг.

- Халуун цэгийн шинж чанарыг тодорхойлох нь хариу үйлдэл үзүүлэхэд чухал ач холбогдолтой.
- Халуун цэгүүд нь тухайн газрын физик орчныг өөрчлөх эсвэл менежментийг өөрчлөх арга замуудыг санал болгодог. Тэд мөн өндөр эрсдэлтэй хохирогчдод хөндлөнгөөс оролцох арга хэмжээг санал болгодог.
- Халуун шугамууд нь гудамж, зам болон бусад маршрут, тэдгээрийн дагуух орчныг өөрчлөхийг санал болгодог.
- Халуун бусүүд нь ойролцоо хороололд өөрчлөлт оруулах зорилгоор өргөн хэмжээний түншлэлийг санал болгодог

Доорх хүснэгтэд гэмт хэргийн төвлөрөл нь түүнийг зураглах арга зам болон түүнд үзүүлэх хариу арга хэмжээ хаана төвлөрч байгаатай хэрхэн холбогдож буйг харууллаа.

## Хэрэг зөрчлийн төвлөрөл, зураглал ба авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Төвлөрөл	Халуун цэгүүдийг дүрсэлсэн байдал	Үйл ажиллагааны түвшин	Авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны жишээ
Цаг, байрлал: Тодорхой хаяг, булан, байгууламж, объектууд	Цэгээр дүрсэлсэн	Байгууламж, объект, булан, хаяг	Зогсоолын талбайд камер суурилуулах, бааранд архи, согтуурлуулах ундаагаар үйлчлэх хэлбэр, арга замыг өөрчлөх
Хохирогч	Цэгээр дүрсэлсэн	Хохирогчийн хаяг	Хохирогч, байг сургах, мэдээллээр хангах замаар дахин гэмт хэрэгт өртөхөөс сэргийлэхэд туслах
Гудамжнууд: гудамж дагуу болон мухар гудамжнууд	Шугамаар дүрсэлсэн	Гудам, зам дагуу	Эргэх тойрог байгуулах, замын хөдөлгөөнд өөрчлөлт оруулах, замын хөдөлгөөн, авто зогсоолын зохицуулалт, дүрэм журмыг өөрчлөх
Хэсэг газар, бүс: хороолол	Сүүдэртэй газар	Хороолол, бүс, бусад газрууд	Олон нийтийн түншлэл, хорооллыг дахин хөгжүүлэх

Халуун цэгүүдийн дүн шинжилгээ нь цэг, байрлалаас эхэлж, дараа нь гудамж, эцэст нь халуун бүс руу шилжих байдлаар явагдах ёстой. Жишээлбэл, шатсан машинуудын асуудлыг авч үзье. Энэ төрлийн хэрэг тодорхой хаягууд дээр олон дахин тохиолдож байна уу? Хэрэв тийм бол яагаад ойролцоо газруудыг сонгохын оронд эдгээр газруудыг яагаад сонгосон талаар асуух хэрэгтэй. Үгүй бол та дараагийн ээлжит халуун цэг болсон гудамжнуудыг шалгах хэрэгтэй.

Хэрэв гудамжны түвшинд хэрэг зөрчил төвлөрч байгаа бол зарим гудамжнуудад шатсан машины хэрэг зөрчил их байгаа, зарим гудамжинд яагаад ийм зөрчил бага байгааг харьцуулан тогтоох хэрэгтэй. Хэрэв гудамжны түвшинд хэрэг зөрчлийн төвлөрөл

бага байгаа бол (өөрөөр хэлбэл, гэмт хэрэг олон гудамжинд харьцангуй жигд тархсан) бол та олон нийтийн түвшний төвлөрлийг анхаарч, их болон бага төвлөрөлтэй хорооллуудыг харьцуулах хэрэгтэй. Энэ арга нь өндөр төвлөрөл ихтэй газруудад хариу арга хэмжээг төвлөрүүлэх чиглэлийг санал болгодог.

## Халуун цэгүүдийн төрөл



## Ратклиффийн халуун цэгийн тодорхойлолт

Жерри Рэтклифф гурван төрлийн халуун цэгийг ялган авч үзсэн. Тэрээр халуун цэгийн бүсээс эхэлж, дараа нь халуун цэгийн нөхцөл байдал, хэв маягийг шалгасан. Хэрэв бүх үйл явдал нэг газарт тохиолдож байгаа бол тухайн газрыг халуун цэг нэрлэж болно. Халуун цэг ба халуун байршилд нь ижил утгатай. Хэрэв үйл явдлууд нь нийт нутаг дэвсгэрт нягт бүлэглэн хуваагдсан бол Рэтклифф үүнийг кластер буюу бөөгнөрөл хэлбэр халуун цэг гэж нэрлэдэг. Эцэст нь, хэрэв үйл явдлууд халуун бүсэд харьцангуй жигд тархсан бол үүнийг тархмал халуун цэг гэж нэрлэнэ. Бөөгнөрсөн болон тархмал халуун цэгүүд нь манай халуун бүсийн ангиллын дэд ангилал юм. Рэтклиффийн арга барил нь үйл явдлын төвлөрөлд анхаарлаа хандуулж, халуун цэгийг ангилахын өмнө шинжээчээс халуун цэгийн тойргийг тодорхойлохыг шаарддаг.

Эх сурвалж: Ratcliffe, Jerry. 2004. "The Hotspot Matrix: A Framework for the Spatio-Temporal Targeting of Crime Reduction." *Police Practice and Research* 5(1):5–23.

Зураг дээр хулгайн халуун цэгүүд нь нийт хорооллын хэмжээнд гарсан хэрэг зөрчлийн давтан хохирогчдыг илэрхийлж байна. Халуун бүс нь дангаараа үүнийг тодорхойлж чадахгүй. Дүн шинжилгээг цааш үргэлжлүүлэхийн өмнө та халуун цэг нь ихэвчлэн хэд хэдэн давтан хулгайн цэгүүдээс шалтгаалсан эсэхийг тодорхойлох хэрэгтэй. Гэмт хэргийн газар, байрлал бүрийг зөвхөн нэг л үйл явдалтай мэт харьцаж, дараа нь тухайн асуудлыг цөөн тооны халуун цэгүүдээр илэрхийлж болно. Хэрэв тодорхой нутаг бүс нь халуун цэг байхаа больсон бол асуудал, хэрэг зөрчил нь хэд хэдэн халуун цэгүүдээс нийлбэр байж болно.

Хэрэв тухайн газар халуун цэг хэвээрээ байгаа бол эдгээр давтагдсан хулгайн цэгүүд нь орон байрны хулгайн нутаг дэвсгэрийн төвлөрлийн хэсгүүд байна.

Халуун цэгийн дүн шинжилгээ нь асуудлыг шийдвэрлэх үйл явцын эхэн үед чухал үнэ цэнтэй хэрэгсэл байж болох ч халуун цэгийг олж мэдсэнийхээ дараа зарим цэгүүд яагаад халуун, зарим нь халуун биш байгааг тодорхойлох хэрэгтэй. Халуун цэгийг илрүүлсний дараа дүн шинжилгээ хийх, үр дүнгүй хариу арга хэмжээ авахад хүргэдэг. Хэрэв асуудалд

газарзүйн бүрэлдэхүүн хэсэг байхгүй бол халуун цэгийн зураглал бага ач холбогдолтой тул та бусад дун шинжилгээний аргыг ашиглах хэрэгтэй.

**Нэмэлт материал:**

Eck, John, Spencer Chainey, and John Cameron. 2005. Mapping Crime: Understanding Hot Spots. Washington, DC: National Institute of Justice.

## 24. Өндөр нарийвчлалтай газрын зургийг хэзээ хэрэглэхийг мэддэг байх

**X**отын төвийн нутаг дэвсгэр, их сургуулийн орчин, нийтийн орон сууцны төсөл эсвэл олон том барилга байгууламжтай газрын гэмт хэргийн зураглалыг гаргахад ердийн программ хангамж тийм ч хэрэгцээтэй биш юм. Учир нь ихэнх барилгууд хэдий том ч гэсэн нэг хаягаар хаягладаг бөгөөд тухайн байранд гарах бүх гэмт хэрэг тухайн хаягт бүртгэгднэ. Тиймээс газрын зураглалд аливаа том барилга, байгууламж гэмт хэргийн асуудалтай гэж гарч ирэх ч тухайн газарт буй олон хүнийг харгалзаж үзвэл харьцангуй аюулгүй байж болох юм. Жишээлбэл, Жорж Ренгерт Филадельфиин төв хэсэгт автомашины гэмт хэргийн голомт гэж тодорхойлогдсон зогсоолын гараашны багтаамжийг тооцож, хэргийн харьцааг гаргахад ойр орчны гудамж, зогсоолоос доогуур гэдгийг харуулсан.

Бодит байдалд олон том барилгыг аюулгүй гэж хэлэх боломжгүй юм. Оскар Ньюман 1960-аад оны Америкийн нийтийн орон сууцны талаар хийсэн ноцтой шүүмжлэлдээ орон сууцны барилга өндөр байх тусам 100 оршин суугч тутамд ногдох гэмт хэргийн түвшин өндөр болохыг харуулсан. Оршин суугчид хөршөө таньдаггүй, барилга байгууламжийн зураг төсөл, зохион байгуулалт нь нарийн, төвөгтэй, коридор, цахилгаан шат, тоглоомын талбай зэрэг нийтийн эзэмшлийн талбайд хяналт тавихад хүндрэлтэй байдаг тул том барилга нь гэмт хэрэг үйлдэхэд тохирсон нөхцөлийг бүрдүүлдэг гэж тэрээр үзжээ. Тус судлаачийн дүгнэлт нь Орчны зохион байгуулалтад тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх (CPTED) гэсэн багц зарчим болж хувирсан билээ.

Аливаа барилгын аюулгүй байдал яагаад муу байдгийг ойлгохын тулд гэмт хэргүүдийг тодорхой ангилалд хийж, барилгыг дотоод зураглалд тусгах шаардлагатай. Үүнд өндөр нарийвчлалтай буюу З хэмжээст зураглал хэрэгтэй байдаг ч тэдгээрийг зурахад хэцүү, их хугацаа шаарддаг. Өндөр нарийвчлалтай зураглал хоёр үндсэн бэрхшээлтэй тулгардаг:

1. Цагдаагийн газрын гэмт хэргийн

бүртгэл, тайланд аливаа хэрэг тухайн барилгын хаана гарсныг тодорхой заадаггүй ч хөрөнгийн ашиглалтын менежер, хамгаалалтын албанаас нь энэ мэдээллийг авах боломжтой, хэрэв боломжгүй бол гэмт хэрэг бүртгэж тайлагнах журмыг тусгайлан боловсруулах шаардлагатай болно (21 дүгээр алхам).

2. Шинэ барилгуудын төлөвлөлт ихэнхдээ дижитал хувилбартай байдаг нь зураглал гаргах явцыг хөнгөвчилж өгдөг. Харин хуучин барилгын хамгийн сүүлийн үеийн зураг, төлөвлөлтийг олж авахад хэцүү тул та шинээр зурах хэрэгтэй болж магадгүй.

Ихэнх тохиолдолд эдгээр бэрхшээлүүд нь өндөр нарийвчлалтай зураглалыг үгүйсгэх үндэслэл болох ч Жорж Ренгерт болон түүний хамтрагчид Филадельфи дахь Темпл их сургуулийн гэмт хэргийн судалгааг хийхдээ уул бэрхшээлийг даван туулах боломжтой гэдгийг харуулсан. Тэд газрын зургийн программыг сургуулийн AutoCAD зурагтай хослуулан өндөр нарийвчлал бүхий GIS (газарзүйн мэдээллийн систем) зураг боловсруулсан байдаг. Ингэхдээ бохир, цахилгааны систем зэргийг зургаас хасаж, гудамжуудыг шугамаар дүрсэлж (хоёрталдаа явган хүний замыг дүрсэлсэн зураастай), барилга байгууламж, спортын талбай, авто зогсоол зэрэг объектыг олон өнцөгт дүрсээр илэрхийлж зургийг боловсруулсан байна. Бут сөөг, хашаа, гэрэлтүүлэг болон бусад биет зүйлсийг газрын зурагт мөн тусгасан байдаг. Иймд сургуулийн цагдаад бүртгэгдсэн гэмт хэргүүд хаана үйлдэгдсэнийг газрын зурагт зурж тэмдэглэснээр тухайн хэрэг зөрчлийг гэрэлтүүлэг муутай, нуугдах боломж бүхий газар байршилтай хамааруулж, дүгнэлт гаргах боломжтой болжээ.

Түүнчлэн, судлаачид дээрх их сургуулийн барилгуудын давхарт тус бүрт гарсан гэмт хэргүүдийг хэвтээ байдлаар зураглаж, доод давхарт нь гарсан мэт тусгав. Нэг барилгыг жишээ болгон Гладфелтер цамхагийн үр дүнг 1 дүгээр зурагт харуулав. 10 дугаар давхрыг

эс тооцвол тус барилгын бүх давхарт гэмт хэрэг гарсан байх ба ихэнх давхрын төв хэсгийн дөрвөн лифтний орчинд гэмт хэрэг бөөгнөрдөг нийтлэг хандлагатай байна. Энэ орчинд тэнхимиин нарийн бичгийн дарга, хүлээн авагч нарын оффисууд байрладаг бөгөөд тус оффисууд нь шилэн цонхоор хүрээлэгдсэн байдаг тул хулгайч нар хүн байгаа эсэх, хулгайлах эд зүйлс байгаа эсэхийг шилэн цонхоор нэвт харах боломжтой байжээ. Үүний хариуд Ренгертийн харьяалагддаг Эрүүгийн хууль зүйн газрынхан оройн цагаар бусад этгээдүүд өрөөг нь гаднаас ажиглах боломжийг арилгахын тулд цонхондоо хөшиг, хаалт суурилуулсан.


Мэдээллийн технологийн хөгжлийн үр дүнд аливаа хотыг бодитоор зураглах, объектын 3-D лазер зураглалыг гаргах боломжтой болсон (тухайлбал дээрх Гладфелтер барилгын компьютерын зургийг ийм төрлийн технологид тулгуурлан зурахад хялбар). Гэмт хэргийн тоо цөөн байх тохиолдолд байршлыг нь тодорхой харуулсан энгийн зураг байхад хангалттай байдаг. 2 дугаар зурагт Лондон дахь Лиссон Грин нийтийн орон сууцанд

нэвтрэх утас бүхий урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээс өмнөх болон хэрэгжүүлсний дараах, тус бүр нь 6 сарыг хамарсан гэмт хэргийн нөхцөл байдлыг харуулсан Барри Пойнерийн зураглалыг тусгалаа. Нэвтрэх утас нь гаднаас барилга руу нэвтрүүлэхгүй байх зориулалттай юм. Энэхүү урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг өндөр нарийвчлалтай зураглалд тулгуурлан үнэлсэн байна. Түүнчлэн хөрш зэргэлдээх барилга байгууламжийн хараа хяналтад байдаггүй явган замын хэсэгт дээрэм, түрийвч булаах зэрэг хэргүүд гарах хандлагатай байдгийг оношлоход уул зураг тус болжээ.


#### Нэмэлт материал:

Crowe, Tim. 1991. Crime Prevention Through Environmental Design. Applications of Architectural Design and Space Management Concepts. Boston: Butterworth-Heinemann. Rengert, George, Mark Mattson, and Kristin Henderson. 2001. Campus Security: Situational Crime Prevention in High-Density Environments. Monsey (New York): Criminal Justice Press.

**Зураг 1. Темпл их сургуулийн орчин, Гладфэлтэрийн схем**



**Зураг 2. Лиссон Гриний барилга  
явган хүний зам дээр гарсан дээрэм, хулгайн гэмт хэргийн байршууд**



Энэхүү баримт бичгийг хөрвүүлэх явцаад гарсан зөрүүтэй ойлголтод зохиогчид хариуцлага хулээхгүй болно.

## 25. Өдөр, долоо хоног тутмын амьдралын хэмнэлд анхаарлаа хандуулах

**А**мьдралын мөчлөг аливаа асуудалд асар их нөлөө үзүүлдэг. Тухайлбал, ажилдаа явах, дэлгүүр хэсэх зэрэгтэй холбоотойгоор тээврийн хэрэгслийн хөдөлгөөн өөрчлөгддөг нь автомашины зогсоол дахь машины болон хамгаалагчдын тоонд нөлөөлдөг. Энэ нь эргээд автомашинтай холбоотой гэмт хэрэгт нөлөөлдөг. Баасан, Бямба гарарт баар хаах үеэр согтуу хүмүүсийн дээрэмдэх хэрэг илүү их тохиолддог, учир нь энэ үед хэргийн өртөгч, бай болох хүмүүсийн тоо илүү олон болдог. Энэ жишээнд хоёр чухал хэмнэл нь асуудал үүсэхэд нөлөөлдөг. Нэгдүгээрт ажлын өдөр, амралтын өдрүүдийн мөчлөг Баасан, Бямба гарагаар орой, үдэш, шөнийн цагаар зугаа цэнгэл, амралт, чөлөөт цагийн үйл ажиллагаа идэвхжихэд нөлөөлдөг. Хоёрдугаарт баар нээх, хаахтай холбоотой өдөр тутмын мөчлөг юм. Энэ алхамд бид цаг, өдөр тутамд тохиолддог богино хугацааны хэлбэлзлийн талаар ярилцах болно. 26 дугаар алхамд бид сар, жилийг тутамд тохиолддог илүү урт хугацааны хэлбэлзлийг авч үзэх болно.

Өөр объект, байгууламжууд аливаа асуудалд нөлөөлж байдаг өөр өөрийн гэсэн үйл ажиллагааны хэмнэлтэй байдаг. Сургуулийн хэмнэл ажлын хэмнэлтэй төстэй боловч ялгатай. Автобусны зогсоолд ажилдаа явах, дэлгүүр хэсэх хэмнэл нөлөөлдөг төдийгүй автобуснууд ойр ойрхон ирж, явах нь ч нөлөөлдөг.

Гэмт хэрэг, хэрэг зөрчлийн хэмнэлийг хүснэгтлэх, зураглах нь түүнд нөлөөлж буй аливаа зүйлийн мөчлөгийг тодорхойлоход хэрэгтэй байдаг. Зураглал А-д харуулсны дагуу хэдэн өдрийн хугацаанд цаг тутамд (эсвэл өөр хугацааны интервалаар) тохиолдох үйл явдлын давтамжийн дунджийг тооцоолж (зураглал А-н дээрх дата матриц), үр дүнг графикаар илэрхийллээ. Зураглал Б-д аливаа өдөр гарсан хэргүүд тухайн долоо хоногт гарсан нийт хэргүүдийн хэдэн хувийг эзэлж буйг харуулав. Рэйчел Боба зарим өдрууд бусад өдрүүдээс огт өөр хэмнэлтэй байдаг тул өдөр, цагийг хамтад нь зурахыг зөвлөсөн (зураглал В). Үр дүн нь хэргийн төвлөрөл

өндөр бүхий цагуудыг харуулж байна. Ийм графикийг гаргахад хэцүү биш. Эдгээр гурван графикийг хүснэгт бүхий программ хангамж (excel) ашиглан боловсруулсан.

Асуудал, зөрчил, үйл явдлууд байнга тохиолддог бол цаг хугацааны дүн шинжилгээ хийхэд хамгийн хялбар. Тиймээс цаг хугацааны дүн шинжилгээг хүн амины гэх мэт ноцтой хэргүүдээс илүүтэй чимээ шуугиантай холбоотой гомдол, зам тээврийн хөнгөн хэлбэрийн осол зэрэг түгээмэл гардаг жижиг хэргүүдэд хэрэглэх нь илүү ашигтай байх болно. Хэрэв хэргийн тоо цөөн бол та илүү өгөгдөл цуглуулахын тулд дүн шинжилгээндээ илүү урт хугацааг хамруулах хэрэгтэй. Гэвч асуудал удаан хугацааны явцад өөрчлөгддөг шинж чанартай бол үр дүн нь бодит байдлаас гажуудсан буюу бодит байдлыг үнэн зөвөөр толилуулахгүй байж болзошгүй.

Аливаа хэрэг хэзээ үйлдэгдсэнийг мэдэх нь цаг хугацааны дүн шинжилгээнд хэрэгтэй. Дээрэм, хүчингийн хэрэг, танхайрах гэх мэт хохирогч, гэмт хэрэгтэн хооронд шууд харилцаа үүсэх хэргийг хэзээ тохиолдсоныг хохирогч тодорхойлж чадах учраас хэргийн цаг хугацааг тогтоох боломжтой байдаг. Харин тээврийн хэрэгслийн гэмт хэрэг, хулгай, эвдэн сүйтгэх зэрэг гэмт хэрэгтэн, хохирогч хооронд шууд харилцаа үүсэхгүй гэмт хэрэг хэзээ үйлдэгдсэнийг хохирогч тодорхой мэддэггүй учраас цаг хугацааны зураглалыг тогтооход амаргүй. Энэ тохиолдолд хохирогчийн мэдүүлсэн барагцаа бүхий цагуудын голчийг хэрэглэх нь түгээмэл боловч бодит байдлаас зөрөх, гажуудал үүсгэх эрсдэлтэй тул хэт урт, удаан хугацааг хамарсан (жишээлбэл, найман цагаас илүү) барагцаа ашиглахаас зайлсхийх хэрэгтэй.

Судлаач Жерри Рэтклифф цаг хугацааны төвлөрөл, бөөгнөрлийн гурван хэлбэрийг тодорхойлсон. Нэгдүгээрт, үйл явдлууд нийт өдрийн турш харьцангуй жигд тархсан байж болно. Тэрээр үүнийг тархмал хэв маяг гэж нэрлэсэн. Хоёрдугаарт, төвлөрсөн хэв маяг нь тодорхой хугацааны хязгаарлагдмал хүрээнд илүү төвлөрсөн байдлаар бөөгнөрдөг. Оргил

ачааллын цагт төвлөрсөн, бөөгнөрсөн үйл явдлууд төвлөрсөн хэв маягт хамаарна. Гуравдугаарт, хурц хэв маяг нь маш богино хугацаанд бөөгнөрдөг. Баар хаагдах үед гардаг хэрэг зөрчлүүдийг энэ жишээнд оруулж болно. Төвлөрсөн болон хурц хэв маяг бүхий гэмт хөргүүдэд цаг хугацааны дүн шинжилгээ хийж, харгалзах мөчлөгийг судлах нь зүйтэй.

Хэдийгээр судлаач Рэтклифф өдөр тутмын хэмнэлд зориулан дээрх хэв маягуудыг боловсруулсан ч долоо хоног хэмнэлд мөн

хэрэглэж болно. Хэрэв долоо хоногийн аль нэг өдөрт асуудал, зөрчил байнга тохиолдоггүй бол үүнийг долоо хоногийн тархсан хэв маягт хамруулж болно. Хэд хэдэн өдөр асуудал харьцангуй их гардаг бол энэ нь төвлөрсөн хэв маяг юм. Эцэст нь, хэрэв нэг эсвэл хоёр өдөр их хэмжээний хэрэг гардаг энэ нь хурц хэв маягт хамаарна.

#### Нэмэлт материал:

Boba, Rachel. 2005. Crime Analysis and Crime Mapping: An Introduction. Thousand Oaks (California): Sage.

Өдрийн дундаж	Цаг																								Өдөр бүрийн дундаж
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	
Даваа	7	3	6	9	9	11	10	17	16	17	5	6	12	7	9	5	20	18	16	8	7	10	8	7	10.1
Мягмар	10	9	10	11	7	6	13	15	15	18	6	12	7	7	8	5	16	18	17	12	5	11	10	4	10.5
Лхагва	4	11	12	6	8	3	18	17	24	14	10	7	4	2	4	9	23	24	24	7	5	12	3	4	10.6
Пүрэв	8	8	7	9	4	10	17	21	20	11	10	5	4	3	9	6	17	24	18	4	5	4	10	6	10.0
Баасан	3	12	6	7	9	12	13	19	20	19	3	4	3	4	9	3	15	16	17	8	10	18	12	13	10.6
Бямба	10	12	3	1	1	1	1	2	3	4	3	4	5	6	4	7	8	7	5	10	21	24	23	6.9	
Ням	21	22	10	2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	3.1
Цаг бүрийн дундаж	9.0	11.0	7.7	6.4	5.6	6.3	10.4	13.0	14.0	11.9	5.6	5.4	5.0	4.1	6.6	4.7	14.1	15.6	14.3	6.4	6.1	11.0	9.7	8.3	

#### Цаг хугацааны хэмнэлийг шалган тодорхойлох нь

График А. Цаг бүрийн дундаж






График Б. Хэрэг зөрчлийн долоо хоногийн хувь хэмжээ



С график. Өдрийн болон цагийн хэмнэл



## 26. Урт хугацааны өөрчлөлтийг харгалзан үзэх

Таны судалж байгаа асуудал улам дордож байна уу эсвэл сайжирч байна уу? Энэ өөрчлөлт нь тогтмол эсвэл санамсаргүй байдлаар хэлбэлзэж байна уу? Эдгээр асуултад хариулахын тулд та хэргийн тоо эсвэл хэргийн харьцааг цагийн хамт графикаар илэрхийлэх замаар асуудлыг судлах хэрэгтэй. Хэргийн харьцаа нь ихэвчлэн гэмт хэрэг, хэрэг зэрчлийн тоог нийт боломжит байнд хуваасан хэмжигдэхүүн (алхам 27) юм.

Асуудлын цаг хугацааны явцыг гурван үндсэн бүрэлдэхүүн хэсэгт хувааж болно.


1. Харахад илт байдаг ерөнхий чиг хандлага. Энэ нь хэрэг зөрчил, асуудал дордож байгаа эсэх, эсвэл сайжирч байгаа эсэх, эсвэл удаан хугацаанд өөрчлөлтгүй хэвээр байгаа эсэхийг харуулдаг
2. Улирлын, өдөр тутмын, долоо хоногийн мөчлөг
3. Санамсаргүй хэлбэлзэл. Олон тооны жижиг нөлөөллөөс хамаарна.
4. Гэмт хэргийн цаг хугацааны явцыг системтэйгээр судлахыг "цаг хугацааны цувааны шинжилгээ" гэнэ.

1-р зурагт Нью-Йоркийн Буффало хотод гарсан хүн амины хэргийн цаг хугацааны цувааг харуулав. Графикийн тэгш шугам нь ерөнхий чиг хандлагыг харуулж байна. Энэ нь бараг хэвтээ буюу маш бага өсөлтийн хандлагыг харуулж байна (100 сар тутамд 1 хүн амины хэрэг нэмэгдэх). 2001 оны 5 дугаар сард маш их хүн амины хэрэг гарсан бол 2000 оны 10, 11 дүгээр сард маш бага байна.

Зурагт тусгасан 58 сарын турш хүн амины хэрэг өндөр хэлбэлзэлтэй байгаа нь графикаас харагдаж байна. Бага давтамжтай асуудлууд ийм шинж чанартай байдаг бол өндөр давтамжтай асуудлуудын цаг хугацааны цуваа хэлбэлзэл багатай байдаг. Эдгээр санамсаргүй хэлбэлзэл, өөрчлөлт нь системчлэгдсэн хэлбэлзлийг далдалдаг билээ. Санамсаргүй өөрчлөлтөөр далдлагдсан чиг хандлагыг хөдөлгөөнт дунджаар илрүүлэх боломжтой. Үүнийг "тэгшигтгэх" гэж нэрлэдэг. Энэ жишээнд гурван сарын хөдөлгөөнт дунджийг ашигласан болно. Жишээлбэл, 7 дугаар сарын утга нь 6, 7, 8 дугаар сарын дундаж бөгөөд 8 дугаар сарын утга нь 7, 8, 9 дүгээр сарын дундаж утга юм. Цувралын эхний болон сүүлийн саруудын мэдээлэл байхгүй байгааг анхаарна уу, учир нь бидэнд харгалзах гурван сарын мэдээлэл байхгүй. Хөдөлгөөнт дундаж үзүүлэлтүүд нь хотгор, хөндий хэсгийг дүүргэж, оргил утгуудыг бууруулна. Илүү урт хөдөлгөөнт дундаж үзүүлэлтүүд нь богино дунджуудаас илүү тэгшивтэр график үүсгэдэг ч графикийг хэт тэгш, гөлгөр болгосноор хэрэгтэй мэдээллийг далдалдаг.

Жилийн ижил саруудыг (эсвэл таны шалгаж буй цаг хугацаанаас хамааран тухайн сарын ижил долоо хоног, долоо хоногийн ижил өдрүүд эсвэл өдрийн ижил цаг) харьцуулах замаар мөчлөг, давтамжийг илрүүлж болно. Гэхдээ сар болгон өөр өөрийн гэсэн онцлогтой байдаг гэдгийг анхаарах нь чухал (мөн 4 жил тутмын 2 дугаар сард 29 өдөр байдгийг мартаж болохгүй). Учир нь энэ нь асуудлын тоонд нөлөөлж болзошгүй. Зарим шинжээчид энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд сар биш харин дөрвөн долоо хоногийн давтамжийг ашигладаг.

**Зураг 1. 2000 оны 1 дүгээр сараас 2004 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд  
Нью-Йоркийн Буфалло хотод гарсан хүн амины хэргүүд**




Улирлын мөчлөгийг Зураг 2-оос харж болно. Эндээс 32 сарын турш сар бүр гарсан унадаг дугуйн хулгайн тоог харж болно. Хулгай 7, 8 дугаар сард дээд цэгтээ хүрч, 1, 2 дугаар сард хамгийн доод цэгтээ хүрсэн байна. Сар бүрийн байдлаар авч үзвэл 2001 он нь 2002 оны сарууд болон 2003 оны саруудаас их байсныг харж болно. Зуны улиралд унадаг дугуйн хулгайн гэмт хэрэг олширдог байна. Зун цагт дугуй элбэг байхаас гадна хулгайчид өвлийн улиралд унадаг дугуй хэрэглэдэггүйтэй (ялангуяа Буфалод) холбоотой.

Цаг хугацааны цувааг бүрэлдэхүүн хэсэгт хуваах нь асуудлын боломжит шалтгааныг илрүүлэхэд хэрэгтэй. Жишээлбэл, хүн амины хэргийн чиг хандлагыг гэр бүлийн болон бусад хүн амины хэрэг (эсвэл галт зэвсэг ба галт зэвсэггүй) гэсэн хоёр график болгон задалж болно. Хэрэв гэр бүлийн бус хүн амины хэрэг өсөх хандлагатай, гэр бүлийн хүн амины хэрэг буурч байгаа бол гэр бүлийн бус хүн амины хэрэгт анхаарлаа хандуулах нь зүйтэй.

Цаг хугацааны цувралын шинжилгээ нь хариу арга хэмжээний үр дүнг үнэлэх хүчирхэг арга хэрэгсэл юм. Үндсэн зарчим нь дээрх арга техникийг ашиглан хариу арга хэмжээ авахаас өмнөх асуудлын үндсэн чиг хандлага, мөчлөг, өөрчлөлтийн талаарх сайтар ойлгож авах явдал юм. Энэ нь та асуудлын талаар ямар нэгэн арга хэмжээ авахгүй байх тохиолдолд ирээдүйд хэрхэх байсныг олж мэдэхэд тус болно. Энэ нь хариу арга хэмжээний авсны дараах үеийг хянаж шалгах суурь болж өгнө. Ерөнхий чиг хандлага, мөчлөг, санамсаргүй хэлбэлзэл зэрэгт өөрчлөлт орох нь хариу үйлдэл тодорхой нөлөөлөлтэй байсныг харуулна. Өмнөх болон дараах үе урт байх тусам та дүгнэлтдээ илүү итгэлтэй байж болно.

Хугацааны цувралын шинжилгээг хийхэд хүндрэлтэй байж болох учраас цаг хугацааны шинжилгээнд нарийн хариулт хэрэгтэй бол энэ чиглэлээр мэргэшсэн статистикчаас зөвлөгөө, тусламж авах нь зүйтэй.

**Зураг 2. 2001 оны 1 дүгээр сараас 2003 оны 8 дугаар сар хүртэлх хугацаанд Буффало хотод унадаг дугуйн хулгайн улирлын өөрчлөлт**



Энэхүү баримт бичгийг хөрвүүлэх явцад гарсан зөрүүтэй ойлголтод зохиогчид хариуцлага хулээхгүй болно.

## 27. Хувь хэмжээ, харьцаа болон хуваагчийг хэрхэн хэрэглэх тухай суралцах

**Н**эг газарт бусад газраас илүү их гэмт хэрэг гардаг бол тухайн газарт илүү олон боломжит бай байгаатай холбоотой байж болно. Хэргийн харьцааг шалгах нь бай, өртөгчийн тоо таны судалж байгаа асуудалд нөлөөлж байгаа эсэхийг ойлгоход тусална (17 дугаар алхмыг үзнэ үү).

Хэргийн харьцаа нь бай буюу хохирогч болох эрсдэлтэй хүн тутамд ногдох гэмт хэргийн тоог хугацааны хамт тодорхойлдог: жишээлбэл 2002 онд 1000 өрх тутамд нэг орон байрны хулгайн гэмт хэрэг гарсан. Зорилтот хэргийн харьцаа нь тухайн цаг хугацаанд аливаа этгээд гэмт хэрэгт өртөх магадлалыг харуулдаг.

Зорилтот хэргийн харьцааг тооцоолохын тулд та дараах зүйлсийг хийх хэрэгтэй. Үүнд:

1. Хэргийн төрлийг тодорхойлох (жишээлбэл, тээврийн хэрэгслийн хулгай)
2. Гэмт хэрэгт өртөж болзошгүй бүлгийг тодорхойлох (жишээлбэл, тээврийн хэрэгсэл)
3. Байршил, цаг хугацааг тодорхойлох (жишээлбэл, 2004 онд хотын төвийн зогсоолд гэх мэт)
4. Шалгаж буй байршилд дахь хэрэг, боломжит байн тоог агуулсан мэдээллийн эх сурвалжийг хайж олох (жишээ нь, цагдаагийн тайлангийн гэмт хэргийн мэдээлэлд хулгайн хаягийг тусгасан байдаг бөгөөд тус хаяг нь автомашины зогсоол байж болно. Хэрэв тийм бол хотын төвийн зогсоолуудыг ашиглаж, тоолсноор нийт багтаамжийг барагцаалж болно).
5. Хэргийн харьцааг бодохын тулд тухайн байршил дахь хэргийн тоог (хуваагдагч) нийт боломжит байн тоонд (хуваагч) хуваана.

Нийт боломжит байг тодорхойлоход болгоомжтой байх нь зүйтэй. Хэрэв та орон байрны хулгайн хэрэгт дүн шинжилгээ хийж байгаа бол таны судлах бай нь хүмүүс эсвэл орон байр уу? Мэдээж “орон байр, айл өрх” гэдэг нь илүү үндэслэлтэй хариулт юм. Хэрэв 1000 хүн 500 нэгжид амьдардаг бол бид ижил

тооны хүмүүс 250 нэгжид амьдардаг байснаас илүү их орон байрны хулгайн гэмт хэрэг гарна гэж бодож байна. Хэрэв та гудамжны дээрмийн хэрэгт дүн шинжилгээ хийж байгаа бол эрсдэлт бүлгийн хүн ам нь шалгаж буй нутаг дэвсгэр дахь явган зорчигчдын тоо юм. Цагдаагийн ослын тайланд ихэвчлэн анхаарал татсан үйл явдлын талаарх мэдээллийг (тухайлбал хаягийн мэдээлэл) агуулагддаг тул аль нэг байршилд гарсан хэргийн тоог тооцох боломжтой. Харин тухайн байршил дахь эрсдэлд өртөж болзошгүй байн тоог тодорхойлсон мэдээллийг олж авахад хэцүү. Жишээлбэл, тээврийн хэрэгслийн хулгайн тайланд зогсоолын хаягийн мэдээлэх байх ч тухайн зогсоолыг ашиглаж буй тээврийн хэрэгслийн тоо байхгүй болов уу (Хүснэгтийг харна уу).

Энэ бэрхшээл, асуудлыг даван тулахын тулд та боломжит байн тоог төлөөлөх хэмжүүрийг олох шаардлагатай байж магадгүй. Жишээлбэл, зогсоол ашиглаж буй тээврийн хэрэгслийн тоо талбайн хэмжээтэй шууд хамааралтай байж болно. Тиймээс эрсдэлд өртсөн тээврийн хэрэгслийн төлөөлөх хэмжүүр нь квадрат метр эсвэл зогсоолын тоо байж болно. Хүснэгтэд хэрэгт өртөх эрсдэлтэй байн тоог тооцоолох зарим жишээг танилцууллаа.

Хэрэгт өртөж болзошгүй байг төлөөлөх хэмжүүр нь хоёр шинж чанартай байх шаардлагатай. Нэгдүгээрт, тэдгээр нь байтай логик холбоотой байх ёстой. Зогсоолын тоо болон тээврийн хэрэгслийн тоо, хэмжээтэй холбоотой гэж таамаглах нь үндэслэлтэй ч авто зогсоолын өргөн тээврийн хэрэгслийн тоотой холбоотой гэж таамаглаж болохгүй юм. Учир нь гүн, урт бүтэцтэй зогсоолуудын өргөн богино буюу гудамж руу харах нүүрэн тал багатай, гэхдээ илүү олон тооны машин, тээврийн хэрэгслийг агуулах боломжтой байдаг. Хоёрдугаарт, төлөөлөл бүхий хэмжигдэхүүн болон хэрэгт өртөж болзошгүй байх хоорондын хамаарал байршилаас хамааралгүй байх хэрэгтэй. Хэрэв долоо хоногт хотын төвийн бүх зогсоолын гуравны хоёр дүүрдэг бол зогсоолын тоог төлөөлөх

хэмжүүрээр хэрэглэж болно. Харин зарим зогсоол нь бүрэн дүүргэлттэй, зарим нь бага

дүүргэлттэй бол зогсоолын тоог төлөөлөх хэмжүүрээр хэрэглэх нь зохижгүй юм.

### Өөр өөр гэмт хэргүүдэд гэмт хэргийн хувь хэмжээний жишээ

Төрөл	Байрлал	Хувь хэмжээ	Тайлбар
Орон байрны хулгай	Орон байр, орон сууц	Нэг байр эсвэл өрх тутам дахь орон байрны хулгай	Оршин суугч тутам дахь хулгайн хэрэг нь томоохон гэр бүлд ихээхэн анхаарал хандуулдаг.
Дэлгүүрийн хулгай	Жижиг худалдааны дэлгүүр	Тавиур дахь эд зүйл эсвэл нэгж талбай тутам дахь хулгай	Үйлчлүүлэгч тутам дахь хулгай нь аливаа этгээдийн хулгай хийх магадлалыг харуулдаг
Мотоциклын хулгай	Хороолол	Бүртгэлтэй мотоцикл тутам дахь мотоциклын хулгай	Мотоцикл унадаг газартаа амьдардаггүй иргээдийн хувьд төвөгтэй
Ханан дээр зураг зурах буюу графитти	Худалдаа, үйлчилгээ, нийтийн зориулалттай талбай	Нэгж талбай тутам дахь зураг	Хэмжихэд хэцүү
Такси дээрэм	Компани	Машин, жолооч, ажлын цаг тутам дахь дээрэм	Эрсдэлд өртөж буй цаг нь илүү чухал ач холбогдолтой, гэхдээ өгөгдөл, мэдээлэл цуглуулах боломжгүй байж болно.
Зочид буудлын зөрчлийн талаарх дуудлага	Зочид буудал	Өрөө, үйлчлүүлэгч тутам дахь зөрчлийн дуудлага	Үйлчлүүлэгч биш хүмүүсийн тоог судлах боломжтой.

Төлөөлөл бүхий хэмжүүрийг ашигласан ч өртөж болзошгүй байн мэдээлэл, өгөгдлийг олж авахад хэцүү. Төрийн байгууллагууд танд хэрэгтэй зарим мэдээллүүдийг өгнө. Жишээлбэл, Охайо мужийн Хамилтон тойргийн аудитор нь тухайн муж дахь газруудын талбай, байршил зэрэг мэдээллийг өгч чадна. Аж ахуйн нэгжүүд болон харгалзах холбоод заримдаа борлуулалтын талаар мэдээлэл өгч чадна. Мөн төрийн байгууллагаас борлуулалтын татварын мэдээлэл авч уул мэдээллийг үйлчлүүлэгчдийн тооны төлөөлөл бүхий

хэмжүүр болгон ашиглаж болно (ижил төрлийн бараа зардаг дэлгүүрүүдийг харьцуулах үед).

Хэргийн харьцааг тооцох нь эрсдэлтэй обьектуудыг олоход чухал ач холбогдолтой. (алхам 28). Карин Шмерлер болон түүний хамтран ажилласгад Чула Виста (Калифорни) хотын зочид буудлуудаас ирсэн дуудлагыг судалжээ. Үндэсний 10 сүлжээ, орон нутгийн 16 бие даасан зочид буудал ойролцоо тооны дуудлага хийсэн хэдий ч үндэсний сүлжээнүүд илүү олон өрөөтэй байв.

Тэд орон нутгийн зочид буудлуудын бүх дуудлагыг нэгтгэж, эдгээрийг зочид буудлын өрөөнүүдэд хуваахад судлаач Шмерлер нь бие даасан мотел зочид буудлын дуудлагын харьцаа нь өрөө тутамд 1.8 байгааг олж мэдэв. Сүлжээ зочид буудлуудын хувьд тус тооцооллыг хийхэд дуудлагын харьцаа өрөө тутамд 0.5 байсан. Орон нутгийн зочид буудлуудаас өрөө тутамд олон дуудлага хийдэг байв.

Та олон, их хэрэг эсвэл өндөр хэргийн харьцааны алийг онцлон авч үзэх хэрэгтэй вэ? Хэрэв таны зорилго гэмт хэргийн тоо


хэмжээг бууруулах бол нийт тоонд анхаарлаа хандуулах нь зэв. Хэрэв таны зорилго гэмт хэрэгт өртөх эрсдэлийг бууруулах бол хэргийн харьцаанд анхаарах нь зүйтэй.

### Нэмэлт материал:

Clarke, Ronald, and Herman Goldstein. 2003. "Thefts from Cars in Center City Parking Facilities." In From Innovation to Mainstream, edited by Johannes Knutsson. Vol. 15 of Crime Prevention Studies. Monsey (New York): Criminal Justice Press. [Http://www.popcenter.org/library/crimeprevention/volume\\_15/](http://www.popcenter.org/library/crimeprevention/volume_15/).

## Эрсдэлтэй автомашины зогсоолыг тодорхойлохын тулд хэргийн харьцаа ашиглах нь – 1999 он, Хойд Каролина, Шарлотт

Хэргийн харьцааг тооцоолохын ач холбогдлыг харуулсан Хойд Каролинагийн Шарлотт хотын нэгэн төсөл дээр энэ зааврыг боловсруулсан судлаач (Кларк) Херман Голдштейнтай хамтран ажилласан. Орон нутгийн шинжээчид болон цагдаагийн ажилтнуудын туслалцаатайгаар бид хотын төвийн зогсоол дахь автомашины доторх эд зүйлсийг хулгайлах гэмт хэргийг шалгасан билээ. Гэмт хэргийн төвлөрөл өндөр бүхий газар, байршлын дун шинжилгээнээс үзэхэд эдгээр хулгайн гэмт хэргүүдийн тухайн газрын төв, голд төвлөрч байгааг харуулсан боловч хулгайн харьцаанд сууриссан газрын зураг илүү их зүйлийг харуулж байв. Энэхүү газрын зургийг гэмт хэргийн шинжээч Мэтт Уайт зохиосон тэрээр газар, байрлал тус бүрийн зогсоолын тоог хэлтсийн алба хаагчдын тусламжтайгаар тооцоолжээ. Дараагаар тэрээр зогсоолын талбай, зогсоолын гарааш тус бүрээр хулгайн харьцааг тооцсон байна. Ийнхүү боловсруулсан газрын зураг нь эрсдэлийн илүү нарийвчилсан дүр зургийг харуулсан. Цаашдын дун шинжилгээнээс харахад авто зогсоолд байршуулсан автомашинуудын хулгайд өртөх эрсдэл гараашинд байгаа автомашинаас зургаа дахин өндөр, зарим зогсоол нь хараа хяналт, мөн харуул хамгаалалт хангалтгүйгээс болж гэмт хэргэг үйлдэх нөхцөл болж бүрдүүлэгч газар болохыг газрын зураг харуулсан.



Хотын төвийн судалгааны талбай ба дун шинжилгээ



## 28. Эрсдэлтэй объектыг тодорхойлох

О бъект нь тусгай чиг үүрэг бүхий орчин юм (алхам 15). Боловсролын объект нь хичээл заах, суралцахад зориулагдсан орчин юм. Аж үйлдвэрийн объект бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэж, боловсруулдаг. Оффисын объект мэдээлэл боловсруулдаг. Жижиглэнгийн худалдааны объект нь борлуулалт, мөнгөний гүйлгээ хийдэг. Зарим объектод гэмт хэрэг, зөрчил их гардаг. Үүнд уушийн газар, цэцэрлэгт хүрээлэн, төмөр замын буудал, утасны бүхээг, дэлгүүр, нийтийн орон сууцууд багтана. Эдгээр объект нь гэмт хэрэг, хэрэг зөрчлийн байдалд харьцангуй их нөлөөлдөг бөгөөд тэдгээрийг ерөнхийд нь "эрсдэлтэй объект" гэж нэрлэдэг.

Гэхдээ энэ нэр томьёо нь илүү нарийн тодорхой утгатай. Эрсдэлтэй объектын төрөл тус бүрийн зарим нь маш их эрсдэлтэй байдаг болохыг илэрхийлнэ. Бид 18 дугаар алхамд 80-20 дүрмийг тайлбарлахдаа Массачусетс мужийн Данверс хотын дэлгүүрүүдийн 5 хувь нь хулгайн гэмт хэргийн 50 хувийг эзэлж байгааг дурдсан (Данверсийн цагдаагийн газрын гэмт хэргийн шинжлэгт Кристофер Брюсийн өгсөн хүснэгтийг үзнэ үү). Эрсдэлтэй байгууламжийн бусад жишээг доор танилцууллаа. Үүнд:

- Дэлгүүрүүд.** Үндэсний хэмжээний судалгаагаар сүлжээ дэлгүүрүүдийн 6.5 хувьд нийт дээрмийн хэргийн 65 хувь нь тохиолддог болохыг тогтоожээ.
- Шатахуун түгээх станцууд.** Техас мужийн Остин хотын шатахуун түгээх станцууд 1998-1999 онд автомашины хулгай болон хар тамхины гэмт хэргийн дуудлагын 50 гаруй хувийг эзэлж байв.
- Банкууд.** Их Британийн банкуудын дөрвөн хувьд дээрмийн гэмт хэргийн гаралт бусад банкнуудаас 4-6 дахин өндөр байв.
- Сургуулиуд.** Стокгольмын сургуулиудын найман хувь нь 1993-1994 оны хичээлийн жилд бүртгэгдсэн хүчирхийллийн гэмт хэргийн 50 хувийг эзэлжээ.
- Автобусны зогсоолууд.** Эндрю Ньютоны докторын диссертациад бичсэнээр Британийн Ливерпуул хотын автобусны буудлуудын 9 хувьд нь эвдэн сүйтгэх гэмт

хэргийн 40 гаруй хувь нь тохиолдсон.

- Машины зогсоол.** Британийн өөр нэг хот болох Ноттингем хотод 2001 онд хотын төвийн 19 талбайд бүртгэгдсэн 415 гэмт хэргийн 25 орчим хувийг (103) зөвхөн нэг зогсоол (Royal Moat House) эзэлж байлаа.

Зарим объект яагаад "өндөр эрсдэлтэй" байгааг найман шалтгаанаар тайлбарлаж болох бөгөөд өөр өөр дүн шинжилгээний аргачлал тухайн нөхцөл байдалд ямар учир шалтгаан үйлчилж байгааг тодорхойлоход тусална:

- Санамсаргүй хэлбэлзэл.** Санамсаргүй тохиолдоор аливаа газарт гэмт хэргийн төвлөрөл бий болох боломжтой. Цөөхөн хэрэг гарсан цөөн хэдэн объектыг судлахад энэ нь илүү их тохиолддог. Ижил объектыг өөр өөр хугацаанд шалгаж үзээрэй. Хэрэв эрэмбийн дараалал нь ойролцоо, ижил байвал хэлбэлзэл нь санамсаргүй биш юм.
- Тайлагнах журам.** Зарим объект гэмт хэргийн талаар цагдаад байнга мэдээлдэг байхад зарим объектууд мэдээлээд байдалгүй. Үүнийг шалгахад хэцүү байж болох ч, бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт нь тухайн объект дахь гэмт хэргийн байдлын талаарх цагдаагийн алба хаагч нарын ойлголтой нийцэж байгаа эсэхийг тухайн объектыг сайн мэддэг цагдаагийн алба хаагчдаас асуух хэрэгтэй.
- Олон бай.** Зарим объект нь олон байтай байдаг. Данверс хотын хамгийн их дэлгүүрийн хулгайн гардаг байсан газар хотын хамгийн том дэлгүүрүүдийн нэг байв. Түүнчлэн 100 квадрат фут тутам дахь хулгайн хэргийг тооцоолоход (хүснэгтийн сүүлчийн баганыг үзнэ үү) дэлгүүрийн хулгай гарах эрсдэлтэй объект нэг хэвээр байлаа (27 дугаар алхмыг үзнэ үү).
- Гэмт хэрэгт өртөх өндөр эрсдэл бүхий бүтээгдэхүүн (hot products).** Эрсдэлтэй объект нь олон тооны байгүй байсан чгэмт хэрэгт өртөх өндөр эрсдэл бүхий байтай байж болно. Данверсийн жагсаалтын 15 дахь дэлгүүр 1,000 квадрат фут тутам

дахь хулгайн гэмт хэргийн гаралтаараа хамгийн өндөр нь байсан. Учир нь тус дэлгүүр 31 дүгээр алхамд тодорхойлсон "CRAVED" шалгуурыг хангасан жижиг бөгөөд өндөр үнэ цэнтэй электрон бараа борлуулдаг байв.

- 5. Байршил.** Гэмт хэрэг ихтэй газарт магадгүй гэмт хэрэг үйлдэгч олноороо амьдардаг байж болох бөгөөд үүнийг дагаадгэмт хэрэггараах эрсдэл нэмэгддэг. Учир нь гэмт хэрэгтнүүд зорьж очиход хол газарт гэмт хэрэг үйлддэггүй билээ (алхам 16).
- 6. Давтан хохирогч.** Зарим газар гэмт хэрэгт өртөмтгий хүмүүсийг өөртөө ихээр татдаг. Эрсдэлтэй болон эрсдэл багатай объектод хохирогч болох эрсдэлийг харьцуулж үзээрэй. Хэрэв олон дахин хохирогч болох хувь хэмжээ ялгаатай, өөр бол олон давтан хохирогч болж буй тухайн объектын эрсдэлийг ихэсгэх шалтгаан байж болно (алхам 29).
- 7. Гэмт хэрэг татагч газрууд.** Гэмт хэрэгтнүүдийг ихээр татдаг объект нь гэмт хэргийн татагч цэг, газар болдог (алхам 15). Гэмт хэргийн татагч газруудад

гэмт хэргийн гаралт их, хэргийн харьцаа өндөр байдаг. Нэмэлт оношилгоо, шалгалтад баривчилгааны тайлан болон гэмт хэрэгтний нэрийг агуулсан бусад мэдээлэлд дүн шинжилгээ хийх явдал юм.

- 8. Сул удирдлага.** Эзэмшигч эсвэл менежерүүд зохих хяналт, зохицуулалтыг хийхгүй бол эрсдэлтэй объект үүсэж болно. Хүснэгтэд орлого багатай хорооллын газрын эзний сул удирдлага, хараа хяналт, харуул хамгаалалтаас болж түүний эзэмшил дэх үл хөдлөх хөрөнгө эрсдэлтэй объект болж хувирсныг харуулав (алхам 44).

#### Нэмэлт материал:

Eck, John, Ronald Clarke, and Rob Guerette. 2007. "Risky Facilities: Crime Concentration in Homogenous Sets of Facilities." In *Imagination for Crime Prevention: Essays in Honour of Ken Pease*, edited by Graham Farrell, Kate J. Bowers, Shane D. Johnson, and Michael Townsley. Vol. 21 of *Crime Prevention Studies*. Monsey (New York): Criminal Justice Press. [Http://www.popcenter.org/library/crimeprevention/volume\\_21/](http://www.popcenter.org/library/crimeprevention/volume_21/).

Орлого багатай иргэдийн хороололд түрээсийн төлбөр багатай сууцуудад гардаг гэмт хэргүүд					
Объектын дугаар	Он	Нэгжийн тоо	Баривчилгааны жилийн дундаж		
			Эзэмшлийн өмнө	Эзэмшлийн дараа	
#1	1977	4	0	1.6	
#2	1982	15	0	16.9	
#3	1983	8	0	2.3	
#4	1985	8	0	4.5	
#5	1985	10	0.1	6	
#6	1986	16	0.2	27.9	
#7	1986	6/8	0	3.4	
#8	1987	5	0	8.3	
#9	1987	12	0	11.3	
#10	1988	6	0.4	8.1	
#11	1991	10	0.2	9.3	
#12	1991	10+	2.3	21.8	
#13	1992	4+	1.1	0.7	
#14	1992	4	0.2	10.7	

Томоохон хот бүрт цөөн тооны түрээсийн орон сууцны барилгуудаас өгөх дуудлага цагдаагийн ажлын ачааллын ихээхэн хувийг эзэлдэг. Эдгээр "эрсдэлтэй объект" нь ихэвчлэн орлого багатай хороололд байдаг. Хууль бусаар газрын эзэд ядуусын хорооллоос үл хөдлөх хөрөнгө худалдан авч, менежмент, харуул хамгаалалт, засвар үйлчилгээнд маш бага хөрөнгө оруулалт хийдэг. Барилгын үйлчилгээ, барилгын нөхцөл байдал муудаж, боломжийн орлоготой түрээслэгчид орхин нүүж, тэдний оронд хар тамхины наймаачид, биеэ үнэлэгчид орж, түрээсийн төлбөрөө төлж чадах эсэх нь эргэлзээтэй хүнд нөхцөлд амьдардаг. Калифорния мужийн Санта Барбара хотод асуудалд тулгуурласан цагдаагийн төслийг хэрэгжүүлэх явцад офицер Ким Фрилси, Майк Апсланд нар ядуусын хорооллын өрхийн түрээсийн 14 байшинг худалдан авахаас өмнөх болон дараах баривчилгааны хэрэгт дүн шинжилгээ хийжээ. Хүснэгтээс харахад байрыг худалдан авснаас хойших жилүүдэд тухайн байршилд баривчлагдсан хүмүүсийн тоо ихээхэн өссөн байна. Мөн эдгээр үл хөдлөх хөрөнгийн гэмт хэрэг, хэрэг зөрчил нь ойролцоо орон сууцны байшингуудад халдвартлах мэтээр нөлөөлдөг байна.

Эх сурвалж: Clarke, Ronald, and Gisela Bichler-Robinson. 1998. "Place Managers, Slumlords, and Crime in Low Rent Apartment Buildings," *Security Journal* 11(1): 11–19.

### 2003.10.01-ны өдрөөс 2004.09.30-ны өдрийн хоорондох хугацаанд Массачусетсийн Данверс хотод гарсан тайлан мэдээлэгдсэн, дэлгүүрээс эд зүйл хулгайлах хэргүүд, дэлгүүр тус бүрээр авч үзвэл

Дэлгүүрийн дугаар	Дэлгүүрээс эд зүйлс хулгайлах хэрэг	Энэ төрлийн нийт хэрэгт эзлэх хувь	Энэ төрлийн нийт хэрэгт эзлэх нэгтгэсэн хувь	Дэлгүүрүүдийн нэгтгэсэн хувь	1000футт квадрат тутам дахь энэ төрлийн гэмт хэргийн тоо
#1	78	26.2	26.2	1.3	1.54
#2	42	14.1	40.3	2.6	0.70
#3	28	9.4	49.7	3.8	0.22
#4	16	5.4	55.0	5.1	0.24
#5	15	5.0	60.1	6.4	0.28
#6	12	4.0	64.1	7.7	0.31
#7	11	3.7	67.8	9.0	0.09
#8	11	3.7	71.5	10.3	0.16
#9	9	3.0	74.5	11.5	0.28
#10	7	2.3	76.8	12.8	2.82
#11	5	1.7	78.5	14.1	0.16
#12	5	1.7	80.2	15.4	0.10
#13	4	1.3	81.5	16.7	0.35
#14	4	1.3	82.9	17.9	0.12
#15	3	1.0	83.9	19.2	3.32
#16	3	1.0	84.9	20.5	0.90
#17	3	1.0	85.9	21.8	0.02
#18. 7 дэлгүүрт 2 тохиолдол гарсан.	14	4.7	90.6	30.8	0.08
#19. 28 дэлгүүрт 1 тохиолдол гарсан.	28	9.4	100.0	66.7	0.06
#20. 26 дэлгүүрт 0 тохиолдол гарсан.	0	0.0	100.0	100.0	0.00
78 дэлгүүр.	298	100.0*	100.0*	100.0*	0.15

Тайлбар: Хамгийн их тохиолдол гарсан 17 дэлгүүр: Best Buy, Boater's World, Circuit City, Costco, CVS Pharmacy, Galyan's, Home Depot, Kohl's, Linens & Things, Lowe's, Marshall's, Old Navy, Radio Shack, Stop & Shop, Target, and Wal-Mart

\*Ойролцоо байдлаар илэрхийлсэн тул тоо яг 100 хувьд хүрэхгүй байж болно.

## 29. Давтан хохирогч бий болох тохиолдолд бэлэн байх

Зарим хүмүүс олон удаа хохирогч болох нь элбэг байдаг ба 80-20 дүрмийн дагуу (алхам 18) хохирогчдын багахан хэсэг нь нийт хохирогчдын дийлэнх хувийг эзэлдэг билээ. Кен Пиз, Грахам Фаррелл нар энэ нөхцөл байдлын талаар Дотоод хэргийн яамны "Нэг удаа ёртсөн, хоёр дахь удаагаа ёртсөн" нэртэй номдоо танилцуулсан. Их Британийн Гэмт хэргийн судалгааны мэдээллийг ашигласнаар (доорх хүснэгтийг харна уу) тэд хүмүүсийн 4 орчим хувь нь нэг жилийн хугацаанд нийт хохирогчдын 40 орчим хувийг эзэлж байгааг харуулсан. Тэд гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хулгай, автомашины хулгай зэрэг олон төрлийн гэмт хэргийн улмаас олон дахин хохирогч болдог гэдгийг харуулсан. Тэд мөн давтан хохирох нь маш богино хугацааны дотор, ихэвчлэн эхний хохирогч болсноос хойш долоо хоногийн дотор тохиолддогийг харуулсан боловч энэ нь гэмт хэргийн төрөл зүйлээс хамаарч өөр өөр байдаг.

### Хүмүүсийн дөрөв орчим хувь нь бүх гэмт хэргийн хохирогчдын 40 орчим хувийг эзэлж байгаа нь.

Өртсөн гэмт хэргийн тоо	Судалгаанд оролцогчдын хувь	Хэрэг зөрчлийн хувь хэмжээ
0	59.5	0.0
1	20.3	18.7
2	9.0	16.5
3	4.5	12.4
4	2.4	8.8
5+	4.3	43.5

Эх сурвалж: British Crime Survey, 1992, all offenses

Судалгаанаас үзэхэд доорх шалтгааны улмаас давтан хохирогчийн нарийн тоог тогтооход хүндрэлтэй байдаг байна. Үүнд:

- Олон хохирогчид гэмт хэргийн талаар цагдаад мэдэгддэггүй, үүний улмаас цагдаагийн албан ёсны бүртгэлд давтан

гэмт хэргийн хохирогч болсон тухай бүртгүүлэх нь бага байдаг гэсэн үг юм. Тийм ч учраас судлаачид цагдаад мэдэгдээгүй гэмт хэргийн талаар судлах зорилгоор түүвэр судалгаа хийхийг хичээсэн. Харамсалтай нь АНУ-д Их Британийн Гэмт хэргийн судалгаатай ижил чиг үүрэг гүйцэтгэдэг Гэмт хэргийн хохирогчийн үндэсний судалгаа нь зөвхөн зургаан сарын хугацааг хамруулдаг, тодорхой хохирогчийн эсрэг олон дахин үйлдэгдсэн бүх гэмт хэргийг тооцдоггүй тул давтан хохирогчдыг дутуу тоолсон байх эрсдэлтэй билээ.

- Гэмт хэргийн шинжээчид ихэвчлэн аливаа хаягт үйлдэгдсэн гэмт хэргийн тоог тоолох замаар давтан хохирогч эсэхийг тогтоодог боловч цагдаагийн тайланд ихэвчлэн хаягтай холбоотой мэдээлэл дутуу тусгагддаг. Энэ нь нэг удаагийн хохирогчдын тоог бодитоос өндөр гаргахад нөлөөлдөг байна. Энэ хүндрэл нь GIS системүүдийн хүртээмж, газрын зургийн программ хангамжид хаяг оноо (жишээ нь, геокодлох) зэргээс шалтгаалж буурч байгаа билээ.
- Давтан хохирогчийг "цаг хугацааны цонхны эффект"-ийн улмаас дутуу үнэлж болно. Хэрэв зөвхөн тодорхой хугацаанд буюу 2002 оны 1 дүгээр сараас 2002 оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд хохирогчдыг тооцвол 2001 оны 12 дугаар сард болон зургаан сарын хугацаанд нэг удаа хохирогч болсон хүнийг давтан хохирогч гэж тооцохгүй. Тэд 2002 оны 7 дугаар сард хохирогч болох золгүй явдал тохиолдсон бол тухайн хүн гурван удаагийн хохирогч болсныг бид мэдэж чадахгүй. Шинэ хохирогчийг мэдүүлгээ өгсний дараа нэг жилийн турш дагаж мөрддөг хөдөлгөөнт цонхыг ашиглах нь хамгийн тохиромжтой.

## Аянга нэг буусан газраа дахин буудаггүй гэдэг худлаа.

Зарим цагдаа нар хулгайн гэмт хэргийн хохирогчид дахин хохирогч болохгүй гэж хэлдэг. Харамсалтай нь энэ нь үнэн биш гэдгийг энд авч үзсэн судалгаа харуулж байна.

Давтан хохирогч болох явдлыг тайлбарлахаа судлаач Кен Пис нь хоёр төрлийн хүчин зүйлсийг ялгаж үзсэн. Үүнд:

- Дэмжих хүчин зүйлс:** энэ нь давталтыг эхний гэмт хэргээс цуглуулсан эерэг туршлагаар тайлбарладаг. Жишээлбэл, хулгайч өмнө хулгай хийсэн орон байрны талаар маш их зүйлийг олж мэддэг тул тус байранд дахин уг гэмт хэрэг хийхээр буцаж ирэхэд түлхэц, өдөөгч болж магадгүй юм. Хулгайч өөрийн үйлдлийн туршлагын талаар бусад хулгайч наарт хэлж, энэ нь бусад хулгайч гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг.
- Түг хүчин зүйлс:** энэ нь олон төрлийн гэмт хэрэгтнүүдийн хохирогч болоход хүргэдэг бай, өртөгчийн эмзэг байдал, өртөмтгий байдлыг гэмт хэрэгт давтан өртөх явдалтай холбож тайлбарладаг. Зарим мэргэжлүүдийн (жишээлбэл таксины жолооч гэх мэт) гэмт хэрэгт өртөх магадлал хамаагүй өндөр байдаг ба эрсдэлтэй газар (тухайлбал, дэлгүүрийн худалдагч гэх мэт) их цагийг өнгөрөөдөг хүмүүс олон дахин хохирогч болох илүү магадлалтай. Эцэст нь, хулгайч нарын анхаарал, сонирхлыг татахуйц машин (31 дүгээр алхам) гэх мэт өртөмтгий эд зүйлсийг эзэмших нь олон дахин хохирогч болох магадлалыг нэмэгдүүлдэг.

Анхны хохирогч эсвэл байтай төстэй шинж чанартай хохирогч гэмт хэрэгт өртөх тохиолдлыг "Бараг" давтан хохирогч гэж нэрлэнэ. Эхний бай руу амжилттай халдсаны дараа гэмт хэрэгтнүүд ижил төстэй шинж чанартай байг судалж эхэлдэг. Жишээлбэл, эхний хулгайн гэмт хэрэг үйлдсэнтэй ижил байршилтай, ижил хороололд байгаа байшингууд нь гэмт хэрэгтэн өмнө нь нэвтэрч

орохдоо тэдний талаар ямар нэг зүйлийг мэдэж, туршлага цуглуулсан тул гэмт хэрэгт өртөх эрсдэл өндөр байх болно.

Давтан хохирогчийн талаар ойлголттой байх нь хэн хамгийн их эрсдэлд өртөж болзошгүй, хэзээ эрсдэлд орохыг урьдчилан таамаглахад хэрэгтэй. Энэ нь гэмт хэрэг үйлдэх эрсдэл маш бага байдаг олон цэгүүдэд цагдаагийн хүч нөөцийг тараахаас илүүтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд өртөж болзошгүй цэгүүдэд цагдаагийн нөөцийг төвлөрүүлэхийг шаардана.

Олон тооны цагдаагийн байгууллагууд дахин хохирогчтой харьцаадаа "зэрэглэлтэй хариу арга хэмжээ" ашигладаг. Энэ нь хэн нэгэн гэмт хэрэгт олон дахин өртөх тусам цагдаагийн байгууллагаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлдэг гэсэн санаа юм. Давталтын хоорондох хугацааг мэдэх нь гэмт хэрэг гарах эрсдэл хамгийн их байгаа үед гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг богино хугацаанд түргэн шуурхай явуулах боломжийг олгодог. Тухайлбал, цагдаагийн зарим байгууллага удахгүй хулгайн гэмт хэрэг дахин гарах эрсдэл өндөр байгаа газарт хулгайчаас сэргийлэх түр дохиолол сууринуулдаг.

### Нэмэлт материал:


Weisel, Deborah L. 2005. Analyzing Repeat Victimization. No. 2 of the Problem-Solving Tools Series. Washington, DC: Office of Community Oriented Policing Services. [Http://ric-zai-inc.com/Publications/cops-p078-pub.pdf](http://ric-zai-inc.com/Publications/cops-p078-pub.pdf).

Johnson, Shane, and Kate Bowers. 2004. "The Burglary as Clue to the Future: The Beginnings of Prospective Hot-Spotting." European Journal of Criminology 1(2): 237–255.

## Хөрш сэргэмжтэй, болгоомжтой байгаарай!

Давтан хохирогч нь өмнөх гэмт хэрэг үйлдэгдсэн даруйд эсвэл долоо хоногийн дараа ижил хохирогч дахин гэмт хэрэгт өртөх эрсдэл өндөр байгаа гэдгийг илэрхийлдэг. Эрсдэлийг ойр орчмын газарт мөн их байж болно. Жилл Дандогийн нэрэмжит Гэмт хэргийн шинжлэх ухааны хүрээлэнгийн Кейт Бауэрс, Шейн Жонсон нар бизнесийн байгууллагууд ихээр байрладаг гудамж, газруудад хулгайн гэмт хэргийн эрсдэл их байгааг харуулсан. Үүнийг доорх графикт үзүүлэв. Гэрт хулгай орсон бол бид үүнийг харьцуулагдах хулгай гэж нэрлэдэг. Графикийн доор байгаа тоонууд нь харьцуулагдах хулгайгаас хол зйтай эсэхийг илэрхийлдэг. Хулгай гарсан цэгүүдийн хоорондох зайд нь

гудамжны нэгэн ижил талд өмнөх хулгайн гэмт хэрэгтэй зэргэлдээ байрлал, цэг эсвэл ойролцоо, эсрэг талын айлыг хэлнэ. Графикт харьцуулагдах хулгайн гэмт хэргийн дараа гарсан хулгайн тоог харуулсан. Мэдээллийг Их Британийн Мерсисайдын цагдаагийн газраас гаргажээ. Харьцуулах хулгайгаас хол байх тусам дахин хулгай хийх эрсдэл буурч байгааг та харж байна. Ямар ч зайд гудамжны нэг талд байгаа байшинд эрсдэл өндөр байдаг. Энэ нь хулгайн гэмт хэргийн дараа ямар байшинг хамгаалах ёстойг харуулж байна. Хулгайллагдсан байшингийн ойролцоо, ялангуяа гудамжны нэг талд байгаа байшингуудад илүү ач холбогдол өгөх хэрэгтэй.



# 30. Давтан гэмт хэргийг харгалзан үзэх

**К**риминологийн үндсэн үзэлбаримтлалын нэг бол гэмт хэрэгтнүүдийн цөөхөн хувь нь хэргийн ихэнхийг үйлддэг. Марвин Вольфгангийн алдарт Филадельфиин судалгаагаар гэмт хэрэг үйлдэгсийн 5 орчим хувь нь гэмт хэргийн 40 хувийг үйлдэж байгааг тогтоосон. Давтан гэмт хэрэг үйлдэхтэй холбоотой хоёр тайлбар байдаг. Нэгдүгээрт бодлогогүй, огцом зантай, бусадтай нийгмийн харилцаа холбоо муутай хүмүүс нийгмийн харилцаа сайтай, огцом биш зантай хүмүүсээс илүү олон удаа асуудалд өртөх хандлагатай байдаг. Хоёр дахь тайлбар нь гэмт хэрэг үйлдэх боломжид ойр хүмүүс тухайн үеийн нөхцөл байдлыг ашиглаж, зохих байдлаар өөрчлөгддөг байна (9 дүгээр алхамыг үзнэ үү). Энэ хоёр онол хоёулаа үнэн. Нийгэмд харилцаа холбоо муутай, бодлогогүй, огцом зантай хүмүүс давтан гэмт хэрэгтэн болохын тулд гэмт хэрэг үйлдэх боломжид тогтмол ойр байх шаардлагатай.

80-20 дүрэм хүчин төгөлдөр эсэхийг шалгах замаар давтан хэрэг байгаа эсэхийг тодорхойлох боломжтой (алхам 18). Гэмт хэрэг үйлдэгчид нэрээ нууцлахыг оролддог тул энэ нь практикт хэцүү байж магадгүй тул цуглуулсан мэдээлэл ямагт бүрэн байдаггүй эсвэл огт хангалтгүй ч байж болно. Тагнуулын мэдээллээр давтан гэмт хэрэг үйлдсэнийг нотлох баримтыг олж болох боловч энэ мэдээллийн чанар нь маш их хувьсамтгай, гэмт хэрэг үйлдэгсийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх нь ховор. Бид ихэвчлэн гэмт хэрэг гарсан газар, хохирогчдын талаар илүү сайн мэддэг. Хэдий тийм ч гэмт хэрэгтэн, тэдний хамтрагчидтай системчилсэн яриллага хийх нь асуудлыг ойлгож, шийдвэрлэхэд хэрэгтэй мэдээллийг олж авахад тусалдаг (алхам 10).

Давтан гэмт хэрэг үйлдэгчийн зорилго, сэдлийг ойлгох нь урьдчилан сэргийлэх стратегийг боловсруулахад тусална. Ганган машин унаж зугаацах, үдэшлэг тараад дараа гэр лүүгээ явах, эсвэл хар тамхи худалдан авахын тулд бэлэн мөнгөөр худалдах зэрэг зорилгуудын аль нь хулгайчийг автомашин хулгайлахад хүргэсэн болохыг олж мэдэх нь асуудлыг шийдвэрлэхэд чухал ач

холбогдолтой. Тодорхой гэмт бүлэглэлийн нутаг дэвсгэрийг тэмдэглэж, "нийтийн зураг, дүрсийг" зурж, хайр сэтгэлээ илэрхийлэх, өөр шашин шүтлэг, арьс өнгө, үндэс угсаатай оршин суугчдыг айлган сүрдүүлэхийг оролдох зэрэг сэдлийн аль нь тухайн этгээдийг графити зурахад хүргэснийг олж мэдсэнээр хариу арга хэмжээ өөрчлөгднө.

Хэргийн эхний оролдлого амжилттай болох нь дараа дараагийн гэмт хэргүүд үргэлжлэх, дахин давтагдахад хүргэдэг. Энэ нь гурван замаар тохиолддог. Үүнд:

1. Гэмт этгээдүүд бусдын адил үйлдлээсээ суралцаж, туршлага хуримтлуулдаг. Эхний оролдлого амжилттай болох нь гэмт хэрэгтнийг олон зүйлд сургадаг. Энэ нь гэмт хэрэгтэн дахин өөр бай, өртөгч руу халдахад хүргэж болзошгүй (хажуугийн талбарыг үзнэ үү). Бусад хүмүүсийн нэгэн адил гэмт хэрэгтнүүд ерөнхийлөн дүгнэж чаддаг. Тиймээс тэд ижил төстэй бай руу халдах тохиолдолд хэрхэн амжилттай гүйцэтгэх талаар суралцдаг. (29 дүгээр алхамыг үзнэ үү).
2. Гэмт этгээдүүд бие биеэсээ суралцдаг. Мэдээлэл жижиг бүлгүүдээр ажиллах, бүлгүүдийг хуваах, шинэ бүлэг байгуулах явцад дамждаг. Энэ нь гэмт хэргийн сүлжээг ойлгох шаардлагатайг харуулж байна. Цагдаа нар гэмт хэрэгтнүүдэд гэмт хэрэг үүлдэхтэй холбоотой эрсдэл, бай газар, байрлалд гэмт хэрэг үйлдэх нь тохиромжгүй талаарх мэдээллийг дээрх сүлжээг ашиглан тарааж болно. Жишээлбэл, Массачусетс мужийн Бостон хотод 18 насанд хүрээгүй хүүхдүүдийн амь насыг хохироосон гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилгоор гэмт бүлэглэлийн гишигдэд чиглэсэн мессежийг дамжуулж байсан билээ.
3. Гэмт хэргийн оролдлого амжилттай болох нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнтэй байдлыг сулруулж, улмаар дараагийн гэмт хэргийн магадлал, эрсдэлийг нэмэгдүүлдэг. Жишээлбэл, хашаанд гарсан жижиг завсар нь

ашиглалтын явцад улам том хэмжээтэй болдог. Хэрэв гэмт хэрэгтнүүдийн шилжилт хөдөлгөөн, үйлдэл нь асран хамгаалагч, менежерийн хариу үйлдлээс илүү хурдан бол уг жижиг асуудал улам дордох болно.

### Давтан хохирогчдод анхаарлаа хандуулснаар давтан гэмт хэрэгтнүүдийг баривчлах боломжтой.

Кен Пис давтан хохирогчдод анхаарлаа хандуулсны үр дүнд бий болох үр дүн, ач холбогдлын талаар бичсэн. Давтан хохироо, халдлага үйлдэх нь ихэнх гэмт хэрэгтнүүдийн түгээмэл сонголт гэдгийг нотлох баримтууд хангальтай хуримтлагдаа байна. Энэ нь нэг өрх, нэг хүний эсрэг давтан гэмт хэрэг үйлдсэнийг илрүүлэх замаар л гэмт этгээдийг онилох, илрүүлэх боломжийг бүрдүүлэх боломжтой гэж тэрээр онцлон тэмдэглэсэн. Гэмт хэрэгтнүүдийг онилох, илрүүлэх энэ төрөл нь иргэний өрх чөлөөг зөрчсөн гэх шүүмжлэлэс зайлсхийх боломж бүрдүүлдэг. Учир нь энэ нь давтан гэмт хэрэг үйлдэгчдийн үйлддэг хамгийн хүндрэлтэй үйлдлүүд дээр төвлөрдөг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон арга техник нь гэмт хэрэгтнүүдэд бодит "эрсдэл" тулгарсныг олж мэднэ гэсэн таамаглал дээр суурилдаг (алхам 40). Камерын хяналт (CCTV) нь гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийг хэн нэгэн хянаж байгаа бөгөөд шаардлагатай тохиолдолд хариу арга хэмжээ авна, эсвэл камерын бичлэгт үндэслэн гэмт этгээдийг дараа нь илрүүлж, баривчлах болно гэсэн "эрсдэл" бий гэх ойлголтыг гэмт хэрэгтнүүдэд төрүүлдэг. Энэ эрсдэлийг бататгахын тулд олон тооны баривчилгаа хийх шаардлагатай гэсэн үг биш бөгөөд цөөн баривчилгааг нийтэд өргөн мэдээлэх нь гэмт хэргийн эсрэг чухал мессежийг дамжуулах бөгөөд тус мессежийг гэмт хэрэгтнүүдийг сүлжээгээр дамжуулан тараах нь илүү үр дүнтэй байх болно.

Ихэнх хэрэг зөрчлийг цөөн хэдэн хүн хийдэг талаар мэдээлэл байгаа бол эдгээр хүмүүст анхаарлаа төвлөрүүлэх нь илүү үр дүнтэй.

Бостоны Цагдаагийн газар харьцангуй цөөн тооны бүлэглэлийн гишүүдийг хянааснаар залуу эрэгтэйчүүдийн дундах хүн амины хэргийг бууруулж чадсан. Фрэнсис Каллен болон түүний хамтрагчид тэнсэн харгалзах болон суллах эрх бүхий газар ямар нөхцөл байдалд хэрэг, зөрчил гарах эрсдэл их байдаг талаар судалж, улмаар гэмт хэрэгтнүүдэд эдгээр нөхцөл байдлаас зайлсхийх төлөвлөгөө боловсруулахад нь тусалж, эцэст нь эдгээр төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавихыг зөвлөж байна.

Орчныг өөрчлөх, арилгах замаар давтан гэмт хэрэгт өртөх магадлалыг бууруулах нь илүү үр ашигтай. Жишээ нь Английн Стейнгийн тосгонд хоёрдогч түүхий эд авах цэг нь хулгайн машин, эд анги болон бусад хулгайн эд зүйлсийг хулээн авдаг байсан бөгөөд үүнтэй холбогдох гэмт хэрэгтнүүдийн талаар цагдаагийн алба нь мэдэж байсан аж. Хэдий тийм ч цагдаагийн байгууллагууд энэ асуудлыг шийдвэрлэж чаддаггүй байжээ. Эцэст нь байгаль орчны бохирдол болон байгаль орчны бусад аюул ослыг зохицуулах хууль тогтоомжид үндэслэн хоёрдогч түүхий эдийн цэгийг хааж чадсан нь тосгоны гэмт хэргийн гаралтыг эрс бууруулсан байна. Үүний нэгэн адил АНУ-ын цагдаа нар хар тамхины наймаа, биээ үнэлэл болон бусад гэмт хэрэг, зөрчлийг өдөөж буй цэг, байгууллагуудыг хаахын тулд иргэний хууль тогтоомжийг өргөнөөр ашигладаг.

Эсрэгээрээ гэмт хэрэгтнүүдийг илрүүлэх, барихын тулд гэмт хэрэг үйлдэх зохиомол боломжийг бий болгох нь нөхцөл байдлыг улам дордуулж болзошгүй. 1970-аад оны сүүл, 1980-аад оны эхээр АНУ-ын цагдаагийн хэд хэдэн хэлтэс хулгайн барааны хуурамч захуудыг бий болгож, ямар хүмүүс энэ зах дээр бараа зарж байсныг баримтжуулсны үр дүнд олон хулгайчийг баривчилсан чадсан. Гэвч үүнд үнэлгээ хийхэд тус арга хэмжээ нь гэмт хэргийн гаралтыг бууруулаагүй, харин хулгайлсан эд зүйлсийг ашигтайгаар зарж борлуулах боломжийг бүрдүүлж, гэмт хэргийн гаралтыг нэмэгдүүлсэн байж болзошгүй гэж зарим судлаачид үзжээ. Энэхүү гарын авлагад бид гэмт хэрэг үйлдэхийг хялбаршуулах нь гэмт хэрэг үйлдэх зан төлөвийг дэмждэг болохыг онцолсоор ирсэн. Тиймээс тодорхой бус давтан гэмт хэрэгтнийг

илрүүлэх зорилгоор гэмт хэргийн зохиомол боломж, орчныг бүрдүүлэх бол маш хянуур, болгоомжтой хандах хэрэгтэй.

Давтан гэмт хэрэг үйлдэгсэд болон тэдний холбоотнуудаас олж авах мэдээлэлд үндэслэн гэмт хэрэг үйлдэх орчин, нөхцөлийг бүрдүүлдэг хүчин зүйлсийн талаар ойлголттой болоход ашиглаж болно. Дэлгүүрт анх хэрэгжүүлсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний ихэнхийг гэмт хэрэгтэнтэй хийсэн ярилцлагын үр дунд боловсруулж байсан (алхам 9). 1970-аад оны эхээр Лейквүүд (Колорадо) цагдаагийн хэлтэс ял эдэлж байсан хулгайч нартай ярилцлага хийж, гэмт хэрэгтнүүд орон байрыг хэрхэн сонгож, онилж, хулгайлсан эд зүйлээ хэрхэн ашигладаг талаар их зүйлийг мэдэж авсан. Ньюпорт Ньюос (Виржиниа) Цагдаагийн газар тээврийн хэрэгслээс эд зүйл хулгайлах гэмт хэрэгт дүн шинжилгээ хийхэд туслах зорилгоор гэмт хэрэгтнүүдтэй хийсэн ярилцлагыг ашигласан. Тэдний олж авсан нэг

чухал мэдээлэл бол хулгайч нар хар тамхи байж болзошгүй машинуудыг гэмт хэргийн бай болгон онилж байв. Саяхан Чула Виста (Калифорни) цагдаагийн газар нь мөрдөн байцаагч нарын сэжиглэж байгаагаас илүү хялбар, энгийн байдлаар машин хулгайлах аргыг хэрэглэдэг болохыг олж мэдсэн. Энэ нь тодорхой хийц, загварын хуучин машинууд хулгайн хэрэгт өртөмтгий, эмзэг байдаг талаар мөрдөн байцаагчдад анхааруулсан. Ийм мэдээллийг өөр эх сурвалжаас авах боломжгүй.

#### **Нэмэлт материал:**

Cullen, Francis, John Eck, and Christopher Lowenkamp. 2002. "Environmental Corrections—A New Framework for Effective Probation and Parole Supervision." *Federal Probation* 66(2):28–37.

Kennedy, David, Anthony Braga, Anne Piehl, and Elin Waring. 2001. Reducing Gun Violence: The Boston Gun Project's Operation Ceasefire. Washington, DC: National Institute of Justice. [Https://www.ncjrs.gov/pdffiles1/nij/188741.pdf](https://www.ncjrs.gov/pdffiles1/nij/188741.pdf).

## 31. Гэмт хэрэгтнүүдийн хүсэж байгаа зүйлсийг тодорхойлох (CRAVED аргачлал)

**A**лхам 18-д дурдсан 80-20 зарчмын дагуу хулгайч нар юу хулгайлах талаар сонголт хийхдээ маш нарийн бодож тооцоолдог тул бүх эд зүйлс хулгайд өртөх бай болдоггүй. Тэд машин, зөөврийн компьютер, DVD тоглуулагч, гар утас гэх мэт харьцангуй цөөн тооны өндөр үнэтэй эд зүйлсэд анхаарлаа хандуулдаг. Хамгийн өртөмтгий бүтээгдэхүүн бол бэлэн мөнгө бөгөөд Маркус Фэлсон үүнийг "гэмт хэрэг үйлдэгчийн гол хүсэл, сонирхол" гэж тодорхойлдог. Энэ нь хулгай, дээрэм, булаалтын гэмт хэргүүдэд хамгийн их өртдөг зүйл юм. Үүний улмаас банкууд болон мөрийтэй тоглоомын газруудыг дээрэмдэх, таксофон руу халдах, ATM-ын ойролцоо хулгай хийх зэрэг гэмт хэрэг үйлдэгддэг.

Хүмүүсийн эд хөрөнгө нь гэмт хэргийн хохирогч болох эрсдэлийг тайлбарлахад тусалдаг. Жишээлбэл, хүн ам зүй, нийгмийн хувьсагчдын олон хүчин зүйлс байгаа боловч машинтай байх нь гэмт хэргийн хохирогч болох эрсдэлийг хоёр дахин нэмэгдүүлдэг. Мөн тухайн машины загвар нь энэ эрсдэлийг хэд дахин нэмэгдүүлдэг.

Хүмүүст өндөр эрсдэлтэй автомашины талаар мэдээлэл өгөх, аюулгүй байдлыг сайжруулахын тулд, үйлдвэрлэгчдэд нөлөөлөл үзүүлэхийн тулд Вашингтон ДС-ийн Замын хулгайн мэдээллийн хүрээлэнгээс зам дээрх тодорхой загвар бүрийн хулгайтай холбоотой даатгалын нөхөн төлбөрийг жил бүр гаргуулдаг. Доорх хүснэгтэд 2001-2003 оны 305 шинэ загвараас хулгайн гэмт хэрэгт хамгийн өндөр болон хамгийн бага давтамжтай (зам дээр байгаа 1000 тээврийн хэрэгсэл тутамд) таван загварыг харуулав. Cadillac Escalade болон Nissan Maxima-ийн өртөх давтамж нь хамгийн бага хулгай, зөрчилтэй таван загвартай харьцуулахад 30 дахин их байсан. Escalades нь тусгай захиалгын дугуйн улмаас, харин Maximas нь өндөр эрчимтэй гэрлээс шалтгаалж хулгайн өртөгч, бай болдог бөгөөд энэ нь ийм гэрлээр тоноглогдоогүй өмнөх загварууд ч мөн адил тохирч байгаа нь хэргийн давтамжийг улам нэмэгдүүлсэн.

Эдгээр өгөгдөл, мэдээлэл нь ач холбогдолтой боловч хулгайн аль нэг хэлбэрт яг ямар машин хамгийн их өртөж байгааг харуулдаггүй. 1980-аад онд хийсэн судалгаагаар машинаар зугацаагчдын илүүд үздэг загварууд нь Chevrolet Camaro зэрэг хүчтэй, хурдтай машинууд байсан болохыг тогтоожээ. Ихэнхдээ хулгайллагаад, дахиж олдоогүй загваруудад нь Линкольнс, Мерседес зэрэг үнэтэй машинууд байсан бол ихэнхдээ эвдэлж эд ангиудыг нь тонож авсан загварууд нь бусад олон төрлийн машины загварт тохирдог, сайн радиотой Volkswagen гэх мэт Европын загварууд байв. Гэр булийн тээврийн гол хэрэгсэл болох дотоодын машинууд хулгайд өртөх эрсдэл багатай байлаа. Эдгээр нь хямдхан бөгөөд муу, чанаргүй радиотой байсан бөгөөд машинаар зугацаагчид сонирхдоггүйтэй холбоотой.

Хулгайн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Судалгааны Зөвлөлөөс хийсэн судалгаагаар дэлгүүрийн хулгайчид CD, тамхи, архи, мөн Hilfiger жинсэн өмд, Nike пүүз зэрэг загварын эд зүйлсийг түлхүү сонгодог болохыг харуулж байна. Эдгээрийн ихэнхийг гудамжинд эсвэл зарим газар хаалганаас хаалганд зарах боломжтой. Ийм төрлийн гэмт хэргийг нотлоход хүндрэлтэй, харьцангуй хөнгөн ял тулгадаг тул ийм төрлийн хулгайн эд зүйлийг хамгаалахад цагдаагийнхан төдийлөн анхаарал хандуулдаггүй ч ломбардын гүйлгээний талаар олон хэлтэс цахим хэлбэрээр тогтмол мэдээлэл авдаг болсон. Эдгээр тайлангуудыг уншиж танилцсанаар танай газар хулгайч болон бусад хүмүүс юу хулгайлж байгаа талаар мэдээлэлтэй байх болно. Энэ нь хулгайлсан бараа хэрхэн зарагддаг, зах зээлд нөлөөлөх арга замуудын талаар бодоход тусална.

## Авто машины хулгайн нэхэмжлэлийн давтамж, 2001-2003

		<b>1000 машин тутам дахь давтамж</b>
<b>Хамгийн өндөр тохиолдол бүхий хулгайн давтамж, 2001-2003</b>		
Cadillac Escalade EXT (2002-03)	Том оврын, тансаг зэрэглэлийн пикап	20,2
Nissan Maxima (2002-03)	Дунд оврын дөрвөн хаалгатай машин	17,0
Cadillac Escalade (2002-03)	Том оврын, тансаг зэрэглэлийн SUV	10,2
Dodge Stratus/Chrysler Sebring	Дунд оврын, 4 хаалгатай машин	8,3
Dodge Intrepid	Том оврын, 4 хаалгатай машин	7,9
<b>Хамгийн бага тохиолдол бүхий хулгайн давтамж, 2001-2003</b>		
Buick lesabre	Том оврын, 4 хаалгатай машин	0,5
Buick Park Avenue	Том оврын, 4 хаалгатай машин	0,5
Ford Taurus	Том оврын, пургон хэлбэрийн машин	0,5
Buick Rendezvous 4WD (2002-03)	Дунд оврын SUV	0,7
Saturn LW	Дунд оврын пургон	0,7
<b>Дундаж:</b>		2,5

Эх сурвалж: Highway Loss Data Institute ([www.hldi.org](http://www.hldi.org))

CRAVED гэсэн товчлол нь ямар эд зүйлс хамгийн ихээр хулгайд өртдөгийн тодорхойлоход тусална. Эдгээр эд зүйлсэд дараах зүйлс багтана. Үүнд:

- нуух боломжтой (concealable),
- зөөвөрлөх боломжтой (removable),
- бэлэн (available),
- үнэ цэнтэй (valuable),

- тааламжтай (enjoyable),
- борлуулахад хялбар (disposable).

Одоо эдгээрийг тус тусад нь тайлбарлай.

- **Нуух боломжтой.** Халаас эсвэл цүнхэнд нуух боломжтой эд зүйл нь дэлгүүрт болон бусад төрлийн хулгайч наарт илүү өртөмтгий байдаг. Хулгайлсны дараа илрүүлэхэд хэцүү эсвэл амархан нуух

боловжтой эд зүйлс хулгайд өндөр эрсдэлтэй байдаг. Зарим тохиолдолд барилгын талбай дээр үлдсэн мод, тоосго хулгайд алдагдах нь элбэг. Хулгайд өртөмтгий эд зүйлсийн жагсаалтыг тоочвол урт жагсаалт болно.

- Шилжүүлэх, салгах, зөөвөрлөх боломжтой.** Машин, унадаг дугуй нь хөдөлгөөнт, шилжүүлэх, зөөх боломжтой учраас хулгайд өртөх нь элбэг байдаг. Зөөврийн компютерууд нь өндөр үнэтэй, чухал хэрэгцээтэй төдийгүй авч явахад хялбар учир хулгайд өртөх магадлал өндөр байдаг нь гайхмаар зүйл биш юм. Юг авч явахад хялбар байх нь хулгайн төрлөөс хамаарна. Орон байрны хулгайч болон дэлгүүрийн хулгайчид хоёулаа супермаркетуудаас тамхи, архи, эм, гоо сайхны хэрэгсэл хулгайлдаг ч орон байрны хулгайч нар илүү олон тоотойгоор хулгайлдаг.
- Бэлэн.** Өргөн тархсан, хайж олоход хялбар эд зүйлс хулгайд өртөх эрсдэл өндөртэй. Энэ нь хүмүүс яагаад хулгайчдаас үнэт эдлэл, бэлэн мөнгөө нуухыг оролддогийг тайлбарладаг. Энэ нь машинууд яагаад хуучрах тусам хулгайд өртөх эрсдэл нэмэгддэг болохыг тайлбарлахад тусалдаг. Тусгай зогсоолын талбай багатай ядуучуудын хороололд амьдардаг, гэмт хэрэг үйлдэгчид олноороо байдаг хороололд амьдардаг хүмүүст ийм эд зүйлс эзэмших нь олонтоо. Эцэст нь, хулгайд өртөх эрсдэл ихтэй зүйлсэд хууль бус зах зээлийг хурдан бий болдог шинэлэг гар утас гэх мэт сонирхол татсан шинэ бүтээгдэхүүн байж болно (хажуугийн самбарыг үзнэ үү).
- Үнэ цэнтэй.** Хулгайч нар ихэвчлэн илүү үнэ цэнтэй эд зүйлсийг сонгодог. Ялангуяа цааш нь дамжуулан худалдах зорилгоор ихэвчлэн хулгай хийдэг. Гэхдээ үнэ цэнийг зүгээр нэг дахин борлуулагдах байдлаар нь тодорхойлохгүй. Тиймээс, насанд хүрээгүй дэлгүүрийн хулгайчид өөрсдийн хэрэгцээнд зориулж хулгай хийхдээ үе тэнгийнхнийхээ дунд байр сууриа илэрхийлэх эд зүйлсийг сонгож болно. Өөрөөр хэлбэл машинаар зугацах гэж хулгай хийдэг хүмүүс машины санхүүгийн

үнэ цэнэ гэхээсээ илүү хурд хүч гэх мэт үзүүлэлтүүдийг илүү анхаардаг.

- Тааламжтай, зугаа цэнгэлийн эд зүйлс.** Өртөмтгий бүтээгдэхүүн нь ихэвчлэн архи, тамхи, DVD гэх мэт хэрэглээний эд зүйлс эсвэл хэрэглэхэд тааламж, зугаатай байдал үүсгэдэг эд зүйлс байх хандлагатай. Тиймээс орон сууцны хулгайчид богино долгионы зуух гэх мэт үнэ цэнтэй электрон бараанаас илүү DVD тоглуулагч, телевизор авах магадлал өндөр байдаг. Энэ нь олон хулгайч нарын (болон тэдний үйлчлүүлэгчдийн) зугаа таашаалд нийцсэн бүтээгдэхүүнүүд юм.
- Борлуулахад хялбар.** Саяхан өртөмтгий эд зүйлс болон хулгайн зах зээлийн хоорондын хамаарлын талаар системтэй судалгаа хийгдэж эхэлсэн боловч хулгайч нар зарахад хялбар зүйлийг сонгох хандлагатай байдаг. Энэ нь яагаад зай хураагуур болон нэг удаагийн сахлын машин нь Америкийн эмийн сангаас хамгийн их хулгайлалддаг эд зүйлс байдгийг тайлбарлахад тусална.

#### Нэмэлт материал:


Clarke, Ronald. 1999. Hot Products: Understanding, anticipating and reducing demand for stolen goods. No. 112 in Police Research Series. London: Home Office. [Http://www.popcenter.org/problems/burglary\\_retail/pdfs/fprs112.pdf](http://www.popcenter.org/problems/burglary_retail/pdfs/fprs112.pdf).

## Тодорхойлох мэдээллийг нь шилжүүлсэн утасны өсөлт, бууралт

Гар утас түгээмэл болохын хэрээр гэмт хэрэгтнүүд ямар ч төлбөр төлөхгүйгээр утасны код, нууцлалыг нээх, хувилах аргыг олжээ. Тэд дуудлага хүлээн авах, илгээхийн тулд утаснуудын дамжуулж буй дугааруудыг олж мэдэх, авахын тулд нисэх онгоцны буудал, зочид буудлын ойролцоо сканер төхөөрөмжийг ашигладаг. Дараа нь тэд хулгайлсан утаснуудынхаа дугаарыг дахин программчлах замаар анхны утаснуудтай ижил "клон, хувилбар"-ыг гаргадаг. Дараа нь клон, хувилбар утсаар хийсэн дуудлагын төлбөр нь эх утсан дээр тооцогдоно. Энэ нь богино хугацаанд маш өргөн хүрээтэй бизнес болж хувирсан. Графикийн дээд шугамаас харахад бүх гар утасны компаниудын хуулбарлалт, клончлолын гэмт хэрэг 1992 оны 6-р сараас 1996 оны 6-р сар хүртэл маш хурдацтай өсөж, өмнөх 6 сарын хугацаанд нийтдээ 450 сая доллар

болсон байна. (энэ төрлийн гэмт хэрэг нь жинхэнэ утаснаас нь хуулбарлагдсан, хууль ёсны захиалагчдын төлбөрийг устгасантай холбоотой юм.) Ийм учраас үүрэн холбооны болон харилцаа холбооны компаниуд утасны дугаар хулгайллах, утасны дугаар ашиглахын эсрэг илүү нарийн төвөгтэй технологиудыг нэвтрүүлж эхэлсэн. Хуулбарлах: Үүний үр дүнд хуулбарлалт, клончлол буурч, 1999 оны 12-р сар гэхэд энэ төрлийн гэмт хэрэг халж чадсан. Дашрамд дурдахад, гар утасны гэмт хэргийн хоёр дахь хамгийн түгээмэл хэлбэр бол "хуурамч захиалгын луйвар" (хуурамч нэр, хаягаар данс нээх) юм. Гэхдээ энэ төрлийн гэмт хэрэг гар утасны хуулбарлалтын адил тийм өндөр хэмжээнд хүртлээ хөгжиж чадаагүй. Энэ нь зохион байгуулалттай гэмт хэрэгтнүүд хуулбарлах, клончлох гэмт хэргийг "бөөнөөр хийх"-эд хялбар байсан байсан бол захиалгын луйвар нь тийм биш.

1992 оны 6-р сараас 1999 оны 12-р сар хүртэлх хугацаанд АНУ-д хагас жилийн залилангийн гэмт хэрэг, доллароор



Эх сурвалж: Clarke, Ronald, Rick Kemper, and Laura Wyckoff. 2001. "Controlling Cell Phone Fraud in the US: Lessons for the UK 'Foresight' Prevention Initiative." Security Journal 14(1): 7–22. <http://www.palgrave-journals.com/sj/journal/v14/n1/pdf/8340070a.pdf>.

**A**суудлыг шинжлэхдээ "Бусад ижил төстэй байгууллагуудад хүндрэл, асуудал бага байхад яагаад зарим хүмүүс, газар, цаг хугацаа, үйл явдлууд илүү асуудалтай, хүндрэлтэй байдаг вэ?" гэж асуух нь чухал ач холбогдолтой асуулт юм. Ийм асуултад хариулахын тулд асуудал ихтэй тохиолдлуудыг (буюу кейсүүдийг) асуудал багатай тохиолдлуудтай харьцуулах хэрэгтэй.

Энэ төрлийн харьцуулалтыг кейс-хяналтын судалгаа гэж нэрлэдэг. Кейс хяналтын судалгаа нь асуудал ихтэй хүмүүс, газар, цаг хугацаа эсвэл үйл явдлыг асуудал багатай хүмүүс, газар, цаг хугацаа, үйл явдлуудтай харьцуулахыг хэлнэ. Хүнд хэцүү, асуудал ихтэй тохиолдлуудыг кейсүүд (хэргүүд) гэж нэрлэдэг. Тэдгээрийг харьцуулсан судалгааг хяналт гэж нэрлэдэг.

Үүний жишээг Шоуни (Канзас) хотын цагдаагийн газрын гэмт хэргийн шинжээч Сюзан Верникийн өгсөн мэдээллээс харж болно. Шоуни дахь баарнуудын хувьд тэрээр мэдүүлсэн хүчин чадлын 100 хүн тутамд ногдох цагдаагийн дуудлагын тоог тооцоолжээ. Үүнийг харилцан адилгүй хүчин чадал, хэмжээтэй бааранд тохируулсан (27 дугаар алхмыг үзнэ үү). Дараагийн хуудсан дээрх зурагт бааруудыг хүчин чадал хамгийн ихээс хамгийн бага руу эрэмбэлсэн байгаа. Кейс-хяналтын үндсэн судалгааг энд ашиглаж болно. Хамгийн өндөр хувь хэмжээтэй бааруудыг хамгийн бага хувь хэмжээтэй бааруудтай харьцуулж, тэдгээрийн үйл ажиллагаа явуулах арга барил, зан төлөв, хэв маяг, соёл, бааранд татагддаг үйлчлүүлэгчдийн төрлөөр системчилсэн ялгаа байгаа эсэхийг шалгасан.

Асуудал ихтэй тохиолдлууд нь асуудал хүндрэл багатай тохиолдлоос давтамжийн хувь бага үед кейс-хяналтын судалгаа илүү ач холбогдолтой байдаг. Асуудлыг шийдвэрлэхэд ийм нөхцөл байдал түгээмэл тохиолддог билээ.

Кейс-хяналтын судалгаа хийхийн тулд та дараах зүйлийг хийх хэрэгтэй. Үүнд:

- Тохиолдлуудаа нарийн тодорхойлоо.

- Эдгээр тохиолдлын төлөөллийн түүврийг сонго.
- Ижил төстэй нөхцөл байдалтай (жишээ нь, нэг хороолол эсвэл хотод, ижил үйлчлүүлэгчтэй зэрэг) часуудалүүсдэггүй хяналтын бүлгийг тодорхойлох.
- Хяналтын түүврийг сонго.
- Тохиолдлуудын шинж чанарыг хяналтын шинж чанаруудтай харьцуулна.

Кейс хоорондын томоохон ялгаа нь асуудалд нөлөөлж байж болзошгүй онцлог шинж чанаруудыг тодорхойлдог. Ижил төстэй байдал нь асуудалд нөлөөлөхгүй байж болох онцлог шинж чанаруудыг илтгэнэ. Эдгээр алхмуудыг жишээгээр авч үзье.

Шоуни хотын баарны энгийн жишээ нь эхний дөрвөн алхмыг харуулдаг. Кейс хяналтын судалгааны зарим нарийн зүйлсийг тодруулахын тулд бид илүү төвөгтэй жишээг авч үзэж болно.

**Тохиолдлуудыг нарийн тодорхойлоо.** 1990-ээд оны эхээр Жон Экк яагаад цөөхөн хэдэн газарт хар тамхины наймаа байнга явагдаж байгааг, ойролцоо бусадихэнх газрууд яагаад тийм биш байгаад анхаарлаа хандуулсан. Сан Диегогийн (Калифорни) цагдаагийн газрын тусlamжтайгаар Сан Диегогийн нэг дүүрэгт хар тамхи тасралтгүй худалдаалдаг газруудын 300 гаруй кейс, хэргийг илрүүлжээ. Эдгээрийг иргэдийн дуудлага, хар тамхитай тэмцэх ажиллагаа, хэргийн газрын байцаалт, баривчилгааны мэдээлэл, эргүүлийн цагдаа нарын ажиглалт зэрэгт үндэслэн тогтоосон. Тасралтгүй гэжангилахын тулд газар, байрлал тус бүр нь нэгээс олон удаа хар тамхины хэрэгтэй холбоотой баривчилгаа явагдах, дуудлага хийгдсэн байх, эсвэл хэргийн газрын байцаалт хийх, эсвэл нэвтрэх зөвшөөрөл авч байсан, эргүүлийн цагдаагийн хяналтад орсон байх зэрэг шалгууруудыг ашигласан. Эдгээр газруудыг тогтоохын тулд олон үзүүлэлт ашигласан тул ихэнх тасралтгүй худалдаалдаг газруудыг илрүүлсэн гэж үзэх нь үндэслэлтэй болов уу.

**Асуудал бүхий тохиолдлуудын түүврийг сонгох.** Нэг хууль бус үйл ажиллагаа явуулдаг газар бүхий хорооллын хувьд тухайн газрыг

судлахаар сонгосон. Хэрэв хороололд хоёр хууль бус арилжаа, худалдаа, үйлчилгээний газар байсан бол хоёуланг нь сонгосон. Хэрэв хоёроос дээш байвал хоёрыг санамсаргүй байдлаар сонгосон. Үүний үр дүнд 189 газар бүхий төлөөлөх түүврийг бий болгосон. Бүх тохиолдлыг хамруулах боломжтой ч энэ нь судалгааны зардлыг нэмэгдүүлнэ. Энгийн санамсаргүй түүврийг бас ашиглаж боломжтой ч нөлөөлөлд өртсөн бүх хорооллыг хамрах эсэх нь мөн тодорхойгүй.

**Асуудал үүсгэж болзошгүй хяналтын бүлгийг тодорхойлох.** Хяналтууд нь хар тамхины наймаа байгаа эсэхийг нотолж чадаагүй газрууд юм. Эдгээр газруудыг гэмт хэрэгтнүүд наймаа хийх байршил хайж байхдаа авч үзсэн боловч сонгоогүй байх тохиолдолд хамгийн тохиромжтой. Тиймээс ойр орчмын газрууд нь хар тамхины наймаачдын хараанд өртсөн боловч сонгогдоогүй газрууд гэсэн үг. Хяналт нь кейс, хэрэг байж болохоор байсан боловч тодорхойгүй шалтгааны улмаас тийм болоогүй байх нь зүйтэй. Иймд судалгааны зорилго энэхүү тодорхой бус хүчин зүйл юу болохыг олж мэдэх явдал юм.

**Хяналтын түүврийг сонгох.** Асуудал бүхий тохиолдлын түүврийг сонгохтой ижил тоо хэмжээгээр түүврийг бүрдүүлсэн. Эдгээр газруудыг (хэрэв тэдгээр нь сугалаанд багтсан бол кейс байж болно) хар тамхины үйл ажиллагааны явуулдаггүй газар тус бүрийн жагсаалтаас санамсаргүй байдлаар сонгосон. Хууль бус үйл ажиллагаа явагддаггүй бүх байрлалуудыг сонгох нь практикийн хувьд боломжгүй. Учир нь хууль бус үйл ажиллагаа явуулдаггүй газрууд мянга мянгаараа байгаа учраас тэдгээрийн тоо маш их болно. Түүврийн явцад тохиолдууд болон хяналтууд нь нэг газраас гаралтай эсэхийг шалгасан болно. Санамсаргүй сонголт хийсэн хууль бус үйл ажиллагаа явуулдаггүй бүх газрыг ижил тэгш төлөөлж чадах түүврийг бүрдүүлэх зорилготой.

**Тохиолдуудыг хяналттай харьцуулах.** Тухайн газрын талаарх мэдээллийг бүртгэхийн тулд кейс ба хяналтуудад ажиглагчдыг хуваарилсан. Үүнд бүтцийн төрлийн мэдээлэл (бизнес, орон сууцны барилга, нэг айлын орон сууц, сүл талбай гэх мэт), тухайн гудамжны төрөл (замын

тоо, нэг талын/хоёр талын гэх мэт), хамгийн ойрын хурдны зам хүртэлх зайд, эргэн тойрон дахь барилга байгууламжийн төрлүүд, гэрэлтүүлгийн байдал, орон сууцны тоо, хашаа болон бусад хамгаалалт байгаа эсэх, гудамж, замтай зэргэлдээ, ойролцоо эсэх болон бусад олон хүчин зүйлсийг харгалzan үзсэн. Зорилго нь эдгээр онцлог шинж чанаруудын аль нэгээр нь хар тамхи худалдаалдаг газрууд нь хар тамхины худалдаа хийдэггүй газруудаас эрс ялгаатай эсэхийг шалгах явдал байв. Хоёр хэв маяг тогтоогдсон. Үүнд: crack (хар тамхины төрөл) худалдаалдаг нэг газар, метамфетамин худалдаалдаг бусад газрууд. Хяналттай харьцуулахад crack-ийн байршил нь цоожтой хашаатай жижиг орон сууцны байшинд илүүтэй байрладаг, харин метамфетамины голомт нь нэг айлын байшинд, замтай зэргэлдээ байх магадлал өндөр байв. Хар тамхины наймаачид жижиг байшинг (цөөн орон сууц эсвэл ганц айлын байшин) илүүд үздэг нь хараа хяналт багатай газрыг илүүд үздэгтэй холбоотой. Хожим хийсэн нэгэн туршилтад судлаач Экк нь орон сууцны эзэдэд хөндлөнгөөс нөлөөлөх нь хар тамхитай холбоотой гэмт хэргийн гаралтыг бууруулдаг болохыг олж мэдсэн.


Кейс хяналтын судалгаа нь бусад ихэнх судалгаанаас ялгаатай бөгөөд өгөгдөл дүн шинжилгээ хийхэд тусгай арга техникийг шаарддаг. 33 дугаар алхамд илүү ач холбогдолтой нэг арга техникийг тайлбарласан.

Асуудалд дүн шинжилгээ хийхэд кейс-хяналтын судалгаа маш их хэрэгтэй байдаг. Энэ аргыг цөөн тооны газруудад (Шавнигийн жишээн дээрх шиг) эсвэл маш олон тооны (Сан Диегогийн жишээн дээрх шиг) газруудад хэрэглэх боломжтой байдаг. Хэдийгээр эдгээр жишээнүүд нь байрлал, газарт гол анхаарлаа хандуулсан боловч хүмүүс, цаг хугацаа, үйл явдал зэрэгт тулгуурлан хэрэглэж болно.

#### **Нэмэлт материал:**

Loftin, Colin, and David McDowall. 1988. "The Analysis of Case-Control Studies in Criminology." Journal of Quantitative Criminology 4(1): 85–98. [Http://link.springer.com/article/10.1007/BF01066886](http://link.springer.com/article/10.1007/BF01066886).

## Канзасын Шоунид цагдаагийн дуудлага ихтэй болон багатай баарнуудыг харьцуулах нь,



### Хяналтгүй кейс судалгааг бүү хий

Зөвхөн асуудалтай байгаа хүмүүс, газар, цаг хугацаа, үйл явдлын талаар мэдээлэл цуглуулах алдааг нийтлэгээр гаргадаг. Энэ нь төөрөгдүүлсэн үр дүнд хүргэж болзошгүй, учир нь та зөвхөн асуудал, хүндрэлтэй тохиолдлуудын дунд нийтлэг байдаг шинж чанаруудын талаар л мэдэж авдаг, гэхдээ тэдгээр нь асуудал, хүндрэл багатай тохиолдлуудаас юугаараа ялгаатай болохыг олж мэдэхгүй. Үүний нэг жишээ бол 1990-ээд оны эхээр Холбооны мөрдөх товчооноос цагдаа нарын амь насыг хөнөөсөн хэрэгт дүн шинжилгээ хийхийн тулд хийсэн судалгаа юм. Судлаачид албан үүргээ гүйцэтгэхдээ амь үрэгдсэн алба хаагчдын мэдээллийг цуглуулсан боловч ижил төстэй нөхцөл байдалд өртсөн боловч амь үрэгдээгүй алба хаагчдын мэдээллийг цуглуулаагүй. Тиймээс нас барсан алба хаагчдын ямар шинж чанар нь тэднийг амшиг алдахад нөлөөлсөн болохыг бид мэдэхгүй. Ижил нөхцөл байдалд өртөөд амьд гарч чадсан цагдаагийн алба хаагчид амь үрэгдсэн алба хаагчидтай ижил шинж чанаруудтай байх боломжтой.

## 33. Хамаарлыг хэмжих

**A**втомашини хулгайн хэрэг үүдний жижүүртэй зогсоолуудад жижүүргүй зогсоолоос бага гардаг уу? Талбайн менежерүүдтэй орон сууцны байшингууд ийм менежергүй байшигуудтай харьцуулахад хар тамхины наймаанд өртөх эрсдэл бага байдаг уу? Энэ мэт асуултуудад хариулахын тулд хүн, газар, үйл явдлын шинж чанар нь асуудалтай (гэмт хэрэг, гэмтэл гэх мэт) статистикийн хамааралтай эсэхийг тодорхойлох шаардлагатай.

Хамаарлыг тооцоолох олон арга замууд бий. Ихэнхдээ корреляцын коэффициентыг ашигладаг. Корреляцын коэффициент нь -1 (хасах нэг) ээс 1 (нэмэх нэг) -ийн хооронд хэлбэлздэг. Сөрөг корреляц хамаарал гэдэг нь нэг шинж чанарын өсөлт нь нөгөөгийнх нь бууралттай (мөн бууралт нь нөгөөгийн өсөлттэй холбоотой) холбоотой гэсэн уг юм. Зэрэг корреляц хамаарал гэдэг нь нэг шинж чанар нэмэгдэх нь нөгөө шинж чанар нь нэмэгдэхийг илэрхийлнэ (мөн нэг нь буурах нь нөгөө нь буурахтай холбоотой). Коэффициентууд их байх нь хамаарал хүчтэйг (зэрэг эсвэл сөрөг) илэрхийлнэ. Хэрэв корреляцын коэффициент тэгтэй ойролцоо байвал хамаарал байхгүй буюу нэг шинж чанарын өөрчлөлт нь нөгөөгийн өөрчлөлттэй холбоогүй болохыг илтгэнэ. Excel, эсвэл статистикийн тооцооны программуудаар энэ тооцооллыг хийх боломжтой.

Жексонвилл-Дювал тойргийн (Флорида) Шерифийн Хэлтсийн Гэмт Хэргийн Шинжилгээний Алба нь 50 гаруй нэгжийн орон сууцны хотхонуудыг шалгажээ. Тэд 269 орон сууцны хотхоны хувьд өрхийн тоо болон гэмт хэргийн тоо хоорондын хамаарал нь ойролцоогоор .57 буюу бага зэрэг зэрэг хамааралтай болохыг тогтоожээ. Эдгээр орон сууцны хотхонд үйлдэгдэж буй өмч хөрөнгийн гэмт хэргийн тоо болон хүчирхийллийн гэмт хэргийн тоо маш өндөр зэрэг (.91) хамааралтай.

Та кейс-хяналтын судалгаанд хамаарлыг хэмжихийн тулд корреляцын коэффициентыг ашиглах нь буруу (алхам 32). Үүний оронд та магадлалын харьцааг (odds ratio) ашиглах хэрэгтэй.

Магадлалын харьцаа нь тэгээс их ямар ч тоо байж болно. Хэрэв магадлалын харьцаа нэгтэй тэнцүү бол шинж чанар ба үр дүнгийн хооронд ямар ч хамаарал байхгүй. Өөрөөр хэлбэл, шинж чанар байгаа эсэхээс үл хамааран үр дүнгийн эрсдэл ижил байна. Хэрэв магадлалын харьцаа 0-с 1-ийн хооронд байвал шинж чанар байхгүй үед үр дүнгийн эрсдэл байгаагаас өндөр байна (сөрөг хамаарал). 0.1 магадлалын харьцаа нь тухайн шинж чанар байгаа үед гарах үр дагаврын эрсдэл нь тухайн шинж чанар байхгүй үед гарах эрсдэлийн аравны нэгтэй тэнцэж байгааг харуулж байна. Хэрэв магадлалын харьцаа 1-ээс их байвал шинж чанар нь байхгүй үеийнхээс (зэрэг хамаарал) байгаа үед үр дүнгийн эрсдэл өндөр байдаг. З магадлалын харьцаа нь шинж чанар байгаа үед үр дагаврын эрсдэл нь байхгүй үеийнхээс 3 дахин их байна гэсэн уг юм.

Магадлалын харьцааг (odds ratio) ашиглахын тулд үр дүн болон шинж чанар нь зөвхөн хоёр утгатай байх ёстой. Жишээлбэл, үр дүнгийн хувьд 1 гэдэг баар нь гэмт хэргийн өндөр үзүүлэлттэй, 0 нь гэмт хэрэг багатай гэсэн уг юм. Онцлогийн хувьд 1 нь халдлага, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалтад хамрагдсан гэсэн уг, 0 нь ажилтнуудыг ийм сургалтад хамруулаагүй гэсэн уг юм. Халдлага, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэгдсэн ажилтнуудтай баар болон их хэмжээний гэмт хэрэг үйлдэгддэг баарны хооронд ямар нэг хамаарал байгаа эсэхийг магадлалын харьцаа танд хэлэх болно. Энд бид сөрөг хамаарал гэсэн хүлээлттэй байгаа тул магадлалын харьцаа нэгээс бага байх ёстой.

1-р Хүснэгт магадлалын харьцааг хэрхэн тооцоолохыг харуулав. Үр дүнг хүснэгтийн мөрөнд, шинж чанарыг хүснэгтийн баганад илэрхийлсэн. Үр дүн болон шинж чанарын аль алинд нь тохиорх утгыг хүснэгтийн огтлолцох нүд бүрт бичигдсэн. А нүд нь тухайн шинж чанартай тохиолдлын тоог агуулна. С нүд нь шинж чанаргүй тохиолдлын тоог агуулдаг. В нүд нь шинж чанартай хяналтын тоог агуулна. Д нүдэнд шинж чанаргүй хяналтын тоог агуулна. Хүснэгтийн доод талд байгаа томьёогоор тооны машин ашиглан

магадлалын харьцааг тооцоолж болох боловч статистикийн олон багц программуудад үүнийг хялбархан гүйцэтгэх боломжтой.

2-р Хүснэгт энд Сан Диего дахь хар тамхины худалдаа эрхэлдэг газруудын хүрээнд кейс-хяналтын судалгаанд магадлалын харьцааг хэрхэн ашиглахыг харуулав (32 дугаар алхмыг үзнэ үү). Үр дүн нь кокаин эсвэл героины тасралтгүй наймаа юм. Судалгаанд тасралтгүй хар тамхины наймаа явагддаг, тасралтгүй үйл ажиллагаатай (кейс) гэсэн үзүүлэлттэй 58 орон сууц байсан. Мөн судалгаанд хар тамхины наймаа илрээгүй (хяналт) 47 орон сууц байсан. Түгжээтэй эсвэл онгорхой хаалга эсвэл талбайн менежерүүд ажиллах нь хар тамхины наймаачин худалдаа хийх байршилаа сонгоход нөлөөлдөг үү? Түгжээгүй хаалгатай орон сууцыг цоожтой хаалгатай эсвэл хаалгагүй орон сууцтай харьцуулж үзэхэд магадлалын харьцаа нэгээс их байсан ч энэ нь статистик ач холбогдолтой байгаагүй (53 дугаар алхмыг

үзнэ үү), тиймээс бид түгжээгүй хаалга болон хар тамхины наймаа явагдах хооронд хамаарал (магадлалын харьцаа нэг бол ямар ч холбоо байхгүй) байхгүй гэж хэлэх боломжийг үгүйсгэж чадахгүй. Түгжээтэй хаалга болон хар тамхины наймаа хоёрын хоорондын хамаарал ач холбогдол бүхий эерэг байна. Хаалга нь түгжээтэй барилгуудад кокаин эсвэл героин худалдаалах магадлал бусад орон сууцны барилгуудтай харьцуулахад бараг 3,5 дахин их байжээ. Талбайн менежерүүдтэй орон сууцны барилгууд нь талбайн менежергүй орон сууцны аравны гурав орчим нь хар тамхины наймааны бай, өртөмтгий газар болох боломжтой байна.

Энэ нь статистик ач холбогдолтой сөрөг уялдаа хамаарал юм. Гэхдээ корреляц нь учир шалтгаантай адил биш гэдгийг ойлгоорой. Корреляц нь тухайн шинж чанар нь нөлөөлөх шалтгаан байж болохыг харуулж байгаа боловч харилцан хамаарал нь учир шалтгааны холбоог харуулахад хангалтгүй.

## Хүснэгт 1. Хамаарлын харьцааг тооцоолох нь – суурь хүснэгт

### Онцлог шинж чанар

Үр дүн	Тийм (1)	Үгүй (0)	Нийт
Тийм (1) – тохиолдол, кейс	Хүснэгтийн нүд А	Хүснэгтийн нүд С	нүд А + нүд С
Үгүй (0) – хяналтууд	Хүснэгтийн нүд В	Хүснэгтийн нүд D	нүд В + нүд D

Хамаарлын харьцааг тооцох томъёо = 
$$(A/B)/(C/D) = (A*B)/(C*D)$$

**Хүснэгт 2. Орон сууцны харуул хамгаалалт болон хар  
Тамхины худалдааны хоорондох хамаарал**

	Хаалга цоожгүй байх	Хаалга цоожтой эсвэл хаалгагүй	Магадлалын харьцаа
Хар тамхины наймаа явагддаг	16	42	1.857
Хар тамхины наймаа явагддаггүй	8	39	
	Хаалга цоожтой	Хаалга цоожтой	Магадлалын харьцаа
Хар тамхины наймаа явагддаг	33	25	3.452
Хар тамхины наймаа явагддаггүй	13	34	
	Талбайн хянагч, зохицуулагч	Талбайн хянагч, зохицуулагч байхгүй	Магадлалын харьцаа
Хар тамхины наймаа явагддаг	14	44	0.305
Хар тамхины наймаа явагддаггүй	24	23	

*Энэхүү баримт бичгийг хөрвүүлэх явцад гарсан зөрүүтэй ойлголтод зохиогчид хариуцлага хүлээхгүй болно.*

## 34. Гэмт хэрэг үйлдэхийг хялбаршуулагч хүчин зүйлийг судлах

Гэмт хэрэг үйлдэхийг хялбаршуулагч хүчин зүйл нь гэмт хэрэгтэн гэмт хэрэг, хэрэг зөрчил үйлдэхэд тусалдаг. Гэмт хэргийг хялбаршуулах хүчин зүйлс (гэмт хэрэгтний хувьд)-ийн гурван үндсэн төрөл байна.

- Биет хүчин зүйлс:** Энэ нь гэмт хэрэгтнүүдийн хэрэг үйлдэх чадавхыг нэмэгдүүлэх эсвэл урьдчилан сэргийлэх арга хэмжээг эсэргүүцэхэд дэмжлэг үзүүлнэ. Жишээ нь ачааны машин гэмт хэрэгтэн хулгайн эд зүйлсээ зөөх боломжийг нэмэгдүүлдэг, гар утас нь хүмүүсийг хоорондоо харилцах боломжийг нэмэгдүүлдэг, галт зэвсэг нь дээрмийн хэрэгт эсэргүүцлийг даван тулахад тусалдаг. Зарим биет хүчин зүйлс нь багаж хэрэгсэл байх боловч зарим нь тухайн орчны нэг хэсэг байдаг. Фелсон болон түүний хамтрагчид Нью-Йорк дахь Портын Автобусны буудлын хуучин зохион байгуулалт нь янз бүрийн гэмт хэрэг үйлдэхэд хэрхэн эергээр нөлөөлж байгааг судалсан. Гэмт хэргийн төрөл нь хуучин автобусны буудлын олон төрлийн төлөвлөлт, зохион байгуулалтаас үүдэлтэй гэмт хэргийн төвлөрлөөс шалтгаалдаг.
- Нийгмийн хүчин зүйлс:** Энэ нь гэмт хэрэгтний үйлдлийг идэвхжүүлэх, урамшуулах, гэмт хэрэг үйлдэхэд түлхэц өгөх замаар гэмт хэрэг, хэрэг зөрчлийн гаралтыг өдөөдөг. Жишээлбэл, залуу эрчүүд спортын арга хэмжээнүүдэд хэрүүл маргаан өдөөж таагүй уур амьсгал, хурцад мал байдлыг бий болгох нь элбэг. Бүлэглэл, зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээ нь гишүүдийнхээ гэмт хэргийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг.
- Бодисын хүчин зүйлс:** Энэ нь гэмт хэрэгтнүүдийн эрсдэл, ёс суртахууны хорио цээрийг үл тоох, үл тоомсорлоход нөлөө үзүүлдэг. Жишээлбэл, зарим гэмт хэрэгтнүүд санаа зовнилоо багасгахын тулд гэмт хэрэг үйлдэхээсээ өмнө

их хэмжээний архи ууж, хар тамхи хэрэглэдэг.

Гэмт хэргийг өдөөгч хүчин зүйлс нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээний эсрэг үйлчилдэг (алхам 39–43). Үүнийг баруун талд байгаа хүснэгтэд үзүүлэв. Эдгээр хүчин зүйлс бүр (баганаар илэрхийлсэн) урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээний эсрэг үйлчилдэг (цэгээр тэмдэглэсэн). Биет хялбаршуулагч хүчин зүйл нь гэмт хэрэгтнүүдэд урьдчилан сэргийлэх арга хэмжээг даван туулж, эрсдэл болон шаардагдах хүчин чармайлтыг бууруулахад тусалдаг. Тэд бас өөрчлөлт, гажуудалд өдөөн хатгагчаар үйлчилж болно. Нийгмийн өдөөгч хүчин зүйлс нь гэмт хэргийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүчийг сулруулдаг. Жишээлбэл, хээл хахууль нь гэмт хэрэгтэнд тулгарах эрсдэлийг бууруулдаг. Зарим гэмт хэргүүдэд гэмт хэрэгтний гаргах хүчин чармайлтыг багасгахын тулд олон гэмт хэрэгтэн оролцохыг хэрэгтэй байдаг. Байг төлөвлөх, сонирхох байдалд бусдын хүсэл сонирхол нөлөө үзүүлдэг. Зөвшөөрөгдөх шалтаг нь бусад хүмүүс юу хүлээж авахаас шалтгаална. Мөн танилууд гэмт хэрэг үйлдэх урам зоригийг өдөөдөг. Бодисын өдөөгч, хялбаршуулагч нь гэмт хэрэг үйлдэх этгээд эрсдэл, шаардагдах хүчин зүйлийг үл тоох нөхцөлийг, хүлээн зөвшөөрөгдөхөөргүй шалтаг тоочих нөхцөлийг бүрдүүлдэг.

Гэмт хэргийн хялбаршуулагч, өдөөгч хүчин зүйлс нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнтэй байдлыг сулруулах нөлөөтэй учраас аливаа асуудалд өдөөгч, хялбаршуулагч хүчин зүйлсийн үүргийг тодорхойлох нь чухал юм. Гэмт хэргийн хялбаршуулагч, өдөөгч хүчин зүйлсийн талаарх нотлох баримтыг мөрдөн байцаалтын тайлан болон мөрдөн байцаагчдаас, хохирогч, гэмт хэрэгтэнтэй ярилцлага хийх, нийгмийн байдлыг ажиглах замаар цуглуулж болно. Гэмт хэргийн талаарх мэдээллүүдийн дун шинжилгээ нь гэмт хэрэг болон гэмт хэргийн хялбаршуулагч, өдөөгч хүчин зүйлс хоорондын холбоог тодорхойлоход ашиглаж болно.

## Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сөрөх, сулруулах, даван туулах зорилгоор гэмт хэрэгтнүүдийн ашигладаг хүчин зүйлс

### Ашигладаг хүчин зүйлсийн төрөл

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга	Биет	Нийгмийн	Химиин
Эрсдэлийг нэмэгдүүлэх	●	●	●
Хичээл чармайлтыг нэмэгдүүлэх	●	●	●
Урам зоригийг бууруулах		●	●
Шалтгааныг арилгах		●	●
Өдөөн хатгалгыг бууруулах	●	●	

### АНУ-ын хотуудад хар тамхины наймаачид нийтийн утсыг Ашиглахаас урьдчилан сэргийлэх аргууд

Гар утас олон нийтэд түгээмэл болохоос өмнө хар тамхины наймаачид нь нийлүүлэгчид болон үйлчлүүлэгчидтэй харилцахын тулд нийтийн утсыг ашигладаг байсан. Тэд нийтийн холбоог ашиглах явдлыг зогсоо олон аргыг туршиж үзсэн бөгөөд үүнд дараах зүйлс орно.

- Тодорхой байршил, ангилалд нийтийн утас ашиглахыг хориглох, эсвэл дугаарыг нь хязгаарлах шийдвэр гаргах
- Пэйжер рүү гарах дуудлагыг зөвшөөрдөггүй эргэн залгах төхөөрөмж суурилуулах
- Орох дуудлагыг хаахын тулд утсанд тохиргоо, өөрчлөлт хийх
- Орон нутгийн утасны компаниуд эсвэл хотын захиргаанд олон нийтийн утсыг хаах эсвэл нүүлгэн шилжүүлэхийг шаардсан дарамт шахалт үзүүлэх, эсвэл гэрэлтүүлэг, хяналт сайтай газруудад утсыг шилжүүлэн байрлуулах.
- Утсанд зоос хүлээн авах үйлдлийг хааж, шөнийн цагаар зөвхөн операторын тусlamжтайгаар дуудлага хийх эсвэл яаралтай тусlamжийн дуудлага хийхийг зөвшөөрөх
- Дэлгүүр, шатахуун түгээх станц гэх мэт байгууллагуудын нийтийн утсыг өөрчлөх
- Цагдаагийн эргүүлийг нэмэгдүүлэх, утсан дээр анхааруулах шошго наах, асуудлыг мэдээлэл "халуун цэгийн утас" зэрэг бусад төрлийн арга хэмжээ авах.

Эх сурвалж: Natarajan, Mangai, Ronald V. Clarke, and Mathieu Belanger. 1996. "Drug Dealing and Pay Phones: The Scope for Intervention." *Security Journal* 7(4): 245–251.

Хэрэв гэмт өдөөгч, хялбаршуулагч хүчин зүйлс нь гэмт хэрэг, асуудалд тодорхой үүрэг гүйцэтгэж байгаа бол дараагийн алхам нь эдгээр хүчин зүйлсийг эх сурвалжийг олох явдал юм. Мэдээжийн хэрэг, эх сурвалж нь гэмт өдөөгч, хялбаршуулагч хүчин зүйлсийн төрлөөс хамааран өөр өөр байх болно.

Босогчдод шидэхэд зориулсан чулуу, хар тамхины наймаачдад нийтийн утас гэх мэт биет хүчин зүйлс гарын доор бэлэн байж байдаг. Эсвэл эдгээр зүйлсийг хулгайн гэмт хэргийн багаж хэрэгсэлтэй адилаар хууль ёсны дагуу худалдаж авч болно. Эсвэл зарим тохиолдолд хүнд гэмт хэрэг үйлдэхэд

ашигладаг тээврийн хэрэгсэлтэй адил аар эдгээрийг хулгайн аргаар олж авсан байж болно. Тэдний эх сурвалж олдвол цаашид ямар зүйл хийх боломжтой вэ гэдгийг тодорхой болгож өгнө. Хажуугийн талбарт хар тамхины наймаанд нийтийн утас ашиглах, бэлэн мөнгөний машинуудын орчинд дэмжлэг үзүүлэх, хөнгөвчлөх зорилгоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээг харуулдаг. Нийгмийн хялбаршуулагч, өдөөгч хүчин зүйлс нь гэмт хэрэгтнүүд хэнтэй харьцах, холбоо тогтоохоос ихээхэн хамаардаг. Жишээлбэл, эрсдэлтэй, өртөмтгийг байгууллага, байгууламжууд (28-р алхам) нь нийгмийн орчин нөхцөлд нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж болно. Гэмт хэргийн бүлэглэлүүд нь өөрийн гишигүүддээ гэмт хэрэг үйлдэх нийгмийн дэмжлэгийг үзүүлдэг. Гэхдээ хууль ёсны үйл

ажиллагаа нь ч гэсэн улс төрийн шалтгаантай хүчирхийлэл, эсвэл түүхэн ач холбогдолтой спортын тоглолтын эсрэг оюутнуудын үймээн самуун зэрэгтэй адил арга хэмжээ, явдуудын үед давхацдаг.

Бодисын өдөөгч хүчин зүйлс олон тоотой бөгөөд ихэнх тохиолдолд гэмт хэрэг, хэрэг зөрчилтэй холбоотой байдаг. Согтууруулах ундаань ийм төрлийн өдөөгчийн жишээ болно. Олон төрлийн өдөөгч хүчин зүйлсийн хольц ерөнхий байдалтай, тухайлбал чөлөөт цаг, зугаа цэнгээний газруудад нийгмийн болон бодисын өдөөгчдийг түгээмэл худалдаалдаг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 25 арга хэмжээний ихэнх нь гэмт хэрэг үйлдэгдэх гурван төрлийн өдөөгчийн үр дүн, нөлөөллийг бууруулах зорилготой (39-43-р алхам).

#### Лос Анжелес, Нью-Йорк хотуудад банкны бэлэн мөнгөний машин (АТМ)-уудад зориулсан хамгаалалтын арга хэмжээ

	Нью-Йорк хот	Лос Анжелес хот
Үүдний хэсэг харуул хамгаалалттай байх, ATM-ийн машинд хаалт, хашилт хийх	√	
Гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	√	√
Цонх, саруул тод байх		
Хэрэглэгч ар талаа хараад зориулсан тольтой байх	√	
ATM-ийн ойролцоо хаалт, өвс ногоог тайрах		√
Хяналтын камер суурилуулах	√	√√
Аюулгүй санамж, сануулга байрлуулах	√	√
Гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүст аюулгүй сануулга, мэдэгдэл өгөх	√	√
ATM суурилуулахын өмнө гэмт хэргийн үнэлгээ хийх		√
Харуул хамгаалалтын ажилтан ажиллуулах	√*	
Тодорхой газарт гэмт хэргийн түр зуурын идэвхжил зэргийг харгалzan ATM-ийн ажлын цагийг бууруулах, түр хаах		√√

Тайлбар:

√ хууль тогтоомжоор шаардсан:

√√ хуулиар шаардаагүй боловч банкны шийдвэрийн дагуу түгээмэл хэрэгжүүлдэг.

\*Банкны барилгын дотор байрлуулсан ATM банкны ажлын бус цагаар ажиллана.

Эх сурвалж: Guerette, Rob, and Ronald Clarke. 2003. "Product Life Cycles and Crime: Automated Teller Machines and Robbery." *Security Journal* 16(1): 7–18, <http://www.palgrave-journals.com/sj/journal/v16/n1/pdf/8340122a.pdf>.

## 35. ГЭМТ ХЭРГИЙГ ЭХНЭЭС НЬ ЭЦС ХҮРТЭЛ НЬ ОЙЛГОХ

**Б**ид гэмт хэргийг гэнэтхэн л болоод өнгөрсөн гэж боддог. Гудамжинд хэн нэгний хүзүүний зүүлтийг шүүрэн авах, халаасны хулгай хийх, машинаас эд зүйлс хулгайллахад хэдхэн секунд зарцуулдаг. Мөн хэнд чойлгомжтой газарт нуугдаад байж байх хулгайч ховорхон биз ээ. Харин тэд хулгайлах зүйлээ олсон даруйдаа буюу орон байранд орж ирээд, шаардлагатай зүйлсээ авснаас хойш хэдхэн минутын дотор зугтан алга болохыг хичээдэг. Хүзүүний зүүлтийг булааж авах эсвэл орон байранд нэвтэрч орох нь үнэндээ эдгээр гэмт хэргийг дуусгахад шаардлагатай хэд хэдэн алхмын зөвхөн нэг алхам юм.

Та гэмт хэрэг, хэрэг зөрчилтэй холбоотой алхмуудын дарааллыг ойлгохыг хичээх хэрэгтэй. Таны дагаж мөрдөх боломжтой хэд хэдэн арга байдаг. Үүнд:

- Ратгерсийн их сургуулийн Лесли Кеннеди болон түүний хамтран зүтгэгч Винсент Сакко нар гэмт хэргийн үе шатуудыг урьтал үе шат, ид явцын үе, дараах үе ялгаж, эдгээр гурван үе шатны талаар "Эрүүгийн хэрэг" хэмээх криминологийн сурх бичгийг гаргажээ.
- Уильям Хэддон зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх дүгнэлтэд туслах зорилгоор ижил төстэй ангиллыг боловсруулсан. Тэрээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг ослын өмнөх, ослын үеийн, ослын дараах гэж хуваасан.
- Дерек Корниш гэмт хэргийн "скрипт" (бичиглэл) гэсэн ойлголтыг дүн шинжилгээ хийхэд ашигладаг. Үүний цаад санаа нь аливаа гэмт хэргийн тодорхой ангилалд хэргийн бичиглэлд нэгэн адил тодорхой дарааллаар явагддаг стандарт үйлдлүүдийг шаарддаг. Хэргийн газар нь гэмт хэргийн дараалсан үе шатууд байна. Харин оролцогчид гэмт хэрэгтэн, хохирогчид, хажууд байгаа хүмүүс, гэрч нар байна. Мөн тэдний ашиглаж байгаа багаж хэрэгсэл нэмэлт зүйлс юм.

Таны ашиглаж байгаа эдгээр аргуудын аль нь ч гэмт хэрэгтэн гэмт хэрэг үйлдэж

дуусгахын тулд хийх үйлдлүүдийн дарааллыг жагсаахыг шаардана. Доорх хүснэгтэд зугацах зорилгоор машин хулгайллагчийн хийх үйлдлүүдийн талаарх Корнишийн хялбаршуулсан дүрслэлийг харуулсан боловч бидний гэмт хэрэг гэж үзэж буй тодорхой үйлдэл (бидний тохиолдолд машин хулгайлах) нь өмнө бэлтгэл үе шаттай, хэрэг үйлдээд зугтах, дараа нь хулгайлсан машинаараа зугацах үе шатнаас бүрддэг болохыг харуулсан. Энэ нь гэмт хэргийг хянуур, нууцтай, болгоомжтой, алхам алхмаар шинжлэх шалтгааныг бидэнд ойлгуулдаг. Гэмт хэргийг амжилттай дуусгахад шаардлагатай үйлдлүүдийн дарааллыг тодорхой ойлгох нь танд илүү олон хөндлөнгийн оролцоо, нөлөөллийн талаар харуулах болно. Өөрөөр хэлбэл, энэ нь таны судалгаанд авч үзэх хариултуудын сонголтыг өргөжүүлнэ. Хүснэгтийн эцсийн баганад зугацах зорилгоор машин хулгайллагчийн үйлдлийн үе шат бүрт тохирсон хариултуудыг жагсаав.

Бусдын машинаар зугацах гэмт хэрэг бол хамгийн энгийн гэмт хэргүүдийн нэг боловч илүү нарийн төвөгтэй гэмт хэргийн хувьд гэмт хэргийг үндсэн үе шат болгон хувааж болно. Жишээ нь олон нийтийн үймээн самуун (бослогыг оролцуулан) гэх мэт. Олон нийтийн цуглааны талаарх тэргүүлэх мэргэжилтэн Кларк Макфейл бүх цуглаанд дүн шинжилгээ хийх гурван үе шаттай үйл явцыг зохиосон. Үүнд: бага багаар цугларах үйл явц, цугларсан ид үе, тарах үе. Цинциннатигийн их сургуулийн төгсөх ангийн оюутан Тамара Маденсен үүнд анхан шатны төлөвлөлт, цугларалтын өмнөх бэлтгэл гэсэн хоёр үе шатыг шинээр нэмж оруулсан. Цагдаа нар анхан шатны төлөвлөлтөөс урьдчилан сэргийлэхийн тулд томоохон шоу, үдэшлэг зохион байгуулахтай холбоотой сануулга, сээрэмжлүүлэг гаргаж болно. Түймрээс урьдчилан сэргийлэхийн тулд цугларалтын бэлтгэлийн үеэр амархан шатдаг хог хаягдал, эд зүйлсийг зайлцуулах хэрэгтэй. Цугларах явцад хууль ёсны үйлдлүүдийг дэмжихийн тулд цагдаа нар ирж буй оюутнуудыг угтан авч болно. Хүмүүс бөөгнөрсөн үед Цагдаа нар хүмүүсийн

үйлдлийг хянаж, асуудал гарвал хөндлөнгөөс оролцох боломжтой. Цуглаан тарах үед цагдаа нар олон нийтийг тайван тараах, эмх замбараагүй байдал үүсэхгүй байгаасай гэж хүсдэг.

### Бусдын машиныг хулгайлж зугацах гэмт хэрэг болон түүний хариу арга хэмжээний үе шатууд

Үе шатууд	Алхмууд	Хариу арга хэмжээнүүд
Бэлтгэл үе шат	Багаж хэрэгслээ бэлтгэх (овтвартка, аптирка, хуулбар түлхүүр, алх, ган хоолой зэргийг бэлтгэх), хамтран оролцогч нарыг сонгох	Гар сканер болон хуулбар түлхүүрээр багаж хэрэгслийн борлуулалтыг хянах
Нэвтрэх орох	Зогсоолд нэвтрэн орох	Зогсоолын хаалт, цөөн хаалгатай байх
Нөхцөлийг бүрдүүлэх	Сэлгүүцэх	Дэмий сэлгүүцэгчдийг илрүүлэх зорилгоор камер, эргүүл хамгаалалтыг ажиллуулах
Байг сонгох	Яаруу, хурдтай яваа машинаас татгалзах, буцаах. Зохих тээврийн хэрэгслийг сонгох.	Тээврийн хэрэгслийн ил харагдах хамгаалалт
Хулгайг үйлдэх	Машин руу нэвтрэх (хуулбар түлхүүр, отвертка ашиглах) Стачерын цоожийг эвдэх (хоолой болон алхаар цохих). Стачерийг оролдох, машиныг асаах.	Сэжигтэй үйлдлийг хянах зорилгоор камер ашиглах, зогсоолын харуул хамгаалалтыг сайжруулах, хөдөлгүүр үл асаагч, идэвхгүй болгогчийг суурилуулах (instabilizer*), харуул хамгаалалтын дохиолол ажиллуулах.
Зогсоолоос гарах, зугтах	Зогсоолыг орхин явах	Гарах явцыг saatuuлах
Хэргийн дараах үе	Хулгайлсан машинаараа зугацах. Машинаа хаях, орхих. Эсвэл гал тавих.	Тээврийн хэрэгслийг хянах системийг идэвхжүүлэх, тээврийн хэрэгслийн хязгаарлалт, шалгалт, хогийн цэгт хяналт тавих.

Эх сурвалж: Cornish, Derek. 1994. "The Procedural Analysis of Offending and Its Relevance for Situational Prevention." In vol. 3 of Crime Prevention Studies, edited by Ronald V. Clarke. Monsey (New York): Criminal Justice Press. [http://www.popcenter.org/library/crimeprevention/volume\\_03/06\\_cornish.pdf](http://www.popcenter.org/library/crimeprevention/volume_03/06_cornish.pdf).

## **Хууль бус цагаачид амь насаараа хохирохоос урьдчилан сэргийлэх.**

Флоридагийн олон улсын их сургуулийн Роб Геретт нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх өвөрмөц хэрэглээний чиглэлээр АНУ-ын хилийн харуулын судалгааг хийжээ. АНУ-Мексикийн хилийг хууль бусаар давах явцад олон тооны цагаачид амь насаа алддаг байна. Жил бүр 300 орчим цагаач эмгэнэлт нөхцөл байдалд нас бардаг. Жишээлбэл, суваг, голын усанд живэх, цөлийн бүс нутагт халуунд цохиулах, хатаж үхэх, эсвэл тээврийн хэрэгслийн осолд өртөх гэх мэт. Хууль бус цагаачид хилээр гарахдаа ямар үе шаттай, ямар үйл явдлууд тохиолддог эсэх, хүний амь нас хохироход хүргэж буй нөхцөл байдлыг ойлгохыг хичээнээр судлаач тэдний амь насыг аврах хэд хэдэн зөвлөмж гаргажээ. Тэрээр эдгээр саналуудыг хоёр талт сүлжээнд ангилсан.

- Хүснэгтийн дээд талд тэрээр Уильям Хэддоны аргыг дагаж, урьдчилан сэргийлэх зөвлөмжүүдийг амь насанд аюултай үйл явдлын өмнө, явц дунд, түүний дараа гэж ангилсан.
- Хүснэгтийн хажуу тал руу доошлоод тэрээр гэмт хэргийн гурвалжныг мөрдэж, арга хэмжээнүүд нь арга хэмжээг зорилгоор эрэмбэлсэн. (1) цагаач буюу "хохирогч", (2) цагаачдыг хилээр аюулгүй гарахад тусалдаг, газарчилдаг "цөөвөр чоно" хотит хөтчүүд ("гэмт этгээд"), (3) "газар" буюу орчин, жишээлбэл, цөл, гол мөрөн, хот суурин газар гэх мэт.

Эдгээр саналуудын зарим нь аль хэдийн хэрэгжиж буй арга хэмжээг өргөтгөх эсвэл сайжруулахад чиглэсэн бол зарим нь шинэлэг шинэ арга хэмжээ байсан нь түүний арга барилын үнэ цэнийг харуулж байна.

Саналуудын ихэнх нь өөрөө тайлбарын шинжтэй боловч заримыг нь ойлгохын тулд нэмэлт мэдээлэл хэрэгтэй (хүснэгтийг дагуу дугаарласан):

1. Түүний судалгаанаас харахад харьцангуй олон эмэгтэйчүүд халууны улмаас амия алддаг байна.
2. Цагаачид ихэвчлэн Мексикийн хилийн ойролцоо хотуудад цугларч, "цөөвөр чоно" хотит хөтөч, газарчинтай харьцдаг.

3. Аврах ажиллагааны зорилгоор өндөр бэлтгэгдсэн эрэн хайх, аврах ажилтнуудыг томилох үед судлаач Гюрет нь цагаачид мэргэжлийн байгууллагуудтай хамтран үед амьд үлдэх магадлал илүү байдаг болохыг олж тогтоосон.
4. Хэт халуун саруудад элсэн цөлийг туулах оролдлогоос урьдчилан сэргийлэхийн тулд энэ үед Аризонагийн цэлд баригдсан цагаачдыг 2003 онд Техасын хилийн ойролцоо Мексикийн хотууд руу буцаан авчирсан. Энэхүү туршилт нь хүний амийг аврахад үр дүнтэй байсан.
5. 2004 онд Мексикийн эрх баригчид Аризонагаас буцаах хүмүүсийг Мексикийн дотоод бүс нутагт хүлээн авахаар тохиролцов.
6. Аризонагийн жолооч нар халуун саруудад элсэн цөлийг гатлах гэж оролдсон хууль бус цагаачдын жижиг бүлгүүдийг эрж хайдаг. Энэхүү кампанит ажлын хүрээнд жолооч нар 1-800 дугаарт залгаж хүний амь насыг аврахад хувь нэмрээ оруулж болно.
7. Аризона дахь хилийн харуулын ажилтнуудаас Гуэреттэд өгүүлснээр бусад баригдсан цагаачдын зүгээс өгсөн мэдээллийн дагуу маш хүнд байдалд байгаа үлдсэн цагаач нарыг эрж олоход нэлээд хүндрэлтэй. Учир нь элсэн цөл нь ямар ч тойм, содон шинж тэмдэггүй, баривчлагдсан цагаачдын өгсөн мэдээлэл нь бүдэг, ерөнхий байдаг. Өнгөний код эсвэл тэмдгийн дагуу цөлийн түр зуурын тэмдэглэгээний хөтөлбөр нь энэ хүндрэлийг шийдвэрлэхэд бага ч гэсэн тусалдаг.

## Хууль бус цагаач нар амь алдахаас сэргийлэхэд зориулсан 16 зөвлөмж

	Амь насанд аюултай нөхцөл байдлаас өмнө	Амь насанд аюултай нөхцөл байдлын үед	Амь насанд аюултай нөхцөл байдлын дараа
Цагаач	<ol style="list-style-type: none"> <li>1. Эмэгтэй цагаачдад цөлийг туулахад тулгарах аюулын талаар мэдээлэх</li> <li>2. Аюултай нөхцөл байдлын дохиолол, сэрэмжлүүлгийн системийг нэвтрүүлэх</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>3. Цагаачдад хүндрэлтэй үед дагаж мөрдөх зааварчилгааг хот суурин газруудад тараах</li> <li>4. Хил хамгаалах байгууллагын эрэн хайх, аврах ажиллагааг өргөжүүлэх</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>5. Хажуугийн, хөндлөнгийн зүгээс нутаг буцаах</li> <li>6. Дотоодын зүгээс нутаг буцаах</li> </ol>
Цөөвөр чоно хотөч, газарчид	<ol style="list-style-type: none"> <li>7. Аюултай нөхцөл байдлын дохиолын системийг нэвтрүүлэх</li> <li>8. Цагаачид нас барсан тохиолдолд цөөвөр чоно нэртэй хотөч, газарчдад хариуцлага тооцохыг сануулах</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>9. Баривчлах шаардлагатай хотөч, газарчингуудыг онилох, судлах</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>10. Цагаачид нас барсан үед хотөч, газарчдад хариуцлага тооцох систем хэрэгжүүлэх</li> </ol>
Орчин	<ol style="list-style-type: none"> <li>11. Өртөмтгий цаг үе, хугацаа, газрыг судлах</li> <li>12. Хил давах, аюултай, өртөмтгий газарт хаалт босгох</li> <li>13. Эрсдэлтэй газруудад ил харгадахуйц анхааруулах самбар байрлуулах</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>14. "Амь аврах/ холбогдох арга хэмжээний талаар цагаачдад мэдээлэх</li> <li>15. Цөлд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>16. Аюулын шинэ хэв маяг, дүр зургийн илрүүлэхийн тулд мэдээлэл, өгөгдлийг байнга хянаж байх</li> </ol>

## 36. Таван "W" (нэг "Н" асуулт) асуултад хариулах

 Мнөх алхмуудад авч үзсэн ойлголтуудыг ашиглан дүн шинжилгээ хийж дуусаад энэ нь сонины сайхан мэдээ болох шалгуурыг хангаж байгаа эсэхийг асуух хэрэгтэй. Энэ нь 5 W ба нэг Н асуултуудад хариулж байна уу?. Үүнд:

- **What – юу?**
- **Where – хаана?**
- **When- хэзээ?**
- **Who-хэн?**
- **Why-яагаад?**
- **How- яж?**

Эдгээр ижил асуултууд нь Барри Пойнерын гэмт хэргийн шинжилгээний аргыг бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваасан бүтэцтэй. Жишээлбэл, Ковентри болон Бирмингем хотын төвд (Английн хоёр том хот) "гудамжны халдлагууд"-ыг судлах талаар Дотоод хэргийн яам түүнээс асуухад цагдаа нар эдгээрийг дээрэм, хулгайн гэмт хэрэг гэж ангилсан боловч гэмт хэргийн дийлэнх нь хэд хэдэн тодорхой асуудалд хамаарч байгааг олж тогтоосон. Үүнд:

- Гудамжны ТҮЦ, лангууны дээрэм
- Согтуу хүмүүсийг дээрэмдэх
- Банк руу хүргэх замд мөнгө дээрэмдэх
- Эмэгтэйчүүдийн түрийвчийг булаах
- Заль мэх зохиож, хохирогчийн гараас түрийвч/мөнгө шүүрч зугтах
- Цүнх сав, торноос хулгай хийх
- Автобусны буудалд халаасны хулгай хийх

Энэ нь "гудамжны халдлага"-ын илүү онцгой шинж чанар байсан бөгөөд үйл явдлыг ойлгох анхны чухал алхам байсан юм. Дараа нь тэрээр ослын тайлангуудыг цэгцэлж, ангилан ялгаж, хариулт олоход нь туслах асуудлын зураглал гаргахыг хичээсэн.

- **Ялангуяа хохирогч байхгүй, гэрч байхгүй үед осол, хэрэг зөрчлийн мэдээллүүд нь бүртгэгдсэн мэдээлэлд нэлээд хувьсамтгай, олон төрөл байдаг.** Гэсэн хэдий ч Пойнер тухайн асуудлын зураглалыг гаргахын тулд тайлангуудыг нэгтгэхийг оролцсон (хажуугийн самбарыг

үзнэ үү). Үйл явдал бүрийн хувьд тэрээр дараах зүйлийг олж мэдэхийг хичээсэн.

- **Юу тохиолдсон бэ?** Энэ нь үйл явдал, оролцсон хүмүүсийн үйлдлийн дарааллыг зөв бичихийг шаарддаг (алхам 35).
- **Энэ хаана болсон бэ?** Заримдаа үйл явдлын дараалал хэд хэдэн байршилд явагддаг. Жишээлбэл, автомашиныг зогсоолоос хулгайлж, эсвэл үнэ цэнтэй эд зүйлсийг нь тонох зорилгоор зорилгоор гараашинд нуух, дараа нь эзгүй газар аваачиж хаях гэх мэт шат дарааллтай үйл явдлууд явагдана. Мэдээлэл нь зөвхөн эхний болон сүүлчийн байршлын талаарх мэдээлэл байж болно. Эдгээр мэдээллийг судлах нь гэмт хэрэгтэн яагаад тэднийг сонгосон гэдгийг тайлбарлахад тусална.
- **Хэзээ тохиолдсон бэ?** Гэрийн эзэд эсвэл автомашины эзэд зөвхөн "амралтын өдрийдэд" л машин нь хулгайлгэсэн талаар мэддэг байх. Харин хүмүүс хоорондын харилцан үйлчлэл, контакт бүхий олон гэмт хэргийн хувьд хохирогч тухайн гэмт хэрэг хэзээ болсон талаар тодорхой мэдээлэх боломжтой бөгөөд энэ нь гудамж эзгүй, хоосон эсэх талаар таамаглал дэвшүүлэх боломжийг олгодог.
- **Хэн оролцсон бэ?** Ихэнх тохиолдолд дор хаяж нэг гэмт хэрэгтэн хэрэгт оролцсон байдаг. Гэмт хэрэгтэнтэй шууд холбоогүй байсан чнэг буюу хэд хэдэн хохирогч байж болно. Гэрч болон бусад гуравдагч этгээд өртсөн байж болно. Гэрч, хохирогчдын зүгээс цагдаад өгсөн мэдүүлэгт нь маш их хэрэгтэй мэдээлэл өгч болох ч зарим үед тухайн үйл явдлын талаар түүвэр судалгаа хийх нь илүү чухал байдаг.
- **Яагаад гэмт хэрэг үйлдсэн бэ?** Тодорхой төрлийн гэмт хэрэг нь үйлдэгч этгээдэд ямар ашиг тустай, ач холбогдол өгөхийг ойлгох нь чухал. Хулгай хийх олон тохиолдлын шалтгаан нь тодорхой байх боловч хүн хоорондын, kontaktyn (хүмүүс

хоорондоо шууд контактлах хэрэг) гэмт хэрэг, эвдэн сүйтгэх гэмт хэргийн сэдэл нь зөвхөн гэмт хэрэгтэнтэй ярилцлага хийх үед л тодорхой болж ирдэг (алхам 10). Хохирогч, гэрч нар яагаад ийм байдал үзүүлснийг ойлгох, "Зарим хохирогч ямар шалтгаанаар гэмт этгээд рүү дайрсан бэ?" Мөн "Яагаад гэрчүүд ихэвчлэн хөндлөнгөөс оролцдоггүй вэ?" гэх мэт асуултад хариулах нь урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

#### • Гэмт этгээд хэргээ хэрхэн үйлдсэн бэ?

Гэмт хэргийг тодорхой цаг мөчид агшин зуур, гэнэт үйлдэгдэх үйлдлээс илүүтэй, эхлэхээс эхлээд дуусгах хүртэлх хэд хэдэн үе шат дамжсан иж бүрэн процесс гэж ойлгож болно. Гэмт хэргийн алхам бүрт гэмт хэрэгтэн шийдвэр гаргах, бусадтай хамтран ажиллах, тодорхой мэдлэг, хэрэгслийг ашиглах шаардлага тулгарна. Энэ нь үндсэндээ 35-р алхамд хэлэлцсэн Корнишний "скрипт" (бичиглэл) арга барилын үндэс болсон үзэл санаа юм. Нарийвчилсан, дэлгэрэнгүй скрипт, бичиглэл боловсруулах нь тийм амар хялбар биш боловч дүн шинжилгээ нь гэмт хэрэг хэрхэн үйлдэгдсэн талаар тодорхой дүр зураг, зураглалыг өгнө.

Пойнерын хийсэн автобусны зогсоол дээрх халаасны хулгайн гэмт хэргийн талаарх дүн шинжилгээ нь тодорхой чиг хандлага, арга барилыг харуулдаг. Тэрээр автобус хүлээж буй шугамуудын ажиглалтаар нэлээд тойм төдий зөрчил, ослын тайланг нэмж оруулснаар гэмт хэргийн нарийвчилсан тайлбарыг гаргаж чадсан. Халаасны хулгайн гэмт хэргийн оргил үе нь үдээс хойш, ялангуяа баасан гаригт, автобусны шугамын ачаалал ихтэй үед таарч байгааг олж мэдсэн. Гурав эсвэл дөрвөн залуучуудаас бүрдсэн бүлэглэлүүд автобусны буудлын ойролцоо ажиглалт хийж, сэжиг төрүүлэхгүйн тулд ойролцоо дэлгүүрийн цонх руу харах, өөр зүйлсийг ажиглах, тохиромжтой хохирогчдыг хайх зэрэг үйлдлүүдийг хийдэг. Тэдний өртөгч, бай нь түрийвчээ өмднийхөө арын халаасанд хийдэг дунд болон түүнээс дээш насны эрчүүд байв. (Залуу эрчүүд илүү барив өмд өмсөж, хэтэвчээ арын халаасандаа хийх нь ховор байдаг).

Хохирогчид орохдоо төлбөр төлдөг төлбөртэй автобусанд зорчикж эхлэхэд залуучууд автобусны урд эгнээ рүү дайрч, автобусны сүл зайд хэсэгт шахцалдаж, бусад хүмүүст хүндрэл учруулж байв. Тэд жолоочоос автобусны очих газрын талаар ямар ч хамааралгүй асуулт асууна. Энэ хооронд залуучуудын нэг нь хохирогчийн халаас руу гарса шургуулж гол ажлаа хийдэг. Хохирогчийг түлхэхэд хохирогч уурлаж, юу болоод байгааг ойлгож амжихгүй. Жолооч нь залуучуудыг автобуснаас буу гэж хашхирч, бусад зорчигчид мён уурлана. Энэ үед залуус автобуснаас бууж, олны дунд орж алга болцгоно. Залуус хэзээ ч баригдаагүй. Хохирогч түрийвчээ алга болсныг сүүлд л мэдэх болно. Энэ бол автобусанд гардаг халаасны хулгайн дүр зураг юм.

Энэхүү шинжилгээ нь дөрвөн боломжит хариултыг санал болгосон:

1. Орохдоо төлбөр төлөхийн оронд зогсоол дээр тасалбарыг урьдчилан худалдах боломжтой.
2. Автобусны зогсоолуудыг явган хүний замаас хол зайд байрлуулж, автобусны буудал адилаар булан тохойд зохион байгуулж болно. Энэ нь гэмт хэрэгтнүүд хохирогчоо хүлээхэд хүндрэлтэй болгоно.
3. Гэмт этгээдүүд болзошгүй хохирогчдыг урьдчилан тодорхойлох боломжгүй болгохын тулд хүлээлгийн дараалалд хяналт тавих\*.
4. Гэмт хэрэгтнүүд автобусны руу үсрэхээс сэргийлэхийн тулд хүлээлгийн цэг дээр шугамын саадыг байгуулах.

Эдгээр бүх шийдэл нь цагдаагийн ердийн ажил үүрэгт хамаарахгүй, хотын захиргаанаас шийдвэрлэх асуудлууд гэдгийг анхаарна уу. Официерууд автобусны буудлуудыг дахин төлөвлөх гэх мэт асуудлуудыг тэдний үүрэг хариуцлага гэж бараг бодлоггүй. Асуудлыг шийдвэрлэх гэмт хэргийн шинжээчийн хувьд таны ажил бол гэмт хэргийг бууруулах бөгөөд өргөн утгаараа энэ нь тэдний ажилд ч бас хамаатай, нөлөөтэй арга хэмжээ юм.

### Археологич шиг ажиллах

"Хэрэг зөрчлүүдийг нэгтгэн судлах нь бас нэг давуу талтай. Зарим тохиолдолд бид бусад тохиолдуудтай харьцуулахад бидэнд дэлгэрэнгүй мэдээлэл бага байж болох ч бидний мэддэг зарим жишээ баримт бидний судалж байгаа хэрэгтэй ижил байх тохиолдол олонтой тохиолддог. Археологич малтлагаар илэрсэн эвдэрхий ваарыг сэргээн босгохтой адилаар бодит мэдээлэл багатай хэрэг зөрчилд дутуу мэдээллийг сэргээх боломжтой. Археологичдод хэдхэн ширхэг хагархай тогоо байж болох ч бусад ижил төрлийн савны талаарх мэдлэгээ ашиглан тэд бүхэл бүтэн савны талаар төсөөлж чаддаг. Археологийн энэхүү арга нь жишээ нь гэмт хэрэгтнүүдийн бусад баригдсан хэд хэдэн тохиолдуудыг ашиглан гэмт хэргийн бусад тохиолдлыг төсөөлөхтэй ижил юм. Гэмтэтгээдүүд баригдаагүй ч ижил төрлийн гэмт хэрэгт ижил төстэй үйлдлүүд гарсан гэж үзэх үндэслэлтэй".

Эх сурвалж: Poyner, Barry. 1986. "A Model for Action." In *Situational Crime Prevention*, edited by Gloria Laycock and Kevin Heal. London: Her Majesty's Stationery Office.

## 37. Алдаа гаргадаггүй хүн байхгүй гэдгийг ойлгох

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь ихэвчлэн урьдчилан таамаглах явдал юм. Хэрэг зөрчил, асуудалтай холбогдсон гэмт хэрэгтнүүд өмнөх шигээ бусдыг хохироосоор байх уу? Ойрын ирээдүйд хохирогч хүмүүс дахин хохирогч болох магадлалтай юу? Гэмт хэргийн төвлөрөл өндөр бүхий буюу халуун, өртөмтгий цэгүүд халуун хэвээр байсаар байх уу? Хэдийгээр өнгөрсөн үйл хөдлөл нь ирээдүйн үйл хөдлөлийг урьдчилан таамаглах хамгийн сайн үзүүлэлт байж болох ч энэ нь үргэлж үнэн байдаггүй.

Дээрх жишээнүүд нь ирээдүйг урьдчилан таамаглахтай холбоотой юм. Гэхдээ бид үл мэдэгдэх зүйлийг өөр аргаар, тэр дундаа асуудалд хариулт олох замаар шалгахыг хичээдэг. Полиграфын шалгагч нь тухайн хүн худал хэлж байгаа эсэхийг үнэлэн дүгнэдэг. Мансууруулах бодисын шалгалт нь хүмүүс сүүлийн үед хууль бус хар тамхи хэрэглэж байсан эсэхийг тогтоодог. Нисэх онгоцны

буудлуудын металл илрүүлэгч, ачаа тээшийг шалгах төхөөрөмж нь зорчигчдын гар дээр эсвэл ачаа тээшинд зэвсэг, хууль бус эд зүйлс байгаа эсэхийг тодорхойлдог. Эдгээр бүх жишээн дээр шалгалт хийж байгаа хүн тодорхойгүй нөхцөл байдлын талаар дүгнэлт хийхийг оролддог. Ирээдүйг таамаглахтай адил шалгагч этгээд үнэн зөв эсвэл буруу дүгнэлт хийж болно. Иймээс таамаглал, дүгнэлтүүд яагаад бүтэлгүйтдэгийг ойлгох нь чухал юм.

Таамаглал болон дүгнэлтийн алдааг шалгах үр дүнтэй арга бол тэдгээр нь бодит байдалтай хэр нийцтэй байгааг харьцуулах явдал юм. 1 дүгээр хүснэгтийн баганууд нь хоёр боломжит таамаглалыг харуулж байна: Тийм гэдэг нь үр дүн үүсэхийг илтгэнэ. Үгүй гэдэг нь үр дүн үүсэхгүйг илтгэнэ. Мөрүүд нь хоёр бодит үр дүнг харуулна. Тийм гэдэг нь үр дүн үүссэн болохыг, Үгүй гэдэг нь үр дүн үүсээгүй болохыг илтгэнэ.

### Хүснэгт 1. Урьдчилан таамаглалын алдааны төрлүүд

Бодит үр дүн	Тийм	Үгүй
Тийм	A.. Бодит жинхэнэ эерэг хариулт	B. Хуурамч сөрөг
Үгүй	C. Хуурамч эерэг	D. Жинхэнэ сөрөг үр дүн
Үнэн бодит байдал, нарийвчлалын хувь хэмжээ: (A+D)/ (A+B+C+D)		
Хуурамч сөрөг хувь хэмжээ: B/ (A+B+C+D)		
Хуурамч эерэг хувь хэмжээ: C/ (A+B+C+D)		

Олон тооны таамаглалыг төсөөлөөд үзээрэй. Хэрэв таамаглал бодит байдалтай нийцэж байвал энэ нь үнэн зөв болно. А ба D нүднүүд нь үнэн зөв таамаглалыг агуулдаг. Та эдгээр хоёр ангилалд хамаарах таамаглалын утгыг нэмж, өөрийн хийсэн бүх таамаглалд хуваах замаар бодит байх нарийвчлалын түвшнийг (энэхүү статистикийн ойлголт "accuracy rate" нь аливаа таамаглал үнэн зөв байх магадлалыг илэрхийлдэг болно) тооцоолж болно.

В ба С нүдийг харцаа. Шийдвэр гаргагч үр дүн үүсэхгүй гэж таамагласан ч тохиолдох тохиолдолд В нүд рүү бичнэ. Үүнийг худал эерэг гэж нэрлэдэг. С нүдэнд байгаа тохиолдлууд нь шийдвэр гаргагч үр дүн үүснэ гэж таамаглаж байсан ч бодит байдалд үүсэхгүй байх нөхцөл байдлыг илэрхийлдэг. Эдгээр нь худал сөрөг юм. Та эдгээр нүдний таамаглалын тоог нийт таамаглалын тоонд хуваах замаар хоёр төрлийн алдааны түвшнийг (error rate) тооцоолж болно.

Нэг жишээг авч үзье. Түрээсийн орон сууцанд гарч буй гэмт хэргийг таслан зогсоохын тулд цагдаагийн хэлтсээс тухайн сууцын эзэд түрээслэх хүсэлт гаргасан хүмүүсийг тохиромжтой байдалд шалгалт хийхийг уриалж, дэмжлэг үзүүлдэг гэж төсөөлье. Жишээ нь гэмт хэрэгтэй холбогдож байсан этгээд түрээслэгч болохыг зөвшөөрөхгүй байх гэх мэт. Ийм бодлого нь гэмт хэрэгт холбогдсон түүхтэй хүмүүс цаашид гэмт хэрэг үйлдэх болно, харин гэмт хэргийн түүхгүй хүмүүс гэмт хэрэг үйлдэхгүй гэсэн таамаглал агуулж буй. Уг таамаглал нь байнга үнэн байна гэдэгтэй ийм бодлогыг дэмжигчид хүртэл санал нийлэхгүй ч хоёр зүйлийг мэдэх нь чухал. Нэгдүгээрт, дээрх бодлого нь түрээсийн үл хөдлөх хөрөнгөтэй

холбоотой гэмт хэргийг бууруулах уу? Үр дүнгийн үнэлгээ энэ асуултад хариулж болно. Гэхдээ гэмт хэргийг бууруулах байсан ч сөрөг үр дагавар нь юу вэ? Энэ асуултад хариулахын тулд уг таамаглалын алдааны түвшинд дүн шинжилгээ хийх шаардлагатай.

Хэрэв бид холбогдох өгөгдлийг цуглуулж чадсан бол доорх хүснэгтийг үүсгэх боломжтой. Бодлогын таамаглал үнэн зөв болохыг харж байна. Гэхдээ бид алдаануудын талаар юу гэж бодож байна вэ? Гэмт хэрэг үйлдэж байгаагүй хүмүүсийн хүрээнд ямар нэг арга хэмжээ авах ёстой юу? Гэмт хэрэг үйлдэхгүй байгаа гэмт хэргийн түүхтэй хүмүүс орон байргүй байсаар байх уу?

## Хүснэгт 2. Таамаглалын алдааны дүн шинжилгээний жишээ

Өмнөх гэмт хэргийн түүх, оролцоо			
Хожмын гэмт хэргийн түүх, оролцоо	Тийм	Үгүй	Нийт
Тийм	35	10	45
Үгүй	35	496	531
Нийт	70	506	576

Үнэн бодит байдал, нарийвчлалын хувь хэмжээ: 92,2%

Худал сөрөг хувь хэмжээ: 1,7%

Худал ээрэг хувь хэмжээ: 6,1%

Сүүлийн хугацаанд гэмт хэрэгтэй холбогдоогүй хүмүүс гэмт хэрэг үйлдэх явдлыг бууруулахад чиглэсэн хязгаарлалтыг нэмэгдүүлснээр худал сөрөг хувь хэмжээг бууруулах боломжтой. Гэвч энэ нь, ялангуяа ашиглаж буй мэдээлэл нь тодорхой биш байх тохиолдолд худал ээрэг хувь хэмжээг нэмэгдүүлэх боломжтой. Нөгөөтээгүүр, сүүлийн хугацаанд гэмт хэрэгтэй холбогдсон этгээдүүдийг ялгаж тодорхойлох нь худал ээрэг хувь хэмжээг бууруулж, худал сөрөг хувь хэмжээг нэмэгдүүлэх үр дагавартай байна. Иймэрхүү хамаарал нэлээд түгээмэл байдал.

Тухайн гэмт хэргийн шинж чанар, төрлөөс хамааран дээрх хувь хэмжээний утга харилцан адилгүй байдаг. Тухайлбал, сууцын эздийн урьдчилан сэргийлж буй гэмт хэрэг нь хөнгөн төрлийнх бол худал ээрэг хувь хэмжээ хэт өндөр байх магадлалтай, харин ноцтой

гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлж байгаа бол худал сөрөг хувь хэмжээнд илүү анхаарах нь зүйтэй. Эдгээр алдааны үр дагавар нь маш чухал бөгөөд ихээхэн саналын зөрүү үүсгэдэг билээ.

Алдааны түвшнийг тооцоолоход саналын зөрүү мөн үүсдэг. Ийм хувь хэмжээг тооцоолоход нэлээд хундрэлтэй байдаг. 2 дугаар хүснэгтийн сүүдэртэй хэсгүүдийг авч үзье. Ихэнх тохиолдолд эдгээрийн утга тодорхойгүй байх болно. Байрны эзэд гэмт хэргийн түүхийн улмаас хэчнээн хүнээс татгалзсаныг тоолж мэдээлж болох ч хулээн авсан тохиолдолд тухайнхүүс хэрхэхбайсан талаар хэлж мэдэхгүй. Бусад тохиолдолд нөхцөл байдал эсрэгээрээ өөрчлөгднө. Худал эергийг тодорхой нарийвчлалтайгаар мэдэж болох ч худал сөрөг нь тодорхой бус байх гэх мэт. Нисэх онгоцны буудлын үзлэгт

худал эергийг мэдэх боломжтой байдаг. Учир нь хууль бус бараа байгаа гэсэн таамаглал дэвшүүлсэн бол нарийн хяналт шалгалт хийж тогтоодог. Аюулгүй байдлын ажилтнууд тухайлбал галт зэвсгийн талаар сэжиглэсэн бол үүнийг хянан шалгаж, ингэснээр анхны таамаглал үнэн эсвэл буруу байсан эсэхийг тодорхойлох боломжтой байдаг. Харин худал сөргийг тогтооход хэцүү. Хууль бус бараа тээвэрлэж буй этгээд нисэх онгоцны буудлын хамгаалалтыг давсан тохиолдолд түүнийг дахин шалгахгүй тул худал сөргийг тооцоух боломжгүй юм.

Таамаглал дэвшүүлж, аливаа нэг арга хэмжээ авахгүйгээр таамаглалын үнэн зөв байдлыг

ажиглаж, улмаар алдааны түвшнийг оновчтой тогтоох зорилго бүхий туршилтуудыг хийх боломжтой. Гэмт үйлдлээ нуун дарагдуулах сонирхолтой хэрэгтнүүдийн хүрээнд энэ туршилтыг хэрэгжүүлэхэд хэцүү байж болох ч гэмт хэрэгт өртэж болзошгүй хохирогч эсвэл газарт боломжтой юм. Жишээлбэл, аль газар гэмт хэрэгт үсэж болохыг урьдчилан таамагласны дараагаар тухайн газарт хариу арга хэмжээ авч болно. Ийнхүү хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхээс өмнө хариу үйлдэл үзүүлэхгүйгээр, зөвхөн таамаглал дэвшүүлэх байдлаар туршилт хийж болно. Хэрэв алдааны түвшин хэт өндөр бол тухайн хариу арга хэмжээг авах шаардлагагүй.

# ХЭРЭГЖИХҮЙЦ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ ОЛОХ НЬ

## 38. Хариу арга хэмжээнд гүйцэтгэх өөрийн үүргийг хүлээн зөвшөөрөх

Цагдаагийн алба хаагчид аливаа асуудлыг нарийвчлан шинжлэхэд оролцдог боловч хууль сахиулах, хууль хэрэгжүүлэх замаар асуудал шийдвэрлэхийг юуны түрүүнд хичээдэг. Үр нөлөө нь ихэвчлэн богино хугацаатай боловч та үүнийг эсэргүүцэхгүй байх хэрэгтэй. Гэхдээ та цагдаагийн албад олонд илүү үр дүнтэй бөгөөд урт хугацааны арга, шийдлийг олоход нь анхнаасаа туслах хэрэгтэй. Тухайн бүс нутгийн түншүүд энэ энэ чиглэлээр тусламж үзүүлж болох ч тэд ерөнхийдөө өөрсдийн ашиг сонирхлыг тэргүүнд тавьдаг тул хязгаарлагдмал нөлөөтэй шийдлийг дэмжих нь олонтоо. Үүний үр дунд оролцогч талуудын ашиг сонирхлыг дэмжсэн боловч үр дүнгүй хариу арга хэмжээ, шийдлүүд гарах хандлагатай байдаг. Энэ явцад аливаа шийдэлд хүрч чадахгүй байх ч боломжтой.

Үүнээс сэргийлэхийн тулд өхлээд шийдэл боловсруулахад мэргэших хэрэгтэй. Жишээлбэл, хэрэв асуудал нь машины хулгайн хэрэг бол тээврийн хэрэгслийг урхи болгон ашиглах арга, "машинаа түгжээрэй" уриа лоозон үр дүнгүй байдгийг илэрхийлэх чадвартай байх хэрэгтэй. Хэрэв хэрэг зөрчил нь орон байрны хулгай байх тохиолдолд боломжит шийдлүүд болох хулгайн дохиолол, гэрэлтүүлгийн үр дүнгийн талаар мэддэг байх нь зүйтэй. Түүнчлэн аливаа шинэлэг шийдлийг үгүйсгэж болзошгүй гэмт хэргийн шилжилт хөдөлгөөний онолын талаар хийгдсэн судалгааг судалсан байх хэрэгтэй.

Шийдэл боловсруулах мэргэжилтэн болохын тулд та аливаа хариу арга хэмжээний талаар түргэн шуурхай судалж чаддаг байх хэрэгтэй (алхам 19). Түүнчлэн гэмт хэрэг үйлдэх нөхцөл, шалтгааныг арилгах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлд мэргэших нь зүйтэй. Энэхүү арга барил нь асуудалд тулгуурласан цагдаагийн

үйл ажиллагаатай адил арга хэмжээ авах-судалгаа хийх аргачлалд суурилсан бөгөөд энэ чиглэлээр олон асуудлууд амжилттай шийдвэрлэгдсэн байдаг. Энэхүү зааварт дурдсан гэмт хэргийн шилжилт хөдөлгөөн, ээрэг нөлөөллийн тархалт, давтан хохирогч болох эрсдэл болон бусад олон ойлголтыг дээрх арга барилын хүрээнд боловсруулсан байдаг. Дараагийн таван алхамд нөхцөл байдлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 25 аргыг авч үзэх бөгөөд эдгээр нь үндсэн таван бүлэгт хуваагдана (хүснэгтийг үзнэ үү). Эдгээрийг Их Британийн Ноттингем Трентийн Их Сургуулийн Ник Тилли урьдчилан сэргийлэх арга хэмжээний "урьдчилан сэргийлэх" шинж чанарыг бүрдүүлдэг механизмууд гэж тодорхойлсон байдаг. Үүнд: гэмт хэрг үйлдэхэд шаардлагатай хүчин чармайлтыг нэмэгдүүлэх, гэмт хэрг үйлдсэнээр хүлээх эрсдэлийг нэмэгдүүлэх, гэмт хэрг үйлдсэнээр хүртэх өгөөжийг бууруулах, гэмт хэрг өдөөгч хүчин зүйлсийг бууруулах, гэмт хэрг үйлдэх шалтгийг арилгах.

Та шийдэл боловсруулах чиг үүрэг яагаад таны хариуцлага байх ёстой юм гэж бодож байж магадгүй. Та асуудлыг задлах, дүн шинжилгээ хийх, үнэлэх үе шатанд их хэмжээний ачаалал үүрч байгаа нь хангалттай биш гэж үү? Түүнчлэн энэ үүрэг таны хариуцлага байсан ч яагаад хэн нэгэн танд анхаарал хандуулах ёстой гэж? Асуудал шийдвэрлэх шинжээч болохын тулд та уламжлалт дүн шинжилгээний аргаасаа салах шаардлагатай. Та асуудлыг шийдвэрлэх багийн бүрэн эрхт гишүүн байх хэрэгтэй. Та харьцангуй шинэ, эсвэл залуу байж болох ч таны эрх мэдэл албан тушаалаас бус харин таны ажлын үр дүн, мэргэжлийн үр чадвараар батламжлагдах учиртай. Хэрэв та шинэлэг санал дэвшиүүлбэл эсвэл бусад хүмүүсийн дэвшилтэт санааг дэмжих нотолгоо өгвөл хүмүүс таныг сонсох болно.

## Нэхцөл байдлын урьдчилан сэргийлэх хорин таван арга техник

<p><b>Гэмт хэрэг үйлдэхэд шаардагдах хичээл чармайлтыг нэмэгдүүлэх</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Харуул хамгаалалтыг сайжруулах</li> <li>2. Объектод нэвтрэх явцад хяналт тавих</li> <li>3. Гарах хүмүүсийг хянах, шалгах</li> <li>4. Гэмт хэрэгтнийг өөрчлөх</li> <li>5. Бага хэрэгсэл, зэвсгийн хяналт.</li> </ol> <p><b>Эрсдэлийг нэмэгдүүлэх.</b></p> <ol style="list-style-type: none"> <li>6. Хамгаалалтыг сайжруулах</li> <li>7. Өөрийн хяналт, хамгаалалтыг сайжруулах</li> <li>8. Тодорхойгүй байдлыг бууруулах</li> <li>9. Талбайн менежерийг ажиллуулах</li> <li>10. Хяналтыг бэхжүүлэх</li> </ol>	<p><b>Гэмт хэргийн өгөөжийг бууруулах</b></p> <ol style="list-style-type: none"> <li>11. Байг нууцлах</li> <li>12. Байг шилжүүлэх</li> <li>13. Өмч хөрөнгийг тодорхойлох</li> <li>14. Зах зээлд нөлөөлөх</li> <li>15. Зан төлөвөөс татгалзах.</li> </ol> <p><b>Гэмт хэрэг өдөөгчийг бууруулах</b></p> <ol style="list-style-type: none"> <li>16. Стресс, бухимдлыг бууруулах</li> <li>17. Маргаанаас зайлсхийх</li> <li>18. Уруу татагдах болон сэтгэл хөөрлийг бууруулах</li> <li>19. Ye тэнгийнхийн дарамт шахалтыг саармагжуулах</li> <li>20. Дуурайх явдлыг дэмжихгүй байх</li> </ol>	<p><b>Гэмт хэрэг үйлдэх шалтгийг арилгах</b></p> <ol style="list-style-type: none"> <li>21. Дүрэм журам тогтоох</li> <li>22. Зааварчилгаа өгөх</li> <li>23. Ухамсрыг сээрэх</li> <li>24. Дагаж мөрдөхөд туслах</li> <li>25. Хар тамхи, архинд хяналт тавих</li> </ol>
---	---	---

## Нэхцөл байдлын урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх долоон шүүмжлэл, сөрөг шүүмжлэл

Шүүмжлэл	Эсрэг няцаалт
1	Энэ нь энгийн бөгөөд онолын үндэслэлгүй юм.
2	Энэ нь үр дүнтэй харагдаагүй, гэмт хэргийн шилжилт үүсгэх, байдлыг улам хүндрүүлдэг.
3	Энэ нь гэмт хэргийн үндсэн шалтгаанаас анхаарлыг сарниулдаг.
4	Хуучинсаг, гэмт хэрэг, зөрчилд удирдлагын байр сууринеас ханддаг.
5	Гадуурхал, хувия хичээсэн байдлыг идэвхжүүлдэг.
6	Бусдыг хянах, удирдах хандлагыг идэвхжүүлж, хувийн уялдаа холбоо, эргэх нэхцөлийг хязгаарладаг.
7	Хохирогчийг буруутгадаг.

Та үргэлж асуудлыг хурдан шийдвэрлэх шийдлийг сонгох хэрэгтэй. Энэ нь та асуудлын алс холын, шууд бус шалтгаанаас илүүтэй ойрын, шууд шалтгаан дээр анхаарлаа төвлөрүүлэх ёстой гэсэн үг юм. Уг ялгааг Дотоод хэргийн яамны ажилтан Пол Экблом боловсруулсан бөгөөд хагархай лонх, стаканаас үүдэлтэй баарны зодооны гэмтлийн асуудлаар дүрсэлж болно. Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, үүнээс шалтгаалан ажил олдохгүй байх, улмаас нийгмээс гадуурхагдах, "лут" байх шаардлага үүсэх зэрэг алсын шалтагт багтана. Илүү ойрын шалтгаанд орон нутгийн баар, ресторанд согтуурах явдлыг сурталчлах, лонх, стаканыг зэвсэг болгон ашиглах зэрэг багтана.

Гэмт хэргийн гаралтыг богино хугацаанд тогтвортой бууруулах нь зөвхөн нөхцөл, шалтгааныг арилгахаас шалтгаална. Бид алсын шалтгааны талаар юу хийхээ мэдэж байсан ч үндсэн шалтгааныг шийдвэрлэх нь алс холын ирээдүйд буюу одоогийн оролцогч талуудад хамааралгүй болсон үед үр дүнгээ өгнө. Харин ойрын шалтгааныг арилгахгүй бол хагархай лонх, стакан зэрэг нь хохирогчдод үргэлжлэн нөлөөлж, хүн амины хэрэг гарсаар байх болно.

Зарим нөхцөл, шалтгааны шийдлийг хэрэгжүүлэхэд удаан хугацаа шаардагддаг. Жишээлбэл, бэхжүүлсэн шил бүхий лонх,

стакан ашиглахыг бар, ресторануудаас шаардаж, хуульчилж болно. Үүнийг хэрэгжүүлэхэд олон жил шаардагдана. Харин бар, ресторануудад зөвхөн бутардаг, бэхжүүлсэн шил ашиглах эсвэл хуванцар стаканаар үйлчлэх зэрэг шаардлагыг олон нийтийн зүгээс тавивал уул шийдэл хурдан хэрэгжих болов уу. Та үүнтэй холбоотойгоор баар, ресторанаас гарах нэмэлт зардлыг осол гэмтэл, яаралтай тусlamжийн зардалтай харьцуулж, дүн шинжилгээ хийж, тус шийдлийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх байх. Асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааны хүрээнд нухацтай авч үзэж байгаа аливаа шийдлийн эдийн засгийн үндэслэл, зардал, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх байдлын талаар мэдээлэл цуглуулах үүрэг танд даалгагдах болов уу.

Хамгийн гол нь та арга зам, шийдлүүдийн талаар маш өргөн хүрээний мэдлэгтэй болж, улмаар шийдлээ хамгаалснаар таны дүн шинжилгээ үр дүнтэй байж чадна.

#### **Нэмэлт материал:**

Clarke, Ronald V., ed. 1997. Situational Crime Prevention: Successful Case Studies, 2nd edition. Guilderland (New York): Harrow and Heston.

Von Hirsch, Andrew, David Garland, and Alison Wakefield, eds. 2000. Ethical and Social Perspectives on Situational Crime Prevention. Oxford: Hart Publishing.

## 39. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХҮЧИН ЧАРМАЙЛТ, ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

**Э**нд бид нөхцөл байдлын арга хэмжээний хамгийн чухал суурь аргыг тайлбарлана. Энэ нь гэмт хэрэгтэн хэрэг зөрчил, гэмт хэрэг үйлдэхэд хүндрэлтэй болгох, нэмэгдүүлэх зорилготой бөгөөд хэргийн бай, өртөгчийг хамгаалах, харуул хамгаалалтыг сайжруулахаас эхэнэ. Нөхцөл, шалтгааныг арилгах замаар урьдчилан сэргийлэх арга барилд үүнээс өөр онцлог байхгүй гэж үл тоомсорлож болох ч энэ нь тус арга барилд багтсан 25 аргын зөвхөн нэг нь юм. Эдгээр арга, техникийн хооронд ихээхэн давтагдал, давхцал байгааг анхаараарай. Жишээлбэл, бай, өртөгчийг хамгаалах, харуул хамгаалалтыг сайжруулах нь гэмт хэрэг үйлдэхэд илүү хүндрэлтэй байдал үүсгэдэг боловч гэмт хэрэгтний үйлдлийг удаашруулах, сэдлийг багасгах, баригдах магадлалыг нэмэгдүүлдэг. Зарим арга хэмжээ нь нэгээс илүү зорилготой байж болно. Энэ ангиллыг ашиглахдаа тодорхой хэмжүүр хаана тохирох вэ гэж санаа зовох хэрэггүй - зөвхөн тодорхой асуудалд нөхцөл, шалтгааныг арилгах бүхий хариу арга хэмжээний хамгийн өргөн хүрээг авч үзэхийн тулд энэ ангиллыг ашиглах нь зүйтэй.

**Бай, өртөгчийг хамгаалах, харуул хамгаалалтыг сайжруулах нь:** Хорлон сүйтгэгч эсвэл хулгайчийг saatuuлах хамгийн анхан шатны бөгөөд өндөр үр дүнтэй арга бол цоож, тор, бэхжүүлсэн материал гэх мэт биет хаалт, саадууд юм. 30 гаруй жилийн өмнө АНУ болон хилийн чанадад жолооны хүрдний түгжээг нэвтрүүлсэн нь автомашины хулгайг урт хугацаанд бууруулахад үр дүнгээ өгсөн, орчин үед моторын асаалтыг хориглогч immobilizer төхөөрөмжийг нэвтрүүлсэн нь үр дүнгээ өгсөөр байна. Лондоны шуудангийн салбаруудад хулгайн эсрэг дэлгэц нь хулгайн гэмт хэргийг 40 хувиар, сумны хамгаалалттай зорчигчийн дэлгэц нь Нью-Йорк хотод таксины жолооч нарын эсрэг үйлдэгдсэн халдлага, дээрмийн гэмтлийг бууруулсан.<sup>1</sup>

**Байгууллага, байгууламжид нэвтрэх хөдөлгөөнийг хяналт:** Цэргийн хуаран, үйлдвэр, орон сууцны хороолол зэрэг орох эрхгүй газарт нь оруулахгүй байх асуудлыг ярихад хүмүүс зөвхөн дундад зууны үеийн цайз, боомт, суваг шуудуу, гүүрэн гарцын талаар боддог. Энэ нь Оскар Ньюманы хамгаалалтын орон зайн тухай үзэл баримтлалын гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нөхцөл, шалтгааныг арилгах замаар урьдчилан сэргийлэх арга барилыг эхлүүлсэн гэж хэлэхүйц ойлголт юм. Барри Пойнер нэвтрэх утас суурилуулж, барилгуудыг холбосон явган хүний замыг буулгаснаар Лондоны орон сууцны хороолол дахь хулгайн гэмт хэргийн гаралтыг эрс багасгасан үр дүнг харуулсан (алхам 24). Зарим тохиолдолд нэвтрэх хөдөлгөөний хяналт нь тасалбар, зөвшөөрөл, үнэмлэх эзэмшихэд чиглэгддэг. Тасалбарыг шалгахад хялбар болгохын тулд тасалбарын шинэчилсэн загвар гаргаж, Канадын Ванкуверын гаталга онгоцны тасалбаргүй орох явдлыг бууруулсан. Хамгийн алдартай жишээн дээр 1970-аад оны эхээр нисэх онгоцны буудлуудад ачаа тээш, зорчигчдын үзлэг шалгалт нь дэлхийн хэмжээнд жилд 70-аас 15 болж буурахад нөлөөлсөн.

**Гарах хөдөлгөөний хяналт:** Гарах хөдөлгөөний шалгалтын зорилго нь барилга, байгууламж, объектоос гарч буй хүмүүс эд зүйлс хулгайлахгүй байх, шаардлагатай хураамж, татварыг хураахад зориулагдсан. Вашингтон ДС-ийн метроны зорчигчид системд орох болон гараадаа тасалбараа автомат хаалганд уншуулан шалгуулах ёстой. Энэ нь төлбөрөө төлсөн эсэхийг шалгах хоёр үйлдлийг гүйцэтгэдэг. Нью-Йорк хотын метронд зорчигчид метронд орохдоо тасалбараа зөвхөн нэг удаа хаалган дээр уншуулдаг нь тасалбар төлөхөөс зайлсхийсэн эсэхийг илрүүлэх боломжийг бууруулдаг. Гарах шалгалтын бусад жишээ гэвэл хил, гаалийн хяналт, номын сангийн номын хяналт, дэлгүүрийн бараа бүтээгдэхүүний хяналт, цахим шошго ашиглах зэрэг багтана. Эдгээр шошго нь номыг шалгаагүй эсвэл хулгайч шошготой зүйлийг дэлгүүрээс

<sup>1</sup> Martha Smith, *Robbery of Taxi Drivers*, no. 34 of Problem-Oriented Guides for Police (Washington, DC: Office of Community Oriented Policing Services, 2005), <http://ric-zai-inc.com/ric.php?page=detail&id=COPS-P072>.

хулгайлах оролдсон тохиолдолд дохиоллыг идэвхжүүлдэг. Судалгаанаас үзэхэд эдгээр арга хэмжээ нь дэлгүүрийн хулгай, номын сангийн номын хулгайг эрс багасгадаг.

## ГЭМТ ХЭРЭГТЭН ХЭРЭГ ЗӨРЧИЛ ҮЙЛДЭХЭД ШААРДАГДАХ ХИЧЭЭЛ ЧАРМАЙЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

### ГЭМТ ХЭРГИЙН БАЙ, ӨРТӨГЧИЙГ ХАМГААЛАХ, ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ

- Жолооны хурдийг түгжих болон моторын асаалтыг хориглогч төхөөрөмж суурилуулах
- Банк, шуудандгийн газруудад дээрмийн эсрэг харуул хамгаалалтыг сайжруулах
- Таксины жолооч суманд тэсвэртэй хуягийг ашиглах

### Объектод нэвтрэх хөдөлгөөний хяналт:

- Орон сууцны цогцолборт дуудлагын хайрцаг байрлуулах
- Гарааш, оффисуудад нэвтрэхэд цахим карт ашиглах
- Нийтийн сууцуудад хамгаалалттай, аюулгүй орон зайлт төлөвлөх

### Гарах хөдөлгөөний хяналт

- Гарах тасалбар ашиглах
- Экспортын баримт бичиг
- Дэлгүүр, номын санд цахим шошго хэрэглэх

### ГЭМТ ХЭРЭГТНИЙ ХӨДӨЛГӨӨНД НӨЛӨӨЛӨХ

- Стадионд эсрэг багийн хөгжөөн дэмжигчдийг тусгаарлан суулгах
- Гудамжийг хаах, түр хаах
- Эмэгтэйчүүдэд зориулсан амрах өрөөг тусгаарлах, тусдаа амрах өрөө байгуулах

### Хяналтын багаж хэрэгсэл

- Буюу хэрэглэх
- Бааранд бэхжүүлсэн, бутардаг стакан, лонх хэрэглэх,
- Хар тамхины наймаачид руу ирэх орох дуудлагыг хориглох
- Зээлийн карт дээр зураг наах, чек дээр хурууны хээтэй байх

## ГЭМТ ХЭРЭГТНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ӨӨРЧЛӨХ:

Нэгдсэн Вант Улсад хөл бөмбөгийн хөгжөөн дэмжигчид, фенүүдийн сөргөлдөөнийг хязгаарлах, багасгахын тулд цэнгэлдэх хүрээлэнд тэднийг тусгаарлан байрлуулж, хүлэх хугацаа үүсгэхгүй тулд тэдний ирэх, гарах хөдөлгөөнийг нарийн хуваарилдаг. Баар хаагдсаны дараа явах сүүлчийн автобусыг нарийн төлөвлөх нь Их Британийн бараг уламжлал болсон баар хаах үед зодоон нүдээн гардаг уламжлалыг таслан зогсоох зорилготой юм. Эдгээр нь өдөр тутмын амьдралын хэв маягийн онолын дагуу гэмт хэрэгтнийг хэргийн өртөгч, байнаас тусгаарлах, гэмт хэрэгтний хөдөлгөөнийг өөрчлөх зорилго бүхий нөхцөл, шалтгааныг арилгах замаар урьдчилан сэргийлэх арга хэмжээний жишээ юм. Зам хаах зэрэг бусад жишээнүүд олон төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулсан байдаг.<sup>2</sup> Лос-Анжелес хотын зарим замыг хааснаар машинтай этгээдийн үйлдэх буудлагын гэмт хэргийг багасгасан (хажуугийн самбарыг үзнэ үү).

**Багаж хэрэгсэл, зэвсэгт хяналт тавих:** АНУ-н "Wild West"-д зарим баарнуудад согтуугаар буудалцах гэмт хэрэг гарах эрсдэл ихтэй байсан тул үйлчлүүлэгчдийг нэвтрэхэд гар бууг нь хурааж авдаг байжээ. Сүүлийн үед тайвшруулагч сум, лааны тостой sumaар бууддаг, эсвэл зөвхөн эзэн нь буудах боломжтой, хурууны хээ таньдаг буунуудыг зохион бүтээсэн. Нэгдсэн Вант улсын олон пабууд стакан, лонх зэргийг зэвсэг болгон ашиглахаас урьдчилан сэргийлэхийн тулд бэхжүүлсэн лонх, стакан зэргийг хэрэглэдэг. Дуудлагын дугаарыг гаргадаг болгосноор (1980-аад оны сүүлээр Нью Жерсид) учир зорилгогүй, гэмт хэргийн сэдэлтэй дуудлагын тоог 25 хувиар бууруулсан. 34 дүгээр алхамд хотууд хар тамхины наймаанд нийтийн утасны хэрэглээг хянах оролдлого хийж байгааг харуулсан. Тухайлбал ирж буй дуудлагыг хориглох, тодорхой байршилд ашиглахыг хориглох янз бүрийн аргуудыг жагсаав. Манхэттэний автобусны буудлын

2 Ronald V. Clarke, Closing Streets and Alleys to Reduce Crime: Should You Go Down This Road?, no. 2 of Problem-Oriented Guides for Police (Washington, DC: Office of Community Oriented Policing Services, 2004), <http://ric-zai-inc.com/ric.php?page=detail&id=COPS-P060>.

нийтийн утсыг дахин программчлах нь олон улсын утасны үйлчилгээнд хууль бусаар нэвтрэхээс сэргийлж, хулгайчдын үйлдсэн олон сая долларын луйврыг зогсооход үр

дүнгээ өгсөн. 1990-ээд оны дундуур энэ улсад зээлийн карт шуудангаар хүргэх аюулгүй байдлын горимыг сайжруулснаар зээлийн картын луйврын хэрэг эрс буурсан (алхам 11).

## Хөдөлгөөнт тээврийн хэргээс буудах гэмт хэргийн шийдэл

Өрсөлдөгч гэмт хэргийн бүлэглэлүүд ихэвчлэн хөдөлгөөнтэй машинаас эсрэг бүлэглэлийн гишүүн рүү буудаж устгах замаар маргаанаа шийддэг. Залуучуудад чиглэсэн үйл ажил эсвэл өндөржүүлсэн эргүүлээр эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хэцүү байдаг. Лос-Анжелес хотын нэгэн 10 блокийн талбайд "Куд-Дэ-Сак ажиллагаа"-ийг хэрэгжүүлж туршсан. Энэ газар нь машинаас буудах, буудалцах гэмт хэргийн гаралтаар хамгийн өндөр хувийг эзэлдэг. Цагдаа нар хамгийн их эрсдэлтэй гудамжинд замын хөдөлгөөний хаалт суурилуулсан. Эдгээр мухар гудамжнууд нь нэг талаасаа машин орохоос сэргийлж, нөгөө талаас орж ирсэн машиныг буцаж гарахыг шаарддаг зохион байгуулалттай. Энэ нь буудалцаанд оролцогчдод хүндрэл учруулаад зогсохгүй баригдах эрсдэлийг нь нэмэгдүүлсэн, учир нь орж ирсэн замаараа буцаж гарахад тэдний эсрэг бүлэглэл нь аль хэдийн буудалцаанд бэлтгээд амжих боломжтой байдаг.

Хаалт саадууд нь машинтай буудалцах гэмт хэргийн гаралтыг бууруулахад үр дүнгээ өгсөн. 1989 онд "Кул-де-Сак" ажиллагаа явуулахаас өмнөх жил энэ нутагт долоон хүн амины хэрэг үйлдэгдсэн байна. Хаалт суурилуулсны дараа дараагийн хоёр жилд ганцхан хүн амины хэрэг бүртгэгджээ. Хүн амины хэрэг өөр хороолол руу шилжсэн гэх нотлох баримт байхгүй. "Кул-де-Сак" ажиллагааны төгсгөлд саад бэрхшээлийг арилгахад хүн амины хэрэг өмнөх түвшиндээ дахин нэмэгдсэн.

Эх сурвалж: Lasley, James. 1998. "Designing Out' Gang Homicides and Street Assaults." Research in Brief (November). Washington, DC: National Institute of Justice. [http://www.popcenter.org/problems/drive\\_by\\_shooting/PDFs/Lasley\\_DesigningOut\\_1998.pdf](http://www.popcenter.org/problems/drive_by_shooting/PDFs/Lasley_DesigningOut_1998.pdf).

# 40. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭД ХҮЛЭЭХ ЭРСДЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Гэмт этгээдүүдтэй хийсэн ярилцлагаас үзэхэд тэд баригдвал ямар үр дагавар гарахаас илүүтэй баригдах эрсдэлийн талаар санаа зовдог. Учир нь гэмт хэрэгтнүүд баригдсан тохиолдолд ялаас бултаж чадахгүй, харин анхааралтай байж баригдах эрсдэлийг бууруулах боломжтой байдагт оршиж буй. Иймд нөхцөл, шалтгааныг арилгах замаар урьдчилан сэргийлэх арга барил баривчлагдах эрсдэлийг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд ял, шийтгэлийг удирдах оролдлого хийдэггүй.

**Харуул хамгаалалтыг сайжруулах, өргөжүүлэх:** Коэн, Фэлсон нар 1960-1970-аад оны үед орон сууцны хулгай ихэссэн нь ажилладаг эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой болохыг харуулсан. Энэ нь олон тооны орон сууц өдрийн дийлэнхэд харуул хамгаалалт, хамгаалагчүй байдгаас хамаарч буй юм. Бусад судалгаагаар хулгайчид хүмүүс гадуур байх магадлалтай үед буюу ажлын өдрийн үдээс хойш гэмт хэрэг үйлдэхийг илүүд үздэг болохыг тогтоожээ. Иймд иргэд амралтаар явахдаа сониноо цуцалж, хөршүүддээ мэдэгдэх нь зүйтэй. Гар утас авч явах эсвэл шөнийн цагаар бусад хүмүүстэй хамт явах нь хамгаалалтыг сайжруулах ёөрнэг арга юм. Гэхдээ эдгээр урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнтэй байдлын талаар төдийлөн судлаагүй бөгөөд хамгаалалтыг сайжруулах цорын ганц системчлэгдсэн арга хэмжээ болох хөршийн хяналтын үр дүнтэй байдалд хийсэн үнэлгээний дүгнэлт тийм ч сайн байгаагүй. Гэсэн хэдий ч Английн Кирхолт хотод авч хэрэгжүүлсэн хулгайн гэмт хэрэг гарсан тохиолдолд эргэн тойрны байшингуудад дохиолол өгдөг "хүр хорхойн үүр" систем амжилттай байсныг онцлох нь зүйтэй.

**Бусад хүмүүсийн хараа хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх:** Байр, сууцны өзэд ойролцоо мод бутыг тайрах, банкууд доторх гэрлээ асаалттай үлдээх зэргээр хажуугаар өнгөрч буй явган хүмүүсийн ажиглах боломжийг буюу "байгалийн хяналт"-ыг нэмэгдүүлж, объектоо хамгаалдаг билээ. Энэхүү байгалийн хяналтыг нэмэгдүүлэх

нь гудамжны гэрэлтүүлэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохион байгуулалтын гол зорилго билээ. Их Британид хийсэн судалгаагаар нийтийн орон сууцны гэрэлтүүлэг сайжрах нь шилжилт хөдөлгөөн өдөөхгүйгээр гэмт хэргийн гаралтыг бууруулдаг болохыг тогтоожээ. Орегон мужийн Портланд хотын дэлгүүрийн хулгайн гэмт хэргийг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлсэн "CPTED"-ийн эхэн үеийн арга хэмжээний нэг дэлгүүрийн гаднах гэрэлтүүлгийг сайжруулах байжээ. Оскар Ньюман байгалийн хяналтыг сайжруулах зарчмыг хэрэгжүүлснээр нийтийн орон сууцанд гэмт хэргийн гаралтыг бууруулахад амжилт гаргасан гэж мэдэгдсэн байдаг. Эцэст нь мэдээлэгчийн шууд утас, гэмт хэргийг таслан зогсоох хөтөлбөрүүд нь олон нийтийн зүгээс үзүүлж буй хараа хяналт, ажиглалтыг ашиглах зорилготой.

**Танигдахгүй байх/нэрээ нууцлах явдлыг бууруулах:** Машины тусламжтайгаар хүмүүс гэрээсээ хол ажиллах боломж бүрдсэн. Хотоос гадуур худалдааны төвүүд хөгжих нь хотын төвийн худалдааг багасгасан. Хямд үнэтэй аялал нь дотоод болон гадаадад аялал жуулчлалыг нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд хүмүүс танихгүй хүмүүсийн дунд илүү их цаг зарцуулах болсон. Томоохон сургуулиудын улмаас сурагч, багш нар бие бие төдийлөн таньдаггүй болсон. Бие бие танихгүй байх энэхүү нөхцөл байдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ нь үр дүнтэй байх боломжтой боловч ховор хэрэглэгддэг билээ. Зарим сургуулиуд сурагчдыг таних үүднээс ирж, харих замдаа дүрэмт хувцастай байхыг шаарддаг. Таксины жолооч үнэмлэх, энгэрийн тэмдэг хэрэглэх, ачааны машинууд 1-800 тоот наалт хэрэглэх нь таньж мэдэгдэхгүй байгааг бууруулах аргууд юм.

**Менежер ажиллуулах:** Зарим ажилтнууд үндсэн үүргээсээ гадна ажиглалт, тандалтын үүргийг давхар гүйцэтгэдэг. Эдгээр ажилчдыг "газрын менежер" гэх бөгөөд үүнд борлуулалтын туслахууд, зочид буудлын хаалгачин, зогсоолын үйлчлэгч нар багтана. Канадын судалгаагаар хаалгачтай орон

сууцны хороолол хулгайд өртөх нь бага байдгийг тогтоожээ. Хуурамч болон хулгайд алдагдсан зээлийн картыг илрүүлэх зорилгоор кассын ажилтныг урамшуулах нь Нью Жерси дэх электрон барааны жижиглэнгийн дэлгүүрт жил бүрийн залилангийн гэмт хэргийг бараг 1 сая доллароор бууруулахад тусалсан. Английн хойд хэсэгт байрлах хоёр давхар автобуснуудыг эвдлэн сүйтгэх хэргийг бууруулахын тулд цөөн хэдэн автобусанд жолооч нарт зориулсан видео камер сууринуулсан нь үр дүнгээ өгсөн. Хоёр ажилтан, ялангуяа шөнийн цагаар жижүүрлэн ажиллах нь дэлгүүрийн хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй байдаг (дараагийн хуудасны хүснэгтийг үзнэ үү).

**Албан ёсны хяналт шалгалтыг бэхжүүлэх:**  
 Албан ёсны хяналтыг цагдаа, хамгаалалтын албаныхан, дэлгүүрийн мөрдөгч нар гүйцэтгэдэг бөгөөд эдгээр нь бүгд хэрэг үйлдэж болзошгүй хүмүүст төвөгтэй, хүндрэлтэй байдал учруулах зорилготой. Хулгайн дохиолол, видео камер, хурдны камер зэрэг нь хяналтыг сайжруулж чадна. Филадельфиин ойролцоо чинээлэг иргэдийн дунд хийсэн судалгаагаар хулгайн дохиоллыг өргөн хэрэглэнээр орон нутагт хулгайн гэмт хэргийн гаралтыг бууруулж, цагдаагийн зардлыг бууруулж байгааг тогтоожээ. Дотоод хэргийн яамны судалгаагаар Их Британийн хотуудад видео камер сууринуулсаны дараа төрөлбүрийн гэмт хэргийн гаралт мэдэгдэхүйц буурсан болохыг тогтоожээ.<sup>3</sup> Австралийн Виктория мужид байрлуулсан фото радарын үнэлгээгээр хурд хэтрүүлэх зөрчлийг бууруулж, зам тээврийн ослыг 45 хувиар бууруулж чадсан. Канадын Ванкувер хотын захын нэгэн том цэцэрлэгт хүрээлэнд хувийн хамгаалалтын компаниас зохион байгуулсан дугуйн эргүүлийг сайн сурталчилсны үр дүнд автомашины хулгайн гэмт хэргийн гаралтыг эрс бууруулжээ. Аюулгүй байдлын ажилтнууд системтэй ажиллаж эхлэхэд Нью Жерсигийн электрон барааны дэлгүүрийн агуулахад өдөр бүр өндөр эрсдэлтэй бараа, тухайлбал видео магнитофон, видео камер, ажилчдын үйлдэх хулгайн хэрэг 80 гаруй хувиар буурчээ. Албан хяналтыг сайжруулах шинэ хүчирхэг аргуудыг Экхарт Кулхорны судалгаанд харуулсан.

<sup>3</sup> Jerry Ratcliffe, Video Surveillance of Public Spaces, no. 4 in Problem-Oriented Guides for Police (Washington, DC: Office of Community Oriented Policing Services, 2011), <http://ric-zai-inc.com/ric.php?page=detail&id=COPS-P097>.

Энд судалгаанд хувь хүмүүсийн талаарх мэдээллийн багцыг холбосон байдаг.

Шведийн засгийн газрын хоёр тусдаа хэлтэст нэхэмжлэгчийн хийсэн хувийн орлогын мэдүүлгийг компьютерт нягтлан шалгах нь халамжтай холбоотой луйврыг бууруулж байгааг тогтоосон. Хүмүүс турээсийн мөнгө нэхэмжлэхдээ орлогоо дутуу харуулахыг эрмэлздэг, мөн өвчний тэтгэмж хүсэхдээ өвчний байдлаа хэтрүүлэн харуулахыг эрмэлздэг байв. Хөрөнгө орлогын мэдүүлгийг нягт нямбай шалгах нь эдгээр залилан хэргийг эрс багасгасан.

### Нэмэлт материал:

Painter, Kate, and Nick Tilley, eds. 1999. Surveillance of Public Space: CCTV, Street Lighting and Crime Prevention. Vol. 10 of Crime Prevention Studies. Monsey (New York): Criminal Justice Press. [Http://www.popcenter.org/library/crime-prevention/volume\\_10/](http://www.popcenter.org/library/crime-prevention/volume_10/).

## Сүлжээ дэлгүүрүүдэд дээрмийн хэргийг бууруулах арга хэмжээ (14 судалгааны үр дүн)

Дэмжих судалгаануудын тоо*	
Хоёр ба түүнээс дээш ажилтан ажиллах	10
Бэлэн мөнгөтэй харьцаад хяналтыг сайжруулах	8
Нууцаар нэвтрэхгүй байх	6
Ойролцоо дэлгүүрүүд	5
Дэлгүүрийн нүүрэн тал сайн харагддаг байх	5
Шөнө ажиллахгүй байх	5
Харуул хамгаалалтын арга технологийг нэвтрүүлэх	5
Касс аюулгүй бүхээг дотор байрлах	4
Ажилчдыг ургах, дадлагажуулах	4
Дэлгүүрийн дотор тал сайн харагддаг байх	3
Нүүрэн талд хийн насостой	3
Касс дэлгүүрийн голд байрлах	3
Хүн ихтэй гудамжинд байрлах	2
Харуул хамгаалалтын ажилтан ажиллуулах	2

\*Бүх судалгаанд дээр дурдагдсан арга хэмжээнүүд бүгд багтаагүй болно.

Эх сурвалж: Hunter, Ronald D., and C. Ray Jeffrey. 1997. "Preventing Convenience Store Robbery through Environmental Design." In *Situational Crime Prevention: Successful Case Studies*, 2nd edition, edited by Ronald V. Clarke. Monsey (New York): Criminal Justice Press.

## Гэмт хэрэгтэн хэрэг үйлдэхэд гэмт хэрэгтэнд учрах эрсдэлийг нэмэгдүүлэх

### Харуул хамгаалалтыг сайжруулах

- Гэрээсээ явахдаа гэрт хүн байгаа мэт шинж тэмдэг үлдээх, гар утас авч явах, шөнийн цагаар ганцаараа явахгүй байх
- Хөршийн хяналт

### Бусад хүмүүсийн зүгээс харах ажиглалт, хяналтыг сайжруулах

- Гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх
- Хамгаалалт хийх боломжтой орон зайд төлөвлөх, байгуулах
- Хөршийн хяналт, мэдээлэгчийн утас

### Тодорхойгүй байдлыг бууруулах

- Таксины жолооч нууц дугаартай байх
- "Таксины үйлчилгээ хэр байна" гэсэн энгэрийн тэмдэг хэрэглэх
- Сургуулийн дүрэмт хувцас

### Объект, талбайн менежерийг ажиллуулах

- Гэмт хэргээс сэргийлэх зорилгоор ажилчдыг сургах
- Сонор сэрэмжтэй байдлыг сайжруулах
- Мэдээлэгчийг дэмжих

### Албан хяналтыг сайжруулах, бэхжүүлэх

- Хурдны камер, согтуурлын зэрэг шалгагч ашиглах
- Хотын төвийн видео, камерын хяналт
- Авто зогсоолуудад дугуйт эргүүл ажиллуулах

# 41. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭНЭЭР ХҮРТЭХ ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛАХ

Оновчтой сонголтын онолын гэмт хэрэгтнүүд гэмт хэрэг үйлдэн өгөөж хүртэхийг эрмэлздэг гэж үздэг. Санхүүгийн ашгаас гадна бэлгийн харьцаа, архидан согтуурах, баясах, зугаацах, өс хонзонгоо авах, мэргэжил нэгт хүмүүсийн дунд хүндлэгдэх зэргийг өгөөж гэж тооцно. Иймд гэмт хэрэг үйлдэх нөхцөл, шалтгааныг арилгах замаар урьдчилан сэргийлэх арга барилын чухал судлагдахуун бол гэмт хэргээс хүртэх өгөөжийг гэмт хэргийн төрөл тус бүрээр тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга замыг олох явдал юм.

Байг нууцлах. Байрны эзэд ихэвчлэн үнэт эдлэл болон бусад үнэт зүйлсийг нуухыг оролддог. Мөн хулгайчийн хараанд өртөхгүй тулд цонхны хөшгөө хаадаг. Зарим хүмүүс олон нийтийн газар алтан гинж зүүдэггүй, Хонда, Акура зэрэг хулгайч нарын хараанд өртөх машинаа гудамжинд эзэнгүй орхихгүй байхыг хичээдэг. Их Британийн Гэмт Хэргийн Судалгаанд үндэслэн боловсруулсан доорх хүснэгтэд тусгасны дагуу гудамжинд орхисон машинуудын хулгайд өртөх эрсдэл гарааш эсвэл хүн ихтэй замд үлдсэн машинуудаас илүү өндөр байдаг байна. Эдгээр нь бүгд гэмт хэргийн бай, өртөгчийг нууж, гэмт хэрэгтнүүдийн хараанд өртөх явдлыг багасгах зорилготой. Бусад нуух аргууд нь тийм ч ойлгомжтой биш юм. Жишээлбэл, хүйс заагаагүй утасны жагсаалт нь эмэгтэйчүүдийг хүчирхийллийн зорилготой дуудлагаас хамгаалахад чиглэсэн ба хуягт

ачааны машинуудыг тэмдэглэдэггүй нь замын хулгайн гэмт хэргээс сэргийлэх зорилготой.

Бай, өртөгчийг шилжүүлэх. Испанийн сүмд зээлийн карт хүлээн авдаг машин суурилуулснаар хэд хэдэн эерэг нөлөөтэй байсан: өргөл өгөгчид төлбөрийн баримт авах боломжтой болсон, өргөлийн хэмжээ ихэссэн, бэлэн мөнгө хадгалахгүй тул хулгайн хэргийн эрсдэлийг бууруулсан билээ.

Үүнтэй төстэй нэгэн жишээ бол Калифорнийн алт олборлогчид буюу "алтны халуурал"-ын үеэс гаралтай. Чиргуулийн хулгай ихээр гардаг нэгэн уурхай 400 фунтийн куб хэмжээтэй алт цутгаж эхлэв. Энэ нь дээрэмчид мориор авч явахад хэтэрхий хүнд байсан аж. Бай, өртөгчийг шилжүүлэхтэй холбоотой хамгийн сүүлийн үеийн жишээ бол төлбөртэй утсанд хийсэн өөрчлөлт юм. Хүмүүс шил хагалахыг зогсоохын тулд Их Британид өндөр эрсдэлтэй газруудад хананд суурилуулсан утсыг бүрхүүлт утсаар сольж, төлбөрийг урьдчилсан төлбөрт картаар хийдэг болсон нь бэлэн мөнгө бүхий байг шилжүүлж, хулгай, дээрмийн гэмт хэргийг бууруулсан. 1960-аад оны сүүлчээр Нью-Йорк болон бусад 18 хотод автобусны жолоочийг дээрэмдэх гэмт хэргийг бууруулахын тулд автобуснуудад тарифын систем, сейфийг нэвтрүүлсэн нь бай, өртөгчийг шилжүүлэх арга хэмжээний тод жишээ болсон.

Их Британийн гэмт хэргийн судалгаа Англи, Вэйлсийн авто зогсоолын газрууд дахь машины хулгайн хэрэг	
Машинаа удаан байрлуулсан газрууд	24 цаг тутамд 100 000 машин тутамд машинтай холбоотой гэмт хэрэг.
Гэрийн гарааш	2
Гудамж, машины зогсоол	40
Бусад гудамж	327
Нийтийн зогсоол	454

\*Хулгай, дээрэм, гэмт үйлдэл хийх оролдлого ба санаатай хохирол учруулах зэрэг багтсан болно.

Эх сурвалж: Clarke, Ronald V., and Pat Mayhew. 1998. "Preventing Crime in Parking Lots: What We Know and Need to Know." In Reducing Crime through Real Estate Development and Planning, edited by Marcus Felson and Richard Peiser. Washington, DC: Urban Land Institute.

Эд хөрөнгийг тодорхойлох. Өндөр хөгжилтэй орнуудад тээврийн хэрэгслийг бүртгэлд оруулах, улсын дугаартай байхыг (VIN) шаарддаг. Энэ нь татвар хураалтыг нэмэгдүүлэх, дэмжихээс гадна хулгайн гэмт хэргийг бууруулдаг. Тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэвтрүүлсэн Хамгийн сүүлчийн мужийн нэг нь Иллинойс муж байсан (1934 онд шилжсэн) бөгөөд энэхүү зохицуулалттай холбоотойгоор тээврийн хэрэгслийн хулгайн хэрэг өмнөх онд 28,000 байсан нь дараа жилдээ 13,000 болж буурчээ. 1984 оны Тээврийн хэрэгслийн хулгайн гэмт хэргийн тухай хуулиар өндөр эрсдэлтэй автомашины бүх гол хэсгүүдэд "VIN" код бичихийг шаардаж эхэлсэн. Гэвч "Тодорхойлох тэмдэг" нэртэй энэхүү цагдаагийн үйл ажиллагааны хөтөлбөрүүд АНУ-д хязгаарлагдмал амжилтад хүрсэн. Харин Жилл Данногийн Гэмт хэргийн шинжлэх ухааны хүрээлэнгийн Гloria Laiкок нь Уэльсиийн гурван жижиг сууринд хөрөнгийн тэмдэг, тэмдэглэгээг хийж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчилсны үр дүнд орон нутагт гардаг хулгайн гэмт хэргийн тоог хоёр дахин бууруулсан болохыг тогтоожээ.

Зах зээлд нөлөөлөх. Криминологичид болон цагдаа нар хулгайн эд зүйлс, хулгайн барааны зах зээлийг ойлгох, түүнд нөлөөлөхөд анхаарлаа төдийлөн хандуулаагүй. Криминологичид хулгайн барааны зах зээлийн талаар мэдээлэл цуглуулахад хүндрэлтэй байдаг бөгөөд хулгайн барааг худалдахад оногдуулах ялшийтгэлхарьцангуй хөнгөн учраас цагдаагийн алба хаагчид хулгайч, дээрэмчдийг барихыг илүүд үздэг. Гэтэл хулгайн эд бараа зардаг зах байхгүй бол хулгайч нар цөөрөх, мөн тамхи, архитай машинаас хулгай хийх хэрэг гарах болов уу. Дотоод хэргийн яаманд зориулж Майк Саттоны хийсэн ажил хулгайн барааны зах

зээлд нөлөөлөх арга хэмжээг хэрэгжүүлэх сонирхлыг өдөөж өгсөн. Эдгээр арга хэмжээг тухайн зах зээлийн онцлогт тохируулан хийх буюу ломбардын гүйлгээнд цагдаагийн байгууллагаас хяналт тавих, хууль бусаар худалдаа эрхлэгчдийг таслан зогсоох, сонин хэвлэлд гарсан жижиг зар сурталчилгаанд хяналт тавьж, давтан худалдагчдыг илрүүлэх шаардлагатай. Судалгаанаас үзэхэд цагдаагийн "sting" ажиллагаа (энэ ажиллагааны хүрээнд цагдаагийн алба хаагч өөр дүрд орж гэмт хэрэгтнийг баривчлахыг зорьдог) объектын эргэн тойронд хулгайн гэмт хэргийг эрчимжүүлж болзошгүй учраас цагдаагийн ийм төрлийн ажиллагаанаас зайлсхийх хэрэгтэй.

Өгөөжийг хязгаарлах. Хурд сааруулагчийг суурилуулах нь хурд хэтрүүлэхээс урьдчилан сэргийлэх өгөөжийг бууруулах арга юм. Аюулгүй байдлын кодтой автомашины радио болон бэхэн тэмдэглэгээ нь мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлдэг. Хулгайч PIN кодыг мэдэхгүй тохиолдолд аюулгүй байдлын кодтой радио ашиглах боломжгүй бөгөөд АНУ болон Австралид хийсэн судалгаагаар эдгээр радиотой машинууд хулгайд өртөх нь бага байдаг байна. Хувцасны дэлгүүрт хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор бэхэн шошиг ашигладаг. Энэ бэхэн шошго нь өөрөөсөө будаг ялгаруулж, хувцсыг дахин ашиглах боломжгүй болгодог. Хулгайчид хувцсыг өмсөх, зарах боломжгүй байдал үүсгэх нь хулгай хийх сэдлийг бууруулдаг.

### **Нэмэлт материал:**

Sutton, Mike, Jacqueline Schneider, and Sarah Hetherington. 2001. Tackling Stolen Goods with the Market Reduction Approach. No. 8 in Crime Reduction Research Series. London: Home Office.

## Гэмт хэргээс хүртэх өгөөжийг бууруулах

### Гэмт хэргийн бай, өртөгчийг нууцлах арга хэмжээнүүд

- Хулгайн машинаар зугаацагчийн анхааралд өртөх машинуудыг гудамжинд орхихгүй байх
- Утасны лавлахад хүйсийг заахгүй байх
- Хуягт машинд тэмдэглэгээ хийхгүй байх

### Өртөгч, Байг шилжүүлэх

- Машины радио салдаг байх
- Эмэгтэйчүүдийн түр байрлах төв
- Төлбөрт утасны урьдчилсан төлбөрт карт

### Өмч хөрөнгийг тодорхойлох

- Өмчийн тэмдэг, тэмдэглэгээ
- Машины дугааржуулалт, сэлбэгийн тэмдэг, дугаарлалт
- Малд тамга тавих

### Хулгайн эд зүйлсийн зах зээлд нөлөөлөх

- Ломбардад хяналт тавих
- Ангилсан зар сурталчилгаанд хяналт тавих
- Гудамжны худалдаачдад зөвшөөрөл олгох

### Боломжийг хязгаарлах

- Хувцсанд бэхэн тэмдэглэгээ хийх
- Ханан дээр зурсан зургийг цэвэрлэх
- Хулгайд өртсөн гар утсыг ашиглах боломжгүй болгох

## Ханан дээр зурсан зургийн ач холбогдлыг хязгаарлах

1970, 1980-аад оны үед ханан дээр битүү зурагтай метронууд нь Нью-Йорк хотын бэлэг тэмдэг болох шахсан бөгөөд Тэд тэнд тавигдсан киноны эхний цувралуудад байнга гардаг байв. Метроны удирдлагууд метроны вагонууд дээрх зургийг арилгахын тулд олон арга хэмжээ хэрэгжүүлсэн боловч үр дүнд хүрээгүй. Эцэст нь тэд ажилтанд хүрэх энгийн санааг олж чадсан. Юу гэвэл вагон дээрх зургийг цэвэрлэж, буцааж үйлчилгээнд оруулна, вагон дээр зураг зурагдсан бол түүнийг үйлчилгээнээс түр гаргаж, зургийг хурдан арилгана. Энэ нь зураач нар зураг зурахын ач холбогдлыг бууруулж, тэдний хөдөлмөрийг үр дүнгүй болгосон. Иймэрхүү байдлаар метроны вагонууд дээрх бүх зургийг арилгахад зургаан жил шаардагдсан. Өнөө үед дэлхийн бусад хотуудын адилаар метроны зургийг бүрэн арилгаж чадсан.

### Машины цэвэр, зураггүй байдал

Жил	1984	1985	1986	1987	1988	1989
Зорилго	—	1720	3434	4707	5946	6221
Бодит	400	1915	3454	4839	6077	6245

Эх сурвалж: Sloan-Howitt, Maryalice, and George Kelling. 1997. "Subway Graffiti in New York City: 'Gettin up' vs. 'Meanin it and Cleanin it.'" In Situational Crime Prevention: Successful Case Studies, 2nd edition, edited by Ronald V. Clarke. Guilderland (New York): Harrow and Heston.

## 42. ГЭМТ ХЭРЭГ ӨДӨӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ БУУРУУЛАХ

**X**орих газрууд, баар зэрэг газруудыг судлах үед бөөгнөрөл, тав тухгүй байдал, бүдүүлэг харилцаа зэрэг нь хорих газар, бааранд хүчирхийллийг өдөөдөг болохыг судлаач Ричард Вортли анзаарчээ. Энэ нь түүнийг нөхцөл, шалтгааны арилгах замаар урьдчилан сэргийлэх арга барил гэмт хэрэг үйлдэх боломжид хэт их анхаарал хандуулж, гэмт хэргийг өдөөж буй нөхцөл байдлын онцлогийг үл тоомсорлосон гэж шүүмжлэхэд хүргэсэн. Түүний ажлын үр дүнд Кларк, Корниш нар нөхцөл, шалтгааны арилгах замаар урьдчилан сэргийлэх арга барилын шинэ ангилалд "өдөөгч хүчин зүйл"-ийг багасгах таван аргыг оруулсан. Эдгээр аргуудыг Вортлигийн жишээн дээр үндэслэн доор тайлбарлав.

**Стресс, бухимдлыг бууруулах.** Үйлчлэгчид хүмүүстэй бүдүүлэг харьцах, эгнээ дараалал дайрах, галт тэрэг ямар ч тайлбаргүйгээр саатахад хүмүүст стресс, бухимдал үүсдэг. Заримдаа тэд иймэрхүү шалтгаанаас болоод маш их уурладаг. Үйлчилгээг сайжруулж үүнээс сэргийлэх боломжтой. Гэсэн хэдий ч таагүй харилцаанд өртсөн хүмүүс эрх мэдэл багатай үед тэдний санал, шүүмжлэлийг орхигдуулах нь элбэг. Жишээлбэл, хоригдлууд өлссөн үедээ хоол идэж чадахгүй, телевизийн хөтөлбөрөө сонгож чадахгүй байна гэсэн гомдол гаргахад тэдний гомдлыг үл тоомсорлож, хоолны цагт анхаарах, олон телевизор байрлуулах тэдний шаардлагыг шийдвэрлэх боломжтой. Хоригдлуудын бухимдлыг төрүүлдэг өөр нэг шалтгаан бол утас, харилцуур ашиглах ээлжийг хүлээх нь компьютержсон системийн тусламжтайгаар бууруулж болно (хажуугийн самбарыг үзнэ үү). Хэт их чимээ шуугиан, бие бие шахах, түлхэх, нудрах, суух газар олдохгүй байх зэрэг шалтгаанууд нь хүмүүсийн уурыг хөдөлгөдөг. Эдгээр нөхцөл байдал нь клуб, баар, өртөө, буудал, онгоцны буудал зэрэг газруудад мөн нислэг саатах, хойшлох үед тохиолдож болно. Суудлын тоог нэмэгдүүлэх, тайвшруулах хөгжим дуугаргах, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх зэрэг нь эдгээр газруудад уур бухимдал, стрессийг багасгахад тодорхой хэмжээгээр тустай.

**Маргаанаас зайлсхийх.** Нэгдсэн Вант Улсад өрсөлдөгч фенүүдийн хооронд зөрчил үүсгэхгүйн тулд цэнгэлдэх хүрээлэнд тэдний байрлалыг тусгаарлах, тэдний ирэх, тарах цагийг нарийн зохион байгуулах арга хэмжээ авдаг. Залилан мэхлэх, тасалбарын талаарх маргаанаас урьдчилан сэргийлэхийн тулд Нью-Йорк хотын Жон Кеннеди нисэх онгоцны буудлаас Манхэттэн хүртэлх таксины үнийг 45 доллараар тогтоосон. Австралийн мотоциклиүүд Гран Приуралдаандолон нийтийн цугларлыг удирдах зорилгоор мотоциклчдод зориулж тусгай талбай, кемпийг ажиллуулах, ашиглахыг зөвшөөрч дэмжлэг үзүүлдэг. Энэ нь өмнөх жилүүдэд гарч байсан цагдаа, мотоциклчдийн хоорондох зөрчлийг арилгахад тус дөхөм болсон.

**Хоргоох байдал, уруу таталтыг бууруулах.** Ресейпшн болон сувилагчгүй үед эрэгтэй эмч нар эмэгтэй өвчтөнүүдэд биет үзлэг хийхгүй байх нь зүйтэй. Энэ нь эмчийг хуурамч гутгэлгээс хамгаалах, өвчтөнтэй бэлгийн зүй бус хандлага гаргах, таагүй байдал үүсэх магадлалыг бууруулдаг. Насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн үйлдэлд уруу татахыг хориглох тухай хуулиар хүүхэдтэй ойртохоос сэргийлэх, хүүхдийг хамгаалахаас гадна насанд хүрэгчдийг бэлгийн дүр хүслээ удирдахад тусалдаг. Буу ил байх нь түрэмгийллийн сэдлийг төрүүлдэг болох нь тогтоогдсон тул галт зэвсгийг ил байлгах явдлыг зохицуулах гол шалтгаан болсон. Үүнээс гадна хүчирхийллийн бичлэгийг хадгалах болон үзэх нь бэлгийн хүчирхийллийг өдөөдөг баримтаас үндэслэн эдгээр төрлийн материалд хяналт тавих үндэслэл бүрддэг. Эцэст нь хэлэхэд уруу таталтыг бууруулснаар олон нийтийн газар биедээ бэлэн мөнгө авч явах, мөн шөнө оройн цагаар эмэгтэй хүмүүс ганцаараа явахдаа болгоомжтой байх зөвлөгөө өгэх үндэслэл болно.

**Мэргэжил нэгт нөхөд, үе тэнгийнхний дарамт шахалтыг бууруулах.** Олон эцэг эхчүүд тэдний хүүхдэд муу нөлөөтэй найзуудыг нь хүүхдээсээ салгах арга хэмжээ авдаг, зарим сургуулиуд асуудал их гардаг ангийн хүүхдүүдийг өөр өөр ангиудад хуваах арга

хэмжээ авдаг. Насанд хүрэгчид төдийгүй хүүхдүүд ч бас үе тэнгийнхний дарамтад өртдөг. Хуучин ажилчид шинэ ажилчдыг уруу татаж, ажил олгогчдоос хулгай хийхийг ятгадаг, залуу эрчүүдийг архи уухыг ятгах нь элбэг тохиолддог. Австралид "сайн найз бол найздаа архи уух, согтуу жолоо барихыг заадаггүй" гэсэн уриатай, согтуугаар жолоо барихын эсрэг олон нийтийн кампанит ажил явагдсан. АНУ-д үүнтэй төстэй "Сайн найз бол найзыг согтуу жолоо бариулдаггүй" уриатай кампанит ажил явагдсан.

**Даган дуурайх явдлыг бууруутгах:** Бүх шинэ телевизүүд нь насанд хүрээгүй хүүхэд хүчирхийллийн агуулгатай зүйл үзэхээс сэргийлэх зорилготой "V-Chip"-тай байдаг болсон. Нийгэмд хүчирхийлэлтэй кино болон бодит амьдралд хүчирхийллийн хооронд тодорхой уялдаа холбоо ихээхэн маргаантай учраас гэмт хэргийн талаарх мэдээлэл нь гэмт хэргийг дуурайхад түлхэц болдог учраас эдгээр нь хуулбар гэмт хэргийн үндэс болдог. Жишээ нь багш нараа хууль бусаар компьютерын үйл ажиллагаа явуулж байгааг харсан сурагчид өөрсдөө компьютерын гэмт хэрэг үйлддэг, бусад жолооч улаан гэрлээр гарч байгааг харсан хэн нэгэн энэ хууль бус үйлдлийг дуурайх хандлагатай. Бодит байдалд та өөрийн ар талд машин байгаа эсэхийг шалгахын тулд арын толиндоо халт харах үед улаан гэрлээр хэр олон удаа гарч байсан бэ? Цэцэрлэгт хүрээлэнгийн аялал зугаалгад зориулсан ширээ зурагдсан байх, дээр нь юм сийлсэн байх нь түүн дээр нэмж зурах явдлыг хоёр дахин нэмэгдүүлдэг болох нь судалгаанаас харагдсан. Энэ мэт дүгнэлтүүд нь эвдлэн сүйтгэх, хорлон сүйтгэх гэмт хэрэгтэй тэмцэх шуурхай арга хэмжээний гол үндэслэл болдог. Вильсон, Келлинг нар энэ зарчмыг өргөжүүлэн, "хагархай цонх" өгүүлэлдээ тэмдэглэснээр гэмт хэргийн анхны шинж тэмдгийг тоохгүй өнгөрөх нь нөхцөл байдлыг улам дордуулж, гэмт хэрэг гараахад хүргэдэг гэж шүүмжилжээ.

#### Нэмэлт материал:

Wortley, Richard. 2001. "A Classification of Techniques for Controlling Situational Precipitators of Crime." *Security Journal* 14(4): 63–82. [Http://www.palgrave-journals.com/sj/journal/v14/n4/pdf/8340098a.pdf](http://www.palgrave-journals.com/sj/journal/v14/n4/pdf/8340098a.pdf).

#### Гэмт хэргийн өдөөн хатгалгыг бууруулах арга хэмжээнүүд

##### Стресс, бухимдлыг бууруулах арга хэмжээнүүд:

- Ээлдэг боловсон үйлчилгээ, эгнээ дарааллын системийг хэрэгжүүлэх
- Суудлын багтаамжийг нэмэгдүүлэх,
- Тайвшруулах ая эгшиглэх, гэрэлтүүлгийг сайжруулах

##### Маргаанаас зайлсхийх

- Хөл бөмбөгийн хоёр багийн хөгжөөн дэмжигчдийг тусгаарлах
- Бааранд бөөгнөрлийг бууруулах
- Таксины үнийн тарифыг тогтоох

##### Хоргоох байдал, уруу таталтыг бууруулах:

- Хүчирхийлэлтэй кино контентод хяналт тавих
- Хүүхэдтэй ажиллах үед хүүхдийг өдөх, хоргоо, оролдохыг хориглох,
- Бэлгийн хохирогч болохоос сэргийлэх тухай зөвлөгөө өгөх

##### Мэргэжил нэгтэн, үе тэнгийнхний дарамт шахалтыг арилгах:

- Тэнэг хүмүүс согтуу үедээ жолоо барьдаг.
- Үгүй гэж хэлж сурцгаая.
- Асуудал зөрчил ихтэй ангийн хүүхдүүдийг өөр өөр ангиудад тараах

##### Даган дуурайх явдлыг бууруутгах:

- Эвдлэн сүйтгэх, хорлон сүйтгэх явдлыг шуурхай шийдвэрлэх
- Телевизэд V чип ашиглах
- Хуулбар гэмт хэргээс сэргийлэх зорилгоор мэдээллийн хөтөлбөрт цензур тогтоох

## Райкерс арал дахь Викториа Секрет болон утасны луйвар, боломжит хугацаа

Нью-Йорк хотын Ла Гуардиа нисэх онгоцны буудлаас холгүй орших Рикерс арал нь 10 том шорон бүхий объект юм. Энд янз бүрийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлууд хоригддог, тэд утас ашиглах эрх нь харилцан адилгүй. Хорих ангийн ажилтнууд тэдний утасны ашиглалтыг бүртгэх, хоригдлуудын утсаар ярьсан цагийг зохицуулахын тулд бүртгэлийн дэвтэр ашигладаг. 1990-ээд оны эхээр энэ бүртгэлийг хэрэгжүүлэхээ болсон. Хоригдлууд "боломжит цаг" гэгддэг өөрсдийн системийг боловсруулж, дуудлагын жилийн зардал нь 3 сая доллароос дээш хэмжээнд хүрч өссөн. Илүү хүчтэй, эрх мэдэлтэй хоригдлууд гадаад ертөнцөд хар тамхины бизнесээ үргэлжлүүлэх, шоронгийн утасны хэрэглээг хянадаг болсон. Мөн үүний зэрэгцээ холын дуудлага хийх, худалдан авалт хийх зорилгоор хулгайн кредит карт ашиглаж, утасныекс (утсаар бэлгийн харьцааны агуулгатай зүйл ярьж зугаацах)-ийн үйлчилгээ үзүүлдэг байлаа. Ратгерсийн их сургуулийн төгсөх курсийн оюутан байхдаа энэ асуудлыг судалж байсан Нэнси Ла Вигне хэлэхдээ, "Эмэгтэй хоригдлууд Victoria's Secret-ийн каталог руу нэвтэрч, албаныхан үүнийг илрүүлэх хүртэл тус шорон тус улсдаа хамгийн дэгжин хувцасласан хоригдлуудыг магтан сайшаадаг тийм шорон болж хувирсан.

Албаны хүмүүс хоригдлын хоригдох дэглэмтэй уялдуулан утасны хэрэглээнд хязгаарлалт тавих компььютержсон системийг нэвтрүүлсэн. Хоригдлууд ID карт дээрх баар кодоор болон PIN кодыг оруулснаар утас ашиглах эрхээ олж авдаг. Энэхүү систем нь утасны зардлыг хагас дахин бууруулсны зэрэгцээ утасны хэрэглээтэй холбоотой маргаан, зодоон багассан. Бодит байдалд Ла Вигнэгийн судалгаанаас харахад ийм төрлийн маргаан, зодооны сарын хувь хэмжээг авч үзвэл шинэ утасны системийг нэвтрүүлэхээс өмнөх жилд 1000 хоригдол тутамд 6.7 байсан бол түүнийг нэвтрүүлсний дараа 1000 хоригдол тутамд 3.6 болтлоо буурчээ.

Эх сурвалж: La Vigne, Nancy. 1994. "Rational Choice and Inmate Disputes over Phone Use on Rikers Island." In vol. 3 of Crime Prevention Studies, edited by Ronald V. Clarke. Monsey (New York): Criminal Justice Press. [http://www.popcenter.org/library/crimeprevention/volume\\_03/04\\_nancy.pdf](http://www.popcenter.org/library/crimeprevention/volume_03/04_nancy.pdf).

## 43. Гэмт хэрэг үйлдэх шалтгийг бууруулах

**Н**өхцөл, шалтгааны арилгах замаар урьдчилан сэргийлэх арга барилын тав дахь ангилал нь гэмт хэрэг үйлдэгчид үйлдэлд ёс суртахууны дүгнэлт гаргадаг, улмаар гэм буруу эсвэл ичгүүртэй байх мэдрэмжээ дараахын тулд зан үйлээ зөвтгөх хүчин чармайлт гаргадаг гэж үздэг. Гэмт хэрэгтнүүд хэлэхдээ "Тэр хүртэх ёстой шангаа хүртсэн", "Би үүнийг зүгээр л зээлсэн", "Би түүнийг зүгээр л алгадсан" гэх мэт өөрийгөө зөвтгөх шалтаг хэлдэг. Эдгээр шалтаг нь татвараас зайлсхийх, согтуу үедээ машин жолоодох, шинэ ажилтанд бэлгийн дарамт үзүүлэх, ажил олгогчдын эд зүйлсийг хулгайллах зэрэг өдөр тутмын үйлдлүүдээ зөвтгөх хариу үйлдэл үзүүлдэг.

**Дүрэм журмыг тогтоох.** Бүх байгууллагууд засаглалын салбартаа ёс зүйн дүрэм баталдаг. Жишээлбэл, аж ахуйн нэгжүүд ажилчдынхаа цагийн бүртгэлийг зохицуулдаг бөгөөд дэлгүүрүүд борлуулалтын туслахуудаас бэлэн мөнгөтэй харьцах хатуу журмыг дагаж мөрдөхийг шаарддаг. Эмнэлэг, нийтийн номын сан, зочид буудал зэрэг байгууллагууд үйлчилж буй үйлчлүүлэгчийнхээ зан үйлийг зохицуулах ёстой. Үйлчлүүлэгчид ашигтай тохиолдолд эдгээр журмын хоёрдмол утга санааг ашиглана. Иймээс нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх нэг чухал үе шат бол дүрэм журам тогтоох явдал юм. Үйл хөдлөл, үйлдлийн хоёрдмол утга санааг арилгахын тулд шинэ дүрэм, журмыг нэвтрүүлэх (мөн аль хэдийн мөрдөгдөж буй журмыг тодруулах) явдал юм. Тухайлбал олон зоогийн газрууд биелээгүй захиалгыг бууруулахын (захиалга өгчхөөд ирэхгүй байх) тулд үйлчлүүлэгч холбогдох утасны дугаараа үлдээсэн тохиолдолд захиалгыг баталгаажуулдаг. Зарим нь зээлийн картын дугаар шаарддаг бөгөөд үйлчлүүлэгч захиалгаа биелээгүй тохиолдолд төлбөр авах боломжтой. Калифорни дахь загасчдаас загас агнуурын лицензээ зүүхийг шаардах нь тэднийг лиценз худалдан авах дүрмийг дагаж мөрдөхөд үр дүнгээ өгсөн.

**Зааварчилгаа гаргах.** Ажлын дүрмийг ихэвчлэн хөдөлмөрийн гэрээнд тусгадаг бөгөөд зээлийн картын компаниуд, утасны үйлчилгээ үзүүлэгч, даатгалын компаниудын тогтоосон дүрмийг үйлчилгээний гэрээнд тусгадаг. Хүмүүс дүрэм журмыг үл тоомсорлоо осс урьдчилан сэргийлэх, ямар дүрэм журам мөрддөг болохыг танилцуулахын тулд олон нийтийн газар, байгууллагатай холбоотой дүрэм журмыг олон нийтэд танилцуулж болно. Ялангуяа машин жолоодох, зогсоолыг удирдан зохицуулах тэмдгийг өргөн ашигладаг. Судалгаанаас харахад анхааруулах тэмдэг нь хөгжлийн бэрхшээлтэй жолоочид зориулсан зогсоолыг хууль бусаар ашиглах зөрчлийг эрс багасгадаг. Цэцэрлэгт хүрээлэн, коллеж, дамжин өнгөрөх эгнээ, орон сууцны төслүүд зэрэг бусад олон байгууламжууд нь олон төрлийн үйлдлийг удирдан зохицуулах тэмдгүүдтэй байдаг. Эдгээрийг өргөнөөр ашиглаж байгаа хэдий ч байрлуулсан зааварчилгааны үр дүнг үнэлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд үр дүнтэй эсэхийг үнэлэн дүгнэсэн судалгаанууд харьцангуй цөөн байдаг боловч эдгээр нь хууль сахиулах чухал хэрэгсэл бөгөөд асуудлыг шийдвэрлэхэд түлхүү ашиглагддаг.

**Сэромжлүүлэх үйлдэл.** Энэхүү нөхцөл байдлын арга нь албан бус нийгмийн хяналтаас хоёр чухал зүйлээр ялгаатай. Нэгдүгээрт, салангид, хязгаарлагдмал орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн тодорхой хэлбэрүүдэд анхаарлаа хандуулдаг; хоёрдугаарт, хууль зөрчихтэй холбоотой нийтлэг хандлагад өөрчлөлт оруулах гэж оролдоо ос илүүтэйгээр тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдэх үед ухамсар, үйлдлийг сэромжлүүлэх зорилготой юм. Жишээлбэл, дэлгүүрийн үүдэнд байрлах самбурууд нь "Дэлгүүрээс эд зүйлс зөвшөөрөлгүй авах нь хулгай" мөн Манхэттэн Хотын Боомтын Удирдлагын Автобусны Терминал дээр "Энд тамхи татах нь хууль бус, хувия хичээсэн, бүдүүлэг үйлдэл юм" гэж бичсэн байдаг. Замын хажуугийн хурдны самбар нь хурдны дээд хязгаараас хэтэрсэн жолооч нарт нэн даруй (торгууль оногдуулахгүйгээр) сануулга өгдөг.

### **Зохицуулалтыг дагаж мөрдөхөд туслах.**

19-р зуунд Италийн криминологич Чезаре Ломбросо хүмүүсийг гудамжинд бие засах зөрчил гаргасан этгээдийг түр саатуулах нь зүйтэй гэж санал болгосон бол харин түүний шавь Энрико Ферри нийтийн бие засах газар барих асуудлыг шийдэх илүү практик арга замыг санал болгосон. Энэ бол хууль, зохицуулалтыг дагаж мөрдөхийг хөнгөвчлөх өргөн хэрэглээний арга техникийн жишээ юм. Үүнд согтууруулах ундаа хэрэглэсэн хүмүүст таксины хөнгөлөлт үзүүлэх; хогийн сав өгөх, зураг зурахад зориулж самбар өгөх, хоцролтыг бууруулах, ном зээлэх дүрэм журмын зөрчлийг арилгах зорилгоор номын сангудад төлбөр тооцооны журмыг боловсронгуй болгох зэрэг олон зохицуулалтууд багтана. Уолт Диснейн ертөнцийн талаарх сонгодог нийтлэлд Shearing and Stenning нь хатуу хучилттай замын тэмдэг, тэмдэглэгээ, анхааруулах тэмдэг, биет саадыг (буруу тийшээ эргэхээс сэргийлэх зорилгоор) ашиглах, Диснейн баяр хөөртэй ажилчдаас зааварчилгаа өгөх зэрэг цугларсан олон нийтийг удирдах, хянах, арга хэмжээний талаар танилцуулсан. Энэхүү арга хэмжээний үр дүнд паркийн сэдэвчилсэн булангуудад гэмт хэрэг, хэрэг зөрчил гарах явдлыг бууруулж чадсан.

### **Мансууруулах бодис, согтууруулах ундааны хэрэглээг хянах.**

Согтууруулах ундаа, мансууруулах бодис нь гэмт хэрэг үйлдэхэд чухал нөлөө үзүүлдэг. Тухайлбал архи, согтууруулах ундаа нь бие хянах, хөдөлгөөний тэнцвэрээ хадгалах, эрүүл шийдвэр гаргах, танин мэдэх чадварт нөлөөлж эдгээрээс шалтгаалаад хууль дүрмийг үл

тоох, зөрчил гаргах шалтгаан болдог. Архи согтууруулах ундааны нөлөөллийн талаар олон судалгаанууд хийгдсэн. Норвегийн Цагдаагийн коллежийн эрдэм шинжилгээний захирал Йоханнес Кнутссон Midsummer Eve дахь Шведийн амралтын хотхонд хүмүүсийн авчирдаг согтууруулах ундааны хэмжээг хязгаарласан нь согтуурах, эмх замбараагүй байдлыг бууруулахад үр дүнтэй болохыг харуулжээ.

Аляскийн Барроу хотод 1994 онд архи согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэхийг хязгаарлах зорилгоор согтууруулах ундаа худалдахыг бүрэн хориглосон бөгөөд үүний үр дүнд согтууруулах ундаатай холбоотой дуудлага 81 хувиар, гэмт хэрэг 43 хувиар буурч, гэмт хэргийн тоо 43 хувиар буурчээ. Олон нийтийн газраас архидан согтуурсан хүмүүсийг гаргах хувь хэмжээ 90 хувиар буурсан (Goldstein шагналыг [www.popcenter.org/library/awards/goldstein/1995/95-56\(W\).pdf](http://www.popcenter.org/library/awards/goldstein/1995/95-56(W).pdf) хуудаснаас үзнэ үү). Архидалтыг сурталчлах талаар орон нутгийн архи, согтууруулах ундааны газруудтай сайн дурын гэрээ хэлэлцээрийн үр дүнд Австралийн шöнийн цэнгээний газруудад архинаас үүдэлтэй гэмт хэргийн гаралтыг бууруулж чадсан. Ратгерсийн их сургуулиас шар айргийг дотуур байрны үдэшлэгт сагснаас биш торхонд хийж өгөх шийдвэр гаргажээ, учир нь хайрцаг, сагснаас өгөх нуухад илүү хялбар байдаг бөгөөд нэгэн оюутан: "Хөргөгчөөс шууд өгөхтэй харьцуулахад хэрэв та нэг торхтой, түүний дэргэд 20 хүний дараалалд зогсож байгаа бол хүмүүс архи бага авах болно" гэжээ."

## Хэргийн үйлдлийг зөвтгөх шалтгааныг арилгах

### **Дүрэм журам тогтоох**

- Түрээсийн гэрээ байгуулах
- Анхаарах хандуулах зүйлсийн дүрэм
- Зочид буудлын бүртгэл

### **Зааварчилгаа өгөх**

- "Машин тавихыг хориглоно" тэмдэг байрлуулах
- "Хувийн өмч" тэмдэг байрлуулах
- "Кемпийн галыг унтраах" тэмдэг байрлуулах

### **Сэргэжилүүлэх**

- Замын хажууд хурдны хязгаарын самбар байрлуулах
- Гаалийн бүрдүүлэлтэд гарын үсэг зурах

- "Дэлгүүрээс эд зүйлс авах нь хулгай мөн" гэсэн самбар байрлуулах.

### **Дүрэм журмыг дагаж мөрдөхөд дэмжлэг үзүүлэх**

- Номын сангийн хяналт шалгалт хийх
- Нийтийн бие засах газар ажиллуулах
- Хогийн сав байрлуулах

### **Хар тамхи болон согтууруулах ундаанд хяналт тавих**

- Бааранд цусан дахь спиртийн түвшнийг шалгах сорил хийх
- Серверийн арга хэмжээ
- Спирт хэрэглэхгүй арга хэмжээ зохион байгуулах

## Диснейн ертөнцөд хүрэлцэн ирэх нь

- Машинаар ирж буй зочдод Диснейн радиогоор мэдээлэл авахыг анхааруулдаг.
- Анхааруулах Тэмдгүүд нь машинаа тавих зогсоол руу чиглүүлнэ, замын тэмдэглэгээнүүд хаашаа ямар замаар явахыг зааж өгдөг.
- Зогсоолын эелдэг үйлчлэгчид зочдыг талбай руу чиглүүлж, чанга яригчаар машинаа түгжихийг сануулдаг.
- Жуулчдыг нэг замтай төмөр зам руу очиход зориулж резинэн дугуйт галт тэрэг рүү чиглүүлнэ.
- Бүртгэгдсэн зарлал нь тэднийг хамгаалалтын хашлаганы ард аюулгүй зогсох талаар мэдээлэл өгнө.
- Тэдэнд зогсоолын байршлын талаар сануулдаг (жишээлбэл, Дональд Нугас 1).
- Тэдэнд суух, гар, хөлөө кабины дотор байлгах, хүүхдүүдийг ийм байдлаар биеэ авч явах талаар эелдгээр сануулна.
- Тоглоомоос буухын өмнө нэг замтай галт тэргэнд хэрхэн суух, буруу зам руу явахаас болгоомжлох талаар сануулна.

- Тавцан дээр үйлчлэгч нар тэднийг нэг замт вагоны нэг тасалгааг зохих багтаамжаар дүүргэхийн тулд үүдний хэсэг рүү чиглүүлнэ.
- Нэг замт вагон ирэх үед л тавцангийн ирмэг дээрх аюулгүй хаалга нээгддэг.
- Хугацаа хоцорсон үйлчилгээг зарлаж, хүрэлцэн ирэх боломжит хугацааг зарлана.
- Тоглоомонд суусан үед зорчигчдыг "өөрийн аюулгүй байдлын үүднээс" суудалдаа суухыг шаарддаг.
- Зорчигчид хэрхэн буух, анхны тоглоом руу хэрхэн шилжихийг хэлж өгнө.
- Хүүхдүүдээ харж, хандаж байх, байраа эзлэхийг сануулна.
- Үзэсгэлэн, тоглоом руу орохоор хүлээх үед зочид эгнээндээ байх, Disney-ийн дүрүүд бүхий тоглоомыг хүлээх хугацааны талаар сануулна.
- Үзэсгэлэн, тоглоомоос гарч явахад тэд тэмдэг, хаалт, үйлчлэгч зэрэг нь дараагийн тоглоом, үзэсгэлэн рүү хэрхэн очихыг зааж өгнө.

Эх сурвалж: Shearing, Clifford, and Phillip Stenning. 1997. "From the Panopticon to Disney World: The Development of Discipline." In *Situational Crime Prevention: Successful Case Studies*, 2nd edition, edited by Ronald V. Clarke. Guilderland (New York): Harrow and Heston.

## 44. Асуудал, зөрчлийн гол эзэн холбогдогчийг олох

**З**арим байгууллага, аж ахуйн нэгж, төрийн байгууллага, бусад байгууллага үйл ажиллагаандaa гэмт хэрэгт нөлөөлөхөөс илүүтэйгээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхд учир дутагдалтай байгаагаас шалтгаалан олон асуудал үүсдэг. Товчхондоо, нэг буюу хэд хэдэн байгууллага урьдчилан сэргийлэх стратеги хэрэгжүүлэх боломжгүй, эсхүл эдгээр байгууллагууд гэмт хэрэг, эмх замбараагүй байдлыг өдөөж буй нөхцөл байдлыг зориудаар бий болгосон учраас олон бэрхшээл, асуудал тулгардаг. Энэ нь эрсдэлтэй, өртөмтгий байгууламж, объект (28 дугаар алхам) болон бусад гэмт хэргийн төвлөрлийг бий болгодог.

Асуудлыг шийдвэрлэхийн тулд ихэвчлэн асуудалд хүргэж буй нөхцөл байдалд хариуцлага хүлээгээгүй хүмүүс байгууллагуудын хооронд идэвхтэй хамтын ажиллагааг шаарддаг. Эдгээр асуудлын эзэн, холбогдогч нь асуудлын хариуцлагыг олон нийт, цагдаа нарт шилжүүлсэн. Тиймээс аливаа асуудлыг шийдвэрлэх үйл явцын чухал зорилго нь тэд асуудалд хариуцлагатай хандах явдал юм. Тиймээс аливаа асуудлыг шийдвэрлэх хамгийн чухал зорилт бол холбогдох хүмүүс нь хариуцлага хүлээх явдал юм.

1. Асуудал, бэрхшээлийн гол эзэн холбогдогч хэн бэ?
2. Асуудлын эзэн холбогдогч нь асуудлыг яагаад өөрчлөн хувирахыг зөвшөөрдөг бэ?
3. Эзэн холбогдогч этгээд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхд юу шаардлагатай бэ?

Энэ гурван асуудлыг тус бүрд нь доор тайлбарлав.

**Асуудал, бэрхшээлийн гол эзэн холбогдогч хэн бэ?** Асуудал нь тодорхой газар байрладаг бол хэн хариуцаж байгааг тодорхойлоход хялбар байдаг. Асуудлын эзэн нь тухайн байршлын эзэн юм. Жишээлбэл, цэцэрлэгт хүрээлэнгийн асуудал нь цэцэрлэгт

хүрээлэнгийн үйл ажиллагааг хариуцдаг байгууллага буюу ихэвчлэн орон нутгийн засаг захиргаа эсвэл зарим хувийн байгууллагад хамаардаг.

Томоохон газар нутгийг хамарсан асуудлын хариуцлагыг тодорхойлох нь илүү хэцүү байдаг. Хэрэв өргөн тархсан асуудал нь тодорхой байршилд төвлөрч байгаа бол тухайн байршил нь ойр орчмын бус нутагт болж буй үйл явдлын эх сурвалж болж, тухайн объектын эзэн хариуцлага хүлээх болно. Хороололд олон эзэнгүй объектыг эзэмшдэг үл хөдлөх хөрөнгийн наймаачны хувьд эдгээр объектод гарсан гэмт хэргийг хариуцна.

Хэрэв ахмад настан, тусгай хэрэгцээ шаардлага хэрэгцээтэй хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүс гэх мэт эмзэг бүлэг бөгөөд эдгээр хүмүүс гэмт хэрэг, хэрэг зөрчлийн бай болж байгаа тохиолдолд асуудлын боломжит холбогдогч (эзэн) нь гэр бүлийн гишүүд юм. Хэрэв эдгээр эмзэг бүлгийн хүмүүсийн сайн сайхан байдлыг хангах үүрэгтэй тусгай байгууллага ажилладаг бол эдгээр үйлчилгээний байгууллагууд асуудлын хамтран эзэмшигч, холбогдогч байж болно. Цагаач ажилчид хурдны замд нас барах тохиолдлыг бууруулахыг ажиллаж байхдаа Калифорнийн авто замын эргүүл нь цагаач ажилчдыг тээвэрлэх чиглэлээр мэргэшсэн байгууллагуудыг олж илрүүлжээ. Тэд энэ асуудлыг хариуцдаг боловч асуудалд хариуцлага хүлээгээгүй. Хариуцлагыг нарийн тодорхойлсноор холбогдох байгууллагуудын зохицуулалтыг сайжруулсан. Тухайлбал хэрэгслийн хяналт, үзлэг, цагаачдыг тээвэрлэхдээ суудлын бус, хамгаалах бус хэрэглэхийг шаардах, аюулгүй байдлын зөрчлийн үед хууль хэрэгжилтийг хангах зэрэг зохицуулалтыг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд цагаач фермийн ажилчид амь насаараа хохирох осол эрс буурсан байна. Энэхүү хүчин чармайлт нь 2002 онд Асуудлыг шийдвэрлэх шилдэг бүтээлд зориулсан Голдштейн шагналыг хүртсэн.

## Асуудлын эзэн холбогдогч нь асуудлыг ягаад өөрчлөн хувирахыг зөвшөөрдөг бэ?

Ихэнх зөрчил, асуудалд дангаараа эсвэл хамтдаа тохирох дөрвөн өрөнхий тайлбар байдаг. Үүнд:

1. Тухайн байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжгүй байж болно. Энэ нь өөрийн үйл ажиллагаа нь гэмт хэрэгт хэрхэн нөлөөлж байгааг мэдэхгүй, эсвэл гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдлэггүйгээс шалтгаалж байж болох юм. Эсвэл энэ нь тухайн байгууллага үйл ажиллагаа нь гэмт хэрэг үүсгэхэд туслах, дэмжих нөлөө үзүүлдэг гэдгийг мэддэг байсан ч нөөцийн хомсдолтой холбоотой байж болох юм. Иймээс тодорхой байгууллагын үйл ажиллагааны ач холбогдлыг хулээн зөвшөөрөх нь чухал юм. Үйл ажиллагааны журмыг өөрчлөх нь мөнгө, хүний нөөц, цаг хугацаа, зардал их шаарддаг. Дэлгүүрийн хулгай болон дотоод хулгайгаас (ажилчид өөрсдөө хулгай хийх) урьдчилан сэргийлэх бараа материалын бүртгэл, хяналтын шинэ журам нь хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байж болно. Учир нь ажилчид ердийн өдөр тутмын бизнесийг хийх арга барилд саад учруулах байдлаар өөрчлөлт шинэчлэлтийг шаарддаг тул хэрэгжүүлэхэд хэцүү байж болно.

2. Зарим байгууллага гэмт хэргийг шийдвэрлэх нь зөвхөн цагдаагийн үйл ажиллагаа, үүрэг гэж үздэг тул өөрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сонирхолгүй байж болно (жишээ нь авсан шатахууны төлбөрөө төлөхгүй зугтах хэрэг их гардах шатахуун түгээх станцууд өөрсдийн үйл ажиллагаанд урьдчилан төлбөрийн бодлого нэвтрүүлэхээс илүүтэйгээр энэ асуудлыг цагдаагийн асуудал гэж үзэх нь элбэг тохиолддог). Гэмт хэрэг үүсгэх нөхцөл боломжийн судлах, хүлээн зөвшөөрөхийн оронд зарим хүмүүс зөвхөн гэмт хэрэгтнүүдийн үүрэг ролийг анхаарч үздэг. Энэ үүднээс авч үзвэл, цагдаагийн байгууллага нь өөрийн үйл ажиллагааг чангатгах замаар гэмт хэргийн гаралтыг бууруулах үүрэгтэй. Энэ аргын дутагдалтай талыг 3-р алхамд танилцуулсан. Хүсэл эрмэлзэлгүй байх

өөр нэг эх сурвалж бол цагдаа нар өмчлөгчийн эрхэнд халдаж байна гэсэн дүгнэлт юм. Жижиглэн худалдаалагч нь өөрийн бараа бүтээгдэхүүнээ хүссэн байдлаар дэлгэн харуулах эрхтэй, цагдаа нар дэлгүүрийн хулгайн гэмт хэргийг бууруулахын тулд бараа бүтээгдэхүүнийг дэлгэн харуулах өөр арга замыг нэвтрүүлэх талаар шахах, албадах, санал болгох ёсгүй гэж жижиглэн худалдаачид гомдоллож болно.

3. Зарим байгууллагууд асуудлыг шийдвэрлэхэд гарах зардлаас шалтгаалаад асуудлыг шийдвэрлэх хүсэлгүй байдаг. Гэмт хэргийг үл тоомсорлосноор тэд алдах, хохирохooosoо илүүтэйгээр илүү ихийг олж авдаг. Урьдчилан сэргийлэх зардал өөрсдөд нь үзүүлэх ашиг тусаас давж байна гэж тэд ойлгож болно. Үзвэр үйлчилгээний газарт харуул хамгаалалтын ажилтан өндөр зардал шаардана, мэргэжлийн хамгаалалтын ажилтнууд хөлсөлнө гэвэл бүр илүү зардал гарна. Асуудлын зардлыг тухайн байгууллага хариуцдаггүй бол урьдчилан сэргийлэх зардлыг даах шаардлага бага байна. Нэг ёсондоо ийм байгууламжууд гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх зардлыг бусдад шилжүүлж, улмаар өөрсдийн зардлаа бууруулдаг.
4. Зарим байгууллагууд хууль бус үйлдэл, гэмт хэрэг, зөрчлөөс ашигладаг. Тухайлбал хуучин бараа бүтээгдэхүүний дэлгүүр нь гарал үүсэл, эзэмшигч нь тодорхойгүй зүйлсийг бусдын гар дээрээс худалдан авч, дамлан зарах замаар ашиг олдог. Автомашины засварын гараашнууд хулгайн машины эд ангиудыг хууль ёсны сэлбэгээс хямд үнээр худалдаж авах боломжтой учраас тэд ашгаа бодоод хууль бус үйлдлийг илүүд үзэх жишээтэй.

**Эзэн холбогдогч этгээд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд ю шаардлагатай бэ?** Херман Голдштейн асуудлын хариуцлагыг цагдаа биш харин асуудал, зөрчилтэй холбоотой объектыг эзэмшдэг байгууллагуудад шилжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ шатлалын бүдүүвч схемийг зурсан. (хажуугийн самбарыг үзнэ үү).

Голдштейн жагсаалтын доороос дээш шилжихэд нэлэөллийн арга хэмжээ нь оролцоо багатай, албадлагын шинж чанартай болж хувирдаг. Үүнээс шалтгаалж ахих тусам хөндлөнгийн оролцооны хүндрэл нэмэгдэж, мөн цагдаад хандаагүйтэй холбоотой зардал нэмэгддэг. Улмаар мэдээллийн ач холбогдол, нарийвчилсан дүн шинжилгээ нь доороосоо дээшээ чиглэлтэйгээр өсдөг. Голдштейн тэмдэглэснээр, энэ шатлал нь яг тодорхой тайлбар гэхээсээ илүү эдгээр чиг хандлагын тойм үзүүлэлт юм. Гэсэн хэдий ч, энэ нь асуудлыг шийдвэрлэх үе шаттай хариу арга хэмжээг төлөвлөхөд ач холбогдолтой. Мэдээллээр дэмжигдсэн тохиолдолд хамтран ажиллах болон дээшээ чиглэлтэйгээр ажиллах замаар эхэнэ.

Хариуцлагыг асуудлын эзэн (объектын эзэнд) шилжүүлэх нь хууль эрх зүйн болон бодлогын зөрчил үүсгэж болно. Асуудал зөрчилтэй холбоотойгоор түүнээс ашиг олдог эсвэл асуудалд хариуцлага хүлээхтэй холбоотойгоор зардал нэмэгдэнэ гэж үзэж байгаа байгууллагууд энэ талаар ямар нэг зүйл санаачлах, хийх саналыг хүлээн

зөвшөөрдөггүй. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Хуурамч дуудлагын хэрэг зөрчил маш их болсон боловч олон оронд өндөр хувь хэмжээтэй хуурамч дохиоллын зөрчлийг даван туулахад хүндрэлтэй байсаар байна. Мэдээж зардал багатай, хүчтэй нэлэөллийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь хамгийн бага өсөргүүцэлтэй нүүр тулах болно (алхам 45). Гэвч эдгээр хариу арга хэмжээ үр дүнгүй болбол цагдаа нар асуудал эзэмшигчдээс өндөр хариуцлага шаардаж, улс төрийн зөрчилдөөн үүсгэх, эсвэл цөөн хэдэн хүний үүсгэсэн асуудалд төсвийн мөнгийг үргэлжлүүлэн зарцуулах гэсэн хэцүү сонголттой тулгардаг. Хийсвэрлэн авч үзвэл хариулт нь тодорхой мэт санагдах боловч бодит байдал дээр энэ нь ихэвчлэн хэцүү шийдвэр байдаг.

#### **Нэмэлт материал:**

Scott, Michael. 2005. "Policing for Prevention: Shifting and Sharing the Responsibility to Address Public Safety Problems." In Handbook of Crime Prevention and Community Safety, edited by Nick Tilley. Cullompton (UK): Willan.

Эзэмшигч өөрчлөх аргуудын талаарх Херман Голдштейний шаталсан загвар	
<b>Хамгийн бага хамтын ажиллагаатай/ хамгийн их хүндрэлтэй</b>  <b>Хамгийн их хамтын ажиллагаатай, хамгийн бага хүндрэлтэй</b>	Иргэний хэрэг үүсгэх Урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг батлах Цагдаагийн үйлчилгээтэй холбоотой төлбөрийг авах Цагдаагийн үйлчилгээг цуцлах Олон нийтэд танилцуулах Өмчлөлийг авах шинэ байгууллагыг олох Одоо байгаа бусад байгууллагыг татан оролцуулах Зорилтот хүсэлт, шаардлагуудыг шийдвэрлэх Шууд албан бус хүсэлтүүд Боловсролын хөтөлбөрүүд

**Т**охиромжтой хариу арга хэмжээг олох нь хүндрэлтэй үйл явц байж болно. Зардал, хүндрэл, хамтын ажиллагааны дутагдал зэргээс шалтгаалж амласан нөлөөллийн үйл ажиллагаанд хориг тавих тохиолдолд та олон удаа сэтгэл санаа хямрах, урам хугарах байдалд орох болно. Гэхдээ асуудлыг шийдэх ганцхан биш олон арга бий. Тиймээс эцэст нь танай баг зарим гол шаардлагыг хангасан хариултыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Үүнд:

- Энэ нь хэтэрхий амбицтai, зардал ихтэй биш.
- Энэ нь алс холын, шууд бус шалтгаанаас илүү ойрын, шууд шалтгаануудад анхаарлаа төвлөрүүлдэг бөгөөд энэ нь түүнд богино хугацааны шууд нөлөөлөл үзүүлэх сайн боломжийг олгодог.
- Хариулт бүр нь асуудалд нөлөөлөх механизмыг өөр хооронд нь уялдуулсан.

Тэгээд эцэст нь таны санаа амарч, тайвширч болно, тийм биш гэж үү? Эсвэл үгүй юу! Сайн хариултад санал нийлэхээс илүү хэцүү зүйл гэвэл түүнийг бодитоор хэрэгжүүлэх эсэхийг шалгах явдал юм. Та үүнийг бие даан баталж чадахгүй, гэхдээ та асуудлыг хэрэгжүүлэхэд гардаг саад бэрхшээлийг мэдэж байгаа бол та эдгээрт өртэх, хамаарах хариу арга хэмжээг сонгохоос илүүтэйгээр түншлэлийг удирдаж болно. Тим Хоп, Дэн Мерфи нар Английн Манчестер хотын 11 сургуульд бусдын эд зүйлсийг эвдлэн сүйтгэх хэргээс урьдчилан сэргийлэх төслийг судалж байхдаа эдгээр бэрхшээлийг олж тогтоожээ.

Сургууль бүр дээр хэрэгжүүлэх хариу арга хэмжээг нутгийн захиргааны байгууллагууд, сургуулийн ажилтнууд, цагдаа нараас бүрдсэн групп сонгосон. Хохирлын ихэнх нь хорлон сүйтгэх гэхээсээ илүү хайхрамж, болгоомжгүй байдлаас шалтгаалж байлаа. Иймээс хоёр өөр шийдлийг санал болгосон: барилга байгууламжийг хамгаалах нөхцөл байдлын хариу арга хэмжээ эсвэл хүүхдүүдийн хорлон сүйтгэх, хор хөнөөл учруулах үйлдлийг хор хөнөөл багатай үйлдэлд шилжүүлэхийн тулд хүүхдэд чиглэсэн чөлөөт цагийн үйл ажиллагаа явуулах. 11 бүлгийн зөвхөн нэг нь чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх

талаар санал дэвшүүлсэн. Хэдийгээр орон нутгийн оршин суугчдыг зэргэлдээх хоёр сургуулийг ажиглахад урамшуулах, дэмжих төлөвлөгөө мөн тоглоомын талбайг өртөх магадлал багатай газар руу шилжүүлэх төлөвлөгөө зэрэг саналууд багтаж байгаа боловч Санал болгож буй нөхцөл байдлын хариу арга хэмжээ нь үндсэндээ гол бай, өртөгчийг хамгаалахад чиглэгдсэн (ценхны сараалж тавих, бэхжүүлсэн шил хэрэглэх, өндөр хашаа барих).

Зөвхөн хоёр сургуульд бүх зөвлөмжийг хэрэгжүүлсэн. Гурван сургуульд нэгийг ч хэрэгжүүлж чадаагүй, үлдсэн зургаан сургуульд нэг буюу хэд хэдэн зөвлөмж хэрэгжээгүй. Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлээгүй сургуулиудад нь бусдын эд хөрөнгийг эвдэн сүйтгэх зөрчлийг шийдвэрлэхэд бага нөлөө үзүүлсэн. Хоуп, Мерфи нар зөвлөмжийг хэрэгжүүлэхэд тулгарч буй таван үндсэн саад бэрхшээлийг тодорхойлсон бөгөөд эдгээр нь бүгд АНУ-ын асуудлыг шийдвэрлэх төслүүдэд тулгарч байсан:

1. **Урьдчилан тооцоолоогүй техник, арга зүйн хүндрэлүүд.** Найман сургуулийн хувьд ажлын хэсэг өртөмтгийн цонхыг поликарбонат шил эсвэл бэхжүүлсэн шилээр солихыг зөвлөжээ. Гэтэл бодит амьдралд нэг ч цонхыг солиогүй. Хотын архитектор мэргэжилтнүүд поликарбонат шилийг хэрэглэхийг хориглосон, учир нь гал түймэр гарсан тохиолдолд хүмүүс зугтахад саад болж, шатах үедээ хорт утая ялгаруулдаг байна. Чанартай бэхжүүлсэн шилийг үйлдвэрлэхийн тулд бэхжүүлэлт хийхийн цонхны хэмжээг авч зүсэлт хийх шаардлагатай. Гэтэл цонхнууд харилцан адилгүй олон янзын хэмжээтэй, мөн тухайн хэмжээнээс цөөн тооны шил бэлтгэхэд хүндрэлтэй. Үүнийг хийхэд удаан хугацаа (зургаан долоо хоног) шаардагдах тул захиалгаар шил нийлүүлэх өөр арга хувилбарыг үгүйсгэв.
2. **Арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байх.** Нэг сургууль дээр тоглоомын талбайг бага өртөмтгийн

газар шилжүүлэхээр шийдсэн. Анхны тоглоомын талбайг цэцгийн мандал болгон солих ёстай байсан ч хэрэгжүүлэх байгууллага нь төрийн байгууллага байсан, бодит байдалд ажлын тооцоог гаргахаас хэтрээгүй. Хүүхдийн тоглоомын талбайг нүүлгэн шилжүүлэх ажлыг хувийн барилгын компаниар гүйцэтгүүлсэн боловч үл ойлголцлын улмаас төлөвлөсөн талбайн ердөө тал хувийг л хамруулсан. Тиймээс хоёр жилийн дараа бусдын эд зүйлсийг эвдлэн сүйтгэх хэрэг өөрчлөгдөөгүй хэвээрээ байсан ба цэцгийн мандал ч үгүй болж, сургуульд үлдсэн жаахан зүйл нь хатуу хучилттай нарийн зам л байв.

3. **Байгууллагуудын хоорондох үйл ажиллагаанд уялдаа холбоо, удирдлага муу байх.** Сургуулийн барилгын засвар үйлчилгээний хэсгийн биелүүлэх гол үүрэгт хамаарах зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн, харин бусад хэлтэс, салбаруудтай холбоотой зөвлөмжүүдийн нэг нь ч хэрэгжээгүй. Тухайлбал, хоёр сургуулийн ойр орчимд амьдардаг иргэдийг хараа хяналт тавьж байх, сэжигтэй зүйл гарвал цагдаад мэдэгдэхийг зөвлөсөн. Энэ нь сургуулийн захиргаа, захирал, ажилчид, сурагчид, мөн цагдаагийн гурван хэсэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн харилцаа, орон нутгийн цагдаагийн үйл ажиллагаанд хамтран ажиллахыг шаарддаг. Холбогдох бүх хүмүүс үүнд тааламжтай байсан боловч хэн ч санаачилгыг гартаа аваагүй.
4. **Өрсөлдөх тэргүүлэх чиглэлүүд.** Хэрэгжилтийн явцад орон нутгийн төрийн албан хаагчдын ажилчдын маргаан, сургуулийн насны хүүхдүүдийн тоог бууруулсан сургуульд өөрчлөлт зохион байгуулалт хийх зэргийн арга хэмжээний улмаас сургуулийн системд олон асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарсан. Сургуулийн албан хаагчдын өөрчлөлт нь бусдын эд зүйлсийг эвдэн сүйтгэх төсөлд хамрагдсан албан тушаалтнуудад өөрчлөлт оруулсан. Ажилтнууд бусдын эд зүйлсийг эвдэн сүйтгэх төсөлд бага ач холбогдол өгсөн нь гайхах зүйл биш юм.
5. **Урьдчилан тооцоолоогүй зардал.** Зарим тохиолдолд тодорхой үйл ажиллагааны үр дагавар нь түүний ач холбогдол, шуудашиг тусаас давж гардаг. Тухайлбал, бусдын эд зүйлсийг эвдэн сүйтгэх зөрчил их гардаг сургуульд удахгүй болох амралтын үеэр эргүүл хамгаалалт ажиллуулахаар шийдвэрлэсэн. Сургуулийн засварын ажилчдыг чөлөөт цагаараа төлбөр төлж сургуулийн эргэн тойронд эргүүлд гаргасан. Энэ нь эвдэн сүйтгэх гэмт хэргийг бууруулахад ач холбогдоо өгсөн бөгөөд орой болон амралтын өдрүүдийг хамруулах зорилгоор хичээлийн завсарлагааны дараа үргэлжлүүлэн ажиллуулсан. Бусад сургуулиуд ижил хамгаалалтыг шаардаж, илүү олон засвар үйлчилгээний ажилчид илүү цагаар ажиллах боломжийг хүсэж байв. Гэтэл бодит байдалд өртөг зардал хэт өндөр болсон учраас энэ төслийг цуцалсан.

Та дээрх жагсаалтаас гарим арга хэмжээний хэрэгжилтийг урьдчилан тооцох боломжгүй бөгөөд сонгосон бүх арга хэмжээний тодорхой хэсэг нь хэзээ ч хэрэгждэггүй гэдгийг харж болно. Гэсэн хэдий ч тодорхой төрлийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүндрэл, асуудалтай тулгарах нь тодорхой бөгөөд тэдгээрийг хажуугийн мөрөнд нэгтгэн харуулав. Мэдээж хэрэг, гарим тохиолдолд хариу арга хэмжээ авах нь маш ирээдүйтэй, үр дүнтэй учраас арга хэмжээний хэрэгжилт амжилтгүй болох эрсдэлийг үл харгалzan үүнийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Гэхдээ урьдчилан анхаарах, сэрэмжлүүлэх нь илүү их боломжийг бий болгоно.

#### **Нэмэлт материал:**

Hope, Tim, and Daniel Murphy. 1983. "Problems of Implementing Crime Prevention: The Experience of a Demonstration Project." The Howard Journal of Criminal Justice 22: 38–50. [Http://onlinelibrary.wiley.com/doi/10.1111/j.1468-2311.1983.tb00469.x/pdf](http://onlinelibrary.wiley.com/doi/10.1111/j.1468-2311.1983.tb00469.x/pdf).

Laycock, Gloria, and Nick Tilley. 1995. "Implementing Crime Prevention." In Building a Safer Society, edited by Michael Tonry and David Farrington. Chicago: University of Chicago Press.

## Хариу арга хэмжээг хэрэгжүүлэх үед тулгарах асуудал бэрхшээлийг урьдчилан тооцох

- Хэд хэдэн тусдаа байгууллагуудын хооронд уялдаа холбоотой үйл ажиллагаа явуулах шаардлагатай.
- Хэрэгжүүлэхэд удаан хугацаа шаардагдана, мөн зохих дарааллын дагуу гүйцэтгэхэд илүү олон үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.
- Зорилго, зорилтын талаар бага ойлголт, мэдлэгтэй ажилтнууд хэрэгжүүлдэг.
- Түншлэлийн баг эсвэл ахлах удирдагч нарын дунд томоохон дэмжигч байхгүй.

## Байгууллагууд хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарах асуудал бэрхшээлийг урьдчилан тооцох

- Түншлэлийн хүрээнд хамарагдахгүй байх
- Нөөц багатай, маргаантай байх
- Асуудлаас хүртэх ашиг, ач холбогдол бага байх

# НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ

## 46. Үйл явцын үнэлгээ хийх

Үнэлгээний эхний чухал алхам бол процесс, үйл явцын үнэлгээг хийх явдал юм. Энэ нь “нөлөөллийн арга хэмжээг төлөвлөсний дагуу хэрэгжүүлсэн үү, хэрэгжүүлэхэд хэрхэн өөрчлөгдсөн бэ?” гэсэн асуултад хариулдаг. Зурагт үзүүлсэнчлэн үйл явцын үнэлгээ нь хариу арга хэмжээ (оролт) болон эдгээр нөөцөөр гүйцэтгэсэн үйл ажиллагаанд (үр дүн) ашигласан нөөцөд анхаарлаа төвлөрүүлдэг боловч хариу арга хэмжээ нь асуудал, хүндрэлийг (үр дүн) бууруулахад үр дүнтэй байсан эсэхийг шалгадаггүй. Үүний тулд танд нөлөөллийн үнэлгээ хэрэгтэй. Нөлөөллийн үнэлгээ нь асуудал өөрчлөгдсөн эсэхийг хэлж өгнө (47-53 дугаар алхам).

### Үйл явц ба нөлөөллийн үнэлгээний үүрэг

Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны төсөлд хоёр төрлийн үнэлгээ шаардлагатай. Хоёр төрлийн үнэлгээний үр дүнд үндэслэн боломжит дүгнэлтийг хүснэгтэд нэгтгэн харуулав. (A) Хариулт нь төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн бөгөөд бууралтын талаар өөр үндэслэлтэй тайлбар байхгүй байна. Тиймээс хариу арга хэмжээ нь бууралтад хүргэсэн гэх найдвартай нотолгоо бий. (B) Хариулт нь төлөвлөсний дагуу хэрэгжсэн боловч асуудал, хүндрэл буураагүй. Тиймээс хариу арга хэмжээ үр дүнгүй байсан гэх баттай нотолгоо бий.

#### Үйл явц ба нөлөөллийн үнэлгээний гол анхаарах асуудлууд

Шаардлагатай зүйлс <ul style="list-style-type: none"><li>хүний нөөц</li><li>тоног төхөөрөмж</li><li>зардал</li><li>бусад нөөц</li></ul>	Үйл явцын үнэлгээний гол анхаарах асуудлууд	Үр дүнгүүд <ul style="list-style-type: none"><li>баривчилгаа</li><li>хүмүүсийг сургах</li><li>хориг саад суурилуулах</li><li>хэрэгжүүлсэн бусад ажлууд</li></ul>	Үр дүн <ul style="list-style-type: none"><li>гэмт хэргийн бууралт</li><li>айдас, стресс багасах</li><li>осол буурах</li><li>асуудал зөрчлийн бусад буурсан үр дүнгүүд</li></ul>
Нөлөөллийн үнэлгээний гол анхаарах асуудлууд		→	

## Үйл явц ба нөлөөллийн үнэлгээний үр дүнг тайлбарлах нь

## Үйл ажиллагааны үнэлгээний үр дүн

		Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ	Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж чадаагүй хариу арга хэмжээ
Нөлөөллийн үнэлгээний үр дүнгүүд	Асуудал, зөрчил буурсан мөн бусад боломжит шалтгаанууд байхгүй	A. Хариу арга хэмжээ нь бууралтад нөлөөлсөн нотолгоо	C. Хариу арга хэмжээ нь санамсаргүй байдлаар үр дүнтэй эсвэл бусад хүчин зүйлс нь бууралтад нөлөөлсөн гэж үзэх.
	Асуудал, зөрчил буураагүй байх	B. Хариу арга хэмжээ үр дүнгүй гэх баталгаа, нотолгоо	D. Эзэмших туршлага мэдлэг бага байх.

Гэвч төлөвлөгөөний дагуу хариу арга хэмжээ аваагүй бол яах вэ? Энэ тохиолдолд ач холбогдолтой дүгнэлтэд хүрэхэд хэцүү байдаг. (C) Хэрэв асуудал, зөрчил буурсан бол энэ нь санамсаргүй байдлаар хариу үйлдэл үзүүлсэн эсвэл өөр хүчин зүйл нөлөөлсөн байж болно. (D) Хэрэв асуудал арилаагүй бол ашигтай дүгнэлт хийх боломжгүй. Магадгүй хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ нь алдаатай байж болох бөгөөд анхны хариу үр дүнтэй байх байсан, эсвэл аль нь ч үр дүнтэй биш байж магадгүй юм. Төлөвлөсөн хариу арга хэмжээ хэрэгжээгүй бол нөлөөллийн үнэлгээнээс суралцахад хэцүү.

Хариу арга хэмжээ нь маш олон элемент, бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдтэй, тэдгээрийн аль нь ч буруу ажиллаж болзошгүй нарийн төвөгтэй систем, механизм юм (алхам 45).

Үйл явцын үнэлгээ нь аль бүрэлдэхүүн хэсгүүд амжилттай ажилласан болохыг шалгадаг. Үйл явцын үнэлгээний хяналтын хуудас нь таны асуувал зохих асуултуудыг танилцуулсан.

Зөрчил, асуудлын хариу арга хэмжээг төлөвлөх ихэнх тохиолдолд гол чухал асуудал байдаг. Ийм учраас гол бүрэлдэхүүн

хэсгүүд хэзээ хэрэгжсэнийг харуулсан төслийн үйл ажиллагааны хуваарийг гаргах хэрэгтэй. Бусад гэнэтийн үйл явдлууд хэзээ тохиолдсоныг харуулах, олон нийтэд сурталчлах нь үр дүнтэй бөгөөд ингэснээр та урьдчилан таамаглаж буй үр өгөөжийг шалгах боломжтой (алхам 52).

Хэрэв та хариу арга хэмжээг боловсруулах явцад дүн шинжилгээнд сул, үр дүн муутай асуудлуудыг илрүүлэх боломжтой бол та болзошгүй нөхцөл байдлын төлөвлөгөөг гаргаж болно (үүнийг батлах, нотлох шаардлагатай бол давтан хохирогчийг хандах төлөвлөгөө). Боломжит хариултуудын жишигээ доор танилцуулав. Үүнд:

- Та зөрчил, асуудлын талаар хангалтгүй ойлголттой байж магадгүй юм. Жишээлбэл, та давтан хохирогчдод хэт бага анхаарал хандуулсан байж болно. Энэ нь асуудлын талаарх буруу таамаглал, дүгнэлт эсвэл хангалтгүй дүн шинжилгээнээс шалтгаалж болно (жишигээлбэл, та давтан хохирогчийг судлаагүй, хайгаагүй). Хэрэв та хариу арга хэмжээг боловсруулах явцад дүн шинжилгээ хийхдээ сул талуудыг олж

илрүүлж чадвал болзошгүй нөхцөл байдлын төлөвлөгөөг гаргаж болно (хэрэв энэ нь шаардлагатай бол давтан хохирогчид хэрхэн хандах төлөвлөгөө гаргах).

- Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд буруу ажилласан. Үйл явцын үнэлгээний хяналтын хуудас нь үүсэж болох олон бүтэлгүйтлүүд, алдаануудыг харуулдаг. Гэсэн хэдий ч системийн элемент, бүх бүрэлдэхүүн хэсгүүд нь амжилтад хүрэхийн тулд адил чухал үүрэг гүйцэтгэхгүй. Цаашлаад зарим тохиолдолд саатал, алдааны өндөр хувь хэмжээ бүхий бүрэлдэхүүн хэсгүүдийг урьдчилан таамаглах боломжтой. Ерөнхийдөө иргэдийн багц асуудал, үүрэг даалгавраа биелүүлэх чадварын хувьд нэлээд хувьсамтгай. Илүүдэл тоог бий болгох эсвэл нөөц төлөвлөгөө боловсруулах нь бүрэлдэхүүн хэсгийн алдааг багасгаж чадна.
- Гэмт этгээдүүд таны хариу үйлдэл сөрөг хариу үйлдэл үзүүлж болно (алхам 11). Сөрөг дасан зохицлын зарим хэлбэрийг урьдчилан харж, төлөвлөх боломжтой.

Заримдаа газарзүйн шилжилтийн байршлыг хариу арга хэмжээ авахаас өмнө тодорхойлж болно, жишээлбэл, тэдгээрийг дархлаажуулахын тулд дэвшилтэт хамгаалалтын арга хэмжээ авч болно.

- Хариу арга хэмжээнд нөлөөлдөг, урьдчилан тооцоолоогүй гадны гэнэтийн өөрчлөлтүүд тулгардаг. Түнш, байгууллагын зардал багассанаар асуудал, зөрчилд хандах арга хэмжээ, хичээл чармайлт хумигдана. Асуудал өөрөө алга болохгүй тул төлөвлөгөөг өөрчлөх нь цорын ганц арга зам юм.

Үйл явцын үнэлгээ хийхэд их хэмжээний мэдээлэл шаардагддаг. Энэ мэдээлэл нь асуудал шийдвэрлэх багийн гишүүдээс хуримтлагдах тул тэдний үйл ажиллагааг баримтжуулах нь чухал юм. Хариу арга хэмжээг төлөвлөхдөө тэд ямар үйл ажиллагааг баримтжуулж бүртгэсэн, хэн үүнийг нарийвчлан бүртгэж байгаа зэрэг асуудлууд хариу арга хэмжээг төлөвлөх үед шийдвэрлэх ёстой асуудлууд юм.

## Үйл явцын үнэлгээний хяналтын жагсаалт

### Хэн оролцоно гэж үзэж байна?

Цагдаагийн хэсгүүд  Засгийн газрын байгууллагууд  Олон нийтийн бүлгүүд, олон нийт Бизнесийн байгууллагууд  Бусад

Тэд юу хийхээр төлөвлөж байна бэ?: \_\_\_\_\_

### Тэдэнд ажиллах чадвар бий юу?

Хуулийн байгууллага  Орон нутгийн байгууллага  Нөөц  Мэргэшсэн байдал

### Тэд хэзээ ажиллах шаардлагатай бэ?

Огноо ба цаг \_\_\_\_\_ Бусадтай хамтран зохицуулах \_\_\_\_\_

### Хэн ба юу үйл ажиллагааг хүлээн авна гэж үзэж байна ?

Хүмүүс \_\_\_\_\_ Газар\_\_\_\_\_

### Үйл ажиллагааг зохих ёсоор хүргэсэн үү?

Төрөл \_\_\_\_\_ Эрчим \_\_\_\_\_ Үргэлжлэх хугацаа\_\_\_\_\_

### Дараах зүйлсэд зориулсан нөөц төлөвлөгөө байгаа эсэх?

Алдаатай төлөвлөгөө ? Бүрэлдэхүүн хэсгийн алдаа  ?

Дасан зохицол ? Гадаад өөрчлөлтүүд  ?

## 47. Хяналтыг хэрхэн хэрэгжүүлэхийг судлах

**X**ариултыг үнэлэхдээ та гурван асуултад хариулах хэрэгтэй.

- "Ямар хариу арга хэмжээ авсан бэ?" Үйл явцын үнэлгээ нь энэ асуултад хариулдаг (алхам 46).
- "Асуудал буурсан уу?" Асуудлын нөхцөл байдлыг хариу арга хэмжээний дараах болон өмнөх байдаар харьцуулж энэ асуултад хариулна.
- Хэрэв буурсан бол "Хариу арга хэмжээ үүнд нөлөөлсөн үү?" гэдгийг асууна. Асуудал буурсан байх өөр шалтгаанууд байх боломжтой.

Гурав дахь асуултад хариулахын тулд хяналтын хэрэгслийг ашиглах хэрэгтэй. Хяналтын зорилго нь асуудалд нөлөөлсөн байж болзошгүй бусад тайлбарыг үгүйсгэх явдал юм. Өөр өөр тайлбаруудыг үгүйсгэхэд доор тайлбарласны дагуу өөр өөр хяналтын хэрэгсэл хэрэгтэй:

**Хэмжээний өөрчлөлт.** Хэрвээ аливаа байрны оршин суугчдын тоо буурсан бол гэмт хэрэгт өртөж болзошгүй бай буурч, энэ мөрөөр хэргийн гаралт буурах ёстай. Гэмт хэрэг багассан нь хэрэгт өртөж болзошгүй этгээдүүдийн тоо буурсантай холбоотой байж болзошгүй. Хэмжээнд өөрчлөлт орсон эсэхийг хянахын тулд хариу арга хэмжээ авахаас өмнөх болон дараах хулгайн тоог хэрэгт өртөж болзошгүй этгээдүүдийн тоонд хувааж харьцуулна. Хүснэгтээс харахад хулгайн гэмт хэрэг буурсан нь оршин суугчдын тоо буурсантай болон хариу арга хэмжээ авсантай холбоотой байна. Түүнчлэн хариу арга хэмжээ авахаас өмнө болон дараах хугацаа нь харилцан адилгүй бол өгөгдлийг харгалзах сард хувааж, өрх тутамд ногдох дээрмийн сарын дундаж дүнг олох нь зүйтэй.

### Хэмжээнд өөрчлөлт орсон эсэхийг хянахын тулд хувь хэмжээг ашиглах

	6 сарын өмнө	6 сарын дараа	Өөрчлөлт
Хулгай	41	20	-21
Оршин суугчдын тоо	83	73	-10
Хулгай/оршин суугчдын тоо	.494	.286	-.208

**Үйл ажиллагааны мөчлөгүүд.** Хүний үйл ажиллагаа өдөр, долоо хоног, сараар хэлбэлзэх циклтэй байдаг. Хамгийн түгээмэл мөчлөгүүдээс дурдвал ажил, сургуульд явах, амралт, улирлын амралт зэрэг бий. Иймд циклүүдийг хянахын тулд хариу арга хэмжээ хэрэгжүүлэхээс өмнөх мөн мөчлөгийг хариу арга хэмжээ авсны дараах мөчлөгтэй харьцуулна.

### Асуудлын урт хугацааны чиг хандлага.

Асуудал нь хариу арга хэмжээ авахаас өмнө тодорхой нэг чиглэлийн дагуу өөрчлөгдж байсан байж болно (алхам 26). Иймд тухайн асуудал нь хариу арга хэмжээ авсан эсэхээс үл хамааран өөрийн урт хугацааны чиг хандлагынхаа дагуу буурч байсан байж болзошгүй. Үүнд хяналт тавих хоёр арга зам бий. Эхний арга нь хариу арга хэмжээ авахаас өмнө урт хугацааг хамарсан түүхэн өгөгдөл үндэслэн асуудлын ерөнхий чиг хандлагыг тодорхойлох юм. Хариу арга хэмжээ авсны дараа дээрх ерөнхий чиг хандлагаас хазайх тохиолдолд хариу хариу арга хэмжээний үр дүнгийн нөлөө гэж үзэж болно. "Урьдчилан таамаглах" нөлөө (алхам 52) нь хариу арга хэмжээнээс шалтгаалж зөрчил, асуудал буурах үзэгдэл бөгөөд энэ өөрчлөлт нь хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхээс өмнө илэрдэг. Эдгээрийг урт хугацааны чиг хандлагаас ялгах шаардлагатай.

Хоёр дахь арга нь хариу арга хэмжээ хэрэгжүүлсэн газар, хүмүүсийг бусад ижил төстэй булэгтэй харьцуулах юм. Үүнийг хяналтын бүлэг эсвэл харьцуулах бүлэг гэж нэрлэдэг. Хяналтын бүлэг нь асуудлын хувьд харьцуулагдах бүлэгтэй төстэй байх бөгөөд тус бүлгийн хүрээнд хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэгүй байх шаардлагатай. Хяналтын бүлэг нь хариу арга хэмжээ аваагүй байх тохиолдолд харьцуулагдаж буй бүлэг хэрхэх байсныг харуулах юм. Хэрэв харьцуулагдаж буй бүлгийн асуудлын нөхцөл байдал хяналтын бүлгээс өөрчлөгдвэл энэ нь хариу арга хэмжээ үр дүнтэй гэдгийн нотолгоо юм.

**Бусад гэнэтийн үйл явдлууд.** Хариу арга хэмжээ авахын зэрэгцээ бусад олон зүйл

өөрчлөгдж байгаа бөгөөд тэдгээрийн нэг буюу хэд хэдэн нь асуудал буурахад нөлөөлж байж болзошгүй. Зам дээрх ослын бууралтад нөлөөлж байгаа хүчин зүйл нь тухайн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ бус, харин зам засварын ажлын улмаас хурдаа хассантай холбоотой байж болзошгүй. Үүнд хяналт тавихын тулд чиг хандлагын адил хяналтын бүлэг ашиглаж болно. Хяналтын бүлэг нь харьцуулагдаж буй бүлэгтэй ижил нөлөөлөлд өртсөн тохиолдолд харьцуулалт үр дүнтэй байна. Иймээс зам засварын ажилд нөлөөлсөн эсэхийг үнэлэхийн тулд хяналтын бүлэг болон харьцуулагдаж буй бүлэгт зам засварын ажил хийгдэж байх шаардлагатай юм. Хэрэв тийм бол уул замуудад гарсан ослуудыг харьцуулж, хариу арга хэмжээний нөлөөллийг үнэлэх боломжтой.

**Асуудлын хэмжилтэд гарах өөрчлөлт.** Хариу арга хэмжээний өмнө ба дараах асуудал, зөрчилд нөлөөллийг ижил зарчмаар хэмжсэн байх тохиолдолд харьцуулалт хийх зүйтэй. Хэрэв өөр зарчмаар хэмжсэн бол асуудалд өөрчлөлт орсон мэт харагдуулж, төөрөгдөл үүсгэх эрсдэлтэй. Ижил зарчмаар хэмжилт хийнэ гэдэг нь нэг байршилаас ижил цагт ижил зүйлсийг ажиглан судалж, ижил зарчмаар бүртгэхийг хэлнэ. Баримт, нотолгоо бүхий гэрэл зураг, видео бичлэгийг мөн ижил нөхцөлд, ижил өнцгөөс, ижил зайд, ижил хэмжээгээр авна. Ярилцлагад оролцогчид мөн этгээдүүд байх ба асуултууд ч ижил байна. Дуу бичлэгийн журам ижил гэдгийг баталгаажуулах зорилгоор өмнөх бичлэгүүдийг шалгаж хэрэгтэй.

**Хэт өндөөс өөрийн жамаар унах.** Нөхцөл байдал маш хүндэрсэн учраас тухайн асуудлыг шийдэх хэрэгтэй болдог. Иймд асуудал хэвийн бус, өндөр байх үед хариу арга хэмжээг хэрэгжүүлдэг. Гэхдээ харьцангуй тогтвортой асуудал ч мөн адил хэлбэлзэж болно. Өөрөөр хэлбэл хэвийнээсээ дордсон асуудал хариу арга хэмжээ аваагүй байхад буцаад хэвийн түвшин хүртлээ буурах болно (үүнийг "дундаж үзүүлэлт рүү буцах" гэж нэрлэдэг бөгөөд энэ нь хэвийн бус доод түвшинд ч хамаатай). Харьцуулагдаж буй бүлэг хэвийн түвшинд, харин хяналтын бүлэг хэвийнээс өндөр түвшинд байх тохиолдолд харьцуулсан судалгаа хийх нь тохиромжгүй.

Үүний оронд асуудлыг урт хугацааны хэлбэлзэлд үндэслэн хариу арга хэмжээ авахаас өмнө хэвийн бус түвшинд байсан эсэхийг шалгах нь зүйтэй.

Доорх зурагт хяналтын хэрэгслийн зарим хэрэглээг харууллаа. А самбар нь эхний жилийн 11 дүгээр сарын эхээр хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ бүхий асуудлын 24 сарыг хамарсан цаг хугацааны цувралыг харууллаа. Хариу арга хэмжээ авсан эсэхээс үл хамааран асуудал буурах хандлагатай байсан бөгөөд арван нэгдүгээр сард авсан хариу арга хэмжээний улмаас огцом өссөн нь тухайн хариу арга хэмжээ эсрэг нөлөө үзүүлсэн байна.


В самбар нь өмнөх болон дараах харьцуулалтаас (2003 оны 8-10-р сарын дундаж үзүүлэлтийг 2003 оны 11-р сараас 2004 оны 1-р сарын дундажтай харьцуулахад) үзэхэд хариу арга хэмжээний дараа асуудал улам дордсон байна.

С самбарт харьцуулах бүлэг нэмсэн байгаа бөгөөд үүнээс үзэхэд харьцуулагдаж буй бүлгийн нөхцөл байдал илүү сайн байна. Гэвч мөчлөгийн нөлөөллийг мөн харгалзаж үзэх шаардлагатай билээ. Иймд хариу арга хэмжээ авахаас өмнөх гурван сарыг өмнөх жилийн мөн гурван сартай харьцуулж циклийн нөлөөг ялгах боломжтой.

Д самбарт энэхүү харьцуулалтыг хийж үзэхэд хариу арга хэмжээний үр дунд асуудал баагүй хэмжээгээр буурсан мэт харагдаж байгаа нь хоёр бүлгийн ерөнхий чиг хандлага буурч байсантай холбоотой байж болзошгүй. Хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхээс өмнө харьцуулагдаж буй бүлэг нь нөгөө бүлгээсээ тогтмол муу буюу илүү их асуудалтай байжээ. Хариу арга хэмжээний дараа хоёулаа ижил төстэй байна. Мөн 11 дүгээр сарын огцом өсөлт нь харьцуулагдаж буй бүлэгт ажиглагдсан тул хариу арга хэмжээтэй холбоогүй байж болзошгүй. Хариу арга хэмжээ иймээс харьцангуй амжилттай байсан гэж дүгнэгдэхээр байгаа боловч хариу арга хэмжээ нь их хэмжээний нөлөө үзүүлээгүй учир хяналтын хэрэгсэл ашиглан үр дүнг үнэлэх шаардлагатай байна (чиг хандлага, цикл, санамсаргүй үйл явдал).

## Хяналтын зарим хэрэглээ

**A. Хариу арга хэмжээний талбарт хамаарах сарын хугацааны цуврал**



**B. Ойролцоогоор 3 сарын өмнөөс ойролцоогоор 3 сарын дараа хүртэл**



**D. Хариу арга хэмжээ болон хяналтын талбарын сарын хугацааны цуврал**



**C. Ойролцоогоор 3 сарын өмнөөс ойролцоогоор 3 сарын дараа хүртэл**



## 48. Газар зүйн болон цаг хугацааны шилжилт хөдөлгөөнийг тооцоолох

Цагдаагийналиваа аргахэмжээтодорхой нэг газар, байгууллага, байгууламжид гэмт хэрэг, хэрэг зэрчлийн боломжийг хориглох тохиолдолд гэмт хэрэгтнүүд газар зүйн шилжилт хөдөлгөөн хийдэг. Цаг хугацааны шилжилт хөдөлгөөн нь амжилттай урьдчилан сэргийлэлтээс үүдэлтэй боловч энэ тохиолдолд гэмт хэрэгтнүүд гэмт хэргээ өөр цаг эсвэл өдөр болгон өөрчилдөг.

Гэмт хэрэг үйлдэх, хэрэг зөрчил гаргах боломж нөхцөл хязгаарлагдмал учраас гэмт хэрэгтнүүд өөр газар руу шилжилт хөдөлгөөн хийхэд амаргүй гэдгийг ойлгодог (алхам 16). Бай, өртөгч нь зарим газар төвлөрч, заримд нь төвлөрдөггүй байж болно (алхам 16). Зарим газар өртөмтийг бай, хохирогчдыг олох боломжтой бол бусад газар боломжгүй байж болно (алхам 29). Зарим байгууламжуудын хяналт сүл байдаг, харин зарим байгууламжийн тийм биш (алхам 28). Гэмт хэрэг үйлдэх нөхцөл, боломж байгаа бол тухайн газар аль хэдийнээ гэмт хэргийн төвлөрөл өндөртэй (цаашид халуун цэг гэх) болсон эсвэл гэмт хэрэгтнээс далд нууцлагдсан байж болно (хол, өгөөжгүй гэх мэт).

Хэрэв гэмт хэрэг үйлдэх нөхцөл, боломжийг бууруулсан бол гэмт хэрэгтнүүд тухайн газраас гэмт хэрэг үйлдэх зорилгоор холдож, бусад газарт эрэл хайгуул хийж цаг зарцуулаад байдаггүй. Тиймээс хэрэв гэмт хэрэгтнүүд шилжиж хөдлөх тохиолдолд тэд газар зүйн хувьд холдоггүй гэсэн үг юм. Доорх зураглалд харуулсны дагуу гэмт этгээдүүд нөхцөл боломжийг хайж шилжин хөдлөх магадлал гэмт хэрэг үйлдсэн анхны газраасаа холдох хэрээр буурдаг. Түүнчлэн бүх газар гэмт хэрэг үйлдэхэд тохиромжтой байдаггүй, гэмт хэрэг үйлдэх боломж газар зүйн хувьд жигд тархсан байдаггүй.

Доорх газрын зурагт анхны халуун цэгтэй ижил шинж чанартай газруудыг ромбоор тэмдэглэв. Анхны халуун цэгт ойр байгаа хүмүүс шилжилт хөдөлгөөнд өртөх магадлалтай хамгийн өндөр. Зайнаас гадна хөдөлгөөнд нөлөөлөх байгалийн саад тоттор

нь гэмт хэргийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарладаг. Зураг дээр зүүн хойш/ баруун урагш урсгалтай гол нь зүүн тийшээ шилжиж хөдлөх боломжийг бууруулж буй. Үүнийг ойлгосноор шилжилт хөдөлгөөний эсрэг арга хэмжээг бусад хариу арга хэмжээтэй хослуулан хамгийн өртөмтийг газруудад хэрэгжүүлж болно.

Гэмт хэрэг хэрэв газарзүйн болон цаг хугацааны хувьд шилжиж хөдөлбөл урьдчилан сэргийлэх арга хэмжээнд өртсөн газар, цаг хугацаатай төстэй байршил, цаг хугацаа руу шилжих магадлал өндөр байдаг. Учир нь ийм шилжилт хөдөлгөөн нь гэмт хэрэгтний огт мэдэхгүй газар, цаг хугацаа руу шилжихээс бага хүчин чармайлт шаарддаг, гэмт хэрэгтэн шинээр суралцах шаардлага бага гардаг, бага эрсдэл шаардлагад оршино. Лоренс Шерманы дүгнэснээр гэмт хэрэгтнүүд хариу арга хэмжээг авч хэрэгжүүлж дуусахыг хүлээхийг илүүд үздэг тул цагдаагийн тусгай ажиллагааны үр дүнтэй байдал аажмаар буурдаг байна. Хэрэв гэмт хэрэгтэн хариу арга хэмжээний дуусахыг хүлээж чадахгүй бол тухайн этгээд өөрийн сайн мэддэг газар луу шилжиж хөдөлдөг байна. Пол, Патрисия Брантингхам нарын онцолсноор шилжилт хөдөлгөөн хийгдэх өндөр магадлалтай газруудыг урьдчилан таамаглах боломжтой байдаг. Гэхдээ ийнхүү шилжихэд гэмт хэрэгтэн нь тухайн үеийн нөхцөл байдалд гэмт хэрэг үйлдэх боломжтой өсөх талаар мэдээлэлтэй байх хэрэгтэй.

Хэрэв газарзүйн шилжилт хөдөлгөөн хийгдсэн бол үр дүнтэй байдлын талаарх дүгнэлтийг гажуудуулж болно. 1 дүгээр хүснэгтэд уг нөхцөл байдал хэрхэн үүсэж болохыг харуулав. Уул арга хэмжээ авахаас өмнө ижил төрлийн гэмт хэрэгтэй ижил төстэй гурван газар байна: (1) арга хэмжээ авсан газар, (2) арга хэмжээ авсан газрын зэргэлдээх газар, (3) арга хэмжээ авсан газраас алслагдсан газар. Арга хэмжээ авсан газрын гэмт хэрэг 25-аар буурсан байна. Харин зэргэлдээх газрын гэмт хэрэг 10-аар нэмэгджээ. Энэ нь нэгдүгээр газарт ямар нэгэн арга хэмжээ аваагүй бол тус газарт

гэмт хэрэг 10-аар нэмэгдэхээр байсан байж болзошгүй тул гэмт хэргийн цэвэр бууралт 35

(арга хэмжээ авсан газрын гэмт хэрэг 25-аар буурч, 10 гэмт хэргээс зайлсхийсэн) байна.



**Хүснэгт 1. Зэргэлдээх, алслагдсан газруудыг газар зүйн шилжилт хөдөлгөөний хянач байдлаар хэрэглэх нь**

	Өмнө	Дараа	Зөрүү	Тооцоолсон цэвэр үр дүн, нөлөөлөл
Арга хэмжээ	100	75	-25	
Зэргэлдээх газар	100	110	+10	-35
Алслагдсан газар	100	100	0	-25

Гэхдээ зэргэлдээх газарт үүссэн нэмэлт 10 гэмт хэрэг нь газарзүйн шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй байж болзошгүй. Иймд харьцуулалт хийхийн тулд алслагдсан газрыг хяначчаар хэрэглэх нь зүйтэй. Алслагдсан бус нутгийн гэмт хэргийн нөхцөл байдлаас үзэхэд хэрэв арга хэмжээ аваагүй бол нэг болон хоёрдугаар газарт гэмт хэрэг өөрчлөгдхгүй байх байж. Өөрөөр хэлбэл арга хэмжээ нь гэмт хэргийг 25-аар нэг газар бууруулж, зэргэлдээх газарт 10-аар нэмэгдүүлсэн байх (гэмт хэрэг шилжиж хөдөлсөн) тул гэмт хэрэг 15-аар буурсан байна. Үр дүнтэй хэдий ч тус арга хэмжээ нь анх төлөвлөгөөт зорилтдоо хүрээгүй байна. 51 дүгээр алхамд үр ашгийг үнэлэхдээ шилжилтийг харгалзан үзэх томьёог тайлбарласан.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнгийн үнэлгээнд зориулан арга хэмжээ

авсан газартай харьцуулах хоёр өөр газар сонгоорой: (1) тухайн газартай ойрхон бөгөөд газарзүйн шилжилт хөдөлгөөн (мөн 51 дүгээр алхамд дурдсан тархалтыг) хийгдэх боломж бүхий газар, (2) хол зай эсвэл өөр ямар нэг саад бэрхшээлээр шилжилт хөдөлгөөн хийгдэх боломжгүй хяналт бүхий газар. Хяналтын болон шилжилт хөдөлгөөний газрыг зөв сонгохын тулд та гэмт хэрэгтнүүдийн зан төлөв, хэв маягийн талаар тодорхой ойлголттой байх хэрэгтэй. Учир нь хяналтын талбар нь гэмт хэрэгтний хэрэн хэсүүчлэх, хөдөлгөөн хийх талбар, дэвсгэрийн гадна байх ёстой. Харин шилжилт хөдөлгөөн хийх боломж бүхий газар нь үүний дотор байх ёстой.

Харьцангуй бага хүчин чармайлт шаарддаг тул цаг хугацааны шилжилт хөдөлгөөн хийхэд гэмт хэрэгтнүүдэд хялбар байдаг.

Хэрэв урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь өдрийн зарим цагт чиглээгүй бол уул шилжилт хөдөлгөөн нь 24 цагийн дотор, зарим тохиолдолд долоо хоног эсвэл түүнээс дээш хугацаанд мөн хийгдэх боломжтой.

Урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авагдсан хугацааг урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авагдаагүй цаг хугацаатай харьцуулж үнэлгээ хийх тохиолдолд цаг хугацааны хяналтууд гажуудах эрсдэлтэй. 2 дугаархүснэгтэд Бямба, Нямгарагт урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлдэг бөгөөд өдгээр өдрүүдэд үйлдэгдсэн гэмт хэргийн too дунджаар 25 буурсан бол Даваа, Баасан гарагт гарсан гэмт хэрэг 10-аар өссөн байна. Энэ нь гэмт хэргийн цаг хугацааны шилжилт хөдөлгөөнтэй холбоотой эсэх? Энэ тохиолдолд долоо хоногийн дунд өдрүүдийг хяналтаар хэрэглэх нь зүйтэй. Учир нь Даваа, Баасан гарагтай харьцуулахад өдгээр өдрүүд нь Бямба, Ням гарагтай нийтлэг шинж чанар бага юм.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ дуусахыг хүлээхньцаг хугацааны шилжилт хөдөлгөөний түгээмэл хэлбэр юм. Хууль сахиулах тусгай ажиллагаанууд нь шинж чанарын хувьд түр зуурынх тул цаг хугацааны энэхүү шилжилт

хөдөлгөөний хэлбэрт илүү өртөмтгий байдаг. Хэрэв урьдчилан сэргийлэх арга хэмжээг урт хугацаанд үргэлжлүүлж чадвал (хууль сахиулах тусгай ажиллагаанаас ялгаатай нь) гэмт хэрэгтнүүд үүнийг хүлээж чадахгүй байх магадлалтай. Энэ тохиолдолд гэмт хэрэгтнүүд сонирхол их татахааргүй газар, бай руу шилжих эсвэл шинэ арга хэрэглэх, эсвэл өөр шинэ гэмт хэрэг үйлдэх хүндрэлтэй арга замуутдай нүүр тулна. Хэрвээ өдгээр сонголтууд нь хэтэрхий хүнд, ашиггүй, эрсдэлтэй эсвэл сонирхол татахуйц биш бол тэд харьцангуй цөөн гэмт хэрэг үйлдэх болно.

### **Нэмэлт материал:**

Brantingham, Paul, and Patricia Brantingham. 2003. "Anticipating the Displacement of Crime Using the Principles of Environmental Criminology." In Theory for Practice in Situational Crime Prevention, edited by Martha J. Smith and Derek B. Cornish. Vol. 16 of Crime Prevention Studies. Monsey (New York): Criminal Justice Press.

Eck, John. 2013. Assessing Responses to Problems: An Introductory Guide for Police Problem-Solvers. Washington, DC: Office of Community Oriented Policing Services. [Http://ric-zai-inc.com/ric.php?Page=detail&id=COPS-P034](http://ric-zai-inc.com/ric.php?Page=detail&id=COPS-P034).

### **Хүснэгт 2. Цаг хугацааны шилжилтийн хянах зорилгоор долоо хоногийн өдрүүдийг ашиглах нь**

	<b>Долоо хоногийн өдрүүд</b>	<b>Өмнө</b>	<b>Дараа</b>	<b>Зөрүү</b>	<b>Тооцоолсон цэвэр үр дүн, нөлөөлэл</b>
<b>Арга хэмжээ</b>	Бямба ба Ням	100	75	-25	
<b>Зэргэлдээх хороолол, талбар</b>	Даваа ба Баасан	100	110	+10	-35
<b>Алс холын талбар, хороолол</b>	Мягмараас Пүрэв хүртэл	100	100	0	-25

## 49. Өөр бай, арга зам, гэмт хэргийн төрөлд шилжилт хөдөлгөөнийг шалган тодорхойлох

Газарзүйн болон цаг хугацааны шилжилт хөдөлгөөнөөс гадна гэмт хэрэгтнүүд байгаа өөрчлөх, арга замаа өөрчлөх, гэмт хэргийн төрөл, байдлыг өөрчилж болно. Бай, өртөгчийн шилжилт гэдэг нь гэмт хэрэгтэн шинээр хамгаалалтад авсан байнаас өөр бусад бай, өртөгч рүү шилжихийг хэлнэ. 1970 онд Их Британид зарагдсан бүх шинэ машинуудад жолооны хүрдний түгжээ суулгуулахыг шаардах болсон. Шинэ автомашины хулгай 1969 онд хулгайлалгдан нийт машины 20.9 хувийг эзэлж байсан бол 1973 онд 5.1 хувь болж буурсан. Гэсэн хэдий ч гэмт хэрэгтнүүд шинээр хамгаалалтад орсон тээврийн хэрэгслээс шилжилт хийж, хамгаалалтад багтаагүй тээврийн хэрэгсэл рүү шилжилт хөдөлгөөн хийсэн тул автомашины хулгайн гэмт хэргийн нийт хэмжээ бараг өөрчлөгдөөгүй байлаа. Энэ нь шилжилт хөдөлгөөний улмаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн, нөлөөллийг үр дүнгүй болгосон цөөн тохиолдлуудын нэг юм. Урт хугацаандаа эдгээр төхөөрөмжүүд (жолооны түгжээ гэх мэт) нь түр зуур хэрэглэх зорилгоор машин хулгайлах хэргийн тоо хэмжээг бууруулсан байна. Энэ тохиолдоос харахад гэмт хэрэг үйлдэгчид төстэй бай, өртөгч рүү шилжилт хийхэд хялбар байдаг. Шинэ бай нь өмнөх байнаас өөр байх тохиолдолд шилжилт хөдөлгөөн хийгдэх магадлал бага байна.

42 дугаар алхамд газарзүйн болон цаг хугацааны шилжилт нь хяналтын бүлгүүдэд хэрхэн гажуу нөлөө үзүүлж буюу бохирдуулж болохыг харуулсан. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг үнэлэхдээ хяналтаар өөр бай бүхий бүлэг хэрэглэдэг бол гажуу нөлөөллийн ижил төстэй хэлбэр үүсэж болно. Худалдааны төвд 60-аас дээш насын эмэгтэйчүүдээс түрийвч хулгайлах гэмт хэргийг таслан зогсоохын тулд ямар арга хэмжээ авахыг төсөөлөөд үзээрэй. Хэрэв ямар нэгэн арга хэмжээ аваагүй бол өндөр настны түрийвчний хулгай ямар хэмжээнд байх байсныг тооцоолохын тулд 45-59 насын дунд эргэм насын эмэгтэйчүүдээс түрийвч хулгайлах гэмт

хэргийг тооцоолно. Хэрэв бидний үл мэдэх хулгайчид хамгаалалтад байгаа өндөр настай эмэгтэйчүүдээс хамгаалалтгүй дунд эргэм насын эмэгтэйчүүд рүү шилжсэн бол аливаа хариу арга хэмжээ аваагүй тохиолдолд гэмт хэргийн тоо хэмжээ нэмэгдэх болно. Хамгийн сайн тохирох хяналтын бүлэг нь залуу насын эмэгтэйчүүд, (30-44 насын) эсвэл эрэгтэйчүүд юм. Хэдийгээр эдгээрийн аль нь ч төгс биш боловч хэрэгтэн өөр, ялгаатай бай, өртөгч рүү арай бага шилжилт хөдөлгөөн хийх учраас уг хяналтын бүлэг нь илүү тохиромжтой юм. Эсвэл өөр дэлгүүрийн төвийн үйлчлүүлэгчдийг хяналтын бүлэг болгон сонгож болно. Энэ тохиолдолд та газарзүйн шилжилт хөдөлгөөний эсрэг хамгаалах арга хэмжээ авах хэрэгтэй (48, 51 дүгээр алхам).

Гэмт хэрэгтэн хэргийн арга зам, аргачлалаа өөрчлөх үед Тактикийн шилжилт хөдөлгөөн тохиолддог. Жишээлбэл, тэд цоож, түгжээг тайлахын тулд өөр өөр илүү ухаалаг арга хэрэгсэлашиглаж болно. Эсвэл компьютерын хакерууд хамгаалалтыг даван туулахын тулд программаа өөрчилдөг. Анагаах ухаанд зарим бактери хурдан мутаци өөрчлөлтөд ордог, нэг төрлийн бактерийн эсрэг үр дүнтэй эм нь мутацид орсон бактерийн эсрэг үйлчилгээтэй мутай болдог. Үүнээс сэргийлэх арга бол өргөн хүрээний мутацийн эсрэг үр дүнтэй өргөн хүрээний эмчилгээг ашиглах явдал юм. Үүний нэгэн адил өргөн хүрээний хариу арга хэмжээ нь гэмт хэрэгтнүүдийн ашиглаж болох одоогийн аргууд болон эдгээр арга тактикийн олон өөрчлөлтөөс хамгаалдаг. Өргөн хүрээний хөндлөнгийн оролцоо нь гэмт хэрэг үйлдэгчдээс зан үйлдээ томоохон өөрчлөлт хийхийг шаарддаг бөгөөд зарим тохиолдолд гэмт хэрэгтнүүд ийм өөрчлөлтийг хийж чадахгүй байж болно. Пол Экблом лангуун дээрх хулгайгаас урьдчилан сэргийлэхийн тулд Их Британийн шуудангийн газруудад саад, хаалт суурилуулсны дараа гэмт хэрэгтнүүдийн арга барил хэрхэн өөрчлөгдөж байгааг судалсан. Зарим гэмт хэрэгтнүүд том алх ашиглахыг завдсан.

Хэргийн арга, тактикийн өөрчлөлт тийм ч амжилттай болоогүй бөгөөд шилжилт хөдөлгөөн хязгаарлагдмал байв. Эдгээр саад бэрхшээлүүд нь шинэ арга тактикуудыг ялж чадсан тул өргөн хүрээний нөлөөллийн арга хэмжээ амжилттай хэрэгжсэн жишээ болсон.

Гэмт хэргийн төрлийг өөрчлөх нь таны судлах ёстой шилжилт хөдөлгөөний өөр нэг төрөл юм. Гэмт этгээдүүд тээврийн хэрэгслийг хулгайлах гэмт хэргээ өөрчилж, машиныг эvdэж, доторх эд зүйлсийг хулгайлах гэмт хэрэг рүү шилжиж болно. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдаагүй ижил төрлийн гэмт хэргийн хандлагыг харьцуулсны үндсэн дээр бид заримдаа нэг төрлийн гэмт хэргийн хариу үйлдлийг үнэлдэг. Жишээлбэл, бид тээврийн хэрэгслээс эд зүйлс хулгайлах хулгайн хэргийг үнэлэхэд тээврийн хэрэгслийн хулгайг хяналт болгон сонгож болно.

Бохирдуулах нөлөөллийн, хамгаалалтын ижил зарчмууд шилжилтийн бусад хэлбэрүүдийн нэгэн адил арга тактикийн болон гэмт хэргийн төрлийн шилжилт хөдөлгөөнд үйлчилнэ. Хэрэв арга тактик эсвэл гэмт хэргийн төрөл нь хэлэлцэж буй арга тактик эсвэл гэмт хэргийн төрөлтэй маш төстэй бол шилжилт хөдөлгөөн нь эдгээр хяналтуудад гажуу нөлөө үзүүлж (бохирдуулж) болзошгүй. Өөр өөр арга тактик эсвэл гэмт хэргийн төрлүүд нь бохирдолд өртөх магадлал бага байдаг. Гэхдээ тэд хэт өөр байвал энэ нь ашигтай хяналт биш юм.

Энэ асуудлыг шийдэх төгс шийдэл байхгүй тул буулт хийх хэрэгтэй. Үүний үр дагавар нь шилжилт явагдаж байгаа эсэхийг мэдэхэд хэцүү, арга хэмжээний үр дүнг үнэлэхэд хэцүү байдагт илэрдэг. Түүнчлэн

шилжилт хөдөлгөөний олон хэлбэр нэгэн зэрэг тохиолдож болзошгүй байдаг нь энэ сөрөг үр дагаврыг дордуулдаг. Бодит байдалд заримдаа шилжилтийн нэг хэлбэр нь өөр хэлбэртэй заавал хамт хийгддэг. Бай, өртөгчийн шилжилт хөдөлгөөн хийхэд арга тактикаа өөрчлөх хэрэгтэй бөгөөд хэрвээ шинэ бай, өртөгч нь өөр газарт байх тохиолдолд газар зүйн шилжилт хөдөлгөөн тохиолдоно.

Та үүнийг ажиглан судлахгүй бол шилжилтийг олж чадахгүй. Өөрөөр хэлбэл асуудлыг сайтар нухацтай судалж, шилжилт хөдөлгөөний хамгийн боломжит хэлбэрийг төсөөлөх хэрэгтэй. Таны таслан зогсоох гэж оролдож буй гэмт хэрэгтэй ижил төстэй гэмт хэрэг, хэрэг зөрчлүүд бий ю? Эдгээр гэмт хэрэг үйлдэх боломжийг гэмт хэрэгтнүүд амархан олж мэдэж чадах уу? Хариу арга хэмжээг эцэслэхээс өмнө шилжилт хөдөлгөөний боломжийг хайж олох нь танд хоёр давуу талыг үүсгэнэ. Нэгдүгээрт, хэрэв шилжилт хөдөлгөөн явагдах боломж гарч ирвэл түүнийг илрүүлэх арга хэмжээг боловсруулж болно. Хоёрдугаарт бөгөөд хамгийн чухал нь, та гэмт хэргийн шилжилт хөдөлгөөнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж болно.

### **Нэмэлт материал:**

Ekblom, Paul. 1987. Preventing Robberies at Sub-Post Offices: An Evaluation of a Security Initiative. Crime Prevention Unit Paper 9. London: Home Office.

Webb, Barry. 1994. "Steering Column Locks and Motor Vehicle Theft: Evaluations from Three Countries." In vol. 2 of Crime Prevention Studies, edited by Ronald Clarke. Monsey (New York): Criminal Justice Press. [Http://www.popcenter.org/library/crimeprevention/volume\\_02/](http://www.popcenter.org/library/crimeprevention/volume_02/).


## Гэмт хэргийн бай, өртөгчийн шилжилтийн судалгаа: дуулга, каскны хууль ба мотоциклын гэмт хэргийн бууралт

Германд (бусад газруудын адилаар) каск (малгай), дуулганы тухай хууль гарсны дараа мотоциклын хулгайн хэрэг их хэмжээгээр буурчээ. 1980 онд хууль хэрэгжиж эхэлснээс хойш мотоцикл хулгайлахаар төлөвлөж байгаа гэмт хэрэгтнүүд каск, дуулга авчрах шаардлага тавигддаг. Энэ шаардлагыг биелүүлээгүй буюу каск өмсөөгүй тохиолдолд хулгайн гэмт хэргийг хурдан илрүүлдэг байв. 1986 он гэхэд мотоциклын хулгай 1980 онд 150,000-аас 50,000 болж буурчээ. (Аажмаар буурч байгаа нь энэ шаардлагын ихээр мөрдөж, хүмүүсийн ухамсар, мэдлэг нэмэгдэж байгааг илтгэж байна). Энэ баримт нь мотоциклын хулгай хэний ч бодож байснаас хамаагүй том оппортунист (нөхцөл боломжоос хамаарсан) бүрэлдэхүүн хэсэгтэй болохыг харуулж байна. Германд хулгайн гэмт хэргийн талаарх мэдээлэл маш сайн өгч байгаа нь судлаачдад мотоциклын хулгай буурсан нь автомашины дугуй хулгайллах, хувийн тээврийн бусад төрлийг хулгайлахад нөлөөлж байгаа эсэхийг судлах боломжийг бүрдүүлсэн.

Нөгөө хоёр мөрөнд тухайн жилүүдэд автомашин болон машины дугуйн хулгайн гэмт хэргийн улсын дүнг харуулав. Энэ нь 1980-1986 оны хооронд автомашины

хулгайн гэмт хэрэг 10 орчим хувиар буюу 64,000-аас 70,000 болж өссөн гэсэн хязгаарлагдмал нотолгоог өгч байна. Мён 1980-1983 онд унадаг дугуйн хулгай өссөн боловч энэ хугацааны эцэс гэхэд 1980 оныхоос доогуур түвшинд хүртэл буурчээ. Нийтдээ хамгаалалтын малгайны хуулиар өөрчилж, багасгасан 100,000 – аар тоологддог мотоциклын хулгайн гэмт хэргийн багахан хувь нь бусад тээврийн хэрэгслийн хулгай руу шилжилт хийсэн.

Товчхон дүгнэлтээс үзэхэд энэ яагаад гайхмаар зүйл биш болохыг харуулна. Хулгайчдын хувьд мотоцикл хулгайлахад тэдний сонирхолтой зүйлсийн нэг байж болох юм. Хулгайчдын дийлэнх хувийг эзэлдэг залуусын хувьд унадаг дугуй унахаас хамаагүй илүү хөгжилтэй байдаг. Хэдийгээр хулгайчид шөнө оройд гэртээ харих зорилготой мотоцикл хулгайлдаг ч хулгайн үйлдэл нь өөрийн амьдардаг газраас хэдэн милээс илүү хол зайд байвал тэдэнд ихээхэн давуу талтай. Мотоциклыг хулгайллах нь машинаас илүү хялбар байдаг, учир нь машиныг асаахаас өмнө тоносон байдаг. Унадаг дугуйн нэгэн адил мотоциклийтой харьцуулахад машин анхаарал татах зүйл бага бөгөөд ашиглахад илүү их мэдлэг шаардагддаг.



Эх сурвалж: Mayhew, Pat, et al. 1989. "Motorcycle Theft, Helmet Legislation and Displacement." *Howard Journal of Criminal Justice* 28(1): 1–8.

# 50. Шинэ, өөр гэмт хэрэгтэн гарч ирж байгаа эсэхэд хяналт тавих

**Э**нэхүү гарын авлагын гурван зарчим нь (1) хэрэг зөрчил, асуудал үүсгэхэд гэмт хэрэгтнээс илүү ихийг шаардах, (2) гэмт хэрэг үйлдэхийг дэмжих нөхцөл, шаардлага болон боломж байхгүй бол гэмт хэрэг багасна (3) гэмт хэрэг үйлдэх нөхцөл, шаардлага ба боломжийг өөрчлөх нь хэрэг зөрчлийн гаралтыг эрс багасгадаг. Үүнээс үзэхэд зөвхөн гэмт хэрэг үйлдэх явдлыг багасгахад чиглэсэн хариу арга хэмжээ нь асуудал зөрчилд хязгаарлагдмал нөлөө үзүүлдэг. Зарим гэмт хэрэгтнүүдийн хэрэг үйлдэх магадлалыг багассаны (баривчлах гэх мэтээр) дараа хэрэг зөрчил, асуудал богино хугацаанд буурч магадгүй - дараа нь хуучин гэмт хэрэгтнүүд нөхцөл боломжуудыг ашиглахын тулд гэмт хэргийн талбарт буцаж гарч ирэх эсвэл шинэ гэмт хэрэгтнүүд хэрэг үйлдэх нөхцөл боломжуудыг ашиглаж эхэлдэг. Үүнийг заримдаа гэмт этгээдийн шилжилт хөдөлгөөн гэж нэрлэдэг. Гэмт этгээдийг байгалийн жамаар багасахыг (нас барах, баривчлах гэх мэтээр) хүлээвэл маш урт хугацаа шаардах нь мэдээж. Гэхдээ хэн нэгэн гэмт хэрэг үйлдэх боломжуудыг өнгөрсөн хугацаанд олж мэдсэн бол өөр бусад этгээд ирээдүйд тухайн боломжийг дахин олж харах нь мэдээж. Хэрэв хуучин гэмт хэрэгтнүүд широньд хоригдсон бол зарим хүмүүс широньоос суллагдсаныхаа дараа хэрэг үйлдэх боломжуудыг ашиглахын тулд гэмт хэргийн талбарт буцаж гарч ирж магадгүй юм.

Гэмт хэрэг үйлдэх боломжид татагдсан шинэ гэмт хэрэгтнүүд урт хугацааны гэмт хэргийн цикл, эргэлтэд оролцож, хувь нэмэр оруулж, гэмт хэрэгтнүүдийн тоог нэмэгдүүлж болзошгүй. Үүний нэг жишээ бол АНУ-ын зарим хэсэгт гардаг банкны дээрэм юм. Хэдэн жилийн турш эдгээр гэмт хэрэгтнүүд маш олон гэмт хэрэг үйлдэж, тэд хэдэн жил нам тайван байсны дараа дахин гэмт хэрэг үйлдэж эхэлдэг. Эдгээр мөчлөг хэрхэн явагдаж байгааг тайлбарлах нэг таамаглал бол дээрмийн оргил үед банкууд урьдчилан сэргийлэх олон арга хэмжээ авч эхэлдэг бөгөөд ихэнх гэмт хэрэгтнүүд баригдаж, широньд хоригддог. Эдгээр хүчин

чармайлт нь банк дээрэмдэх гэмт хэргийн гаралтыг бууруулдаг. Хэсэг хугацаанд буюу хэдэн жилийн туршид банкны дээрэм цөөн байсан тул банкны хамгаалалт сул болж, банк дээрэмдэх боломж нэмэгддэг. Дараа нь шинэ гэмт хэрэгтнүүд хамгаалалтын сул талыг ашиглаж, дээрэм хийх шинэ давлагааг эхлүүлдэг. Энэхүү таамаглалын хууль сахиулах арга хэмжээнээс илүүтэйгээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэмт хэргийн гаралт, тоо хэмжээнд илүү чухал нөлөөтэй болохыг батлахад анхаарал хандуулахад хүргэнэ.

Амжилтгүй, үр дүн муутай хууль сахиулах арга хэмжээний тодорхойлолтоор эхлэх асуудалд тулгуурласан үйл ажиллагааны төслийг унших нь нэлээд түгээмэл. Ямар ч үед хуучин гэмт хэрэгтэн гэмт хэргийн талбарт буцаж гарч ирэх, шинэ гэмт хэрэгтэн тэдний халааг авдаг. Шинэ хүмүүс гэмт хэрэг үйлдэх нөхцөл боломжийг ашиглах гурван үндсэн арга зам байна. Үүнд:

1. Өдөр тутмын амьдралын явцад хүмүүс хэрэг үйлдэх нөхцөл боломжийг ашиглаж мэддэг, хэрэг үйлдэж болзошгүй хүмүүсийн хараанд өртдөг. Тухайлбал, хотын төвд түгжээгүй машинаас эд зүйл хулгайлж байсан залуусыг цагдаа нар баривчилсан ч тухайн түгжээгүй машинууд тэнд үлддэг. Хотын төвөөр өдөр бүр зорчдог олон хүнээс цөөхөн хэд нь эдгээр машиныг анзаарч, хулгай хийх гэж оролдоно. Хэрэв амжилтад хүрвэл эдгээр хүмүүсийн зарим нь машинаас хулгай хийгээд амьдраад байж болох юм байна гэсэн ойлголттой болно.
2. Тэд найз нөхөд, танил хүмүүсийнхээ албан бус сүлжээгээр гэмт хэрэг үйлдэх боломжуудыг олж хардаг. Гэмт хэрэг, хэрэг зөрчил үйлдэх боломжийг ашиглаж байсан хүмүүс бусдыг урьж, тэдэнд туслах эсвэл туршлагаасаа хуваалцдаг. Бид бүх асуудлыг удаан хугацааны турш бүрэн шийдвэрлэхэд буюу 100 хувийн амжилтад хүрэх нь бараг боломжгүй тул шинэ хүмүүсийг хэрэг үйлдэх нөхцөл боломжуудтай танилцуулах хүмүүс олон байдаг.

- Тэд гэмт хэргийн бүлэглэлд элсэх замаар хэрэг үйлдэх боломжуудыг олж хардаг. Хэрвээ хуучны хулгайчид хулгайн эд зүйлсээ хүлээн авагч, зуучлагч хүмүүст зарж борлуулахгүй бол зуучлагч, хулгайн эд зүйл зардаг хүмүүс шинэ хулгайчидтай холбоо тогтоож эхэлнэ. Хэрэв биеэ үнэлэлтийг зохион байгуулсан бол зуучлагчид нь хуучин биеэ үнэлэгчид сүл үлдсэн ажлын байрыг нөхөхийн тулд шинэ биеэ үнэлэгч элсүүлж болно. Гэмт хэргийн бүлэглэлүүд хуучин гишүүдийнхээ оронд шинэ гишүүдийг элсүүлж магадгүй. Хар тамхины хэрэгт холбогдсон наасанд хүрэгчдэд оногдуулах шийтгэл ихээхэн хэмжээгээр нэмэгдвэл арай бага шийтгэлтэй наасанд хүрээгүй хүүхдүүдийг хөлслөн авч ажиллуулах учраас наасанд хүрээгүй хүүхдүүдийн үйлдэх гэмт хэрэг нэмэгдэнэ.

Гэмт этгээдүүд гарч ирж байгаа эсэхийг яаж мэдэх вэ? Хамгийн энгийн арга бол аливаа арга хэмжээ хэрэгжүүлэхээс өмнө асуудал, гэмт хэрэг зөрчилтэй холбоотой гэмт хэрэгтнүүдийн нэрсийг хариу арга хэмжээ хэрэглүүлсний дараах асуудал, гэмт хэрэгтэй холбоотой гэмт хэрэгтнүүдийн нэрстэй харьцуулах явдал юм.

Хэрэв нэrs зөрүүтэй бол шинэ гэмт хэрэг үйлдэгчид гарч ирсэн байх магадлал өндөр юм. Энэ арга барилын хүндрэлтэй тал нь

гэвэл гэмт хэрэгтнүүдийн бүрэн жагсаалтыг гаргах бараг боломжгүй. Тиймээс шинэ нэrs үнэхээр шинэ гэмт хэрэгтнүүд мөн үү, эсвэл удаан хугацаанд хэрэг үйлдэж, нуугдаж байж байгаад саяхан шинээр баригдсан эсэх нь тодорхойгүй байдаг.

Гэмт хэрэгтэнтэй ярилцлага хийх нь бас ашиг тустай байж болно. Гэмт этгээдүүд асуудалд хэзээ холбогдсон, хэрхэн холбогдсон, өөр хэн оролцсон талаар хэлж болно. Тэд мөн хэргийн шилжилт хөдөлгөөний арга тактикийн болон бусад хэлбэрийн талаар мэдээлэл өгөх боломжтой. Гэсэн хэдий ч гэмт хэрэгтнүүдэд хэт найдаж болохгүй, зарим тохиолдолд тэд хамтран ажиллах чадваргүй, найдваргүй байж болно (алхам 10).

Заримдаа гэмт хэрэг үйлдэхэд ашигласан аргуудыг нарийвчлан судлах нь шинээр гэмт хэрэг үйлдсэн эсэхийг ойлгох боломжийг олгодог. Хэрэв арга тактик нь урьд өмнө хэрэглэж байсан аргаас эрс ялгаатай болшинэ гэмт хэрэгтнүүд ажиллаж байх магадлалтай. Гэхдээ хуучин гэмт хэрэгтнүүд арга тактикаа солих магадлалыг бас үгүйсгэхгүй.

#### **Нэмэлт материал:**

Matthews, Roger. 1997. "Developing More Effective Strategies for Curbing Prostitution." Situational Crime Prevention: Successful Case Studies, 2nd edition, edited by Ronald Clarke. Monsey (New York): Criminal Justice Press.

## Цагдаагийн тусгай ажиллагааг орчны өөрчлөлттэй уялдуулан холбох нь: Финсбери паркт биеэ үнэлэгчдийг хянах нь

Рожер Мэттьюс нь Лондон хотын Финсбери Парк хороололд биеэ үнэлэлтийн асуудлыг судалсан. Хэдэн жилийн хугацаанд цагдаагийн олон удаагийн тусгай ажиллагаа хэрэгжүүлсэн боловч бие үнэлэгчдийг бүрэн хяналтдаа авч чадаагүй, хэсэг хугацааны дараа биеэ үнэлэгчид дахин гарч ирсэн. Иймээс Эрчүүд машинаараа тэр хавиар явж биеэ үнэлэгчидтэй уулзах, авахад хүндрэлтэй байдал үүсгэхийн тулд цагдаагийн тусгай ажиллагааны зэрэгцээ гудамжны хаалт, хашлагуудыг давхар хэрэглэсний үр дүнд биеэ үнэлдэг хүмүүсийн тоо эрс буурсан байна. Мэтьюсийн хэлснээр энэ нь гэмт хэрэгтнийг албадан холдуулах, гудамжны саад хаалтаар хязгаарлах, хаах боломжийг хослуулсан арга хэмжээ нь хэргийн бууралтад нөлөөлсөн. Эдгээр нөлөөллийн арга хэмжээнүүд амжилттай хэрэгжсэн нэг чухал шалтгаан нь биеэ үнэлэгчид ийм орлого олох аргад төдийлөн ханддаггүй болсонтой холбоотой. Тэдний цөөхөн хувь нь үйлдэлдээ донтсон эсвэл зуучлагчдын эрхшээлд орсонтой холбоотой.

Бодит байдалд биеэ үнэлэгчээр ажиллах хамгийн нийтлэг шалтгаан нь тэд бусад төрлийнажилтайхарьцуулахадамархялбар аргаар илүү их мөнгө олох боломжтой, цаг хугацаанд баригдахгүй, бие даасан байдалдаа дуртай, янз бүрийн эрчүүдтэй уулзах, зугаа цэнгэлд дуртай байдагтай холбоотой. Бие үнэлэгчдийн олонх нь Финсбери Парк руу алс холын нутгаас галт тэргээр ирсэн хүмүүс юм. Тэд бусад эмэгтэйчүүдийн хамт энэ хавийн олон дотуур байр, зочид буудлуудын аль нэгэнд өрөө хөлсөлж, эсвэл үйлчлүүлэгчдийн машинд бизнесээ үйлддэг. Биеэ үнэлэгчээр ажиллаагүй үедээ тэдний олонх нь баарны үйлчлэгч, бужигчин, тайчигч, дэлгүүрийн худалдагчаар ажилладаг байв. Биеэ үнэлэгч тэдний харьцангуй хөнгөн аргаар мөнгө олох сонирхол нь Финсбери Паркийн биеэ үнэлэгчдийг Лондоны ойролцоо бусад газар руу шилжсэн тухай багахан нотолгоог яагаад олж мэдсэнийг тайлбарлахад тусална.

Эх сурвалж: Shearing, Clifford, and Phillip Stenning. 1997. "From the Panopticon to Disney World: The Development of Discipline." In *Situational Crime Prevention: Successful Case Studies*, 2nd edition, edited by Ronald V. Clarke. Guilderland (New York): Harrow and Heston.

# 51. Санамсаргүй, гэнэтийн эерэг нөлөөлөлд сэрэмжтэй хандах

**X**эрэв та ашиг, нөлөөллийн тархалтыг тооцохгүй бол та нөлөөллийн арга хэмжээний үр дүнг дутуугаар үнэлэх болно (алхам 13). Та аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь ашигтай биш эсвэл асуудлыг шийдвэрлэж чадаагүй гэж дүгнэж болно. Энэ нөлөө ялангуяа тархалт таны хяналтын бүлэгт нөлөөлөх (бохирдуулах) үед үүснэ.


Хяналтын бүлэг нь арга хэмжээ авахгүй байх тохиолдолд зөрчил, асуудал хэрхэх байнсныг харуулдаг (алхам 47). Хяналтын бүлгүүд нь хариу арга хэмжээний бүлэгтэй аль болох адил, төстэй байх нь зохистой боловч тус арга хэмжээ хяналтын бүлэгт нөлөөлөх ёсгүй. Хэрэв урьдчилан сэргийлэх арга хэмжээний нөлөө хяналтын бүлэгт тархвал нөхцөл байдал тухайн арга хэмжээний улмаас дордсон байна гэх буруу дүгнэлтэд хүрнэ. Энэхүү буруу дүгнэлт нь таны арга хэмжээний үр нөлөөг дутуу үнэлэхэд хүргэнэ (шилжилттэй холбоотой асуудлыг 48 дугаар алхмаас үзнэ үү.)

Шилжилт хөдөлгөөн эсвэл нөлөөллийн тархалт бий болох боломжтой үед хяналтын газрыг сонгох талаар Кейт Бауэрс, Шэйн Жонсон нар хоёр арга санал болгосон билээ. Эхнийх нь арга хэмжээ авсан газрын эргэн тойронд хоёр төвлөрсөн бүс бий болгох явдал юм. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь зэргэлдээх хамгаалалтын бүсэд тархаж болох боловч гадуурх хяналтын бүсэд нөлөөлөхгүй. Хяналтын болон арга хэмжээ авсан газрууд нь маш төстэй бөгөөд тархалт эсвэл шилжилт нь хяналтын талбайд нөлөөлөхгүй бол энэ нь боломжтой юм. Хэрэв эдгээр нөхцөл хангагдахгүй бол 2 дугаар аргыг ашиглана. Энд шилжилт хөдөлгөөн, тархалтын нөлөөлөлд өртөмтгийн газар нь арга хэмжээ авсан газартай ойролцоо, хяналтын газар нь харин арга хэмжээ авсан газраас хол бөгөөд шилжилт хөдөлгөөн, тархалтын нөлөөлөлд өртөхөөргүй, тусгаарлагдсан байх шаардлагатай. Хяналтыг урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлсэн газартай ижил төстэй боловч тархалт, шилжилт хөдөлгөөний нөлөөнд өртөхөөргүй байдлыг нь харгалzan сонгоно. Олон хяналтын газруудыг сонгож,

тэдгээрийн гэмт хэргийн дунджийг тооцож болно.

Зурагт 2 дугаар аргын жишээг үзүүлэв. Хойд Каролина мужийн Шарлотт хотын төвд байрлах автомашины зогсоолууд дахь машин доторх эд зүйлсийг хулгайлах хэмт хэрэгт авах хариу арга хэмжээг төсөөлнө үү (алхам 27). Хариу арга хэмжээ авахын тулд гэмт хэргийн төвлөрөл өндөр бүхий газрыг сонгосон. Хөрш зэргэлдээх ийм газрууд нь тохиромжтой тархалт/шилжилтийн газрууд юм. Өмнөх дүн шинжилгээнээс үзэхэд эдгээр зогсоолуудаар дайран өнгөрөх төмөр замууд нь асуудал, гэмт хэргийг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байдаг. Иймээс энэхүү төмөр замын зүүн ба баруун хэсэг дэх гурав дахь хэргийн төвлөрөл өндөр бүхий цэгийг тархалт/шилжилт хөдөлгөөнд өртөмтгийн газраар сонгож болох юм. Хяналтын газар нь төмөр замын шугам дээр биш бөгөөд гэмт хэргийн шилжилт явагдах магадлал багатай, хариу арга хэмжээ авах газраас хангалттай хол зайд байрлаж буй юм.

**Хяналт, нөлөөллийн тархалт, шилжилтийн талбайг сонгох нь- 1999 он, Хойд Каролина муж, Шарлотт хот**



Хариу арга хэмжээний ерөнхий нөлөөг (ямар нэгэн тархалт, нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөг оруулаад) тодорхойлохын тулд та дөрвөн асуултад хариулах хэрэгтэй. Асуулт бүр энгийн томьёотой байдаг. Томьёон дахь үсгүүд дараах хэв маягийг дагаж мөрддөг.

- R: хариу арга хэмжээ авах газрын гэмт хэргийн тоо буюу хувь хэмжээ юм.
- D: гэмт хэргийн шилжилт/тархалтын бус дэх гэмт хэргийн тоо буюу хувь хэмжээ юм.
- С: нь хяналтын бус дэх гэмт хэргийн тоо буюу хувь хэмжээ юм.
- a, b: эдгээр дэд тэмдэгтүүд гэмт хэрэг хэзээ тоологддогийг, хариу арга хэмжээ эхэлснээс хойш эсвэл өмнө болохыг заадаг. Жишээлбэл,  $R_a$  нь хариу арга хэмжээ хэрэгжиж эхлэхээс өмнө хариу арга хэмжээ авах бусэд гарсан гэмт хэргийн түвшин,  $C_b$  нь хариу арга хэмжээ хэрэгжсэнээс хойших хяналтын бусэд гарсан гэмт хэргийн хувь хэмжээг илэрхийлнэ.

- Хариу арга хэмжээний өмнөх үеэс дараах үе хүртэл хэрэг зөрчил, асуудал өөрчлөгдсөн үү?** Нийт ерөнхий нөлөөллийг тооцохын тулд Хариу арга хэмжээний өмнөх үеэс дараах үе хүртэлх хугацаанд арга хэмжээ, нөлөөллийн талбарт гарсан гэмт хэргийг хасна (GE).

$$GE = R_b - R_a$$

Эрэг утга нь зөрчил, асуудал буурч байгааг илтгэнэ. Тэг нь өөрчлөлт байхгүй болохыг илтгэнэ. Сөрөг тоо нь байдал улам дорсонаиг илтгэнэ.

- Хариу арга хэмжээ нь өөрчлөлтийн боломжит шалтгаан болсон уу?** Бауэрс, Жонсон нар арга хэмжээ, нөлөөллийн талбарын хяналтын талбайн өмнөх болон дараагийн харьцааны зөрүүг судлахыг санал болгосон. Өөрөөр хэлбэл, хариу арга хэмжээний өмнөх утгыг хариу арга хэмжээний өмнөх хяналтын бүлэгт хуваана. Мөн хариу арга хэмжээний дараах утгыг хариу арга хэмжээний дараах хяналтын бүлэгт хуваана. Гарсан утгуудыг ялгаврыг олно. Энэ бол цэвэр нөлөө (NE):

$$NE = \frac{R_b}{C_b} - \frac{R_a}{C_a}$$

Хэрэв цэвэр нөлөө 0-тэй ойролцоо байвал хариу нь үр дүнгүй болохыг илтгэх бөгөөд хэрэв NE сөрөг байвал нөхцөл байдлыг улам дордуулсан болохыг илтгэнэ. Аль ч тохиолдолд шилжилт ба тархалт нь хамааралгүй тул та энэ асуултын хариултыг цааш үргэлжлүүлэхгүй зогсоож болно. Гэвч хэрэв NE ээрэг байвал хариу нь сайжрахад хүргэсэн гэж үзэх үндэслэл бий. Энэ нь тархалт ба шилжилтийн боломжийг нэмэгдүүлдэг. Тиймээс та дараагийн асуултад хариулах хэрэгтэй.

- Шилжилт эсвэл тархалтын харьцангуй хэмжээ хэд вэ?** Бауэрс, Жонсон нар үүнийг хэмжихийн тулд жигнэсэн шилжилтийн коэффициентыг (WDQ) санал болгож байна.

$$WDQ = \frac{\frac{D_a}{C_a} - \frac{D_b}{C_b}}{\frac{R_a}{C_a} - \frac{R_b}{C_b}}$$

$D_a$  нь хөтөлбөр хэрэгжсэний дараах тархалт/шилжилтийн бус дэх гэмт хэргийн түвшин,  $D_b$  нь хөтөлбөрөөс өмнөх энэ бусэд гарсан гэмт хэргийн түвшин юм. Томьёоны хуваарийн доод талын нэр томьёо (деноминатор) нь хяналттай харьцуулахад хариу арга хэмжээний үр дүнгийн хэмжигдэхүүн юм. Үр дүнтэй хөтөлбөр нь хуваарыт (denominator\*) сөрөг тоог гаргах болно. Томьёоны хуваарийн дээд нэр томьёо (тоологч) нь тархалт эсвэл шилжилтийн харьцангуй хэмжээг харуулдаг. Тархалт байгаа үед тоологч сөрөг, шилжилт байгаа үед ээрэг байна. Хэрэв энэ нь тэгтэй ойролцоо байвал тархалт ба шилжилтийн аль нь ч байхгүй бөгөөд WDQ нь тэг байна (ингэснээр та 4-р асуултыг алгасаж болно). Хэрэв WDQ ээрэг байвал тархалт байгааг илтгэнэ (хоёр сөрөг тооны харьцаа ээрэг байна гэдгийг санаарай), хэрэв энэ нь нэгээс их байвал тархалтын нөлөө нь хариу арга хэмжээний нөлөөллөөс их байна. Хэрэв WDQ сөрөг байвал шилжилт байна. WDQ нь тэг мөн сөрөг нэгийн хооронд байх үед шилжилт нь хариу үйлдэл үзүүлэх

нөлөөг бүгдийг биш ч заримыг нь үр дүнгүй болгоно. Онолын хувьд, WDO нь сөрөг үзүүлэлтээс бага байж болох бөгөөд энэ нь хариу үйлдэл нь байдлыг улам дордуулж байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч энэ нь магадлал багатай тохиолдол гэдгийг судалгаа харуулж байна.

- Хариу арга хэмжээний нийт цэвэр нөлөө (тархалт ба шилжилтийг оруулаад) ямар байна вэ?** Бауэрс, Жонсон нар TNE-ийг тооцоолоходоо дараах томьёог ашиглахыг санал болгосон.

$$TNE = \begin{bmatrix} C_a \\ R_b & -R_a \\ C_b \end{bmatrix} + \begin{bmatrix} C_a \\ D_b & -D_a \\ C_b \end{bmatrix}$$

Эхний хэсэг нь хариу үйлдлийн талбарт хариу үйлдлийн нөлөөг харуулдаг. Арга хэмжээ илүү үр дүнтэй байх тусам энэ нэр томьёо илүү их утгатай. Хоёр дахь хэсэг нь тархалт эсвэл шилжилтийн түвшнийг харуулдаг. Энэ нь тархалттай үед зэрэг, шилжилттэй үед сөрөг байх болно. TNE зэрэг байх тусам хариу үйлдэл нь илүү үр дүнтэй байдаг.

#### Нэмэлт материал:

Bowers, Kate, and Shane Johnson. 2003. "Measuring the Geographical Displacement and Diffusion of Benefit Effects of Crime Prevention Activity." *Journal of Quantitative Criminology* 19(3):275–301.

## 52. Гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө цуцлагдсан, орхигдсон эсэхийг төсөөлөх

Гэмт хэрэгтэн гэмт үйлдлээ эхлэхээс өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээг бодитоор хэрэгжүүлсэн гэж боддог. Энэ нь урьдчилан сэргийлэх "урьдчилсан таамаглалын ач холбогдол" гэж нэрлэгддэг үр дүнд хүргэдэг. Эдгээр урьдчилсан таамагласан ач холбогдол нь санамсаргүйгээр тохиолдож болох ч цагдаа нар үүнийг бий болгох эсвэл эрчимжүүлэхийн тулд зориуд хүчин чармайлт гаргаж чадна. Үүнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд цагдаа нар гэмт хэрэгтнүүд нөхцөл байдлыг хэрхэн хүлээн авч байгаа талаар тодорхой ойлголттой байх ёстой бөгөөд хөндлөнгийн оролцоо, ажиллагаа, нөлөөллийн жинхэнэ нууц, шинж чанарын талаар гэмт этгээдийг хууран мэхлэх аргуудтай байх хэрэгтэй.

Марта Смит болон түүний хамтрагчид нөхцөл, шалтгааныг арилгах замаар урьдчилан сэргийлэх арга хэмжээний судалгааны 40-с дээш хувьд урьдчилсан таамаглалын ач холбогдлын нөлөөлсөн гэж үзсэн. Тэд урьдчилсан таамаглалын ач холбогдлын талаар зургаан боломжит тайлбарыг дэвшүүлсэн. Үүнд:

- Бэлтгэл-хүлээлтийн үр нөлөө:** хөтөлбөр бодитоор хэрэгжиж эхлэхээс өмнө хөтөлбөр ажиллаж эхэлсэн гэж гэмт хэрэгтнүүд итгэх үед бэлтгэл-хүлээлтийн нөлөө бодитоор тохиолддог. Тухайлбал өмч хөрөнгийн тэмдэглэгээний хөтөлбөрийг олон нийтэд зарласан боловч оршин суугчдыг хүчээр шаардаагүй, дайчлаагүй үед мөн хяналтын камер суурилуулсан ч хараахан хяналт эхлээгүй байж болно.
- Сурталчилгаа/ташаа мэдээлэл тараах:** сурталчилгаа, сенсацийн улмаас нууц ажиллагаа, хууль сахиулах арга хэмжээ явагдаж эхэлсэн гэж гэмт этгээдүүд итгэх үед сурталчилгаа, цуу яриа үр дүнгээ өгнө. Хуурамч худал мэдээллээр дамжуулан гэмт этгээдүүдийн ойлголтыг богино хугацаанд өөрчилж болно. Зарим тохиолдолд худал, ташаа мэдээлэл тараахаас илүүтэй зорилтот бүлэгт

төвлөрөн мэдээлэл тараах нь илүү үр дүнтэй байдаг. Залуучуудын хүн амины хэргийг бууруулах Бостоны нэгэн төсөл нь тодорхой нэг зан төлөв, үйл хөдлөл нь цагдаагийн тусгай ажиллагааг авч хэрэгжүүлэх үндэслэл болно гэх мэдээллийг хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдэд шууд хүргүүлсэн.

- Бэлтгэл ба тасалдлын нөлөө:** Урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн бэлтгэл тухайн газрын хяналт, тандалт хийхэд хүргэдэг нь уг нөлөөг үүсгэдэг. Оршин суугчдын судалгаа нь гэмт хэрэгтнүүдийг сэргэжилүүлж, болгоомжтой байхад хүргэж магадгүй. Хэрэв олон нийтийн дунд нүдэнд үзэгдэхүйц байдлаар лавлагаа, баримт авах тохиолдолд асуудал тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны дүн шинжилгээний үе шатанд "урьдчилсан таамаглалын ач хобогдол"-ын нөлөөг үүсгэх боломжтой. 1980-аад оны сүүлчээр орон байрны хулгайн гэмт хэргийн дүн шинжилгээний нэг хэсэг болох Ньюпорт Ньюос (Виржиниа)-ийн цагдаагийн газрын ажилчид хулгай ихтэй хороололд хаалганаас хаалганы хооронд судалгаа явуулжээ. Энэхүү судалгаа нь судалгааны дараах хэсэг хугацаанд хулгайн гэмт хэрэг буурахад нөлөөлсөн байж магадгүй юм. Шерман, Экк нар цагдаагийн үйл ажиллагааны үр дүнтэй байдлын үнэлгээндээ хаалганаас хаалганд судалгаа хийх нь гэмт хэрэг буурахад нөлөөлсөн болохыг тэмдэглэжээ.
- Алгуур, аажим хэрэгжилт:** хариу арга хэмжээний тодорхой хэсгүүдийг хариу арга арга хэмжээг бодитоор эхлүүлэхээс өмнө нэвтрүүлэхийг алгуур, аажим хэрэгжилт гэж нэрлэнэ. Үнэлгээ хийгч б дугаар сарын 1-ний өдрийг хөтөлбөрийг бүрэн нэвтрүүлэх өдрөөр тогтоосон байж болох ч гэмт хэрэгтнүүд тус арга хэмжээний талаар олж мэдэж б дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд үйл хөдлөлөө өөрчилж болно.

5. **Бэлтгэл-сургалтын үр нөлөө.** Төлөвлөлт, сургалт, судалгаа нь олон нийт эсвэл цагдаа нарыг асуудлыг шийдвэрлэх төсөлд бэлтгэх зорилготой бөгөөд уул бэлтгэлтээр оржавсан мэдлэгээ хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнө ашиглах үед бэлтгэл-сургалтын үр нөлөө бодитоор тохиолдоно. Жишээлбэл, олон бизнесийн байгууллагуудыг хамруулсан, дэлгүүрийн хulgайн эсрэг хөтөлбөрийг тодорхой өдөр эхлүүлэхээр төлөвлөж болох ч ажилчдын хэлэлцүүлэг, сургалт нь энэ өдрөөс өмнө ажилчдыг илүү анхааралтай, сонор сэргэмжтэй (ажилчид дотооддоо хулгай хийхгүй байхад хүргэдэг) болгодог.
6. **Офицерууд болон олон нийтийн сэдэл:** бэлтгэл сургуулиттai адил шалтгааны улмаас тохиолддог бөгөөд мэдлэгтэй болсноос илүүтэй гэмт хэрэг шийдвэрлэх сэдэл нь нэмэгдсэн байдаг. Өндөр сэдэл нь хариу арга хэмжээг хэрэгжүүлэхээс өмнө үйл ажиллагааг сайжруулахад хүргэдэг.

Хариу арга хэмжээний цаглаврыг зурж, түүнд үндэслэн урьдчилсан таамаглалын нөлөөлөл байгаа эсэхийг үнэлж болно (46 дугаар алхмыг үзнэ үү).

Смит болон түүний хамтрагчид буруу тооцоолол, дүн шинжилгээний улмаас урьдчилсан таамаглалын нөлөөлөл мэт харагддаг дөрвөн нөхцөл байдлыг тодорхойлсон байдаг. Үүнд:

- Гэмт хэргийн улирлын чанартай бууралтаас хойш удалгүй урьдчилан сэргийлэх арга хэмжээ эхэлсэн үед улирлын өөрчлөлт нь худал урьдчилсан таамаглалын нөлөөг бий болгодог. Улирлын шинж чанарыг хянах нь (26 ба 47 дугаар алхам) энэхүү бэрхшээл, асуудлыг арилгаж болно.
- Регрессийн нөлөө гэдэг нь ямар ч арга хэмжээ авч хэрэгжүүлэгүй үед гэмт хэргийн онцгой өсөлтөөс доош гэмт хэрэг өөрийн жамаар буурахыг хэлнэ (алхам 47). Хэрэв урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжих болон регрессийн нөлөөгөөр гэмт хэргийн тоо буурсан бол өөрөө буух бууралт нь урьдчилсан нөлөөлөл мэт харагдана. 47 дугаар алхамд санал

болгосны дагуу хариу арга хэмжээ авахаас өмнө урт хугацааны дундаж гэмт хэргийн түвшнийг (26 дугаар алхам) судалж үзэхэд урьдчилсан нөлөөлөл мэт харагдах регрессийн нөлөө илрэч болно.

- Хэрэв өөр гэмт хэргүүдийн ангиллыг өөрчилж (A) төрлийн гэмт хэрэг хэт ихээр бүртгэгдсэн бол урьдчилсан таамаглалын нөлөөлөл шиг харагдах боломжтой. Энэ нь тодорхой нэг төрлийн гэмт хэргийг үйлдэх зорилгоор мөнгө олохын тулд өөр нэг төрлийн гэмт хэргийг хөөрөгдөж, улмаар мөнгө олсны дараа тухайн төрлийн гэмт хэргүүд буцаад хуучин хэвэндээ орсон үед тохиолдож болно. Бусад гэмт хэргийн эсрэг чиг хандлагуудыг судлах замаар Энэхүү хуурамч урьдчилсан таамаглалын нөлөөллийг ажигласнаар илрүүлж болно. Эсрэг чиг хандлагатай ижил төстэй хоёр гэмт хэргийг олж илрүүлэх нь ангиллын өөрчлөлттэй холбоотой нөхцөл байдлыг илрүүлэхэд тусална.
- Санамсаргүй өөрчлөлтөөр далдлагдсан чиг хандлагыг илрүүлэхийн тулд өгөгдлийг тэгшлэх, жигдруүлэх (алхам 26) нь урьдчилсан таамаглалын нөлөө мэт харагдах үр дүнг бий болгож чадна. Хөдөлгөөнт дундаж (жишээ нь гурваас илүү таван үе) хэдий чинээ өргөн, хөндлөнгийн оролцооны дараа гэмт хэргийн тоо илүү их, огцом буурах тусам тэгшлэх, жигдруүлэх нь хуурамч урьдчилсан нөлөөг бий болгох магадлалтай. Тэнцвэржүүлээгүй болон жигдруүлээгүй өгөгдлийг харьцуулах нь энэхүү хуурамч урьдчилсан нөлөөллийг илрүүлэх болно.

#### Нэмэлт материал:

Sherman, Lawrence, and John Eck. 2002. "Policing for Crime Prevention." In Evidence-Based Crime Prevention, edited by Lawrence Sherman, et al., 295–329. New York: Routledge.

Smith, Martha, et al. 2002. "Anticipatory Benefits in Crime Prevention." In Analysis for Crime Prevention, edited by Nick Tilley. Vol. 13 of Crime Prevention Studies. Monsey (New York): Criminal Justice Press. [Http://www.popcenter.org/library/crimeprevention/volume\\_13/](http://www.popcenter.org/library/crimeprevention/volume_13/).

## Мэдээлэл, сурталчилгааны урьдчилсан нөлөөлөл

Пол Барклай болон түүний хамтрагчид Бритиш Колумбын Ванкувер хотын гаднах томоохон авто зогсоолоос автомашин хулгайд алдагдах гэмт хэрэгт дугуйт эргүүл ажиллуулахад гарах нөлөөллийг үнэлсэн. Хариу арга хэмжээ авсны дараа машины хулгай буурсан боловч дугуйн эргүүл хийхээс өмнөх сурталчилгааны кампанит ажил хэрэгжсэнээс хойш хэдэн долоо хоногийн өмнөөс эхлэн машины хулгайн хэрэг буурч эхэлжээ. Энэ тохиолдолд цагдаагийн эргүүл, хамгаалалтын тухай сурталчилгааны ажлын урьдчилсан нөлөө нь (цагдаагийн эргүүл эхлэхээс өмнөх нөлөөлөл) эргүүлийн ерөнхий үр нөлөөг ихээхэн нэмэгдүүлсэн байж болох юм. Санамсаргүй хэлбэлзлийг арилгахын тулд хөдөлж буй дундаж утгыг ашигласан боловч сурталчилгааны эхэн үеэс дугуйт эргүүлийн эхэн үеийн хоорондох хугацаанд машины хулгайн бууралт нь өгөгдлийг жигдрүүлсэнтэй холбоотой хэт их бууралт гарч ирсэн.



Эх сурвалж: Barclay, Paul, et al. 1996. "Preventing Auto Theft in Suburban Vancouver Commuter Lots: Effects of a Bike Patrol." In *Preventing Mass Transit Crime*, edited by Ronald V. Clarke. Vol. 6 of *Crime Prevention Studies*. Monsey (New York): Criminal Justice Press. [http://www.popcenter.org/library/crimeprevention/volume\\_06/](http://www.popcenter.org/library/crimeprevention/volume_06/).




**X**ариу арга хэмжээ нь асуудал буурахад нөлөөлсөн гэдгийг та яаж мэдэх вэ? Ямар ч арга хэмжээ аваагүй үед ихэнх асуудлууд эрчмээрээ харилцан адилгүй байдаг. Жишээлбэл нэг хотын төвд долоо хоногт дунджаар 32 тээврийн хэрэгсэл хулгайд алдагддаг ч долоо хоногт тогтмол 32 хулгайн хэрэг гарах нь ховор. Үүний оронд долоо хоногийн 95 хувьд нь 25-38 хулгай, 5 хувьд нь 25-аас бага буюу 38-аас дээш хулгай бүртгэгдсэн байна. Ийм санамсаргүй өөрчлөлт нь түгээмэл тохиолддог. Тээврийн хэрэгслийн хулгайн гэмт хэрэг долоо хоногт дунджаар 32-оос 24 болж буурсан нь хариу арга хэмжээ гэхээсээ илүү санамсаргүй байдлаас үүдэлтэй байж болох юм. Санамсаргүй байдлыг маш олон тооны жижиг нөлөөллөөс үүдэлтэй гэмт хэргийн урьдчилан таамаглах боломжгүй хэлбэлзэл гэж ойлгоорой, тиймээс цагдаа нар юу ч хийгээгүй байсан ч гэмт хэрэг өөрийн жамаар өөрчлөгдсөөр байдаг.

Ачхолбогдлын сорил нь гэмт хэргийн өөрчлөлт санамсаргүй үйлдлээс үүдэлтэй эсэхийг бидэнд тодруулдаг. Мэдээж чухал ялгаа нь санамсаргүй байдлаас шалтгаалж өндөр үр дүн гарах магадлал багатай. Их хэмжээний зөрүү бүхий ач холбогдлыг олохоос илүү бага зөрүү ач холбогдолтой эсэхийг ялгахад хэцүү байдаг. Хэдийгээр хариу арга хэмжээ үр дүнтэй байсан ч ердийн тогтвортгуй гэмт хэргийн асуудалд мэдэгдэхүйц ялгааг олоход хэцүү. Хэрэв та цөөн хэдэн тохиолдлыг (хүмүүс, газар, үйл явдал, цаг хугацаа) харж байгаа бол олон тохиолдол (хариулт үр дүнтэй байсан ч гэсэн) хархаас илүү ач холбогдлыг олоход хэцүү. Та зөрүү, ялгааны хэмжээ, асуудлыг өөрчлөгднөн хувьсамтгай байдлыг хянах боломжгүй боловч илүү олон тохиолдлын талаар мэдээлэл цуглуулах боломжтой.

Дараах нийтлэг нөхцөл байдлыг авч үзье. Та хариу арга хэмжээ авсны дараа тухайн талбарт гэмт хэрэг буурсан эсэхийг тодорхойлохыг хүсэж байна гэж төсөөльье. Танд хариу арга хэмжээ авахаас өмнө хэдэн долоо хоногийн гэмт хэргийн мэдээлэл, хариу

арга хэмжээ авсны дараах тухайн бус нутгийн хэдэн долоо хоногийн мэдээлэл байна. Та долоо хоног бүрийн дундаж (дундаж) гэмт хэргийн тоог тооцоолж, гэмт хэрэг буурсан болохыг олж харна.

Зураг нь гурван боломжит үр дүнг харуулж байна. Хүснэгт бүрт хоёр хуваарилалт байна. Нэг нь хариу арга хэмжээ авахын өмнөх хэдэн долоо хоногийн хугацаа, нөгөө нь хариу арга хэмжээ авсны дараах хэдэн долоо хоногийн хугацаанд хамаарна. График тус бүрийн босоо зураас нь 0, 1, 2 ба түүнээс дээш гэмт хэрэг үйлдсэн долоо хоногуудын эзлэх хувийг харуулдаг (жишээлбэл, дээд хүснэгтэд хариу үйлдэл үзүүлснээс хойших долоо хоногийн 20 хувьд 6 гэмт хэрэг гарсан). А хэсэгт хуваарилалт бараг давхацсан, учир нь дунджаар илэрхийлсэн зөрүү, ялгаа их, мөн хоёр бүлгийн стандарт хазайлт бага байна (22 дугаар алхмыг үзнэ үү). Хэдэн долоо хоногийн өгөгдлөлтэй байсан ч ач холбогдлын сорил нь санамсаргүй байдлын шалтгааныг үгүйсгэж чадна. В хэсэгт хуваарилалтад давхцал ихтэй, дунджаар тооцсон зөрүү бага, стандарт хазайлт их байна. Иймэрхүү тохиолдлуудын санамсаргүй бус ялгааг илрүүлэхийн тулд өөр олон өгөгдөл, тохиолдол шаардагдана. С хэсэгт бараг л бүрэн давхцал ажиглагдсан, дундаж зөрүү мөн адил бага, стандарт хазайлт нь мөн адил их байна. Зөвхөн маш олон тохиолдол бүхий кейс судалгааны үр дүнд ач холбогдол бүхий мэдэгдэхүйц ялгааг тооцох боломжтой. Гэмт хэргийн ялгаа, зөрүү бага байх тусам энэ нь санамсаргүй байдлаас шалтгаалаагүйг тогтоох хэрэгтэй юм.



Энэхүү баримт бичгийг хөрвүүлэх явцад гарсан зөрүүтэй ойлголтод зохиогчид хариуцлага хулээхгүй болно.

Магадлалын онол нь ялгааны шалтгаан нь санамсаргүй байдлаас шалтгаалаагүй магадлалыг тооцохын тулд дундаж, стандарт хазайлт, тохиолдлын тоог ашиглах боломжийг олгодог. Хэрэв асуудлын өөрчлөлт нь санамсаргүй хэлбэлзлээс болсон байх магадлал 5 хувиас бага байвал бид өөрчлөлтийн шалтгаан болох санамсаргүй байдлын тайлбарыг үгүйсгэж байна. Үүнийг 5 хувийн ач холбогдлын түвшин гэж нэрлэдэг. Товчондоо, санамсаргүй байдлаас үүдэлтэй байх магадлал нь ач холбогдлын түвшнээс доогуур (5 хувь) учир санамсаргүй байдлаас өөр зүйл өөрчлөлтийг нөхцөлдүүлсэн гэдэгт бид тооцсон. Хэдийгээр 5 хувь нь ердийн ач холбогдлын түвшин боловч та 1 хувь гэх мэт илүү хатуу түвшнийг сонгож болно. Таны сонгосон ач холбогдлын түвшин хэдий чинээ хатуу байх тусам хариу үйлдэл нь үр дүнгүй байсан гэж буруу дүгнэх магадлал төдий чинээ их байх болно. Энэ төрлийн алдааг "хуурамч сөрөг" гэж нэрлэдэг (37-р алхмыг үзнэ үү). Хэрэв хариу арга хэмжээний өртөг зардал маш өндөр тул чухал ач холбогдлын түвшнийг сонгож болно.

Заримдаа шинжээчид 10 хувь гэх мэт бага зэргийн ач холбогдлын түвшнийг ашигладаг. Таны сонгосон түвшин бага байх тусам ямар ч өнөө үзүүлэхгүй хариу арга хэмжээг буруугаар батлах өндөр магадлалтай. Энэ төрлийн алдааг "худал эерэг" гэж нэрлэдэг (37-р алхмыг үзнэ үү). Хэрэв асуудал ноцтой, асуудлын арга хэмжээ тийм ч сайн биш, сайн хариу арга хэмжээ хэрэгжүүлэхээс санамсаргүйгээр татгалзаж байгаад санаа зовж байгаа бол та арай бага түвшнийг сонгохыг хүсч болно.

Ач холбогдлын түвшнийг ашиглах хоёр арга бий. Дээрх хэлэлцүүлэгт бид тэдгээрийг татгалзлын босгоболгон ашигласан: энэ босго түвшнээс доош санамсаргүй тохиолдоос татгалзаж, босго түвшнээс дээш түвшинд та үүнийг шалтгаан гэж хүлээн зөвшөөрдөг. Хүссэн үр дүндээ хүрэхийн тулд тоон үзүүлэлтэд цаг хугацаа үрэхээс зайлсхийхийн тулд ач холбогдлын сорил хийхээсээ өмнө үргэлж ач холбогдлын түвшнийг сонгох хэрэгтэй.

Мэдээлэлд сууриссан сонголт хийхийн тулд ач холбогдлын түвшнийг бусад баримтуудын (асуудлын ноцтой байдал, хөтөлбөрийн

зардал, асуудлын үнэмлэхүй бууралт гэх мэт) хамтаар шийдвэр гаргахад туслах хэрэгсэл болгон ашиглах нь зүйтэй. Анааах ухаан зэрэг шинжлэх ухааны олон салбарт энэ аргыг баримталдаг. Хэрэв та энэ аргыг дагаж мөрдвэл ач холбогдлын сорилын оронд р-утгыг ашиглаарай. Р-утга нь асуудлын өөрчлөлт нь тохиолдоос үүдэлтэй байх өндөр магадлал юм. Тиймээс 0.062 гэсэн р-утга нь хариултыг хүлээн авснаар худал эерэг алдаа гаргах магадлал б орчим хувьтай байгааг харуулж байна. Үүнийг ойролцоогоор 100 ийм шийдвэрт хариу арга хэмжээний талд санамсаргүй байдлаас татгалзах шийдвэр нь б дахин буруу байх болно гэсэн үг юм. Та эсвэл танай хамт олон ийм бооцоо тавих эсэх нь олон зүйлээс хамааралтай.

Чухал ач холбогдолтой, утга учиртай гэдгийг ялгах нь чухал. Ач холбогдол нь санамсаргүй тохиолдлын улмаас ялгаа гарах магадлал багатай гэсэн үг юм. Утгатай гэдэг нь зөрүү, ялгаа нь хангалттай том байна гэсэн үг. Хангалттай тохиолдуудад маш бага ялгаа ч гэсэн мэдэгдэхүйц юм. Гэхдээ энэ нь ач холбогдолтой, үнэ цэнтэй гэсэн үг биш юм. Ач холбогдлыг тооцоолж болно. Утга учиртай гэж дүгнэх эсэх нь шинжээчийн дүгнэлтээс шалтгаална.

Санамсаргүй байдлын судалгаа нь маш нарийн нийлмэл байж болно, учир нь маш олон янзын нөхцөл байдалд маш олон төрлийн ач холбогдлын сорил хэрэглэдэг. Тэдгээрийн дотроос аль нь танд хэрэгтэй болохыг сонгоход туслах цахим сайтууд, мөн ном, материалыуд байдаг бөгөөд шаардлагатай тооцоолол хийхэд зориулсан статистикийн олон программууд байдаг. Гэхдээ хэрэв ач холбогдлын сорил, тестийн үр дүн эсвэл р-утга их, та магадлалын онол, статистикийн талаар сайн боловсролгүй бол та орон нутгийн их сургууль эсвэл статистикийн бусад байгууллагаас мэргэжилтний тусlamж авах хэрэгтэй.

#### **Нэмэлт материал:**

Crow, Edwin, et al. 1960. Statistics Manual. New York: Dover.

# ҮРДҮНГИЙН ТАНИЛЦУУЛАХ

## 54. Тодорхой түүхийг өгүүлэх

Таны ажлын зорилго бол хүмүүст илүү сайн шийдвэр гаргахад нь туслах явдал юм. Шийдвэр гаргагчдад туслахын тулд та чухал асуултаас хариулт авах, дараа нь үр дүнтэй арга хэмжээ авах хүртэл тодорхой түүхийг ярих ёстой. Үр дүнтэй харилцахын тулд та үзэгчид хэн болох, тэдний хариулт авахыг хүсэж буйасуултуудыг мэдэххэрэгтэй. Таны түүх тэдний хэрэгцээг хангах ёстой. Энэ түүхийг бичгээр эсвэл аман илтгэлээр ярьж болно (58-р алхмыг үзнэ үү).

Илрүүлэх, дүн шинжилгээ хийх, хариу үйлдэл үзүүлэх, үнэлгээ хийхийн тулд энгийн байдлаар олон зүйлсийг тоочих хэрэггүй. Энэ нь уйтгартай, залхуутай ажил бөгөөд хүмүүст таны ажлаас жишээ аваад бодитой шийдвэр гаргахад тус болохгүй. Та өөрийн дүн шинжилгээний үр дүнгээ үзэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн түүх болгон зохион байгуулах хэрэгтэй.

Таны ажил дөрвөн үндсэн асуултад хариулахад тусална. Эдгээр асуултууд нь SARA (scanning (уншиж судлах/ мэдээллээ задлах), analysis (дүн шинжилгээ хийх), response (хариу арга хэмжээ авах) and assessment (дүн шинжилгээ хийх) дөрвөн үгийн товчлол) үйл явцын үе шатуудтай тохирч байна:

1. Асуудлын мөн чанар юу вэ? (унших танилцах)
2. Асуудал юунаас үүдэлтэй вэ? (дүн шинжилгээ хийх)
3. Асуудалд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй бэ? (хариу арга хэмжээ авах)
4. Хариу арга хэмжээний үр дүнд зөрчил, асуудал буурсан уу? (Үнэлгээ)

Шалгаж буй асуудлын бодит байдалд үндэслэн эдгээр асуудлыг илүү тодорхой

болгох хэрэгтэй. Жишээлбэл, орон нутгийн оршин суугчид шөнийн цагаар чимээ шуугианы талаар гомдол гаргах, гудамжинд хаясан хог хаягдлын талаар гомдол гаргаж болно. Асуудлуудыг ерөнхийлөн уншиж танилцахын оронд та CHEERS тест дээр үндэслэн тодорхой асуултуудыг боловсруулж болно (алхам 14). Үүнд:

- Чимээ шуугианы гомдлын шинж чанар юу вэ? (event/ Үйл явдал)
- Эдгээр тохиолдлууд юугаараа төстэй вэ? (similarity/ижил төстэй байдал)
- Оршин суугчдын тав тухыг алдагдуулж, шөнө дуу чимээ гаргах, ил задгай газар хог хаях тохиолдол байнга гардаг уу? (recurring/давтагдах)
- Эдгээр тохиолдлуудад хэн, хэзээ, хаана холбогддог вэ? (community/ олон нийт)
- Эдгээр тохиолдлууд хүмүүсийн амар тайван байдлыг хэрхэн алдагдуулж байна вэ? (harm/хор хөнөөл)
- Цагдаагийн байгууллагаас асуудлыг шийднэ гэж хэн хүсэн хүлээдэг вэ? (expectation / хүлээлт)

Асуудлын мөн чанар нь юу вэ?- гэсэн ерөнхий асуултад хариулах нь илүү тодорхой асуултуудад хариулахыг шаардана.

Илүү уялдаатай түүх ярихад таны гүйцэтгэх хамгийн эхний ажил бол ямар асуултад хариулах гэж байгаагаа шийдвэрлэх явдал юм. Дараа нь та энэ гарын авлагад дурдсан үндсэн онол, арга барилын (жишээ нь, CHEERS тест, гэмт хэргийн гурвалжин эсвэл 80-20 дүрэм) дагуу өөрийн тооцооллоо зохион байгуулахыг хичээх хэрэгтэй. Эдгээр нь тодорхой тулгуур систем юм. Тулгуур систем нь харилцан үйлчлэгч олон хүчин зүйлийг холбосон ерөнхий түүх бөгөөд олон

төрлийн асуудалд хэрэглэх боломжтой. Тулгуур системийн сонголт нь асуудал, таны олж мэдсэн зүйлс, шийдвэр гаргагчдын хэрэгцээ шаардлагаас хамаарна. Суурь асуултаас эхлээд тулгуур систем, дүгнэлтээр дамжуулан хариулт хүртэл логик урсгал байгаа эсэхийг шалгаарай. Логик уялдаа холбоонд ямар нэгэн сүл тал байгаа эсэхийг шалгана уу. Одоо түүхийг тоймлох хэрэгтэй. Таны ажлыг удирдан чиглүүлэхэд туслах дөрвөн үндсэн түүхийн тойм байдаг. Түүхийн дэлгэрэнгүй мэдээлэл нь таны асуудлын онцлогоос хамаарна.

Шашны үзэл баримтлалын үндсэн дээр эдгээр тойм, чиг хандлагыг бүү дага. Бид тэдгээрийг санаа өгөх эхлэлийн цэг болгон сонгодог. Харин үүний оронд өөрт байгаа цаг хугацааны хүрээнд тэдгээр асуудалд хандах, юуны түрүүнд таны хандаж буй хүмүүсийн санаа зовоосон асуудалд тохируулан харьцана. Тэдний асуултыг урьдчилан харж, тохирох тоймыг өөрчлөхийг хичээ. Хэдийгээр бид энэхүү гарын авлагын техникийн нэр томьёог эдгээр тоймд ашигласан боловч та илтгэлдээ нийтлэг үг хэллэг ашиглах шаардлагатай байж магадгүй. Хэрэв таны үзэгчид асуудлын дүн шинжилгээний нэр томьёоны талаар мэдэхгүй бол та үүнийг хааяа нэг ашиглах эсвэл огт ашиглахгүй байх хэрэгтэй.

## Дөрвөн түүхийн тойм

### 1. Асуудлын мөн чанар юу вэ?

- A. Зохион байгуулалтын хүрээ-жишээ нь, CHEERS элементүүд
- B. Асуудлын төрөл, оршин байгаа байдлын талаарх нотлох баримтуудын системчилсэн тайлбар:
  - Үйл явдлын мөн чанар юу вэ?
  - Эдгээр үйл явдлууд юугаараа төстэй вэ?
  - Эдгээр үйл явдал хэр олон удаа давтагддаг вэ?
  - Эдгээр үйл явдлууд хэзээ, хаана тохиолддог вэ?
  - Эдгээр үйл явдлаас хэн, хэрхэн хохирч байна вэ?
  - Цагдаагийн байгууллагаас асуудлыг

шийднэ гэж хэн хүсэн хүлээдэг вэ?

C. Дүн шинжилгээ, асуудлыг хамтран шийдвэрлэхийн ач холбогдол юу бэ?

- Хариулах шаардлагатай асуултууд
- Тодорхойлолт ба хэмжилтийн асуудлууд
- Оролцох шаардлагатай түншүүд

D. Дүгнэлт

### 2. Асуудалд юу нөлөөлж байна бэ?

A. Асуудлыг зохион байгуулах хүрээ - жишээлбэл, асуудлын шинжилгээний гурвалжин

B. Дараах асуултуудад хариулах асуудлын системчилсэн тайлбар:

- Гэмт этгээдүүд гэж хэн бэ?
- Бай, өртөгч гэж хэн, юу бэ?
- Ямар газар, ямар үед асуудал тохиолддог вэ?
- Гэмт этгээдүүд болон бай, өртөгч хүмүүсийг нэг газар юу нэгтгэдэг вэ?
- Яагаад бусад хүмүүс эдгээр асуудлаас сэргийлэхийн тулд тодорхой алхам хийхгүй байна бэ?
- Асуудлыг дэмжих болон saatuuuldag зүйлс нь юу бэ?

C. Мэдээлэлд нийцсэн хариултын ерөнхий хэлбэрийн талаар:

- Гэмт этгээдийн хандалт буюу хяналт
- Хохирогч/бай, өртөгчийн зан төлөв, хамгаалалт
- Байгууллага, байгууламжийн хандалт эсвэл удирдлага

D. Дүгнэлт

- 3. Энэ асуудлын талаар юу хийх ёстой вэ?**
- A. Нөхцөл байдалд суурilan, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг хариу арга хэмжээг зохион байгуулах тогтолцоо, түүний бүрэлдэхүүн хэсгүүд:
- Гэмт этгээдүүд
  - Бай, өртөгч/хохирогчид
  - Газрууд
- B. Хариу арга хэмжээний стратегийн системчилсэн тайлбар:
- Эрсдэл эсвэл хүчин чармайлтыг нэмэгдүүлэх
  - Гэмт хэргээс авах ач холбогдол, өөрийгөө зөвтгөх шалтаг, сэдлийг багасгах
  - Үйл ажиллагааг хэн, хэзээ, хаана хийх вэ?
  - Нэмэлт нөөц шаардлагатай
- C. Үр дагавар ба хүлээгдэж буй үр дагавар:
- Шууд үр дүн
  - Шилжилт
  - Тархалт
  - Бусад гаж нөлөө
  - Үнэлгээг хэрхэн хийх ёстой вэ
- D. Дүгнэлт
- 4. Хариулт нь асуудлыг багасгасан уу?**
- A. Зохион байгуулалтын тогтолцоожишээлбэл, үнэлгээний зарчим
- B. Үнэлгээний системчилсэн тайлбар:
- Хариу арга хэмжээ нь төлөвлөсний дагуу хэрэгжсэн үү?
  - Асуудал өөрчлөгдсөн үү?
  - Яагаад хариу арга хэмжээ нь өөрчлөлтийн шууд шалтгаан болсон бэ?
  - Шилжилт, тархалт болон бусад гаж нөлөөний хэмжээ
- C. Цаашдын үйл ажиллагааны үр дагавар:
- Энэ асуудлыг шийдвэрлэх хүчин чармайлт бүрэн дууссан уу?
  - Цашид ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?
  - Цашид шинжилгээ хийх шаардлагатай юу?
  - Хариу арга хэмжээг өөрчлөх ёстой юу?
- D. Дүгнэлт

**Г**азрын зураг нь асуудлын талаар сонирхолтой түүхийг өгүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ үүнийг хэрэгжүүлэхийн тулд тэдгээр нь тодорхой байх ёстай. Өөрөөр хэлбэл, газрын зураг нь аль болох их мэдээллийг агуулсан байх ёстай бөгөөд хамааралгүй мэдээлэл байх ёсгүй. Сайн зураг зохиоход баримтлах зарчмуудын талаарх хэд хэдэн гарын авлага байдаг (хажуугийн цэс хэсгийг үзнэ үү).

Бид Норвегийн цагдаагийн газраас хэрэгжүүлсэн асуудал шийдвэрлэх төсөлд газрын зургийн тусламжтайгаар түүхийг хэрхэн өгүүлэх талаар бид танилцуулах болно. Мөн 1 ба 2-р зурагт газрын зургийг асуудал, шийдлийг тайлбарлахад хэрхэн ашиглаж болохыг харуулсан. Норвегийн Цагдаагийн Үндэсний Академийн ажилтан Йоханнес Кнутссон, Вестфоулд цагдаагийн дүүргийн ажилтан Кнут-Эрик Сёвик нар далайн эргийн жижиг хот болох Тонсберг хотод (36,000 хүн амтай) хууль бус ("хууль бус такси") таксины асуудлыг шийдвэрлэхээр оролдож байв. Амралтын өдрууддэд архи, согтууруулах ундаа хэрэглэдэг 30 газарт олон хүн цугларч, хүмүүс хурдны замаар зорчих хөдөлгөөн нэмэгддэг тул баасан, бямба гарагийн шөнө хурдны замыг хаадаг. Энэ үед машины зогсоол бас хаалттай байна. Гэсэн хэдий ч хууль ёсны такси, автобус хурдны замаар зорчиж болно. Зөвшөөрөлгүй таксиныуд энэ бүс дэх ихэнх бизнесийг булаан авч, зарим талаараа лицензтэй таксиныудыг айлган сүрдүүлдэг. Эдгээр хууль бус таксины жолооч нар хэд хэдэн ноцтой гэмт хэрэг үйлдэж, гомдол санал ихээр гаргадаг.

Асуудлын нөхцөлийн талаар 1-р зурийн хоёр газрын зурагт харуулав. Зүүн талын самбар нь гудамжны зураглал юм. Энэ нь асуудалд хамааралгүй олон шинж чанарыг харуулдаг бөгөөд чухал ач холбогдолтой олон шинж чанарыг харуулж чаддагтгүй. Баруун талын самбар нь газрын зургийн нарийвчлан зассан хувилбар юм. Энэ нь зөвхөн үндсэн газрын зургийн холбогдох шинж чанаруудыг агуулсан бөгөөд орхигдсон чухал функцуудыг нэмж, илүү их мэдээллийг өгдөг.

2-р зурагт дүн шинжилгээнээс гарсан дүгнэлт болон хариу арга хэмжээний чухал шинж чанаруудыг нэгтгэсэн хоёр газрын зургийг агуулна. Зүүн талын газрын зураг дээр хууль бус таксины жолооч нарын зорчих үндсэн чиглэлийг харуулсан. Хууль бус таксиныуд гудамжны хаалт, зогсоолыг ашиглан үйлчлүүлэгчдийг хүлээн авдаг. Энэхүү газрын зураг нь автобусны зогсоол болон (хууль ёсны) таксины зогсоол тухайн бүсийг ашиглаж буй хүмүүсээс хэтэрхий хол зйтай харуулсан. Баарнууд шөнийн 03:00 цагаас хойш хаагдах үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, эрэлт нэмэгдэж, хууль бус таксиныуд энэхүү эрэлт хэрэгцээг нөхөхөд хамгийн тохиромжтой байдал үүсдэг.

2-р зургийн баруун талд байгаа хариултын зурагт хууль бус таксиныуд боломжит үйлчлүүлэгчдэд хүрч очибоос сэргийлж хурдны замын хаалтыг хэрхэн хөдөлгөж, эдгээр таксиныудыг оруулахгүй тулд шөнийн цагаар зогсоолуудыг хэрхэн хаасан тухай мөн хууль ёсны зөвшөөрөлтэй такси, автобусныудын зогсоолыг харуулав. Лангууг үйлчлүүлэгчдэд илүү тохиромжтой газар нүүлгэсэн. Энэхүү газрын зураг нь үйл явцын үнэлгээний чухал хэсэг юм (алхам 46).

Эдгээр гурван газрын зураг нийлээд асуудлын мөн чанар, энэ талаар юу хийснийг тодорхой дүрсэлсэн. Энэхүү төслийн үр дүн нь Тонсберг дэх хууль бус таксины асуудлыг эмх замбараагүй байдлыг нэмэгдүүлэхгүйгээр бодит үр дүнд хүрэх явдал байв.

Кнутссон, Совик нар эдгээр газрын зураг дээр ердийн газарзүйн мэдээллийн системд байдаггүй үзүүлэлтүүдийг харуулахын тулд ихээхэн тайлбар хийсэн. Энэ бол сайн туршлага юм. Асуудлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл нь компютерт байдаггүй.

Гэсэн хэдий ч сайн газрын зургийн хэд хэдэн шинж чанарууд дутагдаж байна. Луужингийн чиглэл байхгүй. Гэсэн хэдий ч зүг чиг нь зөрчил, асуудалд ямар ч хамааралгүй учраас чиглэлийг заахгүй байж болно. Мөн газрын зургийн масштаб дутуу байна. Энэ нь тухайн газар нутгийг мэдэхгүй хүмүүсийг ойлгоход төвөгтэй.

## Нэмэлт материал:

Boba, Rachel. 2005. Crime Analysis and Crime Mapping: An Introduction. Thousand Oaks (California): Sage Publications.

Harries, Keith. 1999. Mapping Crime: Principle and Practice. Washington, DC: National Institute of Justice, Crime Mapping Research Center. <Https://www.ncjrs.gov/pdffiles1/nij/178919.pdf>.

Knutsson, Johannes, and Knut-Erik Søvik. 2004. Gypsy Cabs in Tønsberg. Submission to the Herman Goldstein Awards. <Http://www.popcenter.org/library/awards/goldstein/2004/04-35%28F%29.pdf>.

Ratcliffe, Jerry H. 2004. "Jerry's Top Ten Crime Mapping Tips." Last modified October 22, 2014. <Http://www.jratcliffe.net/blog/ten-crime-mapping-tips/>.


## Ач холбогдолтой газрын зураг зураглах нь

- Газрын зургийг хэрэглэх хүмүүст ямар мэдээлэл хэрэгтэй болохыг (мөн ямар мэдээлэл будилаантай, ойлгомжгүй байгааг) мэдэж аваарай.
- Газрын зургийг энгийн, хялбар болго. Асуудлыг ойлгомжтой болгоход ач холбогдолтой бүх үзүүлэлтүүдийг хасах.
- Бодит анхаарлыг сарниулах зураг, дүрслэлээс татгалзах хэрэгтэй.
- Энэ мэдээллийг гараар нэмж оруулсан боловч үзэгчдэд асуудлыг ойлгоход тус дөхөм болох дэлгэрэнгүй мэдээллийг оруулаарай.
- Хэмжээ, масштаб мөн шаардлагатай бол луужингийн чиглэлийг оруулаарай (ихэвчлэн хойд зүгт байдаг).
- Халуун цэгүүдийн эрчмийг харуулахын тулд өнгөний дүрслэлийг ашигла. Жишээлбэл, асуудал улам дордох тусам өнгө нь улам халуун (шараас улаан) болж хувирч болно.
- Гэмт хэргийн төвлөрлийг илэрхийлэх зөв хэмжигдэхүүнийг хэрэглэх: газар, байрлалыг (заримдаа хохирогчид) цэгээр илэрхийлэх, гудамж, хурдны замыг шугамаар илэрхийлэх, хорооллыг тодорхой дүрс, талбараар илэрхийлэх гэх мэт.
- Газрын зурагтай хамт хүснэгт, зураг ашиглаж болно.

1-р зураг. Асуудал, зөрчлийг газрын зураг дээр илэрхийлэх ба түүний ойр орчныг харуулах нь



**Зураг 2. Зөрчил, асуудалд дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээг харуулах нь**



## 56. Энгийн бөгөөд ойлгомжтой хүснэгт ашиглах

**X**эрвээ хүснэгтүүдийг энгийн байдлаар хийсэн бол хүснэгтүүд нь зарим түүхийг ярих арга хэрэгсэл болно. Гэхдээ тэмдэг, тэмдэглэгээ, шугам зэргийг ихээр хэрэглэсэнээс болоод хүснэгт ойлгомжгүй болдог, дун шинжээчид ихэнх тохиолдолд хүснэгтийг ойлгомжтой байдлаар зохион байгуулдаггүй.

Бааранд шар айргийг үзүүлэн болгон тавих нь дэлгүүрээс шар айргийн хулгайг дэмждэг гэдгийг та харуулахаар оролдож байна гэж төсөөльье. Зарим дэлгүүрүүд шар айргаа урд хаалганы ойролцоо, зарим нь ар талдаа байрлуулдаг. Урд талд байрлуулсан дэлгүүрүүдтэй харьцуулахад ар талдаа байрлуулсан тохиолдолд шар айргийн хулгай бага гардаг гэдгийг харуулахыг оролдож байна. 1-р хүснэгтэд энэ мэдээлэл саад болж байна. Өгөгдөл муу зохион байгуулалттай, багцалсан байдал нь анхаарал сарниулж байна.

2-р хүснэгтэд өгөгдлийг зөв зохион байгуулсан. Хувь хэмжээг өгүүллэг, түүхийн гол хэсэгт оруулсан болно. Анхдагч тоонуудаар гол өгүүллэг, түүхийг өгүүлээгүй ч илүү нарийн харахыг хүссэн уншигчдад хэрэгтэй байж болох тул хаалтад хавсаргаснаар хүснэгтүүдийн ач холбогдол сайжирсан. Эцэст нь, (эхний хүснэгтэд байгаа шиг) хүснэгтийн мөрний хувийн оронд хүснэгт 2-д баганын хувийг ашигладаг.

Ямар нэгэн зүйл нь өөр бусад зүйлд нөлөөлж байгаа уялдаа, холбоог шалгах үед хүснэгтийн баганад шалтгааныг оруулж, баганын хувь хэмжээг ашиглах нь зүйтэй. Дараа нь мөрнүүдийн хооронд харьцуулалт хийнэ. Энд бараа бүтээгдэхүүнээ дэлгүүрийн нүүрэн талд байрлуулдаг дэлгүүрүүдийн 29 хувьд нь хулгайн хэрэг гараагүй, харин дэлгүүрийн ар талдаа бараа бүтээгдэхүүнээ тавьдаг дэлгүүрүүдийн 83 хувьд нь хулгайн хэрэг гараагүй. Урд нүүрэн талдаа бараа бүтээгдэхүүнээ дэлгэн харуулдаг дэлгүүрүүдийн бараг 46 хувьд гурав ба түүнээс дээш хулгай тохиолдсон, харин ар талдаа байрлуулдаг дэлгүүрүүдэд ийм

тохиолдол нэг ч гараагүй.

2-р хүснэгтэд зурааснууд багатай. Тод хүрээг арилгаж, түүний оронд нарийн зурааснууд оруулсан. Дотор талд нь үлдсэн эгнээ нь гарчгийг мэдээллээс тусгаарласан. Зураасны оронд мөрнүүд ба доошилсон багануудын хооронд уншигчийн анхаарлыг төвлөрүүлэх зорилгоор хоосон зайл ашигласан. Гарчиг хэсэгт чухал тоонуудыг хувиар илэрхийлж, уншигчид мэдээлэл өгснөөр (боловсруулалт хийгдээгүй тоонуудыг багцалсан) хүснэгтийн нүд бүрд хувь хэмжээний тэмдэг оруулах шаардлагагүй болсон. Зөвхөн баганын нийт дүнг үлдээсэн. Энэ нь чухал ач холбогдолтой нийлбэр нь босоо байгааг уншигчид харуулсан. Эцэст нь бүх хувь хэмжээг аравтын орноор тоймлон харуулсан. Иймээс баганын тоонуудыг нэг эгнээ болгон жигдлэх, тайлбарлахад хялбар боломжтой болгосон. Эдгээр бүх өөрчлөлтүүдийн үр дүнд хүснэгтийн ихэнх мэдээлэл нь мэдээллийг багцлах гэхээсээ илүү өгөгдлийн шинжтэй болсон.

Асуудал нь ихэвчлэн олон шалтгаантай байдаг. Хэдийгээр олон шалтгааныг харуулахын тулд хүснэгтүүд зохиож болох ч хоёроос илүү шалтгааныг илэрхийлэхэд нэг хүснэгт үр дүн муутай. Хүснэгт зохиох үндсэн зарчмууд ижил байна.

Үүнд:

- Бүх шалтгаанууд нэг чиглэлд (ихэвчлэн баганад илэрхийлэгддэг) явдаг.
- Нийлбэр нь шалтгааны чиглэлд (баганаар доошоо чиглэлтэй) явдаг.
- Шалтгаануудын харьцуулалт нь эсрэг чиглэлд (мөр хооронд, хэрэв шалтгаан нь баганад байгаа бол) явагдана.

3-р хүснэгтийг гурван хэмжээст хүснэгт гэж нэрлэдэг. Учир нь энэ хүснэгтэд гурван зүйлийг шалгасан (өмнөх хүснэгт хоёр хэмжээст байсан). 3- хүснэгт нь дараах асуултад хариулна. Үүнд: хоёр сүлжээ дэлгүүрт (Drink –Lots ба Tippers) бараа бүтээгдэхүүнийг дэлгэн харуулах байрлал, хулгайн хоорондох хамаарал ялгаатай

юу? Хариулт нь үгүй. 2-р хүснэгтэд бидний харсан хоёр сүлжээ дэлгүүрт ижил үндсэн дүр зураг харагдаж байна. Хоёр тохиолдолд бид баганын мэдээллийг нэмж, дэлгүүрийн урд бараагаа байрлуулдаг тохиолдлуудыг дэлгүүрийн ард байрлуулсан тохиолдлуудтай харьцуулсан. Дэлгүүрийн арын эгнээнд шар айргийг байрлуулдаг тохиолдлуудад хулгайн гаралт бага байна гэсэн дүгнэлтийг гаргаж болохоор байна.

Бодит байдалд 3-р хүснэгтэд дэлгүүрийн төрөл тогтмол. Хэрвээ бид тэдгээрийг чухал гэж дүгнэвэл бусад хүчин зүйлс тогтмол хэвээр хадгалагдаж болно. Жишээ нь бид дэлгүүрүүдийг хэмжээгээр (жижиг, дунд, том) нь ангилж, энэхүү ангилал тус бүрт барааг дэлгэн харуулах байрлал болон хулгайн гаралтын хоорондох уялдаа хамааралд тусгайлан дүн шинжилгээ хийсэн. Үүнд гурван

самбар шаардлагатай боловч эсрэгээрээ ижил зарчмууд үйлчилнэ.

3-р хүснэгтийн бусад хэд хэдэн үзүүлэлтүүдэд анхаарлаа хандуулаарай:

- Хэрвээ та Drink-Lots-ийн нүдэн дахь анхдагч тоонуудыг (хаалтад) Tippers сүлжээний доорх зохих нүднүүд рүү нэмэх үед та 2-р хүснэгтэд анхдагч тоонуудыг авна. Өөрөөр хэлбэл 2-р хүснэгт нь 3-р хүснэгтийн нийлбэр юм. Гэхдээ та 2-р хүснэгтээс 3-р хүснэгтийг гаргах, зохиох боломжгүй.
- 3-р хүснэгт нь асуудлын хоёр боломжит шалтгааныг агуулж байгаа учраас бид хоёр төрлийн дэлгүүрт анхаарлаа хандуулахын тулд босоо шугамуудыг нэмсэн.

### Хүснэгт 1. Барааг дэлгэн харуулах байрлал болон шар айргийн хулгайн байдал (6-р сар)

Дэлгэн харуулсан байрлал				
Хулгайн гэмт хэргийн мэдээлсэн тоо	Дэлгүүрийн урд эгнээнд	Дэлгүүрийн арын эгнээнд		Нийт
0	7 тохиолдол (17,5%)	33 тохиолдол (82,5%)	40	
1-2	6 тохиолдол (46,15%)	7 тохиолдол (53,85%)	13	
3 ба түүнээс дээш	11 тохиолдол (100%)	0 (0%)	11	
<b>Нийт:</b>	<b>24 тохиолдол (37,5%)</b>	<b>40 тохиолдол (62,5%)</b>	<b>64</b>	

### Хүснэгт 2. Шар айргийн хулгайн мэдээлэл өгсөн дэлгүүрийн хувь хэмжээ (тоог хаалтад бичив)

6-р сард хулгайн хэргийн тохиолдол	Урд эгнээнд	Арын эгнээнд
0	29,2% (7)	82,5 (33)
1-2	25,0% (6)	29,2% (7)
3 ба түүнээс дээш	45,8% (11)	0,0 (0)
<b>Нийт</b>	<b>100,0%* (24)</b>	<b>100,0% (40)</b>

\*Тоймлох, барагцаагаар илэрхийлэх зорилгоор тоонуудыг 100 хувиар илэрхийлсэн.

**Хүснэгт 3. Шар айргийн хулгайн тохиолдлын талаар тайлан мэдээлсэн дэлгүүрүүдийн хувь хэмжээ, жижиглэн худалдааны сүлжээгээр (хаалтад хэргийн тоог бичив)**

<b>6-р сард хулгайн тохиолдол</b>	<b>Drink-Lots дэлгүүрийн урд эгнээнд</b>	<b>Drink-Lots дэлгүүрийн арын эгнээнд</b>	<b>Tippers дэлгүүрийн урд эгнээнд</b>	<b>Tippers дэлгүүрийн арын эгнээнд</b>
<b>0</b>	30,8% (4)	84,2% (16)	27,3% (3)	81,0% (17)
<b>1-2</b>	23,1% (3)	15,8% (3)	27,3% (3)	19,0% (4)
<b>3 ба түүнээс дээш</b>	46,2 % (6)	0,0% (0)	45,5% (5)	0,0% (0)
<b>Нийт:</b>	100,0%* (13)	100,0%* (40)	100,0%* (11)	100,0% (21)

\*Тоймлох, барагцаагаар илэрхийлэх зорилгоор тоонуудыг 100 хувиар илэрхийлсэн.

- Мөрний тэмдэглэгээ нь дэлгүүрийн хоёр төрөлд хамаарна. Иймээс тэдгээрийг хувилах шаардлагагүй.
- Тоймлох, барагцаагаар илэрхийлэх зорилгоор зарим хувь хэмжээг 100-аар илэрхийлсэн. Жишээ нь 99,9 хувь бол түүнийг 100 хувь гэж тэмдэглэсэн. Тоймлох, багцаалахтай холбоотой энэхүү жижиг зөрүү тийм их биш учраас санаа зовоох асуудал биш юм.

Хэрвээ шийдвэр гаргагчид зориулж дээрхийн адил хүснэгтүүдийг байнга гаргах шаардлагатай бол ижил мэдээллээр хэд хэдэн төрлийн хүснэгтийг зохиож тэдэнд харуулаарай. Эдгээр олон төрлүүдээс аль нь тэдэнд тохирохыг тодорхойлж, улмаар энэхүү стандарт форматыг ашиглаарай.

## 57. Энгийн бөгөөд ойлгомжтой дүрслэл ашиглах

**X**үснэгт, газрын зургийн адилаар зураг, диаграммууд нь мэдээлэл өгөх үр дүнтэй хэрэгсэл боловч хамгийн гол нь эдгээр зураг, диаграммууд нь энгийн, ойлгомжтой байх хэрэгтэй. Бүх тооныуд нь багц, агуулга гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Агуулга гэдэг нь таны бусдад дамжуулахыг хүсэж буй мэдээлэл юм. Багцлахын зорилго мэдээллийг хурдан, хялбар, тодорхой, үнэн зөв тайлбарлах нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. Энгийн байдал гэдэг нь багцлахыг хамгийн бага хэмжээнд байлгахыг хэлнэ. Хамгийн нийтлэг алдаа түүх, өгүүлэлмжийн явцад бий болж элемент, бүрэлдэхүүн хэсгүүдийг нэмэх явдал юм. Үүнийг харуулахын тулд бид зохион байгуулалт муутай дүрслэлийн жишээгээр эхлэв. Дараа нь бид дүрслэлийг илүү хялбар болго замаар дүрслэлийг илүү тодорхой, ойлгомжтой, багтаамжтай болго талаар танилцуулна.

1-р зураг нь хулгайчид байшин руу хэрхэн нэвтэрч байнсыг харуулах дугуй график юм. 3D дүрслэл нь мэдээллийг гажуудуулдаг. Хулгайчдын нэвтрэн орох сонголтыг жагсаан үзэхэд Хаалга бол хамгийн том хүндрэл, арын байрлалтай цонх нь "Бусад" гэсэн ангиллын дараагаар дөрөвдүгээр байрыг эзэлдэг. Энэ тухай дараа танилцуулах болно. 3D эфект нь дугуй дүрслэлийн урд хэрчмүүдийн ач холбогдлыг нэмэгдүүлдэг (энэ жишээнд дэлгүүрийн урд, нүүрэн талын цонхнууд нь хулгайч нэвтрэн орох магадлал хамгийн багатай), харин арын хэсэгт байгаа хэрчмүүдийн ач холбогдлыг бууруулсан. Дугуй диаграммын цорын ганц ач холбогдол бүхий үзүүлэлт, шинж чанар нь бүрэлдэхүүн хэсгүүд нь бүхэл зүйлд хэрхэн нөлөөлж байгааг харуулдаг. 3D эфект ашигласнаар энэ нь алдагддаг. Зургаан ангиллыг харуулахын тулд өөр өөр өнгөтэй сүүдэр, хээ зэргийг ашиглах нь зүйтэй. Хэрчмүүдийг өнгө, хээгээр ялгаснаар тодруулга, тайлбар хийх боломжтой болно.

Зураг 2 нь баганан диаграммд 3D эфект үүсгэж болох гажуудлыг харуулж байна. Судлаач баганын урд дээд ирмэг болон арын дээд ирмэгийн хооронд сонголт хийх учраас багануудын өндрүүдийг харьцуулах

нь хүндрэлтэй. Иймээс гурван хэмжээст эфектийг хэзээ ч хэрэглэж болохгүй.


Энэхүү график хэрэглэхэд хүндрэлтэй байдал үүсгэдэг бусад олон үзүүлэлтүүдийг агуулдаг. Жишээ нь баганын гадаргуун сүүдэрлэлт нь баганууд болон арын фоннын хоорондох ялгарал, мөн багануудын тэмдэг, тэмдэглэгээ болон босоо тэнхлэгийн тэмдэг, тэмдэглэгээний хоорондох ялгарлыг далдалж, хэвтээ шугамуудыг гажуудуулдаг. Дүрслэлийн эргэн тойрон дахь хүрээ нь шаардлагагүй, илүү хэрэглэгдсэн байна.

3-р зураг дахь энгийн баганан диаграмм нь мэдээллийг маш үр дүнтэй байдлаар илэрхийлсэн. Учир нь хоёрдугаар зургийн бүх будилаантай үзүүлэлтүүдийг хассан. Хэрвээ бид багана тус бүрээр нарийн тодорхой хувь хэмжээг илэрхийлэхийг хүссэн бол бид багануудын дээд, орой хэсгийг тэмдэглэх хэрэгтэй. Гэхдээ энэхүү үзүүлэлт нь ижил мэдээллийг илэрхийлж байгаа тохиолдолд бид босоо тэнхлэгийг хасах нь зүйтэй.

Нэмж хэлэхэд 3-р зураг дахь мэдээллийг дахин зохион байгуулсан. Хулгайн гэмт хэргийн анхдагч тооныудын оронд график дүрслэлээр нийт тоо хэмжээнд эзлэх хувь хэмжээг илэрхийлсэн. Энэ нь хоёр үндсэн зүйлийг илэрхийлдэг. Нэгдүгээрт ямар аргууд нь илүү олон дахин тохиолдож байгаа эсэхийг. Хоёрдугаарт арга бүр бүхэл бүтэн ямар хэсгийг төлөөлдөг болох. Хэрвээ та бүхэл зүйлийн дотор харьцангуй хувь хэмжээг илэрхийлэх шаардлагатай бол дугуй дүрслэлээс илүүтэйгээр баганан дүрслэлээр хувь хэмжээг илэрхийлээрэй.

3-р зургийн өөр нэг үзүүлэлт бол ангиллыг ач холбогдол бүхий дарааллаар ихээс бага руу чиглэлтэйгээр зохион байгуулсан. Энэ нь таны уншигч анхаарал хандуулбал зохих зүйлд чиглэдэг. Ач холбогдолтой дараалал нь дугуй графикт илэрхийлэхэд хэцүү. Учир нь үүнд тодорхой эхлэл, төгсгөл гэж үгүй. Баганан график нь илүү сайн илэрхийлэх чадвартай учраас дугуй графикийг ашиглах хэрэггүй. Танд ангилалтай мэдээлэл байгаа бол дугуй график энгийн бөгөөд үр дүнтэй.

**Зураг 1. Хулгайчийн нэвтрэн орох аргууд**




**Зураг 2. Хулгайчийн нэвтрэн орох аргууд**




Зургийн гарчгийг мартаж болохгүй. З-р зурагт гарчиг нь өгүүлэмжийн гол утга санааг илэрхийлнэ. Энэ нь "Хулгайчийн нэвтрэн орох аргууд" гэснээс хамаагүй илүү сонирхолтой төдийгүй өгүүлэмжийг хоёрдмол утгатай болгохоос сэргийлнэ. Товчоор хэлэхэд З-р зураг нь өөрөө хангалттай. Дагалдах текстийг уншихгүйгээр уншигч сэдэв, гарчгийг уншаад сэдвийн гол санааг олж авах ёстой.

Сүүлчийн зурагт шугаман графикийг харуулав. Мэдээлэл цаг хугацаанаас хамааралтай үед буюу цаг хугацааны явцад тоон мэдээлэл өөрчлөгджэх байгаа тохиолдолд зураас, шугаман дүрслэлийг ашиглана. Үүнд 4-р зурагт мэдээлэл зургаан сарыг хамарсан. Зураасны дагуух цэгүүд нь хулгайн гэмт хэргийн тоог онцолсон бөгөөд зурааснууд нь тодорхой цаг хугацааны явц дахь үргэлжилсэн уялдаа холбоог илэрхийлнэ. Та босоо тэнхлэгийг тэмдэглэх хэрэгтэй. Үүний үр дүнд зургаар тодорхой нэг өгүүлэмжийг илэрхийлсэн. Энэхүү зурагт орон байрны хулгайн хувь хэмжээгээс илүүтэйгээр орон байрны хулгайн тоог босоо тэнхлэгээр илэрхийлсэн байгааг бид ойлголоо.

**Зураг 3. Хулгайчийн хувьд хаалга бол гол асуудал бэрхшээл юм.**



**Зураг 4. Орон байрны хулгай буурч байна.**



Хэрвээ та цаг хугацаа тус бүрт тоо хэмжээг харуулахыг хүсэж байгаа бол цэгүүдийг нэрлэнэ. Гэхдээ босоо тэнхлэгийг хасна. Босоо тэнхлэг бол илүү тэмдэглэгээ юм. Гэхдээ ямар ч үед хянуур, анхааралтай байгаарай. Цаг хугацаа бүр дэх тоон тэмдэглэгээнүүд нь графикийг уншихад хүндрэлтэй болгодог. Хэрвээ нэгэн ижил зурагт олон графикуудыг илэрхийлсэн (жишээ нь цагдаагийн хэсгүүдэд бүртгэгдсэн хулгайн тоо, хандлага гэх мэт) бол өөр өөр шугамуудыг тодорхой тэмдэглэж, графикт хялбархан ялгах боломжтой байдлыг бүрдүүлэх хэрэгтэй.

## Үр дүнтэй дүрслэл зохиох

- Зураг, дүрслэлийг энгийн байлга. Хэт их багцлах хэрэггүй.
- 3D эффектийн адилаар өнгөц эффектийг ашиглаж болохгүй.
- Дугуй графикаас зайлсхий.
- Ангилал бүхий мэдээлэлд дугуй графикийг ашигла.
- Тэмдэг, тэмдэглэгээнүүдийг үр дүнтэй ашигла.
- Гарчгийг анхааралтай, хянуур сонгоорой.
- Текстийг уншихгүйгээр өгүүлэмжийн гол утгыг илэрхийлээрэй.

### Нэмэлт материал:

Kosslyn, Stephen. 1994. Elements of Graph Design. New York: W. H. Freeman.

## 58. Агууламж сайтай, сайн танилцуулга хийх

Танилцуулга нь үндсэн асуултаар эхэлж, цуглуулсан мэдээллийн тодорхойлолтуудыг танилцуулах системчилсэн бүтцийг ашиглаж, тодорхой дүгнэлтээр дуусах хэрэгтэй (54-р алхмыг үзнэ үү). График материалыг 55-аас 57-р алхамд заасан зааврын дагуу бэлтгэх ёстой. Энэ алхамд бид таны ярж буй түүх, өгүүлэмж дээр анхаарлаа төвлөрүүлэх болно. 59-р алхамд бид танилцуулгыг хэрхэн хүргэх, түүний дотор powerpoint программыг ашиглах талаар судална.

Таны илтгэлийн гол анхаарал хандуулах зүйл нь шийдвэр гаргахад туслах тодорхой асуултуудад хариулах байх ёстой бөгөөд энэ нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

- Таны түүх, өгүүлэмжийн талаар танилцуулсан слайдуудыг ашиглах
- Үзэгч, уншигч нарыг өгүүлэмж, түүхэнд анхаарал хандуулахад туслах график сэдэл, слайдуудыг ашиглах.

Слайд нь шинжилгээний үр дүнг танилцуулдаг. Хөтлөгч болон ахлагч Смит нар хоёр зорилго тавьсан. Эхний нь "Энэ асуудал юунаас үүдэлтэй вэ?" гэсэн асуултад хариулах явдал юм. Хоёр дахь нь боломжит хариултуудын талаар хэлэлцүүлэг өрнүүлэх явдал юм. Гарчгийн слайд нь тодорхой асуултуудыг асуудаг (мөн илтгэгчийг танилцуулдаг). Энэ слайд болон 2-оос 4 хүртэлх слайдууд нь танилцуулга хэсэг юм. 2-р Слайд нь аль юуг дагаж мөрдөх тухай үндэс суурь болох өмнө нь хүлээн зөвшөөрсөн бүлэг асуудлуудыг нэгтгэдэг. 3-р слайд презентаци, танилцуулгыг илэрхийлдэг, 4-р слайд цуглуулсан мэдээллийг нэгтгэн дүгнэдэг.

5-р слайдад хүрээг үзүүлэв. Ахлагч Смит гэмт хэргийн гурвалжныг ашигладаг. Тэрээр энэ гурвалжинд хамаарах бүх мэдээллүүдийг голлон авч үзсэн. (Смитийн үзэгчид гурвалжны талаар сайн мэдэж байгаа тохиолдолд л энэ нь ажилладаг гэдгийг ойлгоорой. Хэрвээ тийм биш бол Смит өөр хүрээ ашиглах ёстой.) Энэ сургамжийг\* бэхжүүлэх, үзэгчдийг төөрөлдөхгүйн тулд ахлагч Смит мэдээллүүдийг танилцуулахаа гурвалжин дүрсийг тодорхой хэмжээнд

ашигласан боловч чухал өөрчлөлтүүдээр ашигладаг. Слайдууд нь өртөгч, бай, хамгаалагчаас газар, менежер рүү мөн гэмт хэрэгтэн, цагдаа руу шилжих үед сүүдэртэй тал болон өнгө өөрчлөгддөг. 5-р слайд дахь дугуй сум нь цагийн зүүний эсрэг дарааллыг харуулж байна. Үүнд Смит судалгааны үр дүнг танилцуулна. Иймээс энэ слайдад, ахлагч Смит нэгэн зэрэг өөрийн систем, хүрээг дүрсэлж, үндсэн дүгнэлтүүдийн тоймыг харуулсан.

6-аас 13-р слайдууд нь үзэгчдэд хүрээн дээр тайлбарласан бүрэлдэхүүн, элементүүдийн талаар өгүүлдэг хүснэгт, зураг, газрын зургийг үзүүлсэн. Өртөгч, байг хамгаалахад ашигласан үйлдлүүдийг дугуй графикт харуулах боломжтой. Зөрчил, асуудал байхгүй газартай харьцуулсан байдлаар асуудал зонхицж буй газруудыг харуулахад байршлын газрыг зургийг ашигласан. Зургууд эдгээр сайтуудын онцгой чухал шинж чанаруудыг харуулж болно. Хүснэгтээр нь гэмт хэрэгтнүүдийг баривчлах давтамжийг харуулах боломжтой.

14-р слайдад эдгээр мэдээллүүдийг нэгтгэн харуулсан. Энд гурвалжны бүх талууд сүүдэртэй харагдаж байна. Бүх талыг сүүдэрлэж харуулсан нь тусдаа мэдээллүүд нь илүү том бүхэл бүтэн зүйлийн нэг хэсэг гэдгийг батлан харуулах зорилготой. 15 ба 16-р слайдуудад цуглуулсан мэдээлэлтэй нийцэж байгаа хариултын сонголтууд болон нийцэхгүй байгаа хувилбаруудыг жагсаав. Хэдийгээр ахлагч Смит өөрийн шинжээчийн дүгнэлтийг танилцуулсан бөгөөд эдгээр эцсийн слайдууд нь өмнөх үр дүнд тулгуурласан хэлэлцүүлгийг танилцуулах зорилготой юм. Энэ бол асуудалд эцсийн өгүүлэлмжтэй шийдвэр гаргагчид юм.

Үзэгчдийг илүү том өгүүлэмж, түүх рүү төвлөрүүлж, нарийн ширийн зүйлд төөрч будилахаас сэргийлэх нь чухал. Үүнийг хэрэгжүүлэх хоёр арга бол үргэлжилсэн мотив, сэдлийг (зураг дээрх гурвалжин шиг) эсвэл онцолсон тойм слайдыг ашиглах явдал юм. Тойм слайдыг ашиглаж байгаа үед сэдэв бүрийн өмнө тоймыг танилцуулдаг. Тойм хэсэгт танилцуулах сэдвийг тодруулж, бусад

сэдвүүдийг бүдгэрүүлсэн байна. Ахлагч Смитийн танилцуулгад тойм слайдыг дөрвөн удаа буюу үндсэн сэдэв тус бүрийн өмнө тус бүр нэг нэг удаа үзүүлнэ.

Слайд хэлбэрийн тараах материалыг ашиглах нь ашигтай боловч зарим сул талуудтай. Та тараах материалаас илүү хялбар байдлаар слайд дээр сүүлчийн минутын өөрчлөлтийг хийх боломжтой. Хэрэв та сүүлийн минутын томоохон өөрчлөлтийг хүлээж байгаа бол тараах материал нь зурагтай тохирохгүй байж магадгүй. Өнгөт слайдыг хар цагаанаар каноноор хуулбарлахад дүрслэл ойлгомжгүй, гаргацгүй болдог. Хэрэв та powerpoint ашиглаж байгаа бол "Хэвлэх" цэс дэх "цэвэр хар цагаан" сонголт нь таны өнгөт слайдыг хар цагаан горим руу хувиргана.

Ихэнх шийдвэр гаргагчид таны адилаар асуудалд дүн шинжилгээ хийхэд ашигласан

аргуудыг сонирхохгүй байж болно. Тиймээс, энэ нь таны илтгэлийн зорилго биш бол та өөрийн аргыг тайлбарлахад их цаг зарцуулах хэрэггүй. Үүний оронд үндсэн элементүүдийг нэгтгэн дүгнэх нь зүйтэй (4-р слайдыг үзнэ үү). Үзэгчид таны ашигласан аргын талаар асууж байгаа бол нөөц, цуглуулгад байгаа аргуудын талаар тусад нь слайд бэлдэж болно.

#### Нэмэлт материал:

RAND Corp. 1996. Guidelines for Preparing Briefings. Santa Monica (California): RAND Corporation.

Ratcliffe, Jerry H. 2004. "Jerry's Top Ten Crime Mapping Tips." Last modified October 22, 2014. [Http://www.jratcliffe.net/blog/ten-crime-mapping-tips/](http://www.jratcliffe.net/blog/ten-crime-mapping-tips/).

<p><b>1. XYZ асуудал, зөрчилд юу нөлөөлж байна бэ?</b></p> <p><b>Ахлагч Смит Асуудлын дүн шинжилгээний бүлэг</b></p>	<p><b>2. XYZ асуудал гэж юу бэ?</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Мэдээлсэн X үйл явдлын тоо өндөр</li> <li>Ү салбарт төвлөрсөн</li> <li>Анх 1986 онд баримтжуулсан</li> <li>Хуулийг сахиулахад сайн тохирдоггүй</li> <li>Бусад цагдаагийн байгууллагад нийтлэг түгээмэл байдаг</li> </ul>
<p><b>3. Энэхүү танилцуулгад дараах зүйлсийг танилцуулна.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Ашигласан мэдээллийн эх сурвалж</li> <li>Мэдээллийг хэрхэн зохион байгуулсан тухай</li> <li>Яагаад бидэнд ийм асуудал тулгараад байгаа тухай</li> <li>Боломжит хариултууд</li> </ul>	<p><b>4. XYZ асуудлын Дүн шинжилгээ</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Асуудлын дүн шинжилгээ хийх хэсэг</li> <li>Төрөл бүрийн эх сурвалжаас авсан мэдээлэл <ul style="list-style-type: none"> <li>- Мэдээлсэн X үйл явдал</li> <li>- Худалдаачид болон худалдан авагчидтай хийсэн ярилцлага</li> <li>- Гэмт этгээдийн ярилцлага</li> <li>- Хяналтын камерын бичлэгийн тойм</li> </ul> </li> <li>Бусад цагдаагийн байгууллагын мэргэжилтнүүд</li> </ul>

**5. XYZ асуудлын Бүрэлдэхүүн хэсгүүд**



**6-13.**



Бай, өртөгч, хамгаалагчийг илэрхийлэх слайд



Байрлал, менежерийг илэрхийлэх слайд



Гэмт хэрэгтэн, харьцагчийг илэрхийлэх слайд

**14. XYZ асуудлын шалтгаанууд**



Өмнөх слайдуудын тоочсон тэмдэг Бүхий дүгнэлт

**15. Үл тохиорх хариултууд бай, өртөгчид:**

- Бай, өртөгчид:
  - A.
  - B.
- Газар, менежер
  - A.
  - B.
- Гэмт хэрэгтэн, харьцагч
- A.

**16. Тохиорх хариултууд**

- Бай, өртөгчид:
  - A.
  - B.
- Газар, менежер
  - A.
  - B.
- Гэмт хэрэгтэн, харьцагч
- A.

# 59. Ур чадвартай илтгэгч болох

**Б**үх мэргэжилтнүүд илтгэл тавих шаардлага тулгарах бөгөөд илтгэх ур чадвар нь бичгийн чадвараас дутахгүй чухал юм. Сайн илтгэлийн гол түлхүүр бол сайтар бэлтгэх явдал юм. Дараах санаанууд нь бидний сайн ба муу туршлага зэрэг харилцан адилгүй эх сурвалжаас гаралтай.

## Танилцуулгын бэлтгэл ажил:

Хэтэрхий яarah хэрэггүй. Туршлагатай илтгэгч хүртэл сандрах тохиолдол гардаг тул илтгэл тавихын өмнө сандрахгүй байхыг хичээгээрэй. Бэлтгэл үе шат нь сандрахгүй байх, хяналттай байхыг хичээгээрэй.

- Сэдвээ сайн ойлгох
- Оролцогч болон ажиглагч нь хэн болох талаар мэдэж авах
- Илтгэлийн үргэлжлэх хугацааг тодорхойлох
- Хэдхэн минутын өмнө дуусгахад бэлтгэ, гэхдээ шаардлагатай бол бүтэн цаг зарцуулах
- Илтгэлээ давтахад цаг гаргах
- Шаардлагатай бол дахин давтах

Танилцуулга хийх өдөрт танилцуулга хийх танхим, өрөөгөө шалгаарай. Та танилцуулга хийх орчноо сайн ойлгох нь гурван зорилтыг биелүүлэхэд тусална. Нэгдүгээрт, энэ нь таныг огцом, цочирдох, сандрахаас сэргийлнэ. Хоёрдугаарт, энэ нь танд гэнэтийн зүйлсийн төлөвлөгөө гаргах боломжийг бүрдүүлдэг. Гуравдугаарт, энэ нь таныг тайван байлгахад тусална. Та өөрийн байгууллагаас гадуур илтгэл тавих, хуралд оролцох тохиолдолд энэ нь илүү үнэн бодитой байна. Зочид буудлын хурлын төхөөрөмжүүд нь зохион байгуулалтын хувьд харилцан адилгүй.

- Танд хэрэгтэй тоног төхөөрөмж бэлэн байгаа эсэх?
  - Үзүүлэн байрлуулах самбар
  - Хар/цагаан самбар
  - Шохой/маркер
  - Проектор
  - Микрофон
  - Лазер заагч
- Та тоног төхөөрөмжийг хэрхэн ашиглах талаар мэдэх үү?

- Та үүнийг ажиллуулж үзсэн үү?
- Та техникчийг хэрхэн дуудах талаар мэдэх үү?
- Та гэрлийг хэрхэн бүдгэрүүлэхээ мэдэх үү?
- Танилцуулгын явцад оролцогчид, сонсогчид таныг харах, сонсоход бэрхшээлтэй тийм газар, хэсэг байгаа эсэх ?

## Проектор

Орчин үеийн танилцуулгын тоног төхөөрөмж нь нарийн төвөгтэй бөгөөд эвдрэх нь амархан болсон. Эдгээр төхөөрөмжүүд хэрхэн ажилладгийг мэдэж, нөөц төлөвлөгөө байгаа эсэхийг шалгаарай. Хэрэв цаг гарвал бид өрөөнд байгаа тоног төхөөрөмжийг ажиллуулж, туршин шалгах нь зүйтэй. Энэ туршилтын үеэр бид танхим, өрөөний өөр өөр хэсэгт сууж, хамгийн хүндрэлтэй, нарийн төвөгтэй слайдуудыг үзэх нь ашигтай. Хэдийгээр та тохируулга хийх боломжгүй байсан ч гэсэн дараа нь оролцогчдоо урьдчилан сануулж болно. (Жишээ нь, зүүн талд суухад зарим график харахад хүндрэлтэй байгаа бол таны зүүн талын хүмүүс танхиминын гол руу суухыг хүсэж болно.)

- Проекторыг үзэгчдэд болон өөртөө хамгийн тохиромжтой байрлалд байрлуулаарай.
- Проектор нь дэлгэцийн харагдах байдлыг хааж байгаа эсэхийг шалгаарай.
- Шаардлагатай бол слайдыг танилцуулахдаа тусламж аваарай.
- Слайдуудыг өрөөний арын хэсгээс унших боломжтой эсэхийг шалгаарай.
- Шаардлагатай бол хөшгөө хаагаарай.
- Бүх зүйл төлөвлөсний дагуу болно гэж бүрэн найдах хэрэггүй.

## Танилцуулга, илтгэлийн хэв маяг

Хэдийгээр танилцуулах материалыа судалж мэдэх нь маш чухал боловч үзэгчдэд ойлгомжтой байдлаар танилцуулгын төрлийг сонгох хэрэгтэй. Үзэгчид таны танилцуулгыг хялбар ойлгож байхаар хялбар байх хэрэгтэй. Үзэгчдэд хүндэтгэлтэй хандах нь туйлын чухал юм.

- Бичгийн хувилбарыг өгсөн байсан ч гэсэн цаасаа байнга бүү унш.
  - Тэмдэглэлээ харах, санаа авч ярих (карт ашиглах нь таныг сэдвийн дарааллаа алдахаас сэргийлдэг).
  - Эелдгээр өхлээрэй (үзэгчдэд баяр хүргэх, өөрийгөө танилцуулах, үзэгчидтэй мэндлэх гэх мэт).
  - Боломжтой бол босоод яриарай (энэ нь үзэгчдийг хяналтдаа авахад тусалдаг).
  - Урт илтгэл тавих явцад та зогсох байрлалаа өөрчилж болно. (гэхдээ яаруу сандруу алхаж болохгүй).
  - Оролцогчид слайдыг харахад бүү саад болоорой.
  - Оролцогчид таныг сонсож чадаж байгаа эсэхийг шалгаарай.
  - Хэтэрхий хурдан ярьж болохгүй (минутад 120 орчим үг тохиромжтой).
  - Оролцогчидтой нүдээрээ харьцах харьцаагаа нэгэн хэвийн хадгалах (гэхдээ нэг хүнийг удаанаар ширтэж болохгүй).
  - Оролцогчид асуулт асуухад тохиромжтой цаг хугацааны (илтгэлийн үеэр эсвэл дараа нь гэх мэтээр) талаар мэдэж байгаа эсэхийг шалгаарай.
  - Бусад хүмүүс сонсож, товч хариулж, тэд асуултад бүрэн хариултаа авсан эсэхийг шалгах зорилгоор асуултуудыг давтаарай.
  - Тараах материал ойлгомжтой, тодорхой байгаа эсэхийг шалгаарай (хүрэлцээтэй эсэхийг асуух).
  - Цагтаа дуусга.
  - Та өөрөө баяр хөөртэй байгаарай!
- нэлээд нарийн төвөгтэй. Дөрөвдүгээрт, программ нь хүмүүсийн асуулт асуух боломжийг хязгаарладаг. Та компьютерын программтай удтал ноцолдохыг харахад хүмүүст уйтгартай байдал үүсгэж, тэднийг залхааж, цагийг нь дэмий үрдэг. KIS зарчмыг санаарай: Энгийн, хялбар, ойлгомжтой байх зарчмыг баримтлаарай.
- Слайдыг шууд унших хэрэггүй. - таны яриа нь слайдыг давтсан уншлага байж болохгүй.
  - Слайд руугаа биш хүмүүс рүүгээ хар!
  - Пресентаци, танилцуулгын сэдэв, гарчиг, өөрийн нэр, байгууллагын танилцуулгаар эхлээрэй (гэхдээ таны мэргэшлээр биш).
  - Слайд хоорондын шилжилтийн зөвхөн нэг хэлбэрийг ашигла, үзэгчдийн анхаарлыг гол зүйлээс нь сарниулахгүй тулд энгийн шилжилтийг (power point-ийн слайд хоорондын шилжилт) ашиглаарай.

### **Powerpoint –ийн Өөрийн зохиосон слайдууд**

Слайд бүр энгийн байх хэрэгтэй. Слайд дээр хэт их текст байх нь текстийг уншихад хэцүү, сонирхолгүй болгоно. Таны зорилго бол слайд бүрийг ерөнхийд нь танилцуулах явдал юм. Слайд бүр нь чухал цэг дээр анхаарлаа төвлөрүүлж, анхаарал сарниулахаас зайлсхийсэн байх, слайдыг унших, ойлгоход хялбар байх хэрэгтэй.

- Танилцуулгадаа зөвхөн нэг л сэдвээр яриарай.
- Асуудлыг шийдвэрлэхэд хангалттай дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.
- Анхаарал сарниулах дууны эфект, хөдөлгөөнтүрс, үсгийн маяг, шилжилтийг аль болох бага ашиглана.
- Текстийн хувьд бараан дэвсгэр (жишээ нь, гүн цэнхэр) болон цайвар өнгийг (жишээ нь, шар) ашиглаарай.
- Том фонт, тод өнгөнүүдийг ашиглана (өнгөнүүд хоорондоо нийцэхгүй байж болохгүй. Жишээ нь хөх ба тод улбар шар өнгө хоорондоо зохицгүй, харин хөх ба шар өнгөнүүд бие биеэсээ тод ялгардаг).
- Арын дэвсгэрээс ялгагдахааргүй нарийн зураас, үсгээс зайлсхий. Жишээ нь шугаман диаграмм, газрын зурагт энэ дүрмийг сайтар мөрдөөрэй.
- Хэт улаан өнгөнөөс зайлсхий - чухал зүйлийг онцлон тэмдэглэхийн тулд улаан

өнгийг сонгоорой.

- Боломжтой бол уг хэллэгээс илүү дүрслэл, графикийг ашигла.
- Тодорхой бөгөөд энгийн зураг, газрын зураг, зураг, хүснэгтийг ашигла.
- График дээр өгүүлэмж биш харин тооцсон цэгийг ашигла.
- Тоочих цэгүүд нь слайдын гол сэдэвтэй холбоотой эсэхийг шалгаарай.

### Эцэст нь аюулгүй байх

Аливаа нэг зүйл буруугаар эргэж болно гэдгийг ойлгоорой. Хэрэв проектор эвдэрвэл нэмэлт слайд болон проектор бэлэн байх хэрэгтэй. Хэрэв энэ нь боломжгүй бол тараах материалыаар орлуулж болно. Хэрэв та тоног төхөөрөмж эвдрэхэд бэлтгэгдсэн бол бага сандарч, хүмүүс бухимдах, ундууцах нь бага байна.

- Байнга эвдэрдэг эсвэл сайн мэдэхгүй төхөөрөмжөөс зайлсхий.
- Тоног төхөөрөмж, программ хангамжийн доголдсон, эвдэрсэн үед хэрэгжүүлэх нөөц төлөвлөгөөтэй байх.
- Слайд тараах материалыг нэмэлтээр өгөх.

### Нэмэлт материал:

Ratcliffe, Jerry H. 2004. "Jerry's Top Ten powerpoint Tips." Last modified October 20, 2014. <Http://www.jratcliffe.net/blog/powerpoint-tips/>.

## 60. Мэдлэг, мэдээлэл хадгалах, хуриатлуулахад хувь нэмрээ оруулах

 нэөдөр бидний сайн мэддэг зүйлс одоогоос 20 жилийн өмнө бидэнд сураг нь ч дуулдаагүй зүйлс байсан. Энэхүү мэдлэгийн хуриатлал нь АНУ, Канад, Их Британи болон бусад орны цагдаа, судлаачид мэдлэгээ хуваалцаж байгаатай холбоотой юм. 54-59-р алхмууд нь цагдаагийн байгууллага болон орон нутгийнхаа шийдвэр гаргагчидтай хэрхэн харилцах талаар тайлбарласан. Та мөн өөрийн орон нутгийн агентлаг, орон нутгийн гадна өөрийн мэдлэг, туршлагаа хуваалцах замаар өөрийн мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх үүрэгтэй.

Мэргэжил нэгт нөхөдтэйгөө харилцах хоёр арга зам бий. Эхнийх нь текст материалыаар дамжуулна. Эдгээрийг тайлан, мэргэжлийн тогтмол сэтгүүл, хэвлэл эсвэл алдартай хэвлэлийн нийтлэлд нийтэлж болно. Хоёр дахь нь мэргэжлийн хурал, уулзалтад илтгэл тавих явдал юм. Мэдээлэл дамжуулах хамгийн үр дүнтэй арга бол эдгээр аргуудыг хослуулан ашиглах явдал юм.

Бичгэн материал, тайлан нь бусад хүмүүс лавлах материал болгон ашиглахад тохиромжтой, дэлгэрэнгүй, чухал хэрэгцээтэй мэдээллийг агуулдаг. Бичгээр мэдээлэл түгээх хэд хэдэн арга байдаг. Мэдээллийг веб сайтаар танилцуулах боломжтой. Үүнийг мэргэжлийн тогтмол хэвлэлд нийтэлж болно. Хүмүүсийн анхаарлыг татах зорилготой богино хэсгүүдийг мэргэжлийн мэдээллийн товхимол болон бусад тогтмол хэвлэлд нийтлэх боломжтой. Эцэст нь хэлэхэд, мэргэжлийн сэтгүүлчдийг таны хөдөлмөр, хичээл зүтгэлийн талаар бичихэд урамшуулах нь илүү өргөн хүрээний үзэгчдэд хүргэхэд тусална. Богинохон, хялбар, хүртээмжтэй өгүүллэгүүд нь илүү олон үзэгчдэд мэдээлэл өгөх боловч мэдээллийн агуулга багатай.

Хурал нь нүүр тулан харилцах, асуулт хариулт, сүүлийн үеийн хөгжлийн талаар ярилцах боломжийг олгодог. Албан бус хэлэлцүүлэг нь хэвлэгдээгүй, нийтлэгдээгүй мэдээлэл, үзэл санаануудын талаар санал бодлоо солилцох, мэргэжил нэгт нөхөдтэй хүндрэлтэй асуудлын

талаар туршлага солилцох, зөвлөгөө авах боломжийг олгодог.

АНУ, Их Британи улсууд жил бүр асуудалд тулгуурласан цагдаагийн байгууллагын бага хурлыг зохион байгуулдаг. Мөн дэлхийн өнцөг булан бүрт гэмт хэргийн дүн шинжилгээ хийх болон бусад чиглэлээр цагдаагийн бага хурлууд байнга зохиогддог. Та эдгээр арга хэмжээнд оролцож асуудлыг шийдвэрлэх дэвшилтэт арга зам, өөрийн туршлагын талаар шинэ мэдээлэл өгч болно.

Эцэст нь хэлэхэд хэрэв та бусад салбарын оролцогчид, түншүүдтэй хамтран ажиллаж байсан бол бусад мэргэжлийн салбарын бага хурлыганхаарч үзэх хэрэгтэй. Бага хурлын гол сул тал нь баримт материалыг танилцуулах хугацаа бага, товч, хурлын үйл ажиллагааны нарийвчилсан бүртгэл дутмаг, харьцангуй цөөн тооны хүмүүс оролцдог. Гэхдээ хурлын төлөөлөгчид хуралд оролцоогүй хүмүүст дамжуулан хэлэх, мэдээллийг түгээх боломжтой.

Харилцааны цогц стратеги нь дараах зүйлээс бүрдэнэ.

- Дэлгэрэнгүй мэдээллийг сонирхож буй хүмүүст зориулан веб сайтаас татах авах боломжтой мэдээллүүдийг байрлуулах.
- Нийтийн сонирхлыг татсан, олон нийтэд зориулсан мэргэжлийн болон алдартай тогтмол хэвлэлд нэг буюу хэд хэдэн богино өгүүлэл тавих, цахим сайтын холбоос, эшлэлийг заах,
- Мэргэжлийн хамт олон, эрдэмтэн судлаачдад зориулж мэргэжлийн сэтгүүлд дэлгэрэнгүй нийтлэл хэвлүүлэх.
- Цөөн боловч нөлөө бүхий мэргэжлийн чуулганд хамгийн багадаа дор хаяж нэг илтгэл тавих.

Үүнээс гадна, сэдвийг сонирхож буй хүмүүст зориулан нийтлэлийн хуулбарыг илгээх нь тустай. Энэ нь таны санааг дэлгэрэнгүй танилцуулахаас гадна өөрийн санаагаа бусдад хэрхэн хүргэх талаар зөвлөгөө авах боломжийг олгодог.

Мэргэжилтнүүд дараах зүйлийг онцгой анхаарал хандуулж, сонирхдог. Үүнд: шинэ нээлт, өөрчлөгдөн хувьсаж буй асуудлын мэдээлэл.

- Шинэ асуултуудад хариулах эсвэл хуучин асуултуудад илүү тодорхой, алдаагүй хариулах зорилгоор дүн шинжилгээний шинэ арга, дэвшлийг ашиглах.
- Асуудалд шинэ, бүтээлч байдлаар хандах, эсвэл хуучин арга хэмжээг шинэ байдлаар хэрэглэх.
- Үр дүнтэй байдлын талаарх баталгаа, нотолгоо, үр нөлөөгүй байдал, эсвэл хариу арга хэмжээний гаж нөлөө

Тодорхой нэг асуудлын кейс судалгаа байдлаар сэдвүүдийг бичиж болно. Чухал ач холбогдолтой кейс судалгааны үндсэн тойм нь дөрвөн зүйлийг хамарна:

1. Хуучин нөхцөл байдалд сэтгэл ханамжгүй байх – яагаад стандарт ойлголт, практик нь тодорхой нөхцөл байдалд хангалтгүй байдаг бэ?
2. Өөр хувилбаруудыг хайж олох - шинэ ойлголт, практикийг хэрхэн нээсэн бэ?
3. Хуучны болон шинэ аргуудыг харьцуулах нэмэлт хувилбарууд.
4. Дүгнэлт ба үр дагавар – хүмүүс анхаарал хандуулах, судлах шаардлагатай зүйлийн нэгдсэн хураангуй.

Энэхүү тойм нь SARA үйл явцыг дагаж мөрддөг. Сканердах нь тодорхой нөхцөл байдалд сэтгэл хангалуун бус байгааг илтгэнэ. Шинжилгээ нь асуудлын талаарх шинэ ойлголтыг эрэлхийлэх явдал юм. Хариулт нь өөр аргуудыг системтэй харьцуулах, тодорхой шинэ хандлагыг сонгохыг шаарддаг. Мөн үнэлгээ нь туршлагаас юу сурснаа нэгтгэн дүгнэдэг.

Энэхүү тоймыг кейсийн судалгааны дөрвөн сэдэв бүрт хэрхэн ашиглаж болохыг хүснэгтэд үзүүлэв. Нөхцөл байдлын дагуу эдгээр төрлийн кейс судалгааг нэгтгэж болно. Асуудлыг шинжлэх шинэ техник нь шинэ төрлийн асуудлыг илрүүлж болно. Ийм нөхцөлд эхний хоёр төрлийн кейс судалгааг нэгтгэх хэрэгтэй.

Үүний нэгэн адил, асуудалд чиглэсэн шинэ хариу арга хэмжээний талаарх тодорхойлолтод үнэлгээний мэдээллийг агуулж болох бөгөөд ингэснээр сүүлийн хоёр төрлийн кейс судалгааг нэгтгэсэн. Бусад хослуудыг ч ашиглах боломжтой.

Эцэст нь бид гэмт хэргийн шинжилгээг цагдаа хүн бүр мэргэжлийн үүднээс заавал мөрдэх зүйл болгохыг уриалж байна. Та өөрийгөө тодорхой ойлгуулахыг хүсэж байгаа ч нотлох баримтаа хэтрүүлэх уруу таталтад хэзээ ч бүү бууж өг. Баримтуудыг дэлгэн харуулахаас илүү таны болон танай хамт олны нэр хүндэд сэргээр нөлөөлөх зүйл гэж байхгүй. Бусад хөнгөн хуумгай байх, дүгнэлт гаргахад хэт яарч болох юм. Гэмт хэргийн шинжээчид заримдаа санамсаргүй үйл явц болох зүйлд хэтэрхий хичээнгүй, шударга хандах тохиолдол гардаг. Хэрэв та хариултыг мэдэхгүй эсвэл асуудлыг дутуу ойлгосон бол хэлээрэй. Ингэснээр та хариултаа олж мэдсэн цагтаа хүмүүс таны мэргэжлийн шийдвэрт илүү итгэлтэй байх болно.

21-р зуун нь цагдаагийн байгууллагад дүн шинжилгээ хийх эрин зуун болж байгаа тул та ч гэсэн энэ ажилд томоохон хувь нэмэр оруулах хэрэгтэй. Одоогоос зуун жилийн дараа цагдаагийн байгууллагад хийх дүн шинжилгээ баттай тогтож, их зүйл өөрчлөгдсөн байх болно. Мэдээж технологи хувьсан өөрчлөгдсөөр байх болно. Гэхдээ хамгийн гол нь бидний шинэ үе маань гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар биднээс илүү ихийг олж мэднэ. Та болон таны адил олон хүмүүс чухал асуулт асуулж, мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, үр дүнгээ үнэн зөв, тодорхой мэдээлж, мэдлэг үеэс үед улиран дамжсаар бидний шинэ үе биднээс илүү өндөр үр дүнд хүрэх нь дамжиггүй.

Кейс судалгааны дөрвөн төрөл				
Ерөнхий тойм	1. Шинэ асуудал	2. Шинэ дүн шинжилгээний арга техник	3. Шинэ хариу арга хэмжээ	4. Үр дүнтэй байдлын талаарх шинэ баталгаа, нотолгоо
I. Сэтгэл ханамжгүй байдал	Хэвийн бус нөхцөл байдлыг олж илрүүлэх	Хуучин арга техник яагаад хязгаарлагдмал байdag вэ?	Яагаад хуучин арга хэмжээ хязгаарлагдмал байdag бэ?	Тодорхой нөхцөл байдалд хариу арга хэмжээний үр дүнгийн тодорхой бус байдал
II. Эрэл хайгуул	Юу ялгаатай болохыг судлах	Шинэ арга техникийг хэрхэн нээсэн бэ?	Шинэ хариу арга хэмжээг хэрхэн нээсэн бэ?	Эдгээр нөхцөл байдалд хариу арга хэмжээг үнэлэхэд гарах хүндрэл
III. Баталгаа, нотолгоо	Хуучин асуудлыг шинэ асуудалтай харьцуулах	Шалгуур үндэслэлд тулгуурлан хуучин арга техникийг шинэ арга техниктэй харьцуулах	Шалгуур үндэслэлд тулгуурлан хуучин арга техникийг шинэ арга техниктэй харьцуулах	Ашигласан үнэлгээний аргууд болон түүний үр дүн
IV. Дүгнэлт	Асуудлыг шийдвэрлэхэд энэ нь ямар ач холбогдолтой бэ?	Шинэ арга техник үр дүнтэй байх нөхцөл байдал	Шинэ арга техник үр дүнтэй байх нөхцөл байдал	Хариу арга хэмжээг ашиглавал зохих нөхцөл байдал, төлөвлөсөн үр дүн

Энэхүү баримт бичгийг хөрвүүлэх явцад гарсан зөрүүтэй ойлголтод зохиогчид хариуцлага хулээхгүй болно.



**Гурван хэмжээст зураглал (3-D Mapping):** Барилга доторх байршлыг дүрсэлсэн өндөр нарийвчлалтай зураглал - 24 дүгээр алхам

**80-20 дүрэм:** Аливаа зүйлийн үр дүн, үйл явдал зэргийн дийлэнх хувь цөөн хэдэн хүн, газарт төвлөрдөг зарчим - 18, 20, 22, 30, 31, 54 дүгээр алхам

**Хурц, гэнэтийн халуун цэгүүд (гэмт хэргийн төвлөрөл өндөр бүхий газар, цэг):**

Гэнэт шинээр гарч ирсэн гэмт хэргийн төвлөрөл өндөр бүхий газар, цэгүүд (архаг цэг, асуудлуудыг үзнэ үү) - 23 дугаар алхам

**Цаг хугацааны хурц, гэнэтийн бөөгнөрөл:** Өдрийн аль нэг цагт гэмт хэргийн гаралт маш өндөр төвлөрөлтэй байх - 25 дугаар алхам

**Хурц, гэнэтийн асуудлууд:** Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны хүрээнд шийдвэрлэх шаардлагагүйгээр аажмаар алга болох, тодорхой давтамж бүхий асуудлуудыг хэлнэ. Ийм асуудал нь архаг болж хувирах эрсдэлтэй - 14 дүгээр алхам

**Дасан зохицох:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хариуд гэмт хэрэгтнүүдийн үйл хөдлөл, зан үйлд урт хугацаанд орох өөрчлөлт - 11, 46 дугаар алхам

**Дүн шинжилгээ:** "SARA" үйл явцын хоёр дахь үе шат. Аливаа асуудлын учир шалтгааныг олж мэдэх, улмаар зохих хариу арга хэмжээг боловсруулах зорилгоор тухайн асуудалд системчилсэн дүн шинжилгээ хийх - 4, 5, 6, 7, 8, 14, 15, 16, 18, 20, 23, 32, 33, 35, 36, 38, 44, 46, 52, 54, 55, 58, 60 дугаар алхам

**Урьдчилсан таамаглалын ач холбогдол, нөлөөлөл:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ эхлэхээс өмнө гарах үр өгөөж, ач холбогдол, нөлөөлөл - 11, 46, 52 дугаар алхам

**Урьдчилсан таамаглалын ач холбогдол, нөлөөлөл үүссэн мэт харагдах:** Өгөгдлийг жигдруулж, тэгшитгэснээс (жишээ нь, хөдөлгөөнт дунджийг ашиглах) шалтгаалж урьдчилсан таамаглалын ач холбогдол, нөлөөлөл үүссэн мэт харагдах байдал - 52 дугаар алхам

**Аористик дүн шинжилгээ:** Гэмт хэрэг үйлдсэн цаг нь тодорхойгүй үед гэмт хэргийн 24 цагийн хэмнэлийг тодорхойлох замаар тогтоох статистикийн арга зам - 25 дугаар алхам

**Үнэлгээ:** "SARA" үйл явцын дөрөвдүгээр үе шат. Энэ шатанд хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний үр дүнтэй байдлыг үнэлнэ - 1, 4, 7, 24, 37, 38, 46, 54, 55, 60 дугаар алхам

**Гэмт хэрэгт татагч хүчин зүйл, гэмт хэрэг:** Гэмт хэрэгтнүүдийн сайн мэддэг, гэмт хэрэг үйлдэх нөхцөл, боломж бүрдсэн газар - 17, 28 дугаар алхам

**Гэмт хэрэгтний зан төлөв:** Хор хөнөөл, зорилго, гэмт хэрэгтэн-бай хоорондын харилцаанд тулгуурласан асуудлыг ангилах шалгуурын нэг ("Орчин"-ы тайлбарыг үзнэ үү) - 15 дугаар алхам

**(Нэг ижил бай, хохирогчийг дахин сонгохыг) Дэмжих хүчин зүйлс:** Хүртэх өгөөжөө харгалзан ижил хохирогчийг дахин байгаар сонгох эсвэл танил этгээдүүддээ



# НЭР ТОМЬЁО

тухайн хохирогчийн талаар мэдээлэх замаар нэг ижил хохирогч давтан гэмт хэргийн бай болох хандлагыг тайлбарлах хүчин зүйлс - 29 дүгээр алхам

**Өргөн хүрээ бүхий арга хэмжээ:** Аливаа гэмт хэргийг үйлдэхэд хэрэглэх янз бүрийн арга техник, тактикт үзүүлэх өргөн хүрээ бүхий урьдчилан сэргийлэх арга хэмжээ - 49 дүгээр алхам

**Хагархай цонхны бодлого:** Жижиг, хөнгөхөн зөрчил нийгмийн амьдралыг бусниулдаг, улмаар илүү том зөрчил, гэмт хэрэг үүсэхийг өдөөдөг. Иймд цагдаагийн үйл ажиллагаа хүрээнд жижиг, хөнгөхөн зөрчилд онцгой анхаарал хандуулах ёстай гэсэн зарчимд сууринсан бодлого - 5 дугаар алхам

**Буфер бүс, газар:** Газар, тухайн газрын эргэн тойрон дахь бүс. Ихэвчлэн гэмт хэрэг гарсан объект, гэмт хэргийн төвлөрөл өндөр бүхий газар, цэг, хариу арга хэмжээ авсан газрын зэргэлдээх бүс, газар - 16, 51 дүгээр алхам

**Кейс-хяналтын судалгаа:** Асуудлыг үүсгэж болох шинж чанаруудыг олж мэдэхийн тулд асуудал үүсгэж буй хүмүүс, газар, цаг хугацаа, үйл явдлыг асуудалгүй газар, цаг хугацаа, үйл явдал, хүмүүстэй системчилсэн байдлаар харьцуулах арга. Хүндрэлтэй тохиолдлууд бүх тохиолдлын маш бага хувийг өзэлж байгаа үед энэ төрлийн судалгаа нь ач холбогдолтой юм.

**Кейсүүд:** Таны судалж буй хүмүүс, газар болон үйл явдлууд - үүнд гэмт хэрэгтэн, бай, хохирогч, объект, цаг хугацаа (жишээ нь: сар эсвэл долоо хоног), гэмт хэрэг зэрэг багтана. Кейс-хяналтын судалгаанд кейсүүд нь асуудалтай хүмүүс, газар эсвэл үйл явдлыг илтгэнэ (Кейс-хяналтын судалгаа ба Хяналтыг үзнэ үү) - 22, 32, 33, 37, 53 дугаар алхам

**"CHEERS" сорил:** Community (олон нийт), Harm (хор хөнөөл), Expectation (хүлээлт, шаардлага), Events (үйл явдал), Recurring (давтагдал, тогтмол давтамж бүхий), ба Similarity (ижил төстэй байдал) гэсэн англи угнуудийн товчлол. Эдгээр нь асуудлыг тодорхойлох элементүүд юм - 14, 15, 54 дүгээр алхам

**Архаг халуун цэг, гэмт хэргийн төвлөрөл өндөр бүхий газар, цэгүүд:** Удаан хугацаагаар асуудалтай байдаг газар, цэгүүд (Гэнэтийн, хурц халуун цэг хэсгийг үзнэ үү) - 23 дугаар алхам

**Архаг асуудлууд:** Урт хугацаанд давтагдах үйл явдлууд буурахгүй үргэлжилсээр байх, мөрдөн шалгах арга хэмжээнд тэсвэртэй үргэлжлэх асуудлууд - 14 дүгээр алхам

**Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа:** Уламжлалт хууль сахиулах ажиллагаа, мөн урьдчилан сэргийлэх, асуудал шийдвэрлэх, олон нийттэй хамтрах, түншлэлийг харилцаанд орох зэргийг хослуулах замаар гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхийг эрмэлздэг арга барил - 1, 3, 4, 5 дугаар алхам

**КомпСтат (CompStat):** Нью-Йорк хотод анх боловсруулсан цагдаагийн удирдлагын систем. Тус систем нь бүс нутаг (жишээ нь, тойрог, дүүрэг) хариуцсан этгээдэд тухайн бүс нутгийн гэмт хэргийн хэв маягийн сүүлийн үеийн мэдээлэлд (газарзүйн мэдээллийн системээр боловсруулсан мэдээлэл) тулгуурлан гэмт хэрэг бууруулах



үүргийг оногдуулж, хариуцлага тооцох- 3, 4, 5 дугаар алхам

**Агуулга:** Хүснэгт эсвэл зураглал дахь мэдээлэл - 56, 57 дугаар алхам

**Хяналтын бүлэг:** Арга хэмжээ авч хэрэгжүүлж буй газар, бүлэг хүмүүстэй төстэй боловч тухайн арга хэмжээний нөлөөлөлд өртдөггүй газар, бүлэг хүмүүсийг хэлнэ. Аливаа арга хэмжээний үр дүнг үнэлэхэд хэрэглэнэ - 47, 49, 51 дүгээр алхам

**Хяналтууд (дүн шинжилгээний зорилгоор):** Тодорхой хүчин зүйлийн нөлөөллийг бусад хүчин зүйлээс тусгаарлаж, дүгнэх зорилготой статистикийн, үнэлгээний аргачлал. Аливаа арга хэмжээ аваагүй газар, бүлэг хүмүүсийг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн газар, бүлэг хүмүүстэй харьцуулна (Хяналтын бүлгийг үзнэ үү) - 47, 48, 49, 51 дүгээр алхам

**Хяналтууд (кейс-хяналтын судалгаанд):** Кэйс-хяналтын судалгаанд хяналтууд гэдэг нь судалж буй үр дүнд өртөөгүй хүмүүс, байрлал, цаг хугацаа, нөхцөл байдлуудыг хэлнэ. Жишээ нь: хүчирхийлэл, зодоон их гардаг бааранд хийж буй судалгааны хувьд кейс нь хүчирхийлэл, зодоон их гардаг баар, харин хяналт нь хүчирхийлэл, зодоон бага гардаг баар юм (Кэйс, кейс-хяналтын судалгааг үзнэ үү) - 32, 33 дугаар алхам

**Хяналтууд (гэмт хэрэгтэнд):** Хэрэг үйлдэж болзошгүй этгээдийн гэмт хэрэг үйлдэх санаа зориг, чадавхыг бууруулах нөхцөл байдал, хүмүүсийг хэлнэ.

**Корреляц буюу хамаарал:** Хоёр үзүүлэлт хоорондын хамаарлыг хэмжих үзүүлэлт - 33 дугаар алхам

**Өртөг зардал:** Гэмт хэрэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой зардал, хүндрэл, чирэгдэл, зардал - 6, 12, 38, 40, 44 дүгээр алхам

**Орчны зохион байгуулалтад тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх (CPT-ED):** (Crime Prevention Through Environmental Design)

**Хулгайд өртөх магадлал ихтэй эд зүйлсийн шинж чанарыг тодорхойлох (CRAVED):** Concealable (нуух далдах боломжтой), Removable (салгах боломжтой), Available (бэлэн), Valuable (үнэ цэнтэй), Enjoyable (сонирхол бүхий), Disposable (худалдах боломжтой) - 28, 31 дүгээр алхам

**Гэмт хэргийн зураглал, газрын зураг:** Газрын зураг дээр дүрслэн үзүүлэх замаар газар зүй, нутаг дэвсгэрт гэмт хэрэг хэрхэн тархахыг шалгах - 1, 4, 5, 16, 17, 21, 23, 24, 29, 55, 58 дугаар алхам

**Орчны зураглал гарган гэмт хэргээс урьдчилан сэргийлэх (Crime prevention through environmental design):** Барилга байгууламж, олон нийтийн зохион байгуулалтыг өөрчилж, харуул хамгаалалтыг нь сайжруулах зарчмууд - 24 дүгээр алхам

**Гэмт хэргийн гурвалжин:** Асуудлын дүн шинжилгээний гурвалжныг үзнэ үү - 8, 35, 54, 58 дугаар алхам

**Гэмт хэргийн хувьд саармаг газар:** Гэмт хэрэгтэн болон байг өөртөө татдаггүй, гэх мэт хэргийн шинж чанартай зан төлөв, үйл хөдлөлд хяналт тавих боломж бүхий газар - 17 дугаар алхам



# НЭР ТОМЬЁО

**Гэмт хэргийн цикл, мөчлөг:** Хүмүүсийн өдөр, долоо хоног, сар, жил эсвэл түүнээс урт хугацаа бүхий амьдралын хэмнэл, мөчлөгийг даган өөрчлөгдөх гэмт хэргийн хэлбэлзэл - 22, 25, 26, 47, 50 дугаар алхам

**Эсэргүүцэл:** Гэмт этгээдүүд урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эсэргүүцэж, өмнөхөөс их гэмт хэрэг үйлдэх явдал - 11 дүгээр алхам

**Ичээний асуудал (газар):** Гэмт хэрэг байнга гардаг газар. (Асуудалд дүн шинжилгээ хийх гурвалжныг, газрыг үзнэ үү). Энэ нь хэрэг үйлдэж болзошгүй этгээд болон бай нь хараа хяналт, хамгаалалт сул газарт олон удаа тааралдахад үүсдэг - 8, 15 дугаар алхам

**Сарнимал, тархмал цаг хугацааны бөөгнөрөл:** 24 цагийн цикл хугацаанд гэмт хэрэг харьцангуй нэгэн жигд, эсвэл санамсаргүй байдлаар тархсан байх - 25 дугаар алхам

**Эерэг үр дагаврын тархалтын улмаас гаж нөлөө үүсэх буюу бохирдох:** Үнэлгээний үед хяналтын бүлэг, газарт эерэг үр дагавар тархаж, нөлөөлөх үед тохиолдоно. Энэ нь арга хэмжээний үр дүнг буруу буюу дутуугаар үнэлэхэд хүргэдэг (Гэмт хэргийн шилжилт хөдөлгөөний тархалт үүсэж бохирдуулах хэсгийг үзнэ үү) - 51 дүгээр алхам

**Эерэг нөлөөллийн тархалт:** Урьдчилан сэргийлэх арга хэмжээний эерэг нөлөөлөл тухайн арга хэмжээний зорилго, хүрээнээс гадуурх зүйлсэд тархаж нөлөөлөхийг хэлнэ. Үр дүнгийн үржвэр бүхий нөлөө юм - 11, 13, 38, 47, 49, 51 дүгээр алхам

**Гэмт хэргийн төрлөөр эерэг нөлөөллийн тархалт:** Зорилгоосоо гадуурх гэмт хэргийн төрлүүдийг хязгаарлах - 13 дугаар алхам

**Газар зүйн эерэг нөлөөллийн тархалт:** Зорилгоосоо гадуурх газар, орон зайд урьдчилан сэргийлэх арга хэмжээ нөлөөлөх - 13 дугаар алхам

**Тактик арга барил дахь эерэг нөлөөллийн тархалт:** Урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд зорилгоосоо гадуурх гэмт хэргийн арга хэмжээг нэмэлтээр хязгаарлах - 13 дугаар алхам

**Байгаа байдал дахь эерэг нөлөөллийн тархалт:** Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зорилгоос гадуурх бай, өртөгч нэмэлтээр хамгаалагдах - 13 дугаар алхам

**Цаг хугацаанд хамаарах эерэг нөлөөллийн тархалт:** Тодорхой цаг хугацаанд нэмэлт урьдчилан сэргийлэлт авах - 13 дугаар алхам

**Эерэг нөлөөллийн тархалт, гэмт хэргийн шилжилт хөдөлгөөнд өртөмтгийн газрууд:** Хяналтын, арга хэмжээ авч хэрэгжүүлсэн газраас тусдаа бөгөөд эерэг нөлөөллийн тархалт, гэмт хэргийн шилжилт хөдөлгөөнийг илрүүлэх зорилго бүхий газрууд - 51 дүгээр алхам

**Гэмт хэргийн шилжилт хөдөлгөөн:** Гэмт хэрэгтэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хариуд өөрийн зан үйл, үйл хөдлөлөө өөрчлөх - 1, 4, 11, 12, 13, 38, 40, 46, 48, 49, 50, 51, 54 дүгээр алхам

**Гэмт хэргийн шилжилт хөдөлгөөний улмаас гаж нөлөө үүсэх буюу бохирдох:** Үр



дүнтэй байдлын үнэлгээний үед хяналтын газар, бүлэг руу гэмт хэргийн шилжилт хөдөлгөөн хийгдэхэд үүснэ. Энэ нь үр дүнтэй байдлыг хөөрөгдөхөд хүргэдэг (Шилжилтийн тархалт хэсгийг үзнэ үү) - 48, 49 дүгээр алхам

**Гэмт хэргийн шилжилт хөдөлгөөний эсрэг арга хэмжээ:** Таамаглаж буй гэмт хэргийн шилжилт хөдөлгөөнөөс сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ - 48 дугаар алхам

**Гэмт хэргийн төрлөөрх шилжилт хөдөлгөөн:** Гэмт хэрэгтэн хэргийн төрлийг өөрчлөх - 12, 13, 49 дүгээр алхам

**Газар зүйн шилжилт хөдөлгөөн:** Гэмт хэрэгтэн нэг газраас нөгөө газарт шилжин гэмт хэрэг үйлдэх - 12, 13, 46, 48 дугаар алхам

**Арга замаарх шилжилт хөдөлгөөн:** Гэмт хэрэгтэн хэрэг үйлдэх арга хэлбэрээ өөрчлөх - 12, 13, 49 дүгээр алхам

**Байгаа байдал дахь шилжилт хөдөлгөөн:** Гэмт хэрэгтэн гэмт хэргийн байг өөрчлөх - 12, 13, 49 дүгээр алхам

**Цаг хугацаанд хамаарах шилжилт хөдөлгөөн:** Гэмт хэрэгтэн хэрэг үйлдэх өдөр, цаг хугацаагаа өөрчлөх - 12, 13, 48, 49 дүгээр алхам

**Хуваарилалт:** Хэдэн хэрэг гарсан, тухайн хэрэг зөрчилд хэдэн хувийг эзэлж байгаа зэргийг илэрхийлнэ - 22 дугаар алхам

**Галууны асуудал:** Хэрэг зөрчилд тодорхой нэг ижил хохирогч олон дахин өртөхийг (гэмт хэргийн гурвалжин хэсгийг үзнэ үү) хэлнэ. Хохирогч нь өөр өөр газруудад хэрэг үйлдэж болзошгүй этгээдтэй тааралдахдаа хараа хяналтаа сайжруулахгүй, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахгүй, хохирогчийн асран хамгаалагч байхгүй зэрэг тохиолдолд үүснэ - 8, 15 дугаар алхам

**Газар, бусийн зааг хязгаар:** Амьдрах, ажиллах, худалдаа, бизнес эрхлэх, чөлөөт цагаа өнгөрөөх газар, бусийн хоорондох хил буюу зааг, хязгаар - 16 дугаар алхам

**Гэмт хэрэг үйлдэх нөхцөл, боломжийг бүрдүүлэгч:** Гэмт хэргийн шинж чанартай зан төлөв, үйл хөдлөлд хяналт тавьдаггүй газрууд - 17 дугаар алхам

**Орчин:** Хэрэг, асуудал тохиолдож байгаа газраар нь асуудлыг тодорхойлох, ангилах шалгуур (Зан төлөв, үйл хөдлөлийг үзнэ үү) - 15, 28, 30 дугаар алхам

**Дэмжигч хүчин зүйл:** Гэмт хэрэг үйлдэхэд туслах, дэмжих бүхий нөлөө үзүүлэх биет хүчин зүйл, нийгмийн нөхцөл байдал эсвэл бодис- 34 дүгээр алхам

**Бодис бүхий дэмжигч хүчин зүйлс:** Эрсдэл, гэмт хэргээс авах ашиг, шалтаг зэргийг үл тоомсорлохыг дэмжигч бодис - 34 дүгээр алхам

**Биет дэмжигч хүчин зүйлс:** Гэмт хэрэгтэн урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг ялан дийлэх, даван туулахад туслах, эсвэл хэрэгтний сэтгэл санаанд нөлөөлөх эд зүйлс - 34 дүгээр алхам

**Нийгмийн нөхцөл байдал бүхий дэмжигч хүчин зүйлс:** Гэмт хэрэгтэн гэмт хэргээс олох ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, гэмт хэрэг үйлдэх шалтаг, сэдлийг төрүүлэх замаар гэмт хэрэг үйлдэхийг дэмжигч нийгмийн нөхцөл байдал - 34 дүгээр алхам

**Объект:** Сургууль, бизнесийн газрууд, ресторан гэх мэт тодорхой чиглэлээр үйл

ажиллагаа явуулдаг газрууд - 15, 18, 20, 23, 25, 27, 28, 30, 34, 38, 39, 42, 43, 44, 48 дугаар алхам

**Эрсдэлтэй объект:** Гэмт хэрэг, зөрчил байнга гардаг, давтамж ихтэй байгууламж, байгууллага, газар - 18, 20, 23, 27, 28, 29, 34, 44 дүгээр алхам

**Худал сөрөг:** Шийдвэр гаргагч сөрөг таамаглал буюу аливаа үр дүн үүсэхгүй гэх таамаглал дэвшигүүлсэн боловч тухайн үр дүн үүсэх нөхцөлийг хэлнэ. Үүнийг 1 дүгээр төрлийн алдаа гэж нэрлэдэг - 37, 53 дугаар алхам

**Худал эерэг:** Шийдвэр гаргагч эерэг таамаглал буюу аливаа үр дүн үүснэ гэх таамаглал дэвшигүүлсэн боловч тухайн үр дүн үүсэхгүй байх нөхцөлийг хэлнэ. Үүнийг 2 дугаар төрлийн алдаа гэж нэрлэдэг - 37, 53 дугаар алхам

**Туг хүчин зүйлс:** Аливаа этгээд нь гэмт хэрэгт өртөх магадлал өндөр бүхий бүтээгдэхүүн буюу халуун бүтээгдэхүүн эзэмшдэг эсвэл мэргэшлээсээ шалтгаалан хэрэг, зөрчилд дахин дахин өртдөг нөхцөл байдлыг тайлбарлах онол (Дэмжих хүчин зүйлс хэсгийг үзнэ үү) - 29 дүгээр алхам

**Цаг хугацааны хувьд төвлөрсөн гэмт хэрэг:** 24 цагийн хугацаанд тодорхой цагуудад гэмт хэрэгт илүү төвлөрөх үзэгдэл - 25 дугаар алхам

**Түүх, өгүүлэлмжийн тогтолцоо:** Олон асуудалд хамаарахуйц олон тооны харилцан үйлчлэх хүчин зүйлсийг нэгтгэдэг "түүх, өгүүлэлмжийн бүрхүүл".

**Гэмт хэрэг үүсгэгч:** Гэмт хэрэг үйлдэх сэдэлтэй холбоогүй шалтгаанаар олон хүмүүс татагдах газар

**Газарзүйн мэдээллийн систем (GIS):** Мэдээллийг газар зүйн байрлалуудад холбосон, зураглах үүсгэх боломж бүхий цахим өгөгдлийн сан. Энэ нь нэг ижил мэдээлэлд үндэслэн өөр өөр байрлал, газруудыг харьцуулах, хоёр ба түүнээс дээш төрлийн мэдээлэл газар зүйн хувьд хамтдаа өөрчлөгдөх эсэхийг тодорхойлох боломжийг олгодог. Газар зүйн мэдээллийн систем бол орчин үеийн гэмт хэргийн зураглалын үйл ажиллагааны гол хэсэг юм.

**Үе шаттай хариу арга хэмжээ:** Давтан хохирогчийн тоо нэмэгдэх хэрээр эрчимжих хариу арга хэмжээг хэлнэ. Давтан хохирогчийн тохиолдлыг бууруулах зорилготой арга хэмжээ юм - 29 дүгээр алхам

**Хариуцагч:** Гэмт хэрэгтнийг сайн мэддэг, гэмт хэрэгтний үйл хөдлөлд хяналт тавих, шахалт үзүүлэх боломж бүхий этгээд - 25, 28 дугаар алхам

**Дотоод хэргийн яам:** АНУ-ын Хууль зүйл яамтай ижил төстэй үүрэгтэй. Тус яам нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйлажиллагааны талаар их хэмжээний судалгаа, шинжилгээний ажлыг санхүүжүүлдэг Их Британи улсын төрийн байгууллага юм - 10, 19, 36, 38, 40, 41 дүгээр алхам

**Гэмт хэргийн төвлөрөл өндөр бүхий хэсэг:** Аль дүүрэг, хороололд гэмт хэрэг төвлөрч буйг харуулна - 23 дугаар алхам

**Гэмт хэргийн төвлөрөл өндөр бүхий цэг:** Гэмт хэргийн гаралт, түвшин өндөртэй байрлал - 23 дугаар алхам

**Гэмт хэргийн төвлөрөл өндөр бүхий шугам:** Гэмт хэрэг төвлөрсөн гудамж - 23 дугаар алхам



**Гэмт хэрэгт өртөх магадлал өндөр бүхий бүтээгдэхүүн:** Хулгайд өртөх магадлал өндөр бүхий эд зүйл, бүтээгдэхүүнийг хэлнэ - 18, 28, 29, 31 дүгээр алхам

**Гэмт хэргийн төвлөрөл өндөр бүхий газар:** Гэмт хэргийн газар зүйн төвлөрөл - 3, 5, 16, 17, 18, 23, 48, 55 дугаар алхам

**Таамаглал:** Аливаа асуудал, зөрчлийн талаар дэвшүүлсэн таамаглал. Таамаглал нь үнэн эсвэл худал, баримт нотолгоогоор дэмжигдсэн эсвэл дэмжигдээгүй байж болно - 20, 50 дугаар алхам

**Нөлөөллийн үнэлгээ:** Хариу арга хэмжээ нь асуудал, хэрэг зөрчилд бодитоор нөлөөлсөн эсэхийг тодорхойлох судалгаа - 46 дугаар алхам

**Дотоод квартил:** Голч дээр төвлөрсөн тохиолдлуудын 50 хувийн дээд ба доод хязгаар (25 дахь, 75 дахь хувь) - 22 дугаар алхам

**Шаардлагатай нөөц:** Хариу арга хэмжээ авахад шаардагдах материал, зүйлс, нөөц - 46 дугаар алхам

**Хариу арга хэмжээ /интервенц/:** Асуудал, зөрчилд үзүүлж буй хариу арга хэмжээ (хариу арга хэмжээ гэж өөрөөр нэрлэдэг, хариу арга хэмжээг үзнэ үү) - 4, 7, 11, 20, 35, 40, 44, 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52 дугаар алхам

**Менежер:** Аливаа газар, байрлалд гаргаж буй хүмүүсийн зан төлөв, үйл хөдлөлийг хянах үүрэгтэй этгээд - 5, 8, 24, 28, 30, 33, 38, 40, 58 дугаар алхам

**Дундаж:** Төвлөрсөн хандлага, чиглэлийг хэмжих. Үүнийг өөрөөр арифметик дундаж гэж нэрлэдэг. Бүх тохиолдлын утгуудыг хооронд нь нэмж, энэхүү нийлбэрийг тохиолдлын тоонд хувааж гаргана. Харьцааг, тэгш хэмт хуваарилалтуудыг тооцоход ач холбогдолтой - 22 дугаар алхам

**Голч:** Төвлөрсөн хандлага, чиглэлийг хэмждэг. Тохиолдлуудыг хоёр тэнцүү бүлэгт хувааж тооцно. Хагас нь голчийн доор, нөгөө хагас нь дээд хэсэгт байна - 22 дугаар алхам

**Дээд утга /mode/:** Төвлөрсөн чиг хандлагыг тооцох хэмжигдэхүүн. Хамгийн өндөр давтамжтай тохиолдлыг хэлнэ - 22 дугаар алхам

**Хөдөлгөөнт дундаж:** Цаг хугацааны хувьд өмнөх тохиолдлуудыг дундажлах замаар цаг хугацааны цувралын санамсаргүй хэлбэлзлийг бууруулах арга (Жигдлэх, тэгшигтгэх хэсгийг үзнэ үү) - 26, 52 дугаар алхам

**Ойролцоо давталт:** Бараг давталтыг үзнэ үү - 29 дүгээр алхам


**Зангилаа:** Орон байр (гэр), ажил, дэлгүүр, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, сургууль зэрэг хүмүүсийн очих цэг (Зам, замнал хэсгийг үзнэ үү) - 16 дугаар алхам

**Нэрлэсэн нэгж:** Оноосон нэр бүхий эрэмбэлэх боломжгүй утга - 22 дугаар алхам

**Магадлалын харьцаа:** Хоёр үзүүлэлтийн хоорондох хамаарлыг хэмжих хэмжигдэхүүн. Энэ нь кейс-хяналтын судалгааг хийх үед хэрэгтэй - 22 дугаар алхам

**Гэмт хэрэгтэн:** Гэмт хэрэг, хэрэг зөрчлийг үйлдэж байгаа этгээд - 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 21, 22, 28, 29, 30, 31, 34, 35, 36, 37, 39, 40, 41, 42, 43, 44, 46, 48, 49, 50, 52, 54, 58 дугаар алхам

# НЭР ТОМЬЁО



**Давтан гэмт хэрэгтэн:** Удаа дараа гэмт хэрэг, хэрэг зөрчил үйлдсэн этгээд - 3, 18, 30 дугаар алхам

**Боломж нөхцөл:** Гэмт хэргийн боломж нөхцөлийн бүтэц гэсэн үгийн товчилсон хэлбэр бөгөөд гэмт хэрэг үйлдэх боломж нөхцөлийг бүрдүүлсэн биет ба нийгмийн нөхцөл байдлыг хэлнэ - 9, 12, 38, 44, 48, 50 дугаар алхам

**Дэс дарааллын нэгж:** Эрэмбэлэх боломжтой боловч өөр бусад математикийн үйлдэл хийх боломжгүй утга - 22 дугаар алхам

**Үр дүн:** Хариу арга хэмжээний асуудал, зөрчилд үзүүлсэн нөлөө - 11, 33, 37, 46, 54 дүгээр алхам

**Багцлах:** Хүснэгт, зурагт илэрхийлсэн шугам, тэмдэг, тэмдэглэгээг хэлнэ. (Агуулгыг үзнэ үү). Агуулгыг тайлбарлахад товч бөгөөд ойлгомжтой байх хэрэгтэй. Хэт их мэдээлэл өгөх нь агуулгын утга санааг алдагдуулна - 56, 57 дугаар алхам

**Зам (замнал):** Зангилааг холбож буй чиглэл, маршрут - 16 дугаар алхам

**Гэмт хэрэгтний ойлголт:** Гэмт хэрэгтэн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрхэн авч үзэж, ойлгож байгааг илэрхийлнэ - 11, 34 дүгээр алхам

**Газар:** Хаяг, гудамжны булан, мухар гудамж зэрэг жижиг газар, орон зай (гэмт хэргийн турвалжныг үзнэ үү, орон байр хэсгийг үзнэ үү) - 8, 12, 13, 17, 18, 20, 27, 30, 32, 38, 39, 40, 48 дугаар алхам

**Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа (POP):** Асуудалд тулгуурласан ажиллагаа хэсгийг үзнэ үү - 4, 5, 6, 8, 14, 19, 46 дугаар алхам

**POP зөвлөмж:** Тодорхой төрлийн гэмт хэргийн тайлбар, түүнд авах хариу арга хэмжээний зөвлөгөө бүхий мэдээлэл, судалгаа, практик ажиллагааны нэгдсэн дүгнэлт Үүнийг [www.popcenter.org](http://www.popcenter.org) болон [www.cops.usdoj.gov](http://www.cops.usdoj.gov) цахим хуудаснаас үзээрэй - 3, 19 дүгээр алхам

**Асуудалд дүн шинжилгээ хийх турвалжин:** Ердийн үйл ажиллагааны онолын зургаан үндсэн элемент, бүрэлдэхүүн хэсгүүдийг харуулсан график. Үүнд: гэмт хэрэгтэн, харьцагч, бай, өртөгч, хохирогч, хамгаалагч, газар, менежер зэрэг багтана. Үүнийг гэмт хэрэг, хэрэг зөрчлийн дүн шинжилгээг хийхэд ашиглана - 8, 16 дугаар алхам

**Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа:** Давтан буюу түгээмэл гардаг гэмт хэргийн асуудлыг үүсгэдэг нөхцөлийг өөрчлөхөд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа. Тус цагдаагийн үйл ажиллагаа нь гэмт хэрэг, зөрчил үүсэхэд хариу үйлдэл үзүүлэх эсвэл тэдгээрийг хойшлуулах нөлөөтэй эргүүлийн ажиллагаанд тулгуурлаагүй байх - 1, 3, 4, 5, 6, 7, 11, 15, 19, 21, 28, 38, 55, 60 дугаар алхам

**Үйл явцын үнэлгээ:** Хариу арга хэмжээг хэрхэн хэрэгжсэнийг үнэлэх - 46, 47, 55 дугаар алхам

**Өдөөгч, сэдэл:** Биет зүйлсийн зохион байгуулалт, эсвэл тухайн газрыг зохицуулах арга зам нь гэмт хэргийг өдөөх шинж чанартай байх - 46, 47, 55 дугаар алхам

**"Р"-утга:** Статистикийн хоёр үзүүлэлтийн хоорондох зөрүү нь санамсаргүй байдлаас шалтгаалсан байх магадлал (ач холбогдлын сорил, тестийг үзнэ үү) - 53 дугаар алхам



**Санамсаргүй хэлбэлзэл:** Асуудлын олон тоот, маш жижиг нөлөөллөөс шалтгаалсан өөрчлөлтүүд - 26, 53 дугаар алхам

**Цар хүрээ:** Тархалтын хамгийн бага ба хамгийн их утгыг харуулах хэмжигдэхүүн - 22, 55 дугаар алхам

**Гэмт хэргийн харьцаа:** Гэмт хэргийн бай, гэмт хэргийн тоог харьцуулсан үзүүлэлт. Газар хоорондын бай, өртөгчийн тооны зөрүүг хянахад ашиглана (гэмт хэргийн эрсдэлийг үзнэ үү) - 9, 17, 20, 24, 26, 27, 28, 32, 37, 42, 44, 49, 51 дүгээр алхам

**Харьцааны нэгж:** Эрэмбэлсэн утга, онолын ач холбогдолтой тэг утгын хоорондох тэнцүү интервалууд бүхий хэмжигдэхүүн. Харьцааны нэгжээр хэмжсэн мэдээлэлд математикийн ямар ч аргачлалыг ашиглах боломжтой - 22 дугаар алхам

**Дундаж руу чиглэсэн регресс:** Хэвийнээс өндөр эсвэл бага давтамжтайгаар гарч буй гэмт хэргийн эргээд хэвийн түвшинд очих хандлага - 47, 52 дугаар алхам

**Хариу арга хэмжээ:** "SARA" процессын гуравдугаар үе шат. Үүнд гэмт хэрэг, хэрэг зөрчлийн асуудлыг бууруулах зорилготой хариу арга хэмжээг сайжруулах, хэрэгжүүлэх зэрэг багтана. Мөн урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг хэлнэ - 2, 4, 5, 6, 7, 14, 15, 17, 19, 20, 21, 23, 26, 29, 35, 36, 37, 38, 39, 40, 44, 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 54, 55, 58, 60 дугаар алхам

**Хариу арга хэмжээ авсан бүлэг:** Хяналтын бүлгийн эсрэг буюу урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан бүлэг, хүмүүс, газар - 47 дугаар алхам

**Үр дүн:** Хариу арга хэмжээний үр дүн - 46 дугаар алхам

**Гэмт хэргийн эрсдэл:** Гэмт хэрэгт бай өртөх магадлал - 6, 16, 17, 18, 20, 21, 23, 26, 27, 28, 29, 31, 33, 34, 38, 39, 41 дүгээр алхам

**"SARA":** Scanning (Тандах), Analysis (Дүн шинжилгээ хийх), Response (Хариу арга хэмжээ авах), Assessment (Үнэлгээ хийх) англи үгсийн товчлол

**Тандах (Scanning):** "SARA" процессын эхний үе шат. Үүнд: асуудлыг тодорхойлох, баталгаажуулах, ангилах үйл ажиллагаанууд багтана - 1, 7, 14, 16, 18, 38, 54 дүгээр алхам

**Бичиглэл:** Гэмт хэрэг үйлдэх тодорхой дараалал бүхий гэмт хэрэгтний стандарт үйлдэл - 35, 36 дугаар алхам

**Ач холбогдлын түвшин:** Өгөгдлүүд хоорондох зөрүү нь санамсаргүй байдлаас шалтгаалсан эсэхийг үгүйсгэх магадлал бүхий босго. Ихэнх тохиолдолд .05 (эсвэл 5 хувь) нь үгүйсгэх босго байдаг (Ач холбогдлын сорилыг үзнэ үү) - 53 дугаар алхам

**Ач холбогдлын сорил:** Өгөгдлүүд хоорондох зөрүү нь санамсаргүй байдлаас шалтгаалах эсэхийг үнэлэх статистик аргачлал - 53 дугаар алхам

**Нөхцөл, шалтгааныг арилгах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх:** Гэмт хэргийн нөхцөл боломжийг бууруулах шинжлэх ухаан - 1, 13, 16, 34, 38, 41, 54 дүгээр алхам

**Жигдлэх, тэгшитгэх:** Хөдөлгөөнт дунджийг ашиглан цаг хугацааны цуваанаас санамсаргүй хэлбэлзлийг арилгах (хөдөлгөөнт дунджийг үзнэ үү) - 26, 52 дугаар алхам

# НЭР ТОМЬЁО

**Стандарт хазайлт, хэлбэлзэл:** Тэгш хэмт хуваарилалтын тархалтыг хэмжихэд чухал ач холбогдолтой тархалтын ерөнхий хэмжигдэхүүн - 22, 53 дугаар алхам

**Стандарт загвар:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүл, хамгаалалт, шуурхай хариу арга хэмжээ, мөрдөн шалгах үйл ажиллагаанд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа - 3 дугаар алхам

**Бай, хохирогч:** Гэмт хэрэгтэн довтлох, хор хөнөөл учруулахад өртөх этгээд - 2, 8, 10, 12, 13, 14, 15, 16, 17, 20, 23, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 34, 35, 38, 39, 41, 44, 47, 48, 49, 52, 54, 58 дугаар алхам

**Эрсдэлт бай, хохирогч:** Гэмт хэрэгт өртөх магадлал бүхий эрсдэл өндөр хүн эсвэл эд зүйлс - 26, 27 дугаар алхам

**Цаг хугацааны бөөгнөрөл:** 24 цагийн тодорхой үед гэмт хэрэг төвлөрөх (гэнэтийн болон хурц, жигд тархмал, төвлөрсөн гэх зэрэг цаг хугацааны бөөгнөрлийг үзнэ үү) - 25 дугаар алхам

**Цаг-ценхны нөлөө:** Тодорхойлсон цаг хугацааг ашигласны улмаас давтан хохирогч үүсэх нөхцөлийг дутуугаар үнэлэх - 29 дүгээр алхам

**Хариу арга хэмжээ /treatment:** Хариу арга хэмжээ, нөлөөллийн арга хэмжээг үзнэ үү - 48, 49, 51 дүгээр алхам

**Хариу арга хэмжээ авсан газар /treatment area:** Хариу арга хэмжээ авсан газрыг үзнэ үү - 48, 51 дүгээр алхам

**Хариу арга хэмжээ авсан бүлэг /treatment group:** Хариу арга хэмжээний бүлгийг үзнэ үү - 49, 51 дүгээр алхам

**Ерөнхий чиг хандлага:** Тодорхой хугацаанд гэмт хэрэг тогтвортойгоор нэмэгдэх, буурах хандлагыг хэлнэ - 2, 20, 22, 26, 47, 49, 52, 57 дугаар алхам

**Хяналтгүй кейс судалгаа:** Асуудалтай этгээд, газар, цаг хугацаа, нөхцөл байдлыг ижилтөстэй, асуудалгүй этгээд, газар, цаг хугацаа, нөхцөл байдалтай харьцуулахгүй байхыг хэлнэ. Энэ судалгааны үр дүн ихэвчлэн буруу байх нь элбэг - 32 дугаар алхам

**Хохирогч:** Гэмт хэрэгт өртсөн эд зүйлс, хөрөнгийн эзэн эсвэл хүнийг хэлнэ - 1, 2, 4, 6, 8, 10, 14, 15, 16, 18, 21, 22, 23, 25, 28, 29, 30, 31, 33, 34, 35, 36, 37, 38, 42, 44, 46, 47, 48, 54, 55 дугаар алхам

**Давтан хохирогч:** Гэмт хэрэг, хэрэг зөрчил олон удаа тохиолддог газар, бай, өртөгчийг хэлнэ. (Суугаа хүн/хүүхдэд хамаарах гэсэн мэдээллийг үзнэ үү) - 18, 23, 28, 29 дүгээр алхам

**Давтан хохирох:** Давтан хохирогч болоход хүргэж байгаа процесс - 8, 28, 29, 30, 33, 38, 46 дугаар алхам

**Бараг давталт:** Анхны байтай шинж чанарын хувьд төстэй дараагийн байг хэлнэ (давтан хохирогч, давтагдсан газар зэрэг тохиолдол) мөн ойр (ойрхон) давталт гэж нэрлэдэг - 29 дүгээр алхам

**Чонын асуудал:** Давтан хэрэгтний үйлдсэн гэмт хэрэг (Гэмт хэргийн гурвалжныг үзнэ үү). Гэмт хэрэгтэн, өртөмтгийн бай, газрыг олж илрүүлэх чадвартай үед тохиолдоно - 8, 15 дугаар алхам



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэшсэн хоёр мэргэжилтний бичсэн энэхүү заавар нь гэмт хэргийн шинжээчид болон асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа бүхий төсөл дээр ажиллаж буй цагдаагийн бусад албан тушаалтнуудад зориулагдсан болно. Энэ зааварт асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагааны суурь ойлголтын талаар танилцуулсан бөгөөд гэмт хэргийн хэв маягт дүн шинжилгээ хийх зорилгоор боловсруулсан шинэ үзэл баримтлал нь гэмт хэргэг, эмх замбараагүй байдлын талаарх ойлголтыг хэрхэн сайжруулж болохыг мөн харуулсан. Түүнчлэн нөхцөл, шалтгааныг арилгах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 25 арга зам цагдаагийн байгууллагын асуудлыг шийдвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх боломжтойг илэрхийлж байна. Эцэст нь, шилжилт хөдөлгөөн үүссэн эсэхийг шалгах арга зэрэгт үндэслэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөтэй байдлыг үнэлэх аргачлалыг талаар зааварчилсан билээ.



Center for  
Problem-Oriented Policing

